

НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН СУРАХ БИЧИГ 2-Р ДЭВТЭР

*Силэн Тагт болон бусад зохиогчид*

# ЭДИЙН ЗАСАГ БА НИЙГМИЙН АРДЧИЛАЛ



AKADEMIE  
FÜR  
SOZIALE  
DEMOKRATIE

FRIEDRICH  
EBERT  
STIFTUNG





Фридрих-Эбертийн сангийн  
Улс төрийн боловсролын академиас  
эрхлэн гаргав.

2009 оны 1-р сар. Бонн хот

Герман хэлнээс орчуулсан:

Фридрих-Эбертийн сангийн  
Монгол дахь Төлөөлөгчийн  
газрын захирал

Редакторласан:

Чогдонгийн Оюунгэрэл  
Нийгмийн хамгааллын сайдын  
зөвлөх, Доктор

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Горчинсүрэнгийн Адъяа  
Фридрих-Эбертийн сангийн  
нарийн бичиг  
Ёндонренчингийн Батболд

## НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН СУРАХ БИЧИГ 2-Р ДЭВТЭР

Симон Баут болон бусад зохиогчид

ЭДИЙН ЗАСАГ  
БА  
НИЙГМИЙН АРДЧИЛАЛ



## АГУУЛГА

|                                                                                       |      |
|---------------------------------------------------------------------------------------|------|
| Хоёрдох хэвлэлд зориулсан өмнөх үг                                                    | 7.   |
| Орчуулагчийн зурвас                                                                   | 9.   |
| 1. Оршил                                                                              | 10.  |
| 2. Эдийн засгийн суурь онолууд                                                        | 14.  |
| 2.1. Адам Смит-Эдийн засгийн либерализмыг үндэслэгч мөн.                              | 17.  |
| 2.2. Карл Марксын капитализмын шүүмж                                                  | 22.  |
| 2.3. Жон Майенард Кенс: Капитализмыг удирдах нь                                       | 28.  |
| 2.4. Эдийн засгийн онолын идеал хэлбэрүүд                                             | 34.  |
| 2.5. Эдийн засгийн өнөөгийн байдал                                                    | 36.  |
| 3. Эдийн засгийн системүүд ба эдийн засгийн дэглэмүүд                                 | 49.  |
| 3.1. Капитализм ба ардчилал                                                           | 49.  |
| 3.2. Зохицуулалттай ба зохицуулалтгүй капитализм                                      | 53.  |
| 3.3. Даяаршлын эрин үеийн шинэ ерөнхий нөхцөлүүд                                      | 58.  |
| 4. Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлага                             | 64.  |
| 4.1. Үнэт зүйлс                                                                       | 64.  |
| 4.2. Үндсэн эрхүүд                                                                    | 67.  |
| 4.3 Эдийн засгийн бодлогын зарчмууд                                                   | 74.  |
| 4.4. Тойрон аялал: Чанарын өсөлтийг хэмжих нь                                         | 84.  |
| 5. Улс төрийн намуудын эдийн засгийн хөтөлбөрүүдийг харьцуулахуй                      | 87.  |
| 5.1. Хамбургийн хөтөлбөр-Германы Социал Демократ Намын (ГСДН) мөрийн хөтөлбөр         | 88.  |
| 5.2. Германы ерөнхий зарчмууд-Христосын Ардчилсан Холбоо Намын (ХАХН) хөтөлбөр        | 92.  |
| 5.3. “Ирээдүй ногоон байх болно - Холбоотон 90\Ногоонтнууд намын мөрийн хөтөлбөр”     | 95.  |
| 5.4. Германы Чөлөөт Ардчилсан Нам (ГЧАН) -ын “Биесбадены ерөнхий зарчмууд”            | 98.  |
| 5.5. “Зүүний нам”-ын “Хөтөлбөрийн үндсэн зорилтууд”                                   | 101. |
| 5.6. Улс төрийн намуудын хөтөлбөрийг Нийгмийн ардчиллын зорилтуудын хүрээнд үнэлэх нь | 104. |
| 6. Эдийн засгийн дэглэмүүд: Улс орнуудын загварууд                                    | 108. |
| 6.1. АНУ                                                                              | 108. |
| 6.2. Их Британи                                                                       | 113. |
| 6.3. Герман                                                                           | 119. |

|                                                                                                                      |             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|
| 6.4. Япон                                                                                                            | 127.        |
| 6.5. Швед                                                                                                            | 134.        |
| <b>7. Эдийн засгийн тодорхой бодлого: Практик жишээнүүд</b>                                                          | <b>141.</b> |
| 7.1 Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого<br>Тогтвортой ирээдүйд хүргэх өсөлтийн бодлого                       | <b>142.</b> |
| 7.2. Төсвийн бодлого: Бид Германд ямар өртэй бэ?                                                                     | 147.        |
| 7.3. Хувьчлалын эрсдэлүүд ба боломж                                                                                  | 153.        |
| 7.4. Сайн хөдөлмөр ба компаниудын шийдвэрт<br>гаргалтанд ажилтнуудын оролцоог хангах нь:<br>Сайн хөдөлмөрийн бодлого | 159.        |
| 7.5. Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоохын<br>эргэн тойронд өрнөж буй мэтгэлцээн                                  | 168.        |
| <b>8. Ирээдүйг эргэцүүлэхүй</b>                                                                                      | <b>176.</b> |
| <b>9. Зохиогчдын тухай</b>                                                                                           | <b>178.</b> |

## ХОЁРДОХ ХЭВЛЭЛД ЗОРИУЛСАН ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн зах зээл ба эдийн засгийн хямрал нь энгийн нэг үйлдвэрлэлийн осол төдий зүйл биш. Энэхүү хямрал манай нийгмийн оршихуйд нөлөөлж буй юм. Бид дараагийн жилүүдэд, дараагийн арванд, жаранд хэрхэн ажиллаж амьдрах бэ? гэдэг шийдвэрээ өнөөдөр гаргах ёстой. Эв санааны нэгдэл, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн эдийн засгийн дэглэм ямар байх ёстой юм бэ? Төр ба зах зээлийн зохистой харьцаа ямар байх ёстой юм бэ? Үнэлэмж дээр суурилсан, орчин үеийн нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх бэ?

Эдийн засгийн бодлогод өөрийн бодлыг нэмэрлэх, бодлогыг хамтран тодорхойлохыг хүсэгч иргэн бүрт дээрх асуултын хариулт шийдвэрлэх ач холбогдолтой. Хямрал бидэнд нэгэн том сургамжийг өглөө. Хяналтгүй зах зээлд бүхнийг даатгах сэтгэлгээ явуургүй гэдэг нь нотлогдлоо. Эндээс эдийн засгийн бодлогын тулгын чулууг шинээр тавих боломж байна уу? гэдэг асуулт урган гарна. Аялалын чиглэлийг хүрэх зорилготойгоо мэдэж буй хүн хамтдаа аялах нь ашигтай гэдэгт бусдыг итгүүлж зорилгодоо хүрч чадна.

Та бүхнийг өөртөө итгэлтэй байхад тань хувь нэмэр болог хэмээн энэхүү сурах бичгийг таньд толилуулж байна. Уг сурах бичигт эдийн засгийн чухал онолууд, эдийн засгийн дэглэмүүдийг тайлбарлаж үндсэн үнэлэмжүүд, чиг хандлагуудыг тодорхойлж эдгээр үнэлэмж, хандлагууд нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогод ямар ач холбогдолтой бэ? гэдгийг тайлбарлана. Гэхдээ дээрх асуултуудад төгс бөгөөд хөдөлшгүй хариулт өгөх боломжгүй гэдэг нь тодорхой. Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд энд дурьдсан үнэлгээ, таамаглуудад байнга шинэчилсэн дүгнэлт хийж тэдгээрийн нотолгоонуудыг шинэчлэн тогтоож байх хэрэгтэй. Энэхүү сурах бичиг та бүхэнд төгс, хөдөлшгүй хариултыг өгөх зорилтыг агуулаагүй, тэгэх ч боломжгүй тул та бүхэнд унших, уншсан дээрээ ургуулан бодох урилга болно хэмээн найдаж байна.

Уг сурах бичиг нь нийгмийн ардчиллын сурах бичгийн 2-р дэвтэр бөгөөд нийгмийн ардчиллын үндсүүд хэмээх нэгдүгээр дэвтэр дээр суурилан боловсруулагдсан билээ. Нэгдүгээр дэвтэрт нийгмийн ардчиллын үнэт зүйлсийг тодорхойлж Либералууд, Консервативчууд, нийгмийн ардчиллыг баримтлагсдын нийгмийн загваруудыг хооронд

нь харьцуулан либертар ардчилал, нийгмийн ардчиллын ялгаатай талуудыг тайлбарласан. Энэхүү сурах бичгийн гуравдах дэвтэр нь Нийгмийн баримжаат төр ба Нийгмийн ардчилал нэртэйгээр та бүхний гар дээр очих болно.

Хэрэв бид 21-р зууны эдийн засгийн талаар мэтгэлцэхийг хүсэж буй бол даяаршлаас үүдэлтэй гүнзгий өөрчлөлтүүдийг анхаарлынхаа гадна орхиж болохгүй. Эдгээр сурах бичгийн дараагийн дэвтэр нь Даяаршил ба нийгмийн ардчилал нэртэйгээр боловсруулагдаж буй. Уг дэвтэрт даяаршил нь эдийн засгийн дэглэмийн ерөнхий нөхцөлүүдийг тогтооход ямар нөлөө үзүүлж буйг авч үзэх болно. Даяаршил хэмээх дэвтэрт даяаршил юунаас үүдэлтэй, даяаршлыг бодлогоор зохицуулах боломж бий эсэхэд дүн шинжилгээ хийх болно.

Энэхүү дэвтрийн үндсэн зохиогчид болох Симон Баут, Товиас Гомберт нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Товиас Гомберт өргөн мэдлэг, өндөр чадвараа дайчлан энэхүү дэвтрийн редакци, сургалт арга зүйн боловсруулалтыг хийсэн юм. Мөн энэ дэвтрийн бүтцийг боловсруулахад үнэтэй зөвлөгөө өгсөн Томас Майер, Михаел Даудерштадт нарт, үнэтэй санаа шүүмжүүдийг өгсөн Вилгелм Ноеллинг болон бусад зохиогчдод харилцан ойлголцож хамтран ажилласанд талархал илэрхийлж байна. Та бүхний хичээл зүтгэлгүйгээр энэ номыг хэвлэн гаргах боломжгүй билээ. Найрсгаар хамтран ажиллаж чадаагүй бол олон бэрхшээлтэй тулгарах байсан нь дамжиггүй.

Нийгмийн ардчиллын академийн бэлэг тэмдэг бол зүг чигийг заагч луужин. Академийн үйл ажиллагаагаар дамжуулан Фридрих-Эбертийн санд тодорхой байр суурь, чиг хандлагыг тайлбарлах ерөнхий хүрээг тогтоож өгөхийг би зорьсон билээ. Та бүхний улс төрийн замаа тодорхойлох үйлст бидний үйл ажиллагаа тус болбол бид баярлах болно. Иргэдийн идэвхтэй хамтын ажиллагаа, идэвх чармайлтаар нийгмийн ардчиллын үзэл баримтлал баяжиж шинэчлэгдэж байдаг билээ.



Христиан Крелл  
Нийгмийн ардчиллын  
академийн захирал



Ёоахен Даам  
Нийгмийн ардчиллын сурах  
бичгүүд төслийн удирдагч

## ОРЧУУЛАГЧИЙН ЗУРВАС

Монголын нийгэмд “Аль улс төрийн нам аль чиглэлийг баримталдаг бэ?”, “Улс төрийн намуудын баримталж буй бодлогуудын хооронд ялгаа байна уу?”, “Бүх нам бүгдээрээ зүүний бодлогыг баримтлаад байгаа юм биш үү?”, “Эдийн засаг өсөөд байгаа хэрнээ ард түмний амьдрал яагаад дээшлэхгүй байна?”, “Улс төрийн намууд буруу тийш нь залаад байгаа юм биш үү?” гэх зэрэг асуултууд хүчтэй тавигдаж байгаа өнөө үед улс төрийн намууд мөрийн хөтөлбөрөө боловсруулахад ард иргэдийнхээ саналыг авах аянд мордож өргөн хүрээтэй кампанит ажлуудыг улс орон даяар өрнүүлж байна. Молхи орчуулагч миний бие Германы нэрт эрдэмтэн Томас Майерийн “Нийгмийн ардчиллын ирээдүй” хэмээх номыг монгол хэлнээ орчуулан мэргэн уншигчиддаа өргөн барьсны дараагаар нийгмийн ардчиллын зорилтуудыг эдийн засгийн ямар бодлогоор хэрэгжүүлэх бэ? гэдэг эргэцүүлэлд тань хувь нэмэр болгох зорилгоор Фридрих-Эбертийн сангийн нийгмийн ардчиллын академиас эрхлэн гаргасан “Эдийн засаг ба нийгмийн ардчилал” хэмээх сурах бичгийг мөн орчуулан хүргэж байна. Ардчилалд иргэдийн оролцоо, улс төрийн намуудад гишүүдийн оролцоо агаар ус мэт хэрэгтэй гэдгийг сүүлийн үеийн улс төрийн хөгжил харуулж байна. Улс төрийн намууд иргэдийнхээ өргөн оролцоонд тулгуурлан иргэдтэйгээ хамт мөрийн хөтөлбөрөө боловсруулахаар хичээл зүтгэл гарган ажиллаж буй нь ардчиллын соёлд гарч буй эерэг алхам гэдгийг сайшаан тэмдэглэхийн ялдамд бусдын туршлагаас суралцаж болзошгүй алдаанаас зайлсхийх боломж байгаа гэдгийг сануулах юун. Даяаршсан дэлхий дээр монголын эдийн засгийг тусгаарлан хөгжүүлэх боломжгүй ч дэлхий ертөнцийн эдийн засгийн хүчит гольдролд өөрийн залууртай явахын чухлыг, зөв залуурдахын тулд эрин цаг үеийнхээ эдийн засгийн хөгжилд дүн шинжилгээ хийх чадвартай байж аялдан дагалдагч биш харин идэвхтэй актёр байхын чухлыг мэдэхэд энэхүү сурах бичиг хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

Луу жил монгол түмэнд маань аз хийморь, амжилт бүтээлийг авчрах болтугай. Дараагийн дэвтрээр уншигч та бүхэнтэйгээ эргэн уулзахын бэлэгтэй ерөөлийг дэвшүүлье.

Фридрих-Эбертийн сангийн  
Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал  
Ч. ОЮУНГЭРЭЛ

## 1. ОРШИЛ

Нийгмийн ардчилал  
эдийн засгийн ямар  
бодлого тохирох бэ?

Холбооны канцлер асан Герхард Шройдер 1998 онд засгийн газрынхаа мэдэгдлийг хийхдээ манай эвсэл зүүний эсвэл барууны чиглэлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг тавиагүй харин орчин үеийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах болно гэж хэлсэн юм.

Канцлер асан Шройдер энэ үгээрээ юуг илэрхийлэхийг хүссэн юм бол?<sup>1</sup> Эдийн засгийн бодлогын салбарт либералууд, консервативууд, социалдемократуудын хооронд зааг ялгаа үгүй болчихсон хэрэг үү?. Бусад урсгалуудаас ялгаатай нийгмийн ардчиллын эдийн засгийн онол гэж байна уу?

Эсвэл бодит байдал дээр “орчин үеийн”, “орчин үеийн бус буюу хуучинсаг” гэдэг хоёрхон ялгаа л байдаг болчихсон хэрэг үү? Бид “хуучинсаг” бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө байна гэж хэлэх нэгэн олдоно гэж үү? Энэ утгаар нь авч үзвэл “орчин үеийн” гэдэг тодотгол ямар утга агуулж байна бэ? Хөл бөмбөгийн дасгалжуулагч Отто Рехагел нэгэн удаа “Амжилтанд хүрсэн баг бүр орчин үеийн тоглолтыг үзүүлж байна” гэж хэлсэн байдаг. Түүний энэ үгийг эдийн засагт хөрвүүлбэл амжилтанд хүрсэн эдийн засгийн бодлого бүрийг орчин үеийн эдийн засгийн бодлого гэж нэрлэнэ гэсэнтэй адилхан утгатай биш гэж үү?

Эдийн засгийн  
бодлогын амжилтыг  
юугаар хэмжих бэ?

Тэгэхлээр эдийн засгийн бодлогын амжилтыг юугаар хэмжих бэ? гэсэн дараагийн асуулт урган гарч ирнэ. Зарим нь эдийн засгийн амжилтыг хангалуун чинээлэг амьдралын түвшин болон эдийн засгийн өсөлт хоёрыг нэмэгдүүлэхэд бүх нөөц бололцоогоо хамгийн дээд зэргээр ашиглаж чадсан эсэхээр нь хэмжинэ гэх байх. Зарим нь тэгш байдал, шударга ёсны зарчмуудын хэрэгжилтийг онцгойлон анхаарах ёстой гэж хэлэх байх. Аливаа эдийн засгийн дэглэмийн гол зорилт нь ямар ч нөхцөлд тэгш бус байдал, мөлжлөг, шударга бус байдалд хүргэж хэрхэвч болохгүй. Тогтвортой байдал, нөөцийн ариг гамтай зарцуулалт, байгаль орчинд ээлтэй байдал нь эдийн засгийн амжилтын хэмжүүр байх ёстой гэдэг байр суурийг баримтлагсад улам бүр нэмэгдсээр байна. Байгаль орчныг хоослон сүйтгэх замаар өсөлтийг бий болгож хэрхэвч болохгүй.

Эдийн засгийн өсөлт,  
нийгмийн тэнцвэрт  
байдал, экологийн  
тогтвортой байдлын  
тэнцвэрийг хангах

Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдэл нь нийгмийн ардчиллын үнэт зүйлс мөн. Тэгэхлээр хөтөлбөрт нийгмийн ардчиллын зүгээс

1 Номд ихэнх тохиолдолд эр ба эр хүйсийг зөвхөн эр хүйсээр төлөөлүүлэн бичсэн. Хэл зүйн хувьд зарим хэсэгт хоёр хүйсийг хоёуланг нь, зарим тохиолдолд нэг хүйсээр төлөөлүүлэн бичсэн.

зөвхөн нэг л хариулт бий. Уг хариулт нь: дээрх гурван зарчим гурвуулаа нэгдүгээрт өсөлт, хоёрдугаарт нийгмийн тэгш байдал, гуравдугаарт байгаль орчинд ээлтэй байдал нэгэн зэрэг зохистой түвшинд хангагдсан байх ёстой гэдэг шаардлага юм.

Дээрх зорилтод хүрэх зам тодорхой бус байна. Герхард Шройдерийн хэлсэн үгээс орчин үеийн, үнэлэмж дээр суурилсан эдийн засгийн бодлого гэж ямар бодлогыг хэлэх бэ?, Сонгодог зүүний эсхүл барууны чиглэлийн эдийн засгийн бодлогын хэрэгслүүдээс алийг нь хэрэглэх бэ? гэдэг нь тодорхойгүй байна. Нийгмийн ардчиллын орчин үеийн үнэлэмж дээр суурилсан эдийн засгийн бодлого нь юуны өмнө үр дүнд чиглэсэн байх ёстой. Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын зорилго нь: Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдлийн үнэт зүйлс хангагдсан, бүх хүмүүсийн улс төр,нийгэм, эдийн засаг, соёлын үндсэн эрхүүд өргөн хүрээнд баталгаажсан нийгмийг цогцлоон байгуулах явдал мөн.

Нийгмийн ардчилал ямар онол дээр суурилбал зохилтой бэ? Эдийн засгийн ямар системүүд ба дэглэмүүд нийгмийн ардчиллын шаардлагуудыг хангахад илүү дөхөмтэй бэ? Бусад орнуудын эдийн засгийн дэглэмүүдэд нийгмийн ардчиллын шаардлагууд ямар түвшинд хангагдсан байна бэ? Эдгээр онолын асуудлууд бодлогын тодорхой төсөлд ямар ач холбогдолтой бэ? гэдэг асуултуудад энэхүү сурах бичиг үндсэн чиг хандлагуудыг өгөх зорилготой.

Энэхүү сурах бичгийн зорилго ба бүтэц

|                                 |                                                               |                                     |  |                                                              |                |      |       |            |                   |                |  |
|---------------------------------|---------------------------------------------------------------|-------------------------------------|--|--------------------------------------------------------------|----------------|------|-------|------------|-------------------|----------------|--|
| Сурах бичгийн сэдэвчилсэн бүлэг |                                                               |                                     |  | Нийгмийн ардчиллын эдийн засгийн чиг хандлагууд (4-р бүлэг ) |                |      |       |            |                   |                |  |
|                                 | “Нийгмийн ардчиллын үндсүүд” сурах бичгийн судлагдахуун       |                                     |  | Либерал ардчилал                                             |                |      |       |            |                   |                |  |
|                                 |                                                               |                                     |  | Нийгмийн ардчилал                                            |                |      |       |            | Либертар ардчилал |                |  |
|                                 | “Эдийн засаг ба нийгмийн ардчилал” Сурах бичгийн судлагдахуун |                                     |  |                                                              |                |      |       |            |                   |                |  |
|                                 | 2-р бүлэг                                                     | Онол                                |  | Маркс                                                        |                | Кенс |       |            | Смит              |                |  |
|                                 | 3.1-р бүлэг                                                   | Систем                              |  |                                                              | Капитализм     |      |       |            |                   |                |  |
|                                 | 3.2-р бүлэг                                                   | Дэглэм                              |  | эзэрхэг                                                      | зохицуулалттай |      |       |            |                   | зохицуулалтгүй |  |
|                                 | 6-р бүлэг                                                     | Улс орнууд                          |  |                                                              | Швед           | Япон | ХБНГУ | Их Британи | АНУ               |                |  |
|                                 | 5-р бүлэг                                                     | Намуудын хөтөлбөрүүдийн харьцуулалт |  |                                                              |                |      |       |            |                   |                |  |
|                                 | 7-р бүлэг                                                     | Практик жишээнүүд                   |  |                                                              |                |      |       |            |                   |                |  |

2-р бүлэг: Эдийн засгийн онолууд

Нэн түрүүнд эдийн засгийн онолын түвшинд түүхэнд нэрээ мөнхөлсөн нөлөө бүхий эдийн засагчид болох Адам Смит, Карл Маркс, Жон Маейнард Кенс нар ямар дүн шинжилгээ, дүгнэлтүүд үлдээснийг тайлбарлана. Эдгээр онол, дүн шинжилгээнээс эх авсан эдийн засгийн либерализм, антикапитализм, зохицуулалттай капитализмын идеал хэлбэрүүдэд нийгмийн ардчиллын өнөөгийн түвшингээс, нийгмийн ардчиллын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хэр нийцэж байна гэдэг талаас нь дүгнэлт өгөх болно. (Хоёрдугаар бүлэг)

3-р бүлэг: Эдийн засгийн системүүд ба дэглэмүүд

Эдийн засгийн системүүд болон дэглэмүүдийн түвшинд капитализм ба ардчиллын харилцан хамаарлыг судалж барууны аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад ноёлж буй эдийн засгийн дэглэмүүд болох зохицуулалттай ба зохицуулалтгүй капитализмын жишээн дээр танилцуулна. (Гуравдугаар бүлэг)

4-р бүлэг: Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлага

Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн түвшинд нэг талаас үнэт зүйлс, үндсэн эрхүүдийн харилцан шүтэлцээ ба эдийн засгийн бодлогын зарчмууд дээр тулгуурлан нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тодорхойлно. (4-р бүлэг)

5-р бүлэг: Улс төрийн намуудын эдийн засгийн бодлогын хөтөлбөрүүд

Нөгөө талаас зохицуулалттай ба зохицуулалтгүй эдийн засгийн дэглэмүүдийн шалгуур үзүүлэлтүүд ба 4-р бүлэгт тодорхойлсон нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлагууд дээр үндэслэн Бундестагт суудалтай улс төрийн намуудын эдийн засгийн бодлогын хөтөлбөрүүдийг тэдгээрийн мөрийн хөтөлбөрүүдийн хүрээнд харьцуулна. (5-р бүлэг)

6 ба 7-р бүлэг: Улс орнуудын загварууд ба практик жишээнүүд

АНУ, Их Британи, Герман, Япон, Швед улсуудын эдийн засгийн дэглэмүүдийг хооронд нь харьцуулж (6-р бүлэг) хувьчлал, байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого, сайн хөдөлмөр, компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах, цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох зэрэг салбаруудад тодорхой, үлгэр жишээ болохуйц бодлогын саналуудыг практик жишээн дээр (7-р бүлэг) дэвшүүлнэ.

Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын асуудал нь бодлогын олон түвшнийг хамрах бөгөөд эдгээр түвшнүүдийг энэхүү сурах бичигт товч тайлбарлах болно. Нэн ялангуяа нийгмийн ардчилал гэж юу бэ? гэдэг асуултанд хариулах болно.

Энэ асуултын эхний хариултыг Германы Социал Демократ Намын



(ГСДН) мөрийн хөтөлбөр өгнө:

Нийгмийн ардчилал нь бүх хүмүүсийн зөвхөн иргэний, улс төрийн, соёлын үндсэн эрхүүдийг хангаад зогсохгүй харин нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийг нэгэн адил хангадаг. Нийгмийн ардчилал нь нийгмийг ардчилах, нэн ялангуяа компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах замаар иргэдийн эрхүүд дээр суурилсан нийгмийн асуудлууд үүсэхээс урьдчилан сэргийлэх чадамжтай нийгмийн баримжаат төр, ардчилал зах зээлээс давуу байх эрхийг хангасан зохицуулалттай зах зээлээр дамжуулан бүх хүмүүсийн тэгш эрхт нийгмийн оролцоог хангадаг.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он 19-р хуудас)

## 2. ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ ОНОЛУУД

### ЭНЭ БҮЛЭГТ:

- ~ Эдийн засгийн онолын түүхэнд хамгийн нөлөө бүхий эдийн засгийн онолуудыг танилцуулна.
- ~ Тэдгээрийн өнөөгийн ач холбогдлыг үнэлнэ.
- ~ Эдгээр онолуудын нийгмийн ардчилалд ямар ач холбогдолтой болохыг танилцуулна.

*Смит, Маркс, Кенс  
нарын гурван том  
эдийн засагчид*

“Сэхээтнүүдийн нөлөөнөөс бүрэн ангид гэж өөрсдийгөө үздэг практикийнхан аль нэгэн мартагдсан эдийн засагчийн боол байх нь олонтоо.” гэж Кенс 1966 онд бичсэн байдаг. Жон Майенерт Кенс нь өөрөө эдийн засагч эрдэмтдийн түүхэнд хамгийн нөлөө бүхий эрдэмтдийн нэг юм. Энэхүү бүлэгт түүний онолын үндсэн шинжүүд мөн түүнтэй эн зэрэгцэхүйц ач холбогдол, нөлөө бүхий эдийн засагчид болох Адам Смит, Карл Маркс нарын онолыг танилцуулж хооронд нь харьцуулах болно. Ингэснээр бид эдийн засгийн онолын түүхийн гурван өндөрлөгтэй танилцах болно.

*Эдгээр сонгодогуудын  
ач холбогдол өнөө ч  
хэвээрээ юү?*

Өчнөөн олон жилийн өмнө, өөрсдийнхөө амьдарч байсан эрин үедээ бүтээлээ туурвин үлдээсэн дээрх эдийн засагчдын оюуны ертөнцтэй танилцах нь ямар ашигтай юм бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Тэдний үлдээсэн тайлбар он цагийн эргэлтэнд хувьсан өөрчлөгдсөөр байгаа өнөөгийн даяаршсан дэлхийд таарах уу? Эсвэл тэдний бүтээлүүд он цагийн тоосонд дарагдсаар ойлгомжгүй болж түүх тэднийг няцаачихсан хэрэг биш гэж үү?

Яагаад, ямар учир холбогдлоор эдгээр онолууд нийгмийн ардчилалд ач холбогдолтой хэвээрээ байгаа юм бэ? гэвэл дараах хоёр үндэслэлийг нэрлэж болно.

*Үзэл суртлын “чулуу  
буталгааны газар”*

Нэгдүгээрт эдгээр онолууд нь олон тохиолдолд “Үзэл суртлын чулуу буталгааны газар”-ын үүргийг гүйцэтгэж улс төр тэндээс эх ундаргаа авсаар ирсэн. Чулуу хэрхэн буталдагийг мэддэг байх нь эдийн засгийн бодлогын үндэслэлүүд үнэнд хэр нийцэж байна бэ? гэдэг дүн шинжилгээ хийх боломжийг олгож ингэснээр үзэл суртлын “чулуу нийлүүлэлтэнд” “мухар сохроор” итгэхээс өөр аргагүй байдлаас аварна.

Хоёрдугаарт нийгмийн ардчилал нь дээрх эдийн засгийн онолын аль нэгнийг зуун хувь баримталдаггүй, харин гурвууланг нь хамарсан ерөнхий норматив хүрээг тогтоодог. Тэгэхлээр нийгмийн ардчилал нь хэдийгээр Кенсийн тодорхойлсон зохицуулалттай капитализмын чиг урсгалыг илүүтэй баримталдаг ч дээр дурьдсан гурван онолын аль алинаас нь тодорхой элементүүдийг авч хэрэгжүүлдэг.

*Нийгмийн ардчилал нь дээрх гурван эдийн засагчдын онолоос гурвуулангаас нь тодорхой элементүүдийг авч хэрэгжүүлдэг.*

Гэхдээ дээрх гурван онол байнга хүчтэй шүүмжлэлд өртсөөр ирсэн. Тэдгээрийг үгүйсгэх оролдлого тоо томшгүй олон удаа гарсан. Тэднийг булшлагдсан, мартагдсан гэж олонтоо ярьдаг ч бурхан болсон гэж худал цуу тарсан хүн илүү урт насалдаг гэх үнэн үг гэдгийг батлах мэт бидний үед тэдгээр нь оршсоор, алдаршсаар байна. Эдийн засгийн гүнзгий мэдлэгтэй болохыг хүсэгч хүн бүр Адам Смит, Маркс, Кенсийн санаануудыг судлахгүйгээр санасандаа хүрэх боломжгүй юм.

Эдгээр сонгодогуудыг судлахдаа тэдний амьдарч байсан түүхэн цаг үед эргэн очих хэрэгтэй. Адам Смит өөрийн санаануудаа 18-р зууны дунд үед, хаад ноёдыг хэвийн хэмжээнээс хэтэрсэн асар том эзэмшил, худалдаанд хяналт тавих, эдийн засгийг удирдах замаар санхүүжүүлэхэд сургах зорилготой Меркантиализмын онол хэрэгжиж байсан тэр цаг үед боловсруулсан. Тэрбээр зөвхөн өөрсдөө баяжихаас бусдыг боддоггүй, хэтэрхий үрэлгэн хаад ноёдыг харан байж өөрийн санаануудаа боловсруулсан болохоор төрд тун таагүй хандаж байсан юм. Үүнийг орчин үеийн нийтийн сайн сайхны төлөөх төрд ч мөн таагүй хандах байсан мэтээр ойлгож болохгүй нь мэдээж.

*Түүхэн цаг үе: Смит; 18-р зууны дунд үе*

Марксын капитализмыг хайр найргүй шүүмжилсэн шүүмжлэл нь 19-р зууны дунд үеийн аж үйлдвэржилтийн эхэн үе буюу даяаршлын эхний давалгаа эхэлж байсан тэр үед хүн амын дийлэнх хэсгийг хэрхэн зовлон зүдгүүрээс гаргах бэ? гэдэг асуултанд өгсөн хариулт байлаа. Өдгөө Марксын амьдарч байсан түүхэн цаг үеийн тухай төсөөллийг 20-р зууны социалист төрөөр төлөөлүүлэн ойлгох болсон нь түүний санааг урж зэрэмдэглэсэн зураг мэт болгож орхисон юм.

*Маркс: 19-р зууны дунд үе*

Кенс 1930-аад оны дэлхийн эдийн засгийн хямралын улмаас хөгжлийнхөө замаас хазайсан нь тодорхой болсон эдийн засгийн либерализмд дүн шинжилгээ хийсэн юм. Түүний “Хөдөлмөр эрхлэлт, хүү, мөнгөний ерөнхий онол” нь эдийн засгийн системийг

*Кенс: 1930-аад он*

тогтворжуулах саналуудыг дэвшүүлэх, тэдгээрийн тусламжтайгаар ардчиллыг радикал диктатурт шилжүүлэхгүй байх гэсэн оролдлого байлаа. 2007 оны дэлхийн санхүүгийн хямрал нь Кенсийн сэтгэлгээнд дахин сэргэн мандлын үеийг авчирсан юм. Түүний санхүүгийн зах зээлийг дэлхий дахинаа зохицуулалтанд оруулах, төрийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санаа дахин өргөн хүрээнд яригдаж эхэллээ.

Он цагийн урсгалд ач холбогдлоо гээдэггүй эдийн засгийн ойлголтууд ба дүрслэл

Смит, Маркс, Кенс нарын гурван том онолчдыг судалснаар зарчмын чиг хандлага олж авахаас гадна практикын бас нэгэн давуу талыг олж мэдэх болно. Бид хэдийгээр эх сурвалжийг нь мэдэхгүй ч амьдралдаа байнга хэрэглэдэг, итгэл үнэмшил болгодог эдийн засгийн олон дүрслэл, тайлбарууд нь дээрх гурван онолчдоос эхтэй байдаг.

|                                         | Смит                                         | Маркс                                                                         | Кенс                                                                        |
|-----------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|
| Хэзээ                                   | 18-р зууны дунд үе                           | 19-р зууны дунд үе                                                            | 1930-аад он                                                                 |
| Онолыг боловсруулах болсон шалтгаан     | Меркентализм<br>Абсолютизм                   | Аж үйлдвэржилт<br>Ажилчин ангийн зовлон<br>зүдгүүр                            | Дэлхийн эдийн засгийн хямрал<br>Диктатур үүссэн                             |
| Үндсэн зорилго                          | Меркенталист<br>төрийн үед эрх чөлөөг олох   | Ажилтнуудын аж байдлыг сайжруулах<br>тэднийг мөлжлөгөөс чөлөөлөх              | Эдийн засаг ба хөдөлмөрийн зах зээлийг тогтворжуулснаар ардчиллыг бэхжүүлэх |
| Нийгмийн ардчиллалын зангилаа асуудлууд | Эрх чөлөө ба хамтын ажиллагааны үндсэн санаа | "Сайн хөдөлмөр"-ийн үндсэн санаа, хөдөлмөр ба капиталыг тэнцвэржүүлэх асуудал | Зохицуулалттай зах зээл ба эдийн засгийн идэвхтэй бодлогын үндсэн санаа     |

Смит: "Зах зээлийн үл үзэгдэгч гар"

"Зах зээлийн үл үзэгдэгч гарын" зүйрлэлийг Адам Смит анх нэвтрүүлсэн. Тэрбээр зах зээлийн үр ашигтай байдлыг энэ зүйрлэлээр тайлбарласан. Өдгөө уг зүйрлэлээр зарим тохиолдолд зах зээлд үлгэрт гардаг шиг аз дайрах гэдэг санааг илэрхийлдэг болжээ. Ийм аз дайрсан нөхцөлд зах зээл хүссэнээ хийж болно гэсэн санаа юм.

Маркс: "Сайн хөдөлмөр"

"Сайн хөдөлмөр" –ийн бодлогыг хэрэгжүүлэхийг хүсэгч хүн бүр Марксын онолыг тойрон гарах боломжгүй юм. Тэр "Хөдөлмөрийг хүнээс хөндийрүүлэх" гэдэг ойлголтыг хүн бүхэнд ойлгомжтойгоор тодорхойлсон юм.

Кенс олон хүний ишлэл татах дуртай “Алсдаа бид бүгдээрээ үхэх болно.” гэдэг үгийг хэлсэн. Тэр энэ үгээрээ зах зээл бүтэлгүйтсэн нөхцөлд төр хариуцлага хүлээх ёстой гэдэг санаагаа илэрхийлсэн. Тэр зах зээл аажимдаа өөрөө өөрийгөө эмчилдэг гэдэг байр суурийг баримтлагсдын эсрэг төр эдийн засгийн бодлогын хариуцлагыг хүлээх ёстой гэдэг “зааварчилгаа”-г өгсөн билээ.

## 2.1. Адам Смит нь эдийн засгийн либерализмыг үндэслэгч мөн.

Адам Смит (1723-1790 он)

Адам Смит нь эдийн засгийн либерализмын эцэг бөгөөд Шотландын ёс суртахууны философич, гаалийн ажилтан байлаа. Тэр “Хүн бүр амин хувийн ашгийн төлөө ажиллаж хүчнүүд чөлөөт зах зээлийн тоглоомоор наадаж буй нөхцөлд хангалуун амьдралын дийлэнх хэсэг бий болдог” гэдэг нотолгоог дэвшүүлсэн. Смит 1776 онд “Улс үндэстнүүдийн хангалуун чинээлэг амьдралын мөн чанар ба учир шалтгааны судалгаа” гэдэг бүтээлээ хэвлүүлсэн юм. Түүний энэхүү бүтээлийг “Улс үндэстнүүдийн хангалуун амьдрал” нэрээр олонтоо ишлэл татдаг бөгөөд шинэ цагийн эдийн засгийн үндэслэлийг тавьсан бүтээл хэмээн өндрөөр үнэлдэг. Түүний дэвшүүлсэн үндсэн санаанууд өнөөг хүртэл эдийн засгийн сурах бичгүүдэд бичигдсээр байна.

Харин түүний ёс суртахууны философичийн хувиар туурвисан бүтээлүүд нь төдийлөн олноо танил болоогүй бөгөөд “”с зүйн мэдрэмжүүдийн онол” бүтээлдээ “Шударга байдал, итгэл, үнэнч байдал нь эдийн засгийн үйл ажиллагаанд нэн чухал ач холбогдолтой бөгөөд нэг нь нөгөөгийнхөө байр суурин дээр өөрийгөө аваачин тавьж харилцан ойлголцох нь нийгмийн хамтын амьдралын чухал нэгэн хөдөлгөгч хүч мөн.” гэж бичжээ.

Эдийн засгийн либерал үзлийг баримтлагсдын онолын үндэс нь 1776 онд Адам Смитийн хэвлүүлсэн “Улс үндэстнүүдийн хангалуун чинээлэг байдал” бүтээл юм.

Тухайн түүхэн цаг үед Их Британид Меркантилизмаас капитализмд шилжих шилжилт явагдаж байлаа. (Герстенбергер 2006 он. 40, 57-65-р хуудас, Конерт 2002 он 64-р хуудас) Меркантилизмын эрин үе 16-18-р зууныг хүртэл үргэлжилсэн бөгөөд хаад ноёд цуглуулсан мөнгө, алтныхаа хэмжээгээр эдийн засгийн бодлогын амжилтыг хэмждэг байлаа. Худалдааг “Тэг” нийлбэрийн тоглоом гэж үздэг байлаа: Энэ нь

аль нэг орны олсон хэмжээгээр өөр нэг орон алдах ёстой гэдэг зарчим юм. Хоёр тал хоёулаа хожно гэдэг ойлголт байсангүй. Тийм ч учраас бараа бүтээгдэхүүнийг гаднаас оруулахад маш өндөр гаалийн хамгаалалтын татвар ноогдуулж харин түүхий эдийг оруулж ирэхэд дэмжлэг үзүүлдэг байлаа. Хаад ноёд эдийн засгийг удирдах оролдлогуудыг хийдэг байлаа. Тодорхой бүлэглэлүүдээс тогтоосон дэглэмээр хэн ямар хөдөлмөр эрхэлж болох, ямар бараа бүтээгдэхүүнийг хэр хэмжээгээр үйлдвэрлэх ёстойг маш нарийн зохицуулдаг байлаа.

Кенс: “Алсдаа бид бүгдээрээ үхэх болно.”

Гүнзгийрүүлэн судлах материалууд:  
Николаус Пиперийн (1996) Том эдийн засагчид: Эдийн засгийн шинжлэх ухааны урьдчилан сэтгэгчдийн амьдрал ба бүтээлүүд /Штутгарт/

Смит :“Улс үндэстнүүдийн хангалуун чинээлэг байдал”

Тухайн түүхэн цаг үеийн байдал: 18-р зууны дунд үеийн меркантилизм

Смитийн зорилго:  
Меркантизмыг  
халах

Смит эдийн засгийн меркантилист хатуу дэглэмийг халах зорилгоор “капитализмын тунхаг” –аа бичсэн. Түүний энэ санаа үржил шимт хөрсөн дээр унасан юм. Тэрбээр ийнхүү эдийн засаг, худалдааны либералчлалд өөрийн хувь нэмрээ оруулсан.

Смит улс ардын аж ахуйн баялагийн тухай онолыг үндсээр нь өөрчилсөн. Тэр баялгийг меркантилистууд алтны нөөцөөр үнэлдэг байсныг халж хөдөлмөрийн бүтээмжээр үнэлэх шинэ үнэлэмжийг нэвтрүүлсэн.

Хангалуун  
амьдралын гурван  
эх үүсвэр

Смит бүх нийтийн хангалуун амьдралын тухайн үеийн хүрсэн түвшинг дараах гурван эх үүсвэрээс үүдэлтэй гэж үзсэн:

Хувийн эрх ашиг, өмч хөрөнгөтэй болохын төлөөх  
идэвх чармайлт  
Хөдөлмөрийн хувиарлалт ба тусгай мэргэшил  
Чөлөөт худалдаа ба өрсөлдөөн

Хувийн эрх ашгийн  
төлөөх идэвхи  
чармайлт

Тэр дараах жишээн дээр хувийн эрх ашгаа гүйцэлдүүлж, өмч хөрөнгөтөй болох идэвх чармайлт нь ямар нэг хэмжээгээр үйлдвэрлэл хийхэд хүргэж энэ нь эцэстээ бүх нийтийн хангалуун амьдралд нэмэр болдог гэдгийг тайлбарласан байна.

“Хиам үйлдвэрлэгч, тариачин, нарийн боов үйлдвэрлэгчид сайхан сэтгэлтэй учраас биднийг өлсөж байгаа гээд хоол хүнс бэлтгэж өгөөд байгаа юм биш, харин тэд хувийн эрх ашгаа гүйцэлдүүдэхийн төлөө хийж өгч байгаа гэдгийг бид мэднэ. Бид ч хүмүүст хандахдаа хүнд нь хандахаасаа илүү аминч үзэлд нь ханддаг. Бид ч гэсэн яриагаа өөрсдийнхөө хэрэгцээний тухай яриагаар бус тэдний давуу талын тухай яриагаар эхэлдэг. (Смит 1974: 17)

“Үндэстний хангалуун амьдрал” бүтээлээ тэр “эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь хөдөлмөрийн хувиарлалт мөн” гэдэг өгүүлбэрээр эхэлсэн байдаг.

“Хөдөлмөрийн хувиарлалт нь хөдөлмөрийн үйлдвэрлэгч хүчнүүдийг бусад бүх хүчин зүйлүүдээс илүүтэйгээр дэмжин сайжруулдаг.” (Смит 1974:9)

Хөдөлмөрийн  
хувиарлалт нь  
бүтээмжийн өсөлтийн  
эх үүсвэр мөн.

Тэрбээр хөдөлмөрийн хувиарлалтын давуу талыг битүү зүүний үйлдвэрлэлийн жишээн дээр тайлбарласан. Нэг ажилчин ганцаараа өдөрт цөөн тооны битүү зүү үйлдвэрлэнэ. Харин битүү зүүний үйлдвэрлэлийг олон тооны хөдөлмөрийн алхамд хувиарлаад алхам бүрийг мэргэшсэн ажилчдаар гүйцэтгүүлбэл өдөрт маш олон мянган битүү зүү үйлдвэрлэх боломжтой болно. Бас нэгэн давуу тал нь ажилчид үйлдвэрлэлийн зөвхөн нэг процесс дээр хамаг анхаарлаа төвлөрүүлэн ажилладаг.

Эцэст нь Смит чөлөөт худалдаа, чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн байдаг. Олон чиглэлээр мэргэшсэн ажилчдад хөдөлмөрийн хувиарлалтын тодорхой нэгэн алхам ногддогтой төстэйгээр хоорондоо чөлөөт худалдаа хийх боломжтой бүлгүүд хамгийн сайн хийж чаддаг худалдааныхаа төрлөөр дагнан мэргэшинэ. Ингэснээр үйлдвэрлэлийн бүтээмж бүхэлдээ нэмэгдэх боломж бүрдэнэ. Смит нь “Зах зээлийн үл үзэгдэгч гараар” дамжин хийгдэх хувиарлалт нь илүү үр өгөөжтэй, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн ямар ч хэлбэрээс илүү бүтээмжийг нэмэгдүүлэх сонирхлыг бий болгоно гэж үзэж байлаа. Португал, Шотландын хоорондох худалдааг Смит жишээ болгон авч тайлбарласан байдаг.

*Чөлөөт худалдаа болон өрсөлдөөн нь хангалуун амьдралыг бүтээдэг.*

Шотланд улс маш сайн чанарын ноос үйлдвэрлэдэг бол Португал хямд өртөгтөй дарс үйлдвэрлэдэг. Үүнийг Смит харьцуулсан давуу тал гэж нэрлэдэг байлаа. Хэрэв эдгээр хоёр орон ноос, дарсны үйлдвэрлэл дээрээ гол анхаарлаа төвлөрүүлэн худалдаа эрхэлбэл өөрийн нутаг дэвсгэр дээрээ өндөр зардалтайгаар дарс болон ноос үйлдвэрлэх гэж оролдсоноос хамаагүй бага зардлаар хэрэгцээгээ хангахаас гадна худалдаанаас хоёр улс хоёулаа ашиг олно. Уг эргэцүүлэл нь түүний амьдарч байсан цаг үеийн худалдаа гэдэг бол тэг нийлбэрийн тоглоом гэдэг үзлээс ухарсан явдал байлаа. Энд нэг инээдэмтэй зүйл бол Смит арав гаруй жил гаалийн ажилтан байсан бөгөөд меркантилист худалдааны дүрэм, журмуудыг сахиулахын төлөө ажиллаж байжээ.

*Худалдаагаар дамжуулан давуу талыг бүрэн ашигладаг.*

Хангалуун амьдралын эх үүсвэр болох хувьдаа ашиг олохын төлөө чармайлт, хөдөлмөрийн хувиарлалт, худалдаа, өрсөлдөөнийг ашиглахын тулд Смитийн бодлоор төр нь зөвхөн шууд бус байдлаар зах зээлд нөлөөлж зах зээлд аль болох их чөлөөт орон зай үлдээж өгөх ёстой. Түүний энэ үзлээс “Laissez-faire”<sup>2</sup> буюу баталгаа нь хангагдах тухай номлол үүсчээ. Энэ номлолын гол санаа нь: Төр зөвхөн олон нийтийн аюулгүй байдал, улс орныг батлан хамгаалах, эрх зүйн баталгаат байдал, дэд бүтэц, боловсролыг хариуцах ёстой, харин зах зээлд төрийн оролцоо байх ёсгүй. Ингэсэн нөхцөлд үйлдвэрлэлийн бүтээмж эрс дээшлэх аж.

*“Laissez-faire” буюу төрийн оролцоогүй чөлөөт зах зээл” юу гэсэн утгатай үг бэ?*

Смит эдийн засгийн либералчлалын онолын үндсийг тавьснаараа юуны өмнө 19-р зууны аж үйлдвэржилтийн процесс эхлэх хүртэл далд байсан үйлдвэрлэгч хүчнүүдийн гарыг гавнаас нь чөлөөлж өгчээ. Смит нэн түрүүнд чөлөөт зах зээлийн эдийн засаг автоматаар тэнцвэрт байдлаа хадгалдаг гэж үзэж байсан бөгөөд хямрал, эдийн

*Үйлдвэрлэгч хүчнүүдийн гарыг гавнаас чөлөөл.*

---

<sup>2</sup> Laissez faire гэдэг үг нь баталгаа хангагдах гэдэг утгаар хэрэглэгддэг.

засгийн бууралтуудыг урьдчилан харж чадаагүй юм.

Хөдөлмөрийн  
хувиарлалтын асуудлууд

Маркс өөрийн онолдоо ажилчдыг дарлан мөлжих ба хөдөлмөрийг хүнээс хөндийрүүлэх байдалд дүн шинжилгээ хийсэнтэй адилаар Смит капитализмын сүүдэртэй талуудыг нэгэн адил олж харсан юм. Тэр хөдөлмөрийг улам олон жижиг алхмуудад хуваах нь хүмүүсийг мохооход хүргэнэ гэж болгоомжилж байсан учраас тэнцвэржүүлэхийн тулд сургалтын олон төрлийн хөтөлбөрүүдийг бий болгож сургалтын орон тоог нэмэгдүүлэхийг шаардаж байлаа.

Смитийн “Ёс зүйн  
мэдрэмжүүдийн  
тухай онол”

Смит олноо төдийлөн танил болоогүй “Ёс зүйн мэдрэмжүүдийн онол” хэмээх хоёрдох бүтээлдээ (1759) хүмүүсийн аминч үзлийг боловсон бөгөөд шударгаар биеэ авч явах болон хамт олны дунд байх хэрэгцээ нь ялан дийлнэ гэж үзжээ. Ингэснээр Смит бол хүмүүсийг зөвхөн өөртөө хамгийн их ашиг олохын төлөө ажиллагч бодьгал мөн гэж үздэг хомо экономист үзлийг баримтлагч гэж нотолдог хүмүүст няцаалт өгчээ.

Смит өөрийгөө эдийн засагч гэж үзэхээсээ илүү ёс суртахууны философич гэж үздэг байсан бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаан дахь шударга ёс, итгэл, үнэнч байдлын ач холбогдлыг онцгойлон үнэлдэг байжээ.



Смитийн нөлөө

Смитийн санаан дээр суурилсан эдийн засгийн сонгодог либерализмын онол нь 1929 оны дэлхийн эдийн засгийн хямралыг хүртэл олноо хүлээн зөвшөөрөгдсөн эдийн засгийн суурь онол байлаа. Хямралын дараагаар л үл үзэгдэгч гараар удирдуулсан зах



зээл байнга тэнцвэртэй байдалд байж чадаж байна уу үгүй юу гэдэг эргэлзээ хүмүүсийн дунд төрж эхэлсэн байна. Эдийн засгийн гүнзгий хямрал, түүний дараагаар удаан хугацаагаар үргэлжилсэн ажилгүйдэл **Laissez-faire** буюу төрийн оролцоогүй чөлөөт зах зээлийн сэтгэлгээний үнэн байдалд эргэлзэхэд хүргэж улмаар эдийн засгийн сонгодог либерализмын онол сууриараа ганхахад хүргэсэн юм. Нобелийн шагналт Жозеф Э. Стиглицт өнгөрсөн үед дүн шинжилгээ хийснийхээ үндсэн дээр зах зээлийг далдаас удирдагч үл үзэгдэгч гар нь ихэнх тохиолдолд огт байдаггүйд л хамаг учир нь байгаа юм гэж хэлсэн байдаг. (Стиглицт 2002 он) Смитийн дараагаар олон арван жилийн туршид энэхүү номын дараагийн бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлагдах Кенсианизмын эрин үе үргэлжилсэн юм. Олон жилийн турш сүүдэрт байсан эдийн засгийн либерал сэтгэлгээнд 1980-аад оны үед шинэ либералууд гарч ирснээр дахин сэргэн мандлын үе ирсэн юм.

Смитийн санаан дээр суурилан цааш нь хөгжүүлж, сурталчилсан эдийн засагчдын дундаас Фридрих Аугуст фон Хайек, Милтон Фридман нар олноо хамгийн ихээр танигдсан төлөөлөгчид юм. Милтон Фридман нь хожмоо “Чикагогийн сургууль” гэж нэрлэгдсэн либерал эдийн засгийн үзэл суртлыг үндэслэгч юм. Учир нь Фридман Чикагогийн их сургуулийн профессор байсан юм. Нео буюу шинэ либерал үзлийг баримтлагсад Смитийн санааг төрийн шүүмжлэл, чөлөөт зах зээлийг өмгөөлж хэлсэн үгийн хүрээнд товчлон харин Смитийн “**Ёс зүйн мэдрэмжийн онол**”-ыг анхаарлынхаа гадна орхигдуулсан байна.

Смитийн бүтээлүүдэд шинэчилсэн тайлбар өгөх явдал АНУ-ын ерөнхийлөгч асан Роналд Рейганы засаглалын үед, Их Британид ерөнхий сайд асан Маргарит Тетчерийн үед ихээхэн идэвхжсэн байна. Тэдний баримталж байсан улс төрийн гол санаа нь “Төр бол асуудлыг шийдвэрлэх нэгэн хэсэг биш бөгөөд –харин өөрөө асуудал юм.” гэдэг үзэл байлаа. Үүгээрээ тэд зохицуулалтыг задлах, хувьчлах, төрийн үйлчилгээг бууруулах санаагаа илэрхийлж байлаа.

Зах зээлд бүхнийг даатгах ёстой гэдэг үзлийг номлогсод Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн бодлогод ихээхэн нөлөөтэй байлаа. Вашингтоны зөвшилцөлийн хүрээнд дээрх байгууллагууд эдийн засгийн либерал үзэл суртлаа Латин Америк, хуучин коммунист

Чикагогийн сургууль

Тетчер ба Рейган  
нарын шинэчилсэн  
тайлбар

Вашингтоны зөвшилцөл

#### Бусад эх сурвалжууд:

Хелен Винтор ба  
Томас Роммел (1999  
он), Адам Смитийн  
эхлэн суралцагчаад  
зориулсан сурах бичиг  
Улс үндэстнүүдийн  
хангалуун чинээлэг  
амьдрал  
/Мюнхен/

орнууд, мөн 1997 оны азийн хямралын дараа Зүүн-өмнөд азид хүчтэй дэлгэрүүлсэн юм. Мөн санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг задалсан нь дээрх үзэл баримтлалын нөлөө байлаа. Түүний үр дагавараар даяаршлын санхүүгийн бүтэц түүхэнд тохиолдож байгаагүй гүнзгий хямралд өртөж 2008 оноос эхэлж дэлхий дахины эдийн засаг уналтанд орсон юм. Уг хямралын хамрах хүрээ, хэмжээ нь эдийн засаг, бодлогын сэтгэлгээнд өөрчлөлт гарахад хүргэсэн байна. Зах зээлд сохроор итгэдэг эдийн засгийн либерал үзэл суртлын оронд төр ба зах зээлийн тэнцвэрийг шинэчлэн тогтоож улс төрд зах зээлээс давуу эрх олгох хэрэгтэй гэдэг үзлийг баримтлагсад давамгайлах болсон байна.

## 2.2 Карл Марксын капитализмын шүүмж

Марксыг Смиттэй  
харьцуулах нь

**Карл Хейнрих Маркс** Карл Хейнрих Маркс (1818-1883) нь германы философич, улс төрийн сэтгүүлч байлаа. Либерал эдийн засагчид зах зээлийг чөлөөтэй тавьснаар тогтвортой байдал ба өсөлт аяндаа бий болно гэж үзэж байхад Маркс ангийн тэмцэл, дарлал мөлжлөг, зовлон зүдгүүр, хямрамтгай систем нь алсдаа пролетарийн хувьсгалд хүргэж болзошгүй хэмээн тодорхойлсон юм.

Марксын эдийн засгийн онолын хамгийн чухал бүтээл нь түүнийг насан эцэслэсний дараа хэвлэгдсэн “Капитал” бөгөөд 1867-1894 оны хооронд гурван боть нь хэвлэгдсэн гарсан. Түүний 1848 онд хэвлэгдэн гарсан “Коммунизмын тунхаг” хэмээх бүтээл нь улс төрд асар их нөлөө үзүүлсэн юм.

Германы философич Карл Марксын капитализмын шүүмжийг Смитийн санааны эсрэг онолын төсөл гэж олонтаа нэрлэсэн байдаг. Гэхдээ энэ нь зөвхөн зарим талаар үнэний хувьтай. Маркс Смитийн бүтээлийг нухацтай судалж эцэст нь түүнтэй төсөөтэй дүн шинжилгээнд хүрсэн юм. Капитализмын үйлдвэрлэгч хүч ба шинэчлэгдэх чадамжийг Маркс Смитээс илүү өндрөөр үнэлсэн байдаг. Харин Маркс тэдгээрээс урган гарах үр дагавруудыг өөрөөр үнэлсэн. Маркс капитализмыг зарчмын

хувьд тогтворгүй, эвдэн сүйтгэгч шинж чанартай гэж үзэж байснаараа Смитээс ялгаатай. Капитализм бол “Улс үндэстний хангалуун чинээлэг амьдрал”-д хүргэхгүй харин ажилчдын дийлэнх олонхийг зовлон зүдгүүрт хүргэнэ гэж үзэж байсан юм.

Марксын санааг ойлгохын тулд 19-р зууны аж үйлдвэржилтийн эхэн үеийн ажилчдын хэцүү хүнд амьдралын нөхцөл дунд өөрийгөө аваачиж тавих хэрэгтэй. Дүйсбург хотноо байрладаг Аж үйлдвэрийн соёлын музей дэх бичмэлүүд тухайн цаг үеийн дүр зургийг ой тойнд ортол дүрсэлсэн байдаг. (Вайер 2002 он)

Түүхэн цаг үе: 19-р  
зууны дунд үед аж  
үйлдвэржилтийн  
процесс эхэлж байлаа.

Чинээлэг давхаргынхан хотын захад хувийн орон сууцны хорооллуудыг барьж байхад ажилчид давчуухан гудамжуудыг дагуулан барьсан дорд муу хөлсний оромжуудыг хөлслөн суудаг байлаа. Тэдгээр оромжууд нь пиг дүүрэн, ариун цэврийн наад захын шаардлагыг хангахгүй бохир заваан, хэрээс хэтэрсэн өндөр хөлстэйг яана. (...) Нэгэн гэр бүлийнхэнтэй гаднын хэн нэгэн өрөөнд хамтдаа унтаж олон хүмүүс нэг орон дээр хэд хэдээрээ шахалдан ээлжлэн нүдний хор гаргах нь олонтаа. Хүмүүс шөнийн ээлж солигдох цагаар нойрсох хэмнэлээ зохицуулна. Фабрикуудын хөдөлмөрийн нөхцөл нь машин дээр ажиллах хүмүүст биш машинуудад тааруулсан байдаг байлаа. Долоо хоногийн ажлын цаг нь 70 цагтай тэнцдэг журамтай байсан бөгөөд нэхмэлийн аж үйлдвэрт тэр ч байтугай 80 цаг байлаа. Хүүхдийн хөдөлмөр өргөнөөр дэлгэрч нийгмийн аюулгүй байдал туйлын хангалтгүй, эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай байлаа.

Уг тодорхойлолт өнөө ч гэсэн дэлхийн олон ядуу орны амьдрал-хөдөлмөрийн нөхцөлтэй ихээхэн төсөөтэй, тэр ч байтугай тохирсон хэвээр байна.

Маркс хүмүүн бусын хөдөлмөрийн болон амьдралын нөхцөлийг азгүй тохиолдол бус харин капитализмын зайлшгүй үр дагавар хэмээн үзэж байлаа. Капиталистуудын нэмүү өртөг ажилчдыг дарлан мөлжсөний үр дүнд бүтээгддэг тул чөлөөт зах зээл зайлшгүй зовлон зүдгүүр, мөлжлөгт хүргэдэг гэдэг дүгнэлтэнд тэр хүрсэн юм.

*Дарлан мөлжлөг бол капитализмын үр дагавар мөн.*

Марксын онолд “нэмүү өртгийн” тухай ойлголт чухал байр суурийг эзэлдэг бөгөөд 1867 онд хэвлэгдэн гарсан “Капитал” бүтээлийнхээ эхний ботиор танилцуулсан ба насан эцэслэснийх нь дараа хэвлэгдсэн гарсан дараагийн ботиудад дэлгэрүүлэн тайлбарласан. Нэмүү өртөг бол үйлдвэрийн эзэд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан өртөг дээрээ нэмээд арилжаанаас олж буй өртөг юм. Жишээлбэл компанийн эзэн үйлдвэрлэлд нэг зуун евро оруулаад (бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ногдох цалингийн зардал ба бүх үйлдвэрлэлийн хэрэгслийн зардал) зах зээл дээр 110 еврогоор борлуулжээ. Энэхүү 10 еврогийн нэмүү өртгийг Марксын онолоор гагцхүү хүмүүсийн бүтээлч хөдөлмөр л бий болгоно. Өөрөөр хэлбэл: Ажилчид цалингийн хэлбэрээр авч буй мөнгөнөөсөө илүү өртгийг үйлдвэрлэсэн бол түүнийг нэмүү өртөг гэнэ.

*“Нэмүү өртгийн” тухай ойлголт*

Маркс ажилчид амьжиргааны эх үүсвэрээ дөнгөж залгуулах төдий цалин авдаг гэж тодорхойлсон. Харин капиталистууд ажилчдын авч буй дээрх цалин, тэдний бүтээж буй нэмүү өртөг хоёрын зөрүүгээр баяждаг.

Тэрбээр улам бүр хурцдаж буй өрсөлдөөний улмаас капиталистууд нэмүү өртгийг улам бүр нэмэгдүүлэхийг оролдох болно гэж үзэж байлаа. Цалин хөлс улам бүр хасагдаж ажлын цаг улам бүр уртсаж үйлдвэрлэлийн машинууд улам бүр нэмэгдсээр л байх болно. Үүний үр дагавраар ажилгүйдэл эрс нэмэгдэнэ. Үүний зэрэгцээ өрсөлдөгчид зах зээлээс олноороо шахагдан гарах болно. Эцэстээ нийгэм бүхэлдээ эзэмшилгүйчүүд ба гартаа бүх капиталыг (хөрөнгийг) атгасан цөөн баячуудын давхаргад хуваагдсаар байх болно.

Марксын хөдөлмөрийн үнэлгээний онолоор үйлдвэрийн эзэд ажилчдын хөдөлмөрийн бүтээмжээс тэдний цалингийн зардал, зарцуулагдсан бүх үйлдвэрлэлийн хэрэгслүүдийн өртгийг хасаад үлдэж буй ашгийг нэмүү өртөг гэнэ. Ингэхлээр нэмүү өртөг нь ажилчдын дарлал мөлжлөгтэй тэнцэнэ. Маркс нэмүү өртгийг энгийн хөдөлмөрийг удаан хугацаагаар хийсний үр дүнд бүтсэн өртгийг үнэмлэхүй нэмүү өртөг (илүү урт ажлын цаг зарцуулсны дүнд үйлдвэрлэгдэх), техникийн дэвшлийг нэвтрүүлсний үр дүнд үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн бол харьцангуй нэмүү өртөг гэнэ хэмээн хоёр ангилсан.

(Эдийн засгийн нэвтэрхий толь 2009 он)


Хөдөлмөрийг хүнээс  
хөндийрүүлэх тухай  
ойлголт

**Бусад эх сурвалжууд:**  
Полкер Хаппе, Густав  
Хорн, Ким Отто, (2009  
он) Эдийн засгийн  
лексикон Ойлголтууд,  
тоо баримтууд, учир  
холбогдууд,  
/Бонн хот/ <sup>3</sup>

Маркс “нэмүү өртгийн” тухай ойлголтоос гадна 1884 онд туурвисан “Философи ба эдийн засгийн эх бичмэл” бүтээлдээ “Хөдөлмөрийг хүнээс хөндийрүүлэх” тухай ойлголтыг тайлбарласан. Уг ойлголтоор Маркс Смиттэй төстэйгөөр үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж буй хөдөлмөрийн хувиарлалтын сүүдэртэй талуудыг олж харсан юм. Үй олноор нь үйлдвэрлэх үйлдвэрлэлийн явцад ажилчин хүн үйлдвэрлэлийн процессын нэгээхэн хэсэгт нэгэн хэвийн үйдвэрлэлийн алхамд оролцдог. Үйлдвэрлэлийн эцсийн шатаар гарч буй бэлэн бүтээгдэхүүн, түүнтэй холбоотой сэтгэл ханамж үгүй болно.

Өрсөлдөөн ба хөдөлмөрийн хувиарлалтыг Смит хөгжил дэвшлийн эх сурвалж гэж үзэж байсан бол харин Маркс өрсөлдөөн ба хөдөлмөрийн хувиарлалтыг капитализмын гол аюул, дарлал мөлжлөг, хөдөлмөрийг хүнээс хөндийрүүлэх гол шалтгаан хэмээн үзэж байлаа. Тэр өөрийнхөө амьдарч байсан эрин үеийн үйлдвэрлэлийн дэвшлийг зөвхөн хөрөнгийн эздэд ашигтай, харин ажилчдад зөвхөн зовлон зүдгүүр авчирч байна хэмээн үзэж байлаа.

<sup>3</sup> Бонн хотноо байрладаг J.H.W. Dietz Nachf., хэвлэлийн газарт олон ойлголтын тайлбарыг эдийн засгийн нэвтэрхий тольноос авч ашиглах боломжийг олгосонд талархаж байгаагаа илэрхийлье.



Зөвхөн ашиг олох зорилготой эдийн засгийн дэглэмийг Маркс тогтворгүй, хямралд өртөмхий гэж үзэж байлаа. Уг тогтворгүй байдал нь эцэстээ дарлагдаж буй ангийг хувьсгал гаргахад хүргэж болзошгүй гэж үзэж байлаа.<sup>4</sup>

Капитализмын  
тогтвортой бус  
байдал

Үйлдвэрлэлийн хэрэгслүүдийн төвлөрөл, хөдөлмөрийн нийгэмшил нь капиталист хүрээллийнхээ дунд тэвчиж болшгүй нэгэн цэгт хүрэх болно. Тэр цагт тэсэрнэ. Тэсрэлттэй хамт капиталист хувийн өмчлөлийн үе дуусгавар болох болно. (Маркс 1991 он. 684-р тал)

Марксын онолын сүүлчийн нэг үндсэн ойлголт нь "өмч"-ийн тухай ойлголт юм. Тэр 1848 онд туурвисан "Коммунист намын тунхаг бичиг" бүтээлдээ өмчийн тухай ойлголтод дэлгэрэнгүй тайлбар өгсөн юм. Тэр өмчийн тухай ойлголтоороо "Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх хувийн өмч" –ийг онцгойлон авч үзсэн юм.

Үйлдвэрлэлийн  
хэрэгслийн хувийн  
өмчлөл нь ангит  
нийгмийн онцлог  
шинж мөн.

Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх хувийн өмч нь Марксын хувьд капиталист ангит нийгмийн чухал онцлог шинж юм. Тэр өмнөх бүтээлүүдээ пролетарийн хувьсгал болно гэдэг таамаглалуудыг

<sup>4</sup> Маркс судлалд тэрбээр хувьсгалыг зайлшгүй байх ёстой гэж үзэж байсан уу? эсхүл байж болох түүхэн хөгжлийн боломж гэж үзэж байсан уу? гэдэг талаар өөр өөр тайлбар өгдөг. Энэ асуултын хариулт түүний бүтээлээ туурвиж байсан тодорхой цаг үеийн байдалд дүгнэлт өгч байна уу? эсхүл түүний бүтээлийг бүрэн судалсны дараагаар дүгнэлт өгч байна уу? гэдгээс хамаарна. Бусад эх сурвалж: Heinrich (2004: 169-178)

дэвшүүлсэн бөгөөд түүний бодлоор пролетарийн хувьсгалын дараа үйлдвэрлэлийн хэрэгслэлийн хувийн өмчлөл үгүй болох ёстой байлаа. Ажилчин ангийн хувьд амьжиргааныхаа баталгааг хангахтай үгүйтэй цалинтай тул олигтой өмчтэй болох ямар ч боломжгүй байлаа. Харин капиталистууд ажилчин ангийг дарлан мөлжсөний хүчинд өмчтэй болох боломжтой байлаа.

Коммунист намын  
тунхаг бичигт  
тавигдсан улс төрийн  
шаардлагууд

Тэр коммунист намын тунхаг бичгээр дамжуулан дараах шаардлагуудыг тавьж байлаа:

- ~ Төрийн өмчийн үндэсний банкыг байгуулах замаар зээлийг төрийн мэдэлд төвлөрүүлэх, зөвхөн төр монопол эрхтэй байх.
- ~ Бүх төрлийн тээврийн хэрэгслийг төрийн мэдэлд төвлөрүүлэх.
- ~ Үндэсний фабрикууд, үйлдвэрлэлийн хэрэгслүүд, атар эзэмшлийг нэмэгдүүлэх, улс орнуудыг хамтарсан эдийн засгийн төлөвлөгөөний дагуу сайжруулах (Маркс Энгельс 1987 он, 54-р тал)

Бүхнийг төрийн мэдэлд  
шилжүүлэх оролдлого  
ба тулгарах асуудлууд

Марксын хамгийн нөлөө бүхий тайлбарлагч Фридрих Энгельс хожим нь бүхнийг төрийн мэдэлд байлгах оролдлого нь зарим талаараа сөрөг талуудыг дагуулдаг болохыг олж харсан юм. "Төр үйлдвэрлэгч хүчнүүдийг өөрийнхөө өмчлөлд хэдийчинээ их авна, төдий чинээгээр ерөнхийдөө жинхэнэ капиталистын дүрд хувирч түүнийхээ хэрээр төрт улсынхаа иргэдийг дарлан мөлжих болно." (....) Харин өмчийн харьцаанд өөрчлөлт орохгүй бөгөөд харин төр оргил руу түрэгдсээр байх болно. (Энгельс 1988 он 553-р тал)

Түүхийг ангийн  
тэмцлийн үр дагавар  
хэмээн тайлбарлах нь:

Эдийн засагч Жон Кеннет Гэлврайть энэ хамаарлын талаар дараах ишлэлийг бичсэн. "Капиталист нийгэмд хүн хүнээ дарлан мөлждөг. Харин коммунизмд бол эсрэгээрээ." "Коммунист намын тунхаг бичигт тавьсан банкууд, дараагаар нь тээврийн хэрэгслүүд, үйлдвэрлэлийн хэрэгслүүдийг нэгтгэн төвлөрүүлж нийгэмчлэх шаардлагуудыг биелүүлсэн Зөвлөлт Холбоот улс, Ардчилсан Герман Улс гэх мэтийн улсууд бүтэлгүйтсэн.

Маркс ангийн тэмцлийн үр дагавраар хөрөнгөтнүүд, пролетарийн тэмцэл дээд цэгтээ хүрч эцэстээ пролетарийн хувьсгалаар төгсөнө гэж түүхийг таамаглаж байлаа. Тэр ангигүй, өрсөлдөөнгүй, үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчгүй нийгмийн тухай үл гүйцэлдэх онолыг дэвшүүлж байлаа.

Маркс хөрөнгөтнүүд ба пролетаруудын хоорондын тэмцэл дээд цэгтээ хүрсний улмаас эцэстээ пролетарийн хувьсгал гарах болно гэж түүхийг таамагласан байдаг. Тэрбээр үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчлөл ба өрсөлдөөнгүй анги давхаргагүй нийгмийн үл гүйцэлдэх санааг боловсруулсан юм.

Харин түүх Марксын тодорхойлсон ажилчдын зовлон зүдгүүр ба хөрөнгө өмчлөгчдийн гарт төвлөрөх төвлөрөл нь зайлшгүй гарах ёстой үр дагавар биш гэдгийг харуулсан. Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтанд орсноор ажилчдын эв санааны нэгдэл, зохион байгуулалт хүчирхэгжиж, нийгмийн баримжаат төр байгуулагдан төлөвшсөнөөр хангалуун амьдралын ашиг илүү шударгаар хувиарлагдах боломжтой болдог.

Марксын хэрэглэх дуртай байсан *“Буржуазие”*, *“Пролетари”* гэдэг ойлголтууд нь эсрэг тэсрэг байр суурьтай ангиудыг илэрхийлдэг. *“Пролетарчууд”* гэдэг ойлголт латин хэлний *proletarius* гэдэг үгнээс гаралтай ард түмний доод давхаргад хамаардаг гэдэг санааг илэрхийлдэг *“bourgeoisie”* буюу хөрөнгөтөн гэдэг ойлголт нь франц үгнээс гаралтай *“Эдийн засгийн хөрөнгөтөн”* гэсэн утгатай үг юм.

Хөрөнгийн төвлөрөл нь Австрийн эдийн засагч Жозеф Шүмпетерийн тодорхойлсон *“Бүтээлч сүйтгэл”* – ийн нөлөөгөөр саарах болно. Тэр эдийн засгийн компаниуд техник технологийн шинэчлэл, өрсөлдөөн, хямрал, эсхүл

худалдааны зах зээлүүд шинээр бий болсны нөлөөгөөр байнга шинэчлэгдэн эрэмбэлэгдэж байдгийг тодорхойлсон.

*Дарлал мөлжлөг нь зайлшгүй гарах үр дагавар биш юм.*

*Шүмпетер:  
“Бүтээлч сүйтгэл”*

*“Гаднын болон үндэсний зах зээлүүд шинээр нээгдэх, гар урчуудын үйлдвэрүүдийн зохион байгуулалтын хөгжил болон фабрикууд концерн болон өргөжсөн явдал нь .....эдийн засгийн хуучин бүтэц дотроосоо байнга шинэчлэгдэж, хуучин бүтцийг зогсолтгүй сүйтгэж дахин нэг шинэ бүтцийг үүсгэх байдлаар зогсолтгүй шинэчлэгдэн өөрчлөгдөх процессыг эхлүүлсэн. Энэхүү бүтээлч сүйтгэлийн процесс нь капитализмын мөн чанарыг илэрхийлдэг.”*

*( Шүмпетер 1942 он 137-р тал.)*

Авто машины үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж Күчер-морин тэрэгний үйлдвэрлэл, Хүфшмиед-морины тах үйлдвэрлэгч, Шталмайстер-ган хайлуулагч нарын байр суурийг эзэлж эхэллээ. Бичгийн машин үйлдвэрлэгчид бууж өгөхөөс өөр аргагүй байдалд хүрч тэдний байр суурийг компьютер үйлдвэрлэгчид эзэллээ.

Төрийн удирдлагат  
социализмын  
бүтэлгүйтэл

Эдгээр нь нэг талаасаа техник технологийн шинэчлэлийг дэмжигч нөгөө талаасаа шинэ найдваргүй байдлыг бий болгож хүмүүсээс хэвийн хэмжээнээс хэтэрсэн уян хатан байдлыг шаарддаг бүтээлч сүйтгэлийн жишээ юм.

Марксын дүн  
шинжилгээний  
амьдрах чадвар

Марксын сургааль дээр үндэслэн төрийн удирдлагатай социализмыг байгуулах туршилт бүтэлгүйтэж түүний онолыг баримтлагсдын нэр хүндийг эрс бууруулав. Ингэснээр түүний онол хэрэггүй болсон хэрэг үү? Зах зээлийн үр өгөөж, хувийн өмч дээр суурилсан эдийн засгийн дэглэмээс өөр, практик туршилтыг давж чадсан, хэрэгжих боломжтой нь нотлогдсон өөр хувилбар өнөөг хүртэл гарч ирээгүй байна.

Маркс нь зөвлөгч гэхээсээ илүү шинжээч байлаа. Түүний сургаалуудаас бид практик шийдвэр гаргахад хэрэгтэй хувилбаруудыг хайгаад олохгүй бөгөөд түүний дэвшүүлсэн таамаглалууд түүхээр батлагдаагүй юм. Гэхдээ түүний хийсэн дүн шинжилгээнүүд бидний анхаарлыг татсаар байна. Хазааргүй капитализмын аюул, эрсдэлүүдийг тэр маш хурцаар шүүмжилсэн юм. Түүнээс илүү дээрх аюул, эрсдэлүүдийг олж харсан хүн түүний дараа үеийнхэнд ч гараагүй юм.

Марксыг аль урсгалд  
хамруулах нь зохилтой  
бэ?  
Билли Брандт түүнийг  
“Эрх чөлөөг эрхэмлэгч”  
хэмээн тодорхойлсон.

**Бусад эх сурвалжууд:**  
Францис Вийн (2008  
он)  
Карл Марксын тухай  
Капитал  
/Мюнхен/

Марксыг эрдэмтдийн аль урсгалд хамруулбал зохилтой бэ? 1977 онд Билли Брандт Триер дэх Карл Марксын гэр музейд зочлохдоо “Маркст хамгийн шударгаар хандъя гэвэл эерэг сөрөг аль ч өнцгөөс харсан түүнийг халдашгүй байдлын тавцангаас буулгаж ирэх хэрэгтэй. Марксын сургаалийг хэн хэрхэн гажуудуулсан, ирээдүйд магадгүй гажуудуулахыг хүсэж байгааг үл харгалзан “Эрх чөлөөг эрхэмлэж, хүмүүсийг боолчлол, хараат байдлаас чөлөөлөх нь түүний сэтгэлгээ, үйл ажиллагааны эрхэм зорилго байлаа.” хэмээн хэлсэн байдаг.

### 2.3. Жон Майенерд Кенс-капитализмын удирдлага

Кенс: Дундаж замыг  
сонгох уу?

**Жон Майенерд Кенс** нь (1883-1946) английн эдийн засагч байлаа. Түүний бүтээлүүд нь 20-р зууны эдийн засгийн онолын гол ноён нуруу нь болсон юм. Тэрбээр “Хөдөлмөр эрхлэлт, хүү, мөнгөний ерөнхий онол” алдарт бүтээлдээ зах зээлүүдийн өөрийгөө анагаах чадварт итгэж болох эсэх тухай асуудлыг дэвшүүлж капитализмыг жолоодох оролдлого болох Кенсианизмын суурийг тавьсан юм. Кенс бүтээлээ туурвихын зэрэгцээгээр дайны дараах үеийн эдийн засаг ба санхүүгийн зах зээлийг тодорхойлж байсан Бреттон-Вүүдс системийн хөтөлбөр дээр ажилласан юм.

Адам Смитийн  
төрийн нөлөөг  
аль болох  
бага хэмжээнд  
байлгах чөлөөт  
капитализмын  
тухай сургаал,



Карл Марксын өрсөлдөөн болон үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчөөс татгалзах тухай сургаал нь хоёулаа асуудалтай юм. Тэгэхлээр зах зээлийн үйлдвэрлэгч хүчийг ашиглан харин түүний сүйтгэгч хүчнүүдийг тэнцвэржүүлэн бууруулах чадамжтай зохицуулалттай зах зээлийн дундаж зам байж болох уу?

Британийн эдийн засагч Жон Майенерд Кенс капитализмын хоёр нүүрт байдал буюу нэг талаас нь харахад үр өгөөжтэй, бүтээлч атлаа нөгөө талаас нь харахад бүтцийн хувьд тогтворгүй байдалд дүн шинжилгээ хийсэн байна. Тэрбээр өмч болон өрсөлдөөн дээр суурилсан эдийн засгийн дэглэм байх ёстой гэдэг итгэл үнэмшилтэй байсан ч Смитийн сургаал дээр суурилсан шинэ сонгодог сэтгэлгээний сургуульд шүүмжлэлтэй хандаж байлаа. "...тэдний чангахан дуугарч чадахгүй шивнэх шахам тавиад байгаа шаардлагуудын ихэнх нь биелэгдээгүй, хэзээ ч биелэгдэх боломжгүй байхад тэд бодит ертөнцийн эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй гэдэг нь тодорхой" гэх мэтээр шүүмжилж байжээ. (Кенс 1966 он, 319-р хуудас)

Кенс 1929 оны дэлхийн эдийн засгийн гүнзгий хямралтай холбогдуулан "үл үзэгдэгч гар" байдаг эсэхэд эргэлзэж байгаагаа илэрхийлсэн юм. Смитийн хэлснээр зах зээл өөрөө тэнцвэрт байдалдаа эргэн орохын оронд ажилгүйдэл өндөр түвшинд удаан хугацаагаар үргэлжилж эдийн засгийн зогсонги байдал ч мөн удаан хугацаагаар үргэлжилсэн юм.

Кенс эдийн засгийн бууралт ороомог хэлбэрээр явагдаж буйг тогтоожээ. Бараа таваарын үйлдвэрлэл буурахын хэрээр хүмүүсийг ажлаас халах нь нэмэгддэг. Энэ нь хэрэглэгчид ба үйлдвэрлэгчдэд эргэлзээ төрүүлснээр зарцуулах мөнгөнийхөө хэмжээг багасгадаг. (Үүнийг айдсаас үүдэлтэй хэмнэлт гэж нэрлэсэн.) Эрэлт улам буурсны улмаас компаниуд үйлдвэрлэлээ бууруулж ажлын байрны цомхотгол эрчимжиж айдсаас үүдэлтэй хэмнэлт улам бүр нэмэгдэнэ. Хямрал улам бүр гүнзгийрч эдийн засаг удаан хугацаагаар сэтгэл гутралын байдалд автагдана. Түүний энэхүү тайлбар дэлхийн эдийн засгийн хямралын дараах байдалтай тохирч байсан тул үржил шимт хөрсөн дээр унасан юм. Кенс зах зээл ямар нөхцөлд үүргээ гүйцэтгэх чадамжгүй болдог бэ? гэдгийг тогтоогоод зогсохгүй харин ороомог хэлбэрт бууралтын эсрэг үйлчлэх эдийн засгийг удирдах хөтөлбөрийг боловсруулсан юм.

*Кенс шинэ сонгодог сэтгэлгээний сургуулийг шүүмжилсэн нь:*

*Үл үзэгдэгч гар байдаг эсэхэд эргэлзсэн нь*

*Эдийн засгийн ороомог хэлбэрт бууралтын аюул*

Төрийн идэвхтэй  
оролцоог шаардсан.

Төр нь эдийн засгийн бууралтын үе шатанд зах зээлд хөндлөнгөөс оролцож өр тавих, зарлагаа нэмэгдүүлэх замаар хувийн эрэлтийг орлох ёстой гэж үзэж байсан юм. Төр иргэдэд жишээлбэл татвар бууруулах замаар шууд мөнгө өгч болно. Гэхдээ хүмүүс итгэлгүй байдлаасаа болж мөнгөө цаашид хэмнэсэн хэвээрээ байх юм бол энэ арга хэмжээ үр дүнгүй болно.

Эдийн засгийн  
сэргэлтийг төрөөс  
удирдах нь

Төр мөнгөө зам, сургууль барих зэрэг хэлбэрээр шууд зарцуулбал илүү үр дүнтэй болно. Ийнхүү нэмэлт зардал өссөнөөр олон хүн ажилтай болж хэрэглээ нэмэгдэж эрэлт өснө. Эцэстээ ороомог хэлбэрт эерэг хөдөлгөөн буюу өсөлт идэвхжинэ. Кенс үүнийг дараах байдлаар илэрхийлсэн юм:

Хэрэв бид зуун тавин сая паундаас илүү мөнгө зарцуулах юм бол үүний үр дүнд бүх хүмүүсийн орлого нэмэгдэнэ. Удаан хугацаагаар ажилгүй байсан хүмүүст ажилгүйдлийн мөнгө олгох шаардлагагүй болно. Үүгээр ч зогсохгүй дээрх зардал бусад олон хүнд ажлын байрыг бий болгоно. Мөнгө эдийн засгийн эргэлтэнд орж зөвхөн цөөн хэдэн аж үйлдвэрийн салбарын бус нийт бараа үйлчилгээний борлуулалт нэмэгдэнэ.

(Кенс 1939 он. 2008 онд Байнертийн ишлэл татсанаас)

Алсдаа бид бүгдээрээ  
үхэх болно.


Тэрбээр ингэж хэлснээрээ зах зээл ямагт тэнцвэрт байдлаа олох болно гэдэг Смитийн сэтгэлгээнээс салах цаг болсныг сануулсан юм. Түүний “Алсдаа бид бүгдээрээ үхэх болно.” гэдэг үгийг олонтаа ишлэл татдаг. Энэ үгээрээ тэр өөрийн гольдролоор бүхнийг зохицуулах зах зээл илүү сайхан ирээдүйг бий болгоно гэж бүрхэг зүйлд найдаж сууснаас ажлын байр, эдийн засгийн өсөлтийг бий болгох улс төрийн хариуцлагад найдах нь илүү дээр хэмээн уриалсан юм.

Гэхдээ Кенс цагийг нь олж оролцох, оролцооны хэмжээг тохируулах нь бэрхшээлтэй асуудал учраас төр хөндлөнгөөс зах зээлд оролцох нь эрсдэл дагуулдаг гэдгийг нуугаагүй юм. Тэр ингэж бичсэн юм:

Төр зах зээлд хөндлөнгөөс оролцох ёстой гэдэг Кенсийн дүн

Олж болох орлогыг урьдчилан таамаглаж буй бидний мэдлэгийн суурь маш их эргэлзээтэй байгаа нь асуудлыг улам бүр бэрхшээлтэй болгож байгаа юм. Хөрөнгө оруулалт хэдэн жилийн дараа ямар ашиг авчрах бэ? гэдгийг тодорхойлдог хүчин зүйлүүдийн талаарх бидний мэдлэг туйлын хомс бөгөөд огт ач холбогдолгүй байх нь ч олонтаа.

(Кенс 1966 он, 126)



шинжилгээ ба зөвлөмжүүд нь түүний амьдарч байсан эрин үед тун содон зүйл байсан учраас хүмүүс "Кенсийн хувьсгал" хэмээн нэрлэх болж энэ дүгнэлтээрээ тэр Смит болон Марксын эсрэг зогссон юм. Смит болон Марксыг баримтлагсдын эсэргүүцэлтэй тулгарсан нь мэдээж: Либералууд болон консервативууд түүнийг мангуурч гүйцсэн социалист гэж нэрлэж байлаа. Марксистууд түүнийг зах зээлд бүхнийг даатгагч гэж шүүмжилж байлаа. Кенс өөрийн амьдарч байсан цаг үед Германд төдийгүй бусад оронд бүрэлдэж байсан диктатурын эсрэг зогссоноор барахгүй өөрийн зөвлөмжүүдээр ардчиллыг хамгаалахыг хүсч байсан нь тодорхой болсон юм.

Яагаад Кенсийн хувьсгал гэж нэрлэхэд хүрэв ээ ?

Өнөөгийн эзэрхэг төрийн системүүд нь ажилгүйдлийн асуудлыг бүтээмжийн чадамжийг бууруулах, эрх чөлөөг хязгаарлах замаар шийдвэрлэж байгаа мэтээр харагдаж байна. Богинохон хугацаанд үргэлжилдэг эдийн засгийн сэргэлтийн үеүдийг эс тооцвол ажилгүйдэл нь миний бодлоор зайлшгүй гарах үр дагавар гэдэг нь тодорхой бөгөөд өнөөгийн капиталист аминч үзэлтнүүдтэй холбоотой юм. Харин ажилгүйчүүд удаан хугацаагаар хүлцэнгүй хэвээр байхгүй гэдэг нь тодорхой. Гэхдээ асуудалд зөв дүн шинжилгээ хийснээр энэ өвчнийг анагаахын зэрэгцээгээр бүтээмжийн чадамж, эрх чөлөөг баталгаатай хангах боломж олдох болно. (Кенс 1966 он, 321)

Сэтгэл зүйн хууль

Кенс “сэтгэл зүйн хуулиараа” дахин хувиарлалт ямар учраас нийгэмд ашигтай төдийгүй эдийн засгийн хувьд ч бүтээлч байдаг бэ? гэдэг үндэслэлийг гаргаж ирсэн. Эдийн засгийг эрчимтэй байлгахын тулд эрэлт өндөр байх шаардлагатай. Орлого нэмэгдэхийн хэрээр хадгаламжийн хувь нэмэгдэж хэрэглээ буурах хандлага ажиглагддаг тул цалин багатай ажилтнуудын хувьд хадгаламжийн эзлэх хувь бага байдаг тул тэдний орлогыг нэмэгдүүлэх нь зүйтэй. Кенс эцэстээ Бреттон-Вүүдсийн систем хэмээн нэрлэгддэг бүтцийг бий болгоход шийдвэрлэх үүргийг гүйцэтгэсэн юм.

Кенс 20-р зууныг тодорхойлсон юм.

Кенстэй эн зэрэгцэж 20-р зууныг тодорхойлох эдийн засагч төрөөгүй юм. Кенсийн зөвлөмжүүдийг АНУ -д ардчилсан ерөнхийлөгч Франклин Рузвельтийн санаачилсан “Шинэ зорилт-New Deal” хөтөлбөрийн хүрээнд зорилттойгоор хэрэгжүүлсэн юм. **Нэгдүгээрт** олон нийтийн буюу төсвийн хөрөнгө оруулалтыг (жишээлбэл: дэд бүтцийн салбарт) ихээхэн нэмэгдүүлсэн юм. **Хоёрдугаарт** бага орлоготой, эсхүл орлогогүй хүмүүс хадгаламж эзэмшигчдийн дунд өчүүхэн бага хувийг эзэлдэг тул нийгмийн зардлыг нэмэгдүүлснээр (тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлснээр) хэрэглээ өссөн. 1970-аад оныг хүртэл Кенсийн сургаал сургалтын салбарт давамгайлж байлаа. Германд Кенсийн онолыг баримтлагсдыг нэн ялангуяа 1966-1972 онд Холбооны санхүү, эдийн засгийн сайдын албыг хашиж байсан эдийн засагч Карл Шиллер төлөөлж байлаа. Тухайн цаг үед АНУ-ын

#### Бреттон-Вүүдсийн систем:

1944 онд америкийн Бреттон-Вүүдс гэдэг амралтын газарт дайны дараах үеийн олон улсын санхүүгийн байгууламж ямар бүтэцтэй байх бэ? гэдгийг тогтсон юм. Уг байгууламжийн цөм нь хөрвөх ханшийн савлагааг америк долларын ханштай уялдуулан бууруулах олон улсын валютын систем байлаа. Олон улсын зээллэг, санхүүгийн зах зээлийг зохицуулах зорилгоор олон улсын валютын сан, дэлхийн банкыг байгуулсан юм. Бреттон-Вүүдсийн систем нь 1973 оныг хүртэл оршин тогтнож байлаа. Валютын зах зээл дээр үүссэн хүчит давалгаануудын дараагаар хөрвөх ханшийг доллартай холбох холбоосыг задлахаас өөр аргагүй байдалд хүрсэн юм. Ингэснээр санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал буурсан юм.

консерватив ерөнхийлөгч асан Ричард Никсон хүртэл “Бид одоо бүгдээрээ Кенсийн онолыг баримтлагсад болсон” гэж хэлж байлаа.

1970-аад оны дунд үеэс төгс онол мэт харагдаж байсан Кенсианизм ч хямралд орсон юм. Нэг талаас эдийн засгийн бууралтын ороомог хэлбэрт давтамжийн эсрэг явуулж байсан улсын төсвийн бодлого Кенсийн санаснаар хэрэгжихээ байлаа. Түүний хөтөлбөрийн дагуу хямралын үед төсвийн зарлагыг нэмэгдүүлж байсан ч эдийн засгийн хувьд өсөлттэй, амжилттай жилүүдэд төсвийн өрийг буцааж төлсөнгүй. Ингэснээр жил ирэх тутам олон нийтийн буюу төсвийн алдагдал нэмэгдэж хямралаас хямралын хооронд алдагдлыг нөхөх орон зай хумигдсаар байлаа. Үүн дээр нэмээд газрын тосны хоёр удаагийн хямрал дайран дээр давс нэмэв гэгч болов. Газрын тосны үнэ тэнгэрт тултал нэмэгдсэн нь дараах хэлбэрийн чөтгөрийн тойргийг бий болгов: Цалин хөлс нэмэгдэнэ. Гэтэл цалингийн нэмэгдлийг эрчим хүчний үнийн нэмэгдэл хуу хамж орхино. Тэгэхлээр нь цалинг дахин нэмэгдүүлнэ. Цалинг ийнхүү нэмэх нь ханшийн бууралтыг нэмэгдүүлнэ. Ханшийн уналт нь цалинг дахин нэмэхээс өөр аргагүй байдалд хүргэнэ. Төрийн зүгээс эдийн засгийг сэргээх чиглэлээр явуулж буй арга хэмжээнүүд үр дүнд хүрэхээ байна. Эдийн засаг зогсонги байдалд орохын зэрэгцээ ханшийн уналт өндөр хэвээрээ байна. Үүнийг (**Stagflation = stagnation + inflation**) буюу эдийн засгийн зогсонги байдал ба ханшийн уналтын давхцал гэж нэрлэдэг. Шинэ либералчууд, шинэ сонгодогууд хамтран төлөвлөгөө боловсруулж компаниудад ээлтэй нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого боловсруулав.

(**Stagflation = stagnation + inflation**) буюу эдийн засгийн зогсонги байдал ба ханшийн уналт нь цаг хугацааын хувьд давхцахыг стагфлацион гэж нэрлэдэг.

(Эдийн засгийн нэвтэрхий толь. 2009 он)

Үнэ бууруулах замаар байршлын давуу талуудыг бий болгох, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх, төсвийг эрүүлжүүлэх нь цаг үеийн шаардлага байлаа.

Ийнхүү эдийн засгийн либерал бодлогыг олон жилийн туршид хэрэгжүүлсний дараагаар, 2007 оны санхүүгийн зах зээлийн хямрал эхэлмэгц олон жил зохицуулалтгүй явж ирсэн зах зээлд төрийн зүгээс зохицуулалт хийж хөндлөнгөөс оролцох нь зүйтэй гэсэн дуу хоолой хүчтэй болж ирлээ. Энэ нь Кенсийн сургаалийг дахин санагалзсаны дохио байлаа. Үүнийг гайхаад байх хэрэггүй юм.

Кенсианизмын  
асуудлууд

**Бусад эх сурвалжууд:**  
Райнхард Бломерт 2007  
он, Жон Майенерд  
Кенс, Райнбек Хайнц-  
Ж-Бонтруф (2006 он)  
Кенс капитализмыг  
аврахыг л хүссэн юм.  
Ноён Жон Майенерт  
Кенсийн насан  
эцэслэсний 60 жилийн  
ойд зориулан хэлсэн үг  
/Бонн хот/

Кенсийн олон улсын санхүүгийн зах зээлийн талаар бичиж байсан зүйлс урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр чухал болж ирлээ.

Мөнгө хүүлэгчид компаниудын ашиг сонирхлын тогтвортой урсгал дээр тогтон буй савангийн хөөс мэт ямар ч хохиролгүй гарахыг хүсэж байгаа нь мэдээж. Харин байдал эсрэгээрээ эргэж компаниудын ашиг сонирхол нь өөрөө мөнгө хүүлэгчдийн хүчит давалгаан дээрх савангийн хөөс болон хувирбал ноцтой байдал үүснэ. Хэрэв аль нэгэн улс орны хөрөнгийн хөгжил нь тоглоомын заалны үйл ажиллагааны дайвар бүтээгдэхүүн болж хувирбал хөдөлмөрт хандах хандлага муудах нь гарцаагүй.

(Кенс 1966 он 134-р тал)

## 2.4. Эдийн засгийн онолын идеал хэлбэрүүд

Өдөр тутмын бодлогын мэтгэлцээнд Смит, Маркс, Кенс нарын санаа байнга л давтагдаж байдаг. Хэрэв хэн нэгэн либерал бодлогыг баримтлагч улс төрч “Төрд зөвхөн түүнд ноогдох үүргийг нь л ногдуулъя, төр бол асуудлыг шийдэх шийдлийн нэгэн хэсэг биш, харин өөрөө асуудал үүсгэгч болж байна” гэдэг шаардлагыг тавибал тэр Адам Смитийн санааг давтаж буй нь тэр. Зах зээл байсхийгээд эргээ халин чиглэлээ өөрчлөн урсах гол мэт тогтворгүй авир гаргах болсон даяаршсан капитализмын хүчит гольдрол юунд ч дийлдэшгүй хүчээ авсан энэ цаг үед Кенсийн зах зээлийн эдийн засгийг удирдах шийдлийн хувилбарууд дахин сэргэх нь ойлгомжтой. Хөгжиж буй орнуудын хувцас үйлдвэрлэлийн фабрикуудад хоногт 14 цаг ажиллаж дарлагдан мөлжигдөж амьжиргаагаа залгуулж буй ажилчдыг харахад Марксын дүн шинжилгээ хол зөрөөгүй гэдэг нь харагдана. Смит, Маркс, Кенсийн онолууд нь гурван өөр хэлбэрийн эдийн засгийн ертөнцийг үзэх үзлийн идеал хэлбэр<sup>5</sup> гэдэг утгаар нь авч үзвэл хувиарлалт, зах зээл ба төрийн харьцааны асуудал болон бусад эдийн засгийн бодлогын асуудлуудын талаар мэтгэлцээн өрнөх бүрт улс төрийн өөр өөр үзлийг баримтлагсад дахин дахин сөхөж байдагт гайхахын хэрэггүй юм. Эдгээр гурван идеал хэлбэрийг дараах байдлаар тодорхойлж болох юм:

1. Төр эдийн засгийн процессуудаас ангид байх ёстой. Өмчтөй байх эрмэлзэл нь эдийн засгийн үйл ажиллагааны хөдөлгөгч хүч мөн тул аливаа хэлбэрийн оролцооноос ангид хөндлөнгийн байх ёстой. (Смитээс эхтэй либертар үзэл)

<sup>5</sup> “Идеал хэв шинж” гэдэг нь социологич Макс Вебер нийгмийн бодит байдлыг тодорхой хэсгүүдэд хуваан бодол санаандаа цэгцлэн судлахын тулд бодит байдлыг зориудаар, судалгааны зорилгоор бодит байдлыг хялбарчлан дүрслэн буулгасныг хэлж байгаа юм. Нөгөөтэйгүүр “идеал хэв шинжтэй” гэдэг нь энэхүү сурах бичигт зөвхөн хялбарчилсан байдлаар авч үзсэн гэдэг санааг илэрхийлж байгаа юм.

2. Үйлдвэрлэлийн хэрэгсэлийн хувийн өмч ба өрсөлдөөн дээр суурилсан капиталист эдийн засгийн систем нь олон түмний (массыг) зовлон зүдгүүр, дарлал мөлжлөгөд хүргэдэг. Иймээс уг дэглэмийг халах хэрэгтэй. (Марксаас эхтэй коммунист үзэл)

2.Капитализмын эсрэг-антикапитализм

3. Өмч ба зах зээлийн эдийн засаг дээр суурилсан эдийн засгийн дэглэм байх бөгөөд төр харин зохицуулалт, дахин хувиарлалт, макро эдийн засгийн зохицуулалт хийх замаар өөрөөр хэлбэл эрэлтийн зорилтот зохицуулалтыг хийх замаар улс ардын аж ахуйд хөндлөнгөөс оролцоно. Өмчийн баталгааг хангана. Өмчид нийгмийн хариуцлага ноогдуулж өмч нь олон нийтийн өмнө үүрэг хүлээнэ. (Нийгмийн ардчиллын үзэл, Кенсээс эхтэй.)

3.Жолоодлоготой капитализм

Эдийн засгийн онолын талаарх мэтгэлцээнээс дараах зүйл тодорхой болж байна: Зах зээлийг хазааргүй хүлэг мэт дураар нь тавибал зах зээлээс бүрэн татгалзах оролдлоготой нэгэн адил бүтэлгүйтнэ. Түүх бидэнд зах зээлийн радикализм (чөлөөт зах зээл) ч, зах зээлээс бүрэн татгалзах оролдлого ч адилхан бүтэлгүйтдэг гэдгийг сургалаа. Нийгмийн ардчиллын зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд зах зээлийг удирдах ч, зохицуулах ч шаардлагатай. 1959 онд боловсруулагдсан ГСДН-ын Годесбергийн хөтөлбөрт нөлөө бүхий социалдемократ эдийн засагч Карл Шиллерийн томъёолсон “Зах зээлд аль болох их чөлөөт орон зай олгож, зөвхөн шаардагдах хэмжээнд төлөвлөлт хийх” эрмэлзлийг тусгасан юм.

“Зах зээлд аль болох их чөлөөт орон зай олгож зөвхөн шаардагдах хэмжээнд төлөвлөлт хий.”

Эдгээр эдийн засгийн онолуудыг тухайн түүхэн цаг үеийнх нь нөхцөл байдалтай холбон тайлбарлах нь зүйтэй. Түүх бидэнд зах зээлийн эдийн засаг Марксын таамаглалын дагуу дотоод зөрчлийнхөө улмаас төгсгөл болоогүй гэдгийг харууллаа. Мөн капитализм нь Адам Смитийн төсөөлж байснаар эв зүйт тэнцвэрт байдлаа өөрөө тогтоож чаддаггүй гэдгийг харууллаа. 20-р зуун хүн төрөлхтөнд хүн амын өргөн хүрээг хамарсан урьд өмнө нь төсөөлөгдөшгүй мэт санагдаж байсан хангалуун чинээлэг амьдрал мөн хүн амын нэлээд хэсэгт нийгмийн доройтол, тоолж баршгүй олон хямралуудыг авчирсан юм. Энэхүү хөгжилд нийгмийн ардчиллын зүгээс ямар үнэлэлт өгөх бэ? Маттиас Платцэк, Пеер Штайнбрук, Франкбалтер Штайнмайер нар 2007 онд хэвлэгдэн гарсан “Цаг үеийнхээ манлайд” гэдэг бүтээлээрээ дээрх асуултанд хариулт өгсөн юм.

Социалдемократ улс төрчид эдгээр асуултуудад ямар хариулт өгч байна бэ?

“Ортодокс Марксистуудын эдийн засгийн явцуу сэтгэлгээний эсрэг нэг талд нь либералууд, нөгөө талд нь бодлогын давуу эрх ба ангийн хязгаарыг давсан шинэчлэлийн зарчмууд, дэвшил, харилцан буулт, ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах бодлогыг баримталдаг онолч Эдуард Бернштайныг тойрсон “ревизионист” социалдемократууд сөрөн зогсож байлаа. Нөгөө тал эдийн засаг болон түүхэн хүчнүүдийг өөрийн гольдролоороо эргэнэ гэдэгт итгэн найдаж байсан бол социалдемократууд хувьсал өөрчлөлтийг идэвхтэй, прагматикаар хийхийн төлөө байлаа. Зах зээлийн эрчимийг социал шинэчлэл, нийгмийн өөрчлөлттэй бүтээлчээр холбосны үндсэн дээр эдийн засгийн өсөлт ба хангалуун амьдралыг хүн амын бүх бүлгүүдэд системтэйгээр хүртээхийг зорьж байлаа. Зах зээлийн эдийн засаг, ардчилал, нийгмийн тогтвортой байдлыг хооронд нь уялдуулаад зогсохгүй харин улс төрийн хэрэгслүүдийг ухаалгаар ашиглан тэр ч байтугай эерэг харилцан үйлчлэлийн харьцаанд оруулахын төлөө байлаа. Чухамхүү үүнд 20-р зууны эхэн үеийн нийгмийн ардчиллын дэвшлийн төслийн цоо шинэ өөр юутай ч зүйрлэшгүй ач холбогдол оршиж байлаа. Түүхэнд анх удаагаа өмнө нь хэзээ ч нэгтгэх боломжгүй гэж үзэж байсан, сөргөлдүүлэн тавьж ирсэн эрчимтэй зах зээлийн эдийн засаг, амьд ардчилал ба нийгмийн нэгдмэл байдлыг практик дээр хэрэгжүүлж урьд өмнө байгаагүй амжилттайгаар эвлэрүүлэн нэгтгэж чадсан юм. Нийгэм судлаач Ралф Даарендорф “20-р зууныг социалдемократ зуун” хэмээн тодорхойлсон нь үнэнд зүй ёсоор нийцсэн хэрэг байлаа. (...) Өнөөдөр бид тухайн цаг үед өрсөлдөгчдөөсөө даван гарч нийгмийн ардчиллыг ялалтанд хүргэх нь ямар их хичээл зүтгэлээр бүтсэнийг, ямар хүнд бэрх үеийг туулсныг, мөн энэхүү амжилтын үр жимс 21-р зуунд хэрхэн буурч ирснийг дахин шинээр, илүү тодоор сануулах хэрэгтэй. (...) Тийм ч учраас марксист ортодоксууд, Либерал Laisser-faire буюу төрийн зохицуулалтгүй чөлөөт зах зээлийн сэтгэлгээг давж чадсан амжилтын санаа 21-р зуунд ч ач холбогдолтой, бидний замыг заагч хэвээрээ байгаа гэдгийг зорилгоо ухамсарласан социалдемократууд бид үргэлж санаж байх ёстой. Учир нь даяаршлын эрин үед ч зах зээл, ардчилал, нийгмийн дотоод зөрчилт үндсэн харьцааны хувьд юу ч өөрчлөгдөөгүй хэвээрээ байгаа юм. (Платцек, Штайнбрук, Штайнмайер 2007 он 19-21р тал)

## 2.5. Өнөөгийн эдийн засаг

Түүхэнд нэрээ үлдээсэн эдийн засагчдыг танилцуулсны дараагаар эдийн засгийн шинжлэх ухааны өнөөгийн түвшин хаа байна бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Энэ асуултын хариулт амаргүй гэдгийг дараах түүх харуулах болно.

Эдийн засгийн шинжлэх ухааны өнөөгийн түвшин хаа байна бэ?

Энэ бол хариулахад хэцүү асуулт: Нэгэн жишээ

1973 онд Их Британи Европын Хамтын Нийгэмлэгт элсэн орсны дараагаар “Лондон Таймс” өдөр тутмын сонинд 154 эдийн засагчийн гарын үсэг бүхий “Их Британи Европын Хамтын Нийгэмлэгт элссэнээр эерэгээсээ илүү сөрөг талуудыг авчрах болно” гэсэн утгатай зар нийтлүүлжээ. Дараагийн өдөр нь 142 (өөр) эдийн засагчдын гарын үсэг бүхий “Их Британи Европын Хамтын нийгэмлэгт элссэнээр эдийн засгийн хувьд сөрөг талуудаасаа илүүтэйгээр давуу талуудыг авчрах болно” гэсэн мэдэгдэл нийтлэгдсэн байна. Түүний дараагаар Их Британийн эдийн засагчид улсынхаа эдийн засагт давуу талуудаасаа илүү сөрөг талуудыг авчрах магадлал өндөртэй гэсэн утгатай уншигчийн захидал нийтлэгдсэн байна. (Багнер Биегард 2002 он. 773-р тал)



Энэ онигоо эдийн засгийн шинжлэх ухаанд нэгдмэл буюу ноёлох санаа байдаггүй гэдгийг харуулж байна. Үүнд дараах хоёр шалтгаан бий:

*Аливаа юм сайн, муу хоёр талтай байдаг учраас нэгдмэл санаа байдаггүй.*

Эдийн засаг нь бусад бүх шинжлэх ухааны нэгэн адил философич Карл Попперын хэлснээр хадан цохион дээр биш харин намган дээр суурилдаг. Эдийн засагчдын дүгнэлт нотолгоонуудаа үндэслэдэг тоо баримтууд, нотолгоо, ажиглалтуудын дунд тодорхой бус заримдаа худал зүйлс ч байх нь бий.

*Эхнийх нь: Ямар ч шинжлэх ухаан “хадан цохион дээр” суурилдаггүй.*

Эдийн засгийн шинжлэх ухааны байгалийн шинжлэх ухаануудаас ялгаатай тал нь гэвэл таамаглал, онол нь хүмүүс ба нийгмийн зургуудаар тодорхойлогддог. Хүн бол өөртөө хамгийн ашигтай байдлыг эрхэмлэгч homo oeconomicus гэж үздэг эдийн засагч нь хүмүүсийг нийгмийн цогц бодьгал гэж үздэг эдийн засагчдаас өөр дүгнэлтэнд хүрэх нь ойлгомжтой.

*Хоёрдугаарт: Эдийн засгийн шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлтүүд нь үнэлэмжтэй холбоотой байдаг.*

Хүмүүсийн бодлоор хатуу баримт нотолгоон дээр суурилдаг эдийн засгийн шинжлэх ухаан нь санаснаас илүү үзэл санаа сурталчилдаг тул эдийн засагчдын зөвлөгөөнд байнга шүүмжлэлтэй хандаж байх ёстой гэдэг сануулгыг эдийн засгийн сэтгүүлч Андреас Хофман нийтлүүлсэн байна:

“Онгоцонд суух бүртээ би төрийн хөнгөлөлтүүдийн \татаас\ талаар боддог. Эдийн засагчид төрийн зүгээс хөнгөлөлт үзүүлэхийг үзэж чаддаггүй юм. Тэдний бодлоор төрийн хөнгөлөлт муу санаатнуудын ертөнцөөс үүсэлтэй бөгөөд эдийн засгийг ямагт доголдуулж байдаг. Төрийн хөнгөлөлт байгаагүйсэн бол Аэробус онгоцнууд нисэхгүй байсан шүү дээ. Зарим нэгэн улсын удирдагчид нисэх онгоцны үйлдвэр байгуулах санал дэвшүлсэн учраас л бид Аэробус онгоцоор нисэж байгаа юм. Тэгээгүй бол компьютерийн ертөнцөд Билл Гетс ноёлж байгаа шиг тэнгэрт Боинг ноёлох байлаа. (...) Эсхүл үйлдвэрчний эвлэлийнхэн ноёлж байх байлаа. Үйлдвэрчний эвлэлийнхэн л компаниудын амжилтыг доош нь чангааж байдаг гэж ярьцгаадаг. Гэтэл чухам ямар шалтгааны улмаас германы авто машин үйлдвэрлэгчид, үйлдвэрлэлийн машин үйлдвэрлэгчид, металл-болон цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэгчид дэлхий дахинд тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа юм бэ? Эдгээр компаниудын үйлдвэрчний эвлэл хамгийн хүчирхэг тул бүгдээрээ бүтэлгүйтэх ёстой юм биш үү? (...) Гэтэл зөв эдийн засгийн шинжээчдийн практикт зориулсан зааварчилгаа туйлын хангалтгүй хэрэгждэг. Хэн нэгэн эдийн засагч ёоз муутайхан хараад наадах чинь бодит амьдралд зориулаагүй, харин дэг журам сахиулах бодлогын хувилбар шүү дээ гэсэн үг хавчуулахыг сонсдог. Ямар учраас газрын зурган дээр зурсан чиглэлүүдийн нэг нь ч зөв байдаггүй бүгдээрээ буруу байдаг юм бэ? Эдийн засагчдын үгийг бүгд сонсдог байсан бол дэлхийн нэгдүгээр дайн гарах ёсгүй байсан юм. Дэлхийн нэгдүгээр дайныг бүх эдийн засагчид ашиггүй гэж үзэж байлаа. 1929 оны аравдугаар сарын хар пүрэв гаригаас наймхан өдрийн өмнө тэргүүлэх эдийн засагч Ирбинг Фишер хөрөнгийн биржүүдийн мөргөлдөөн хэзээ ч гарахгүй гэж хэлж байлаа. Эдийн засгийн таван удаагийн уналтын нэгийг нь ч, ерээд оны үед интернетийн тэсрэлт болно гэдгийг нэг ч судлаач урьдчилан таамаглаж байгаагүй юм. 2002 оны намар институтууд 2003 онд эдийн засгийн өсөлт 1.4 хувьд хүрнэ гэж таамаглаж байтал эдийн засагчид бодит байдал дээр 0.2 хувиар буурсан юм. Өдгөө ямар учраас ажлын байрууд шинээр бий

болж эдийн засаг дахин өсөх болов? гэдэг оньсогыг бүгдээрээ таахад хүргээд байна. Газрын тосны үнэ хэт өндөр байхад, Ангела Меркел шинэчлэлүүдийг амжилтанд хүргэж чадахгүй байхад.” (Өмнөд Германы сонин дээр 2006 оны 09-р сарын 16-нд нийтлэгдсэн.)

Эдийн засаг нарийн  
чанд байгалийн  
шинжлэх ухаантай  
адилгүй.

Дүгнэлт:  
Өөрийнхөө гарааны  
цэгийг нээлттэй байлгах

Хоёр лагерь:  
Нийлүүлэлтийн ба  
эрэлтийн бодлого

Нийлүүлэлтийг дэмжих  
бодлого: Адам Смит,  
Давид Рикардо, Жон  
Стюарт Милл

Эдийн засаг бол хөдөлшгүй таамаглал дэвшүүлж чаддаг нарийн чанд байгалийн шинжлэх ухаантай адилгүй, харин таамаглал дээр суурилсан их бага хэмжээгээр ойлгомжтой, улс орнуудын туршлагаар батлагдсан нотолгоонуудыг гаргадаг гэдгийг бид мэддэг болсон.

Энэхүү мэдлэгээс ямар дүгнэлтэд хүрэх ёстой бэ? Ямартай ч та бүхэн эдийн засгийн шинжлэх ухаан нь ямар ч шинжлэх ухаанч шинжгүй тул эдийн засгийн таамаглалыг хүссэн зоргоороо тайлбарлаж болно гэдэг дүгнэлтэнд хүрээгүй гэдэгт итгэлтэй байна. Хамгийн чухал нь эдийн засагч эрдэмтэд тухайн үеийнхээ гарааны нөхцөл болон түүн дээр тулгуурласан өөрийн байр сууриа олон нийтэд нээлттэй байлгах ёстой. Тэдний судалгаа шинжилгээ, таамаглалыг уншиж буй бүх хүмүүс тэдгээрийн цаад учир шалтгааныг мэдэж, эрэмбэлэх, тайлбарлах тэдний байр суурин дээрээс асуудалд хандах боломжоор хангагдсан байх ёстой.

Эдийн засгийн шинжлэх ухааны лагерийг ерөнхийд нь нийлүүлэлт ба эрэлтийг дэмжих бодлого гэж хувааж болох бөгөөд тэдгээрийн хооронд чөлөөтэй урсах шилжилтүүд болон давхцалууд байдаг.

### Нийлүүлэлтийг дэмжих бодлого

Нийлүүлэлтийг дэмжих эдийн засгийн бодлого нь Адам Смитийн шинэ сонгодог бодлогын уламжлал бөгөөд энэхүү бодлогыг залгамжлагчид нь Дэвид Рикардо, Жон Стюарт Милл болон бусад эдийн засагчид юм. Төрийг шүүмжилсэн, зах зээлийн либерал онолоос “Компаниудад өндөр ашигтай ажиллах хамгийн таатай нөхцөлүүдийг бүрдүүлж өгөх ёстой” гэдэг шаардлага урган гарч буй юм. Ийм учраас “нийлүүлэлтийн бодлого” гэж нэрлэсэн юм. “Бараа болон үйлчилгээг хамгийн таатай нөхцөлөөр санал болгох ёстой. Онолын дагуу нийлүүлэлт хамгийн таатай нөхцөлтэй байхад автоматаар эрэлтийг бий болдог. Төр аль болох бага хэмжээнд зах зээлд хөндлөнгөөс оролцох ёстой. Төрийн хөнгөлөлт (татаас), олон нийтийн эзэмшлийн өмч хөрөнгө ба төрийн зохицуулалтыг аль

болох бага хэмжээнд барьж татвар, цалингийн нэмэлт зардлыг аль болох бага түвшинд байлгах хэрэгтэй. Төв банк мөнгөний тогтвортой байдлыг хангах үүргийг хүлээх боловч харин эдийн засгийн сэргэлт ба бууралтын давтамжид хөндлөнгөөс оролцохгүй.

### **Эрэлтийг дэмжих бодлого**

Эрэлтэд чиглэсэн буюу эрэлтийг дэмжих эдийн засгийн бодлогын суурийг Жон Майенерт Кенс тавьсан бөгөөд түүнийхээр төр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн сэргэлтийг удирдах идэвхтэй үүргийг хүлээх ёстой. Эрэлтийг дэмжих бодлогын гол санаа нь улс ардын аж ахуйд байнгын эрэлтийг баталгаажуулах явдал. Үүний тулд цалинг хамгийн багаар бодоход үйлдвэрлэлийн бүтээмжээс хоцрохгүй байх хэмжээнд нэмэгдүүлж байх шаардлагатай. Хенри Форд үйлдвэртээ бөөнөөр нь үйлдвэрлэх шугамыг нэвтрүүлж үйлдвэрлэлийн бүтээмжийг эрс дээшлүүлснийхээ дараагаар эрэлт нэмэгдэхгүй байх бий гэдэгт санаа зовниж цалинг нэмэгдүүлэхийг дэмждэг байжээ. Түүний хэлсэн "Машиныг машинууд худалдан авдаггүй" гэдэг үгийг хожмоо олонтаа ишлэл татсан байдаг.

Хувийн хэрэглээ, хувийн хөрөнгө оруулалт буурах нөхцөлд төр хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийг идэвхтэй дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар зах зээлд хөндлөнгөөс оролцох ёстой. Ийнхүү эрэлтийг нэмэгдүүлснээр компаниудын хөрөнгө оруулалт дахин нэмэгдэж хөдөлмөр эрхлэлт болон хувийн эрэлт дагаад нэмэгдэнэ. Төв банк хямралын үед мөнгөний хүүг бууруулах, мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн сэргэлтийг идэвхжүүлнэ.

### **Ялгагдах шинж тэмдэгүүд**

Нийлүүлэлтийг дэмжих, эрэлтийг дэмжих эдийн засгийн бодлогын үндсэн ялгаа нь цалингийн ач холбогдлыг өөр өөрөөр үнэлдэгт оршдог. Эхнийх нь (нийлүүлэлтийг дэмжих бодлого) цалинг өртөг нэмэгдүүлдэг, дарамт болдог хүчин зүйл тул ялангуяа хямралын үед бууруулах ёстой гэж үздэг. Хоёрдох нь (эрэлтийг дэмжих бодлого) цалин бол улс ардын аж ахуйн эрэлтийг нэмэгдүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйл тул эдийн засгийн бууралтын үед ороомог хэлбэрт бууралтыг идэвхжүүлэхгүй байхын тулд нэмэгдүүлэх ёстой гэж тайлбарладаг. 1920 оны дэлхийн эдийн засгийн хямралын үед эдийн засгийн бууралтын мөчлөг, эдийн засгийн ороомог хэлбэрийн

*Жон Майенерт  
Кенсийн эрэлтийн  
бодлого*

*Цалингийн талаарх  
хоёр өөр ойлголт*

бууралт хоёр давхцан тохиосон юм. Германы эдийн засаг 2001 оноос 2005 оны хооронд зогсонги байдалд байсныг зарим эдийн засагчид эрэлт доголдолтой байснаас үүдэлтэй гэж тайлбарладаг. Олон жилийн туршид цалинг тогтмол хэмжээнд барьсан нь олон нийтийн хөрөнгө оруулалтын бууралттай давхцсан учраас дотоодын зах зээл дээр эрэлт буурч улмаар германы эдийн засагт хүндрэл авчирсан юм. Энэ хямралаас гарахын тулд цалинг нэмэгдүүлж, эдийн засгийг сэргээх олон нийтийн төсвийн хөрөнгө оруулалттай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг шаардаж байлаа. (2005 он Хорн.) Эрэлтийг дэмжих бодлогод хоёр бэрхшээл үүссэн юм. **Нэгдүгээрт** эдийн засгийн байдал сайн байгаа жилүүдэд ч гэсэн улсын төсвийн өрийг бодитойгоор буцаан төлөх нь практик дээр амаргүй гэдэг нь батлагдсан юм. Ийм ч учраас улсын төсвийн өрийн дарамт нэмэгдсээр байлаа. Төсвийн алдагдал нэмэгдэхийн хэрээр эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүд болон улс төрийн бодлого зохицуулалтын орон зай улам бүр хумигдсаар байв. **Хоёрдугаарт** урамшуулалтай эрэлт ба төв банкны бодлогыг хооронд нь уялдуулах явцад зах зээл дээр мөнгөний илүүдэл үүсэх, зарим талаар цалингийн бодит бус өсөлтөд хүргэж ханшийн уналтыг нэмэгдүүлэх зэрэг үзэгдлийг дагуулж байлаа. Үүний зэрэгцээгээр цалингийн нэмэгдлийг ханшийн уналт залгих зэрэг үзэгдэл ч гарч байлаа. Мөн үүний зэрэгцээгээр ханшийн уналт “Айдсаас үүдэлтэй мөнгөө хэмнэх”--эд хүргэж байлаа. Айдсаас үүдэлтэй хэмнэлтээс хэрэглээ зогсонги байдалд орж байлаа. Энэхүү хөгжлийн логик үр дагавар нь 1970-аад онд эдийн засгийн зогсонги байдал ба ханшийн уналт хоёрын гайтай давхцал болох стагфлацийг авчирсан юм.

*Бусад эх сурвалжууд:  
Петер Бофингер (2007)  
“Улс ардын аж ахуйн  
сургуулийн үндсэн  
зорилтууд”*

*1970-аад оны  
Кенсанизмаас 1990-  
ээд оны Вашингтоны  
зөвшилцөл хүртэл*

Энэ хоёр онолын аль нь илүү нөлөөтэй бэ? 1920-иод оноос 1970-аад он хүртэл олон улсын түвшинд Кенсийн эрэлтийн бодлого давамгайлж байлаа. Дэлхийн эдийн засаг зогсонги байдалд орж ханшийн уналт гаарсан (стагфлацион) –ы эсрэг хариу үйлдэл нь 1970-аад онд шинэ сонгодог хэлбэрийн нийлүүлэлтийн бодлогод сэргэн мандалтыг авчирсан юм. 1980-аад онд АНУ-д Роналд Рейган, Их Британид Маргерет Тетчер нар нийлүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлж түүний сулруулсан хэлбэрийг Германд Хэлмут Коль хэрэгжүүлсэн юм. 1990-ээд онд Вашингтоны зөвшилцөлийн номлолд нийлүүлэлтийн бодлого тусгалаа олж улмаар олон улсад тархсан байна. Юуны өмнө Дэлхийн банк, Олон улсын валютын сангаар дамжин эдийн засгийг либералчлах бодлогын сурталчилгаа явагдаж татварыг бууруулах,

хувьчлалыг дэмжих, зохицуулалтыг задлах, чөлөөт худалдаа, төрийн хөнгөлөлтийг бууруулахыг шаардаж байлаа. Зах зээлийг бэхжүүлж төрийн оролцоог бууруулахыг шаардаж байлаа. Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч асан Нобелийн шагналт Жозеф Э. Стиглицт өдгөө Вашингтоны зөвшилцлийн нөлөө бүхий шүүмжлэгч болсон байна. Тэр уг зөвшилцлийг улс орнуудын туршлагаар сайн гэдэг нь батлагдаагүй үзэл сурталд сохроор итгэсэн гэж шүүмжилдэг. Төрийн зохицуулалтыг идэвхжүүлэн зах зээлийг удирдсанаар нийгэм, эдийн засгийн амжилтанд хүрсэн улс орнууд байхад зах зээлийн либерализмыг зохих жорын дагуу хэрэгжүүлсэн, эдийн засгийн зогсонги байдалд орсон улс орнууд ч бий. (Стиглицт 2002 он.)

Өдгөө Германы эдийн засагчдын олонхи нь нийлүүлэлтэнд чиглэсэн бодлогыг дэмждэг мэт харагдаж байна. 2005 онд улаан-ногооны эвсэл (ГСДН ба Холбоотон 90\Ногоонтнууд намуудын эвслийн засгийн газар) эвслийн гэрээгээ байгуулахдаа доголдож буй эрэлтийг олон нийтийн зарлагыг нэмэгдүүлэх (төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр өсгөх) өөрөөр хэлбэл сонгодог кенсийн бодлогыг хэрэгжүүлэх эдийн засгийн бодлогыг дэмжих чиглэлийг баримталж байсан ч улс ардын аж ахуйн ухааны 250 гаруй профессорууд нэгдэн “Хамбургийн уриалга”-ыг боловсруулан гаргаж нийлүүлэлтэнд чиглэсэн эдийн засгийн бодлого явуулахыг шаардсан юм. Тухайн цаг үеийг хүртэл эрэлтэд чиглэсэн эдийн засгийн бодлогыг дэмждэг эдийн засгийн шинжлэх ухааныхан хориглолтонд орчихоод байсан бөгөөд сүүлийн үед тэдний үгийг сонсдог хүмүүсийн тоо харьцангуй нэмэгдсэний улмаас илүү чангаар дуугарах болсон байна.

Кенсийн эрэлтийн онолоор 2008 оны санхүүгийн хямрал ямар нөхцөл, шалтгааны улмаас асар хурдан хугацаанд маш гүнзгий хямралыг бодит эдийн засагт авчирч дэлхий дахины эдийн засгийг уналтанд оруулав аа гэдэгт тайлбар өгч болно. Дэлхийн маш олон орон уг санхүүгийн хямралд сонгодог кенсийн бодлогоор хариулт өгч төсвийн зарлагыг нэмэгдүүлэн эрэлтийг урамшуулж хүн амын дийлэнх олонхийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх замыг сонгон авсан юм.

2008 оны санхүүгийн зах зээл ба эдийн засгийн хямралын улмаас эдийн засгийн сэтгэлгээнд томоохон өөрчлөлт гарчээ. Германы

*Германы эдийн засагчид: олонхи нь нийлүүлэлтэнд чиглэсэн эдийн засгийн бодлогыг дэмждэг.*

*2008 оны санхүүгийн хямралд Кенсианизмыг баримтлагсдын өгөх хариулт*

банкны ерөнхийлөгч Жозеф Акерман хүртэл “Би зах зээлийн өөрийгөө анагаах чадварт итгэхээ байсан.” гэж хэлсэн юм. (Акерман 2008 он.) Тэр санхүүгийн хяналтын даяаршлын байгууллага байгуулахыг шаардаж байлаа. Зах зээлийн радикализмыг дэмжигсэд хориглолтонд орж Кенсийн сургаалийг дахин нээлээ. Түүний онол эдгээр хүнд хямралд тайлбар өгч чадсан учраас хямралаас гарах замыг ч зааж өгөх болно.

Кенсийн онол дахин сэргэсэн нь тохиолдлын хэрэг биш. Түүний “Хөдөлмөр эрхлэлт, хүү, мөнгөний ерөнхий онол” бүтээл нь өнөөгийн хямралын байдалтай зарим талаараа төстэй 1930-аад оны дэлхийн эдийн засгийн хямралаас мэндэлсэн хүүхэд билээ. Түүнийг уг бүтээлээ туурвиж байсан түүхэн цаг үед санхүүгийн зах зээл дээр саатал гарсаны улмаас дэлхий дахины эдийн засгийн байдал муудаж эдийн засгийн бууралтын ороомог хэлбэрт бууралт идэвхжсэн юм. Худалдан авах чадвар доройтож эдийн засгийн илүү гүнзгий хямрал болох бий гэдэг айдсаас айл өрхүүд хэрэглээгээ багасгаж компаниуд хөрөнгө оруулалтаа хойшлуулж банкууд зээлээ бараг зогсоож байлаа. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан учраас ажилгүйдэл нэмэгдэж хэрэглээ улам бүр буурсаар байлаа. 1930-аад оны хямралаас Кенсийн онолын дагуу зах зээлийн зохицуулалтыг эрчимжүүлэх, төрийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар гарсан юм.

Америкийн үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр саяхан гарсан хямрал юунаас үүдэлтэй бэ? Америкт дамын наймааны аварга том хөөс үүсч түүний нөлөөгөөр олон улсын банкны систем муужралтын байдалд орох шахжээ. Кенсийн шавь Химан Мински Кенсийн онол дээр суурилан багштайгаа төстэй тайлбарыг өгсөн байна. (Мински 1986 он) Эдийн засгийн өсөлтийн үе шат удаан үргэлжлэхийн хэрээр шунаг сэтгэл, эрсдэлээс буцахгүй байх хандлага нэмэгддэг. Ашиг орлогыг улам нэмэгдүүлэх хүсэлдээ хөтлөгдөн өндөр эрсдэлтэй алхмуудыг хийдэг. Банкуудын хоорондын өрсөлдөөн нь санхүүгийн шинэ хэлбэрийн бүтээгдэхүүнээс ашиг олохын тулд зохих дүрэм журмыг үл харгалзан эрсдэлтэй санхүүжилтийг хийхэд хүргэдэг. Эрсдэл овоорсоор нэг л өдөр байшинг тэр чигээрээ нуран унахад хүргэдэг. Байшин ч нурлаа. Мински зах зээлийг өөрийг нь өөрөөс нь хамгаалах, санхүүгийн хямралаас сэргийлэхийн тулд зах зээлийг төрөөс зохицуулахыг шаардсан юм. Даяаршлын зохицуулалтгүй зах зээлд баяртай гэж хэлэх цаг нь болсон гэдгийг Кенс 1926 онд бичсэн “*Laissez-faire* -ийн төгсгөл” өгүүллэгтээ сануулж байлаа. (Кенс 1926

он) Тэр үүгээрээ дэлхийн зах зээлийн зохицуулалтын дүрэмд хувь нэмрээ оруулсан. Үүний зэрэгцээ тэрбээр Бреттон-Вүүдсийн бага хуралд ажиллаж олон арван жилийн туршид дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж чадсан дэлхийн санхүүгийн зах зээлийн журмыг боловсруулахад биечлэн оролцсон юм. Энэ сэдэв дахиад л олон улсын зорилт боллоо. 2009 оны 4-р сард дэлхийн эдийн засагт тэргүүлэгч их 20 гүрний уулзалтыг хоёрдох Бреттон-Вүүдсийг байгуулах оролдлого хэмээн нэрлэж болох юм. Хоёрдох Бреттон-Вүүдсийг байгуулах жижиг ч гэсэн чухал алхмуудыг хийсэн билээ. Даяаршсан санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг хийх эрсдэлээс зайлсхийх сан байгуулах, рейтингийн судалгааны агентлагууд байгуулах, олон улсын валютын сангийн дэргэд санхүүгийн тогтвортой байдлыг хангах чуулганыг байгуулахаар тохиролцжээ.

Тэгэхлээр Кенс хямралаас гарах ямар замыг заасан бэ? Эдийн засгийн сэргэлтийн давтамжийг ердийн нөхцөлд хүүгийн бодлогоор дамжуулан удирддаг. Үүний дагуу дэлхий дахины Төв банкууд 2008 оны хямралаас гарахын тулд зээлийн хүүгээ буурууллаа. Уг хямрал дэндүү гүнзгий хямрал байсан учраас хүссэн үр дүн гарахын оронд Кенсийн гүнзгий хямралын үед айдсаас үүдэлтэй хэмнэлт үүсдэг гэдэг онолыг нотолж мөнгөн хуримтлал нэмэгдэж эхэллээ. Үүний үр дагавараар зогссон хувийн хөрөнгө оруулалт, хувийн хэрэглээг тэнцвэржүүлэхийн тулд өрөөр буюу төсвийн алдагдлаар санхүүжсэн төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг Кенс зөвлөж байлаа. 2008-2009 онд дэлхийн олон улс орон төсвийн зардал, хүн амын олонхийн худалдан авах чадварыг урьд өмнө байгаагүй өндөр хэмжээнд нэмэгдүүлэх замаар эрэлтийг урамшуулах Кенсийн сонгодог бодлогыг хэрэгжүүлсэн. АНУ, Хятад, Европын орнуудад эдийн засгаа сэргээх томоохон хөтөлбөрийг баталсны дараагаар дэлхийн эдийн засгийн хамгийн хүчирхэг 20 гүрний их 20-ийн уулзалт 2009 оны 4-р сард Лондон хотноо болж дэлхий дахинд 1.1 миллиард Еврог эдийн засагт цутгаж эдийн засгийг дахин сэргээхээр тохиролцлоо. Британий социал демократ сангийн сайд Алистайр Дарлинг өөрийн засгийн газрын эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг танилцуулахдаа Кенсийн онол дээр суурилсан гэдгийг онцолсон юм.

Улс ардын аж ахуйн сургаалын хүрээнд германы эдийн засгийн судалгааны институтууд ихэвчлэн зарчмын хувьд нэг чиглэлийг (нийлүүлэлтэнд чиглэсэн бодлогыг эсхүл эрэлтэд чиглэсэн бодлогыг) баримталж ингэснээрээ дээр дурьдсан онолуудын аль нэгэн дээр суурилж байдаг. Германы тэргүүлэх таван том эдийн засгийн

#### **Гүнзгийрүүлэн сулгах материалууд:**

Михаел Даудерштадт  
2009 он, Хямралын  
үед: Өр яаж хөрөнгө  
бүтээдэг бэ? Хөрөнгө  
ямар өрийг бий  
болгодог бэ?  
Фридрих-Эбертийн  
санаас эрхлэн гаргав./  
Бонн хот/

Германы эдийн  
засгийн судалгааны  
институтуудын ангилал

судалгааны институтуудыг чиг хандлагынх нь хувьд “эрэлтийг” эсхүл нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг сурталчилдаг гэдгээр нь ангилж болно. Тэд судалгааныхаа үр дүнгээр эдийн засгийн бодлогын мэтгэлцээнд чухал байр суурийг эзэлдэг. Тийм ч учраас тэдний эдийн засгийн үндсэн итгэл үнэмшлийг мэддэг байх шаардлагатай бөгөөд тэдний хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт, зөвлөмжин дээр байнга харгалзан үзэх хэрэгтэй. Гэхдээ эдгээр таван том судалгааны байгуулагууд улсын төсвийн үндэслэл болсон эдийн засгийн сэргэлтийн таамаглал зэрэг чухал салбаруудад хамтран ажилладаг. Уг таамаглал нь олон компаниудын төлөвлөлтөнд чухал нөлөө үзүүлдэг.

~ Профессор Клаус Циммерманы удирддаг Берлин хотноо байрлах Германы эдийн засгийн судалгааны институт (DIW) нь эрэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй сурталчилдаг. ВЕБ сайт нь: [www.diw.de](http://www.diw.de),

~ Профессор Улрих Блумын удирддаг Халле\Саале хотноо байрлах эдийн засгийн судалгааны институт (IHW) нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй дэмждэг. ВЕБ сайт нь: [www.ihw-halle.de](http://www.ihw-halle.de),

~ Профессор Деннис. Ж.Сноберийн удирддаг Киел хотноо байрлах Дэлхийн эдийн засгийн институт (IFW) нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй дэмждэг. ВЕБ сайт: [www.ifw.de](http://www.ifw.de),

Профессор Христоф Шмидтийн удирддаг, Эссен хотноо байрладаг Райн-Бестфалены эдийн засгийн судалгааны институт (RWI) нь нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй дэмждэг. ВЕБ сайт: [www.rwi-essen.de](http://www.rwi-essen.de)

~ Профессор Ханс-Вернер - Зинний удирддаг Мюнхен хотноо байрладаг эдийн засгийн судалгааны институт (ifo) нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй дэмждэг, дээрх таван институтын дотор зах зээлийн либерал бодлогыг хамгийн ихээр дэмждэг. ВЕБ-сайт: [www.ifo.de](http://www.ifo.de)

~ Мөн Коелн хотноо байрладаг, профессор Михаел Хютнерийн удирдлагад байдаг “Германы эдийн засгийн институт” (IW) ВЕБ сайт нь : [www.iwkoeln.de](http://www.iwkoeln.de) нь нийлүүлэлтийг дэмжсэн бодлогыг илүүтэй дэмждэг. Уг институт ажил олгогчидтой илүү ойр байдаг. Үйлдвэрчний эвлэлтэй ойр байдаг эрэлтийг дэмжсэн эдийн засгийн бодлогыг илүүтэй дэмждэг профессор, доктор Хайде Пфаррын удирддаг “Эдийн засаг-нийгмийн шинжлэх ухааны институт” (WSI) болон түүний харъяанд байдаг, доктор Густав Хорны удирддаг “Макро эдийн засаг-эдийн засгийн



сэргэлтийн судалгааны институт” ВЭБ сайт [www.wsi.de](http://www.wsi.de) -тай илүү ойр хамтран ажилладаг.

| Нийлүүлэлтийг дэмжсэн бодлого   |                                                                                                                                                                                                                                               | Эрэлтийг дэмжсэн бодлого                                                                                                                                                       |
|---------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үндсэн санаа                    | Компаниудад өндөр ашигтай ажиллах хамгийн тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх                                                                                                                                                                      | Төрийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлого явуулснаар улс ардын аж ахуйд эрэлтийг байнга баталгаатай байлгах                            |
| Сэтгэлгээний уламжлал           | Адам Смит, Девид Рикардо, Жон Стюарт Милл                                                                                                                                                                                                     | Жон Майенерт Кенс                                                                                                                                                              |
| Төрийн тухай ойлголт            | Пассив буюу идэвхгүй төр                                                                                                                                                                                                                      | Актив буюу идэвхтэй төр                                                                                                                                                        |
| Цалингийн тухай ойлголт         | Цалин нь өртгийг нэмэгдүүлэх шийдвэрлэх хүчин зүйл доогуур тогтоох хэрэгтэй.                                                                                                                                                                  | Цалин нь эрэлтийг нэмэгдүүлэх нэгэн чухал хүчин зүйл тул үйлдвэрлэлийн бүтээмж өсөхийн хэрээр нэмэгдэж байх ёстой.                                                             |
| Төв банкны үүрэг                | Мөнгөний ханшийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй.                                                                                                                                                                                          | Мөнгөний ханшийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн байнгын өсөлтөнд хувь нэмрээ оруулах ёстой.                                              |
| Ямар цаг үеийг тодорхойлж байв? | 1980-аад оноос хойш                                                                                                                                                                                                                           | 1930-аад оноос 1970-аад онд, 2008 оноос дахин хүчээ авсан.                                                                                                                     |
| Институтууд                     | Халлегийн эдийн засгийн судалгааны институт (IWH)<br>Дэлхийн эдийн засгийн институт (IfW)<br>Райн-Бестфалены эдийн засгийн судалгааны институт (RWI)<br>Эдийн засгийн судалгааны институт (ifo)<br>Коелны германы эдийн засгийн институт (IW) | Германы эдийн засгийн судалгааны институт (DIW)<br>Макро эдийн засаг- эдийн засгийн сэргэлтийн судалгааны институт (IMK)<br>Эдийн засаг-Нийгмийн шинжлэх ухааны институт (WSI) |

**Зах зээл, компанийн шийдвэр гаргалтанд ажилчдын оролцоог хангах, зохицуулалт болон улс төрийн удирдлага зэрэг зөрчилтэй талбарууд**

Зах зээл, ардчилал,  
нийгмийн нэгдмэл  
байдлын тэнцвэртэй  
байдлыг хангах

Эдийн засгийн суурь онолуудтай танилцсаны дараагаар орчин үеийн, үнэлэмжид суурилсан, нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлого эдгээр онолууд дээр хэрхэн суурилах юм бэ? гэдэг асуулт гарч ирнэ. Нийгмийн ардчиллын чиг хандлагын чигийг заагч луужингийн талаар дараагийн хоёр бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлах болно. Энэ хэсэгт нийгмийн ардчиллын чиг хандлагаас авч үзэхэд тэнцвэрт байдал нь хангагдаж байх ёстой зөрчилтэй талбаруудыг авч үзье. (Томас Майер 20056, 67-р хуудас)

Эдийн засгийн өсөлт  
ба шударга ёс

**1. Үйлдвэрлэлийн бүтээмж ба эдийн засгийн өсөлт нийгмийн шударга ёс ба аюулгүй байдлын эсрэг**

Адам Смит, Маркс нарын тодорхойлсноор хувийн эрх ашгаа гүйцэлдүүлэх сонирхол, өмчтэй болохын тулд хүнээс хэрээс хэтэрсэн их хүч гардаг байна. Зах зээл ба өрсөлдөөний нөлөөгөөр хязгаарлагдмал, хомс нөөц хамгийн өндөр бүтээмжтэй байх тэр газрыг олж байршдаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг ч зах зээлээс илүү үр дүнтэй байршуулалтыг хийж чаддаггүй гэдэг нь нотлогдсон.

Нөгөө талаас зах зээл тэгш бус хувиарлалтыг бий болгодог бөгөөд Кенсийн тодорхойлсноор зах зээл нь давтамжит хэлбэлзэлд оршдог бөгөөд хямрамтгай байдлынхаа улмаас бүтцийн хувьд тогтвортой бус байдаг. Тийм ч учраас хямрамтгай байдлыг бууруулахын тулд зах зээлд ерөнхий нөхцөлүүдийг нь бодлогоор тогтоож өгөх шаардлагатай. Нийгмийн баримжаат төр нь хүмүүсийг зах зээлийн эрсдэлүүдээс хамгаалах үүрэгтэй. Дэвшилтэт буюу орлого нэмэгдэхийн хэрээр нэмэгдэж байдаг орлогын албан татвар, өв залгамжилсан хөрөнгө болон хөрөнгийн албан татвараар дамжуулан шударга хувиарлалтыг бий болгох хэрэгтэй. Мөн төр нь **Зарцуулалт-Татвар-Мөнгөний** хүүгийн бодлогоор дамжуулан эдийн засгийн давтамжуудыг зохистойгоор удирдах ёстой. Өөрөөр хэлбэл: эдийн засгийн хямралын үед төр төсвийн зарлагыг нэмэгдүүлэх замаар хэрэглээг тогтвортой барьж хүү багатай, тааламжтай зээлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хөрөнгө оруулах идэвхийг сэргээх ёстой.

2. Уян хатан байдал ба техник, технологийн шинэчлэл дээр суурилсан эдийн засгийн шинэчлэл - хараат хөдөлмөр эрхлэгсдийн хамгаалал ба өргөн хүрээтэй нийгмийн хамгааллын эсрэг.

*Уян хатан байдал ба аюулгүй байдал*

Өрсөлдөөн ба уралдаан нь нэг талаас техник, технологийн шинэчлэл дээр суурилсан эдийн засгийн өсөлтөнд хүргэдэг. өрсөлдөөнөөс эхтэй эвдрэл, хямралын нөлөөг нэг талаас хөдөлмөр эрхлэгсдийг ажлаас халагдахаас хамгаалах болон нийгмийн хамгааллын үйлчилгээгээр дамжуулан бууруулах ёстой. Бүтцийн гүнзгий өөрчлөлт, жишээлбэл: Рүүр нутаг дахь уул уурхайн үйлдвэрлэл буурахад зөвхөн зорилтот бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах замаар ажлын байруудыг шинээр бий болгосон юм.

3. Өмч ба өрсөлдөөн - нийгмийн холбоос ба зохицуулалтын эсрэг

*Өмч ба нийгмийн холбоос*

Үйлдвэрлэлийн хэрэгслүүдийг өмчлөх эрх ба өрсөлдөөнөөс бүр мөсөн татгалзсан эдийн засгийн дэглэмүүд бүгдээрээ бүтэлгүйтсэн. Амжилттай хэрэгжиж буй эдийн засгийн бүх дэглэмүүд өмч ба өрсөлдөөн дээр суурилдаг. Гэхдээ энэ дэглэм өмчийг нийгмийн хариуцлагаас салгадаггүй. Германы үндсэн хуулийн 14-р зүйлд : Өмч ба өв залгамжлах эрхийг хангана. (...) Өмчид хариуцлага ногдоно. Өмчийн хэрэглээ нь олны тусын тулд үйлчлэх ёстой. "Зах зээл дээр шударга байдлыг хангах, актёруудад зах зээл дээр дангаараа давамгайлах боломжийг олгохгүй байхын тулд өрсөлдөөнийг зохицуулах шаардлагатай." гэж заасан байдаг.

4. Компаниудын бие даасан үйл ажиллагаа - компаниудын шийдвэр гаргалтанд ажилчдын оролцоог хангаж бодлогоор ерөнхий нөхцөлийг тогтоохын эсрэг.

*Компанийн эздийн шийдвэр ба компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах*

Өмчтэй байх эрхээс аж ахуйн нэгж, компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах эрх нээгддэг. Харин аж ахуйн нэгж, компаниудын шийдвэрт зөвхөн хөрөнгийн эзэд бус, өөрсдийн ажиллах хүчээ бүтээмжийг үйлдвэрлэхэд нэмэрлэж буй хүмүүсийн оролцоо хангагдсан байх ёстой. Иймээс компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах тухай хуулиар хөрөнгийн эздийн шийдвэр гаргах эрхийг хязгаарласан.

Өмчлөх эрх ба аж ахуйн нэгж, компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах эрхээс үүдэлтэйгээр эдийн засгийн бодлогын дараах дөрвөн хамрах хүрээг тогтоодог:

*Эдийн засгийн бодлогын хамрах дөрвөн хүрээ.*

- ~ Бодлогоор ерөнхий нөхцөлүүдийг тогтоож өгөх
- ~ Зах зээлийн логикийг хөгжүүлэх
- ~ Хамтран нөлөөлөх-компанийн шийдвэр гаргалтанд оролцох эрх
- ~ Макро эдийн засгийн зохицуулалт

Эцэст нь дүгнэн хэлэхэд Нийгмийн Ардчиллын үнэлэмжүүд дээр суурилсан эдийн засгийн дэглэмд зах зээлийн логик нь бодлогоор тогтоож өгсөн ерөнхий нөхцөлүүдийн дунд хөгжиж боломжтой юм. Өмчид хариуцлага ногддог төдийгүй нийтийн сайн сайхны төлөө зориулагдаж байх ёстой. Өмчид ногдох энэ үүрэг компанийн шийдвэр гаргалтанд зөвхөн хөрөнгийн эзэд бус, харин ажилтнуудын оролцоог хуулиар хангаж өгснөөр давхар биелэгдэж байдаг. Нийт эдийн засгийн тогтвортой байдлыг макро эдийн засгийн зохицуулалтаар хангадаг. Өөрөөр хэлбэл төр өөрийн төсөв болон мөнгөний хүүгийн бодлогоор эдийн засгийн өсөлт байнга тогтвортой байж хөдөлмөр эрхлэлт өндөр байхад нөлөөлж байдаг.

Нийгмийн ардчилалын зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн бодлогод ямар шаардлагууд тавигдаж байна бэ?

- ~ Эдийн засгийн асуудлыг сонирхогч хүн бүр онолын төрөл бүрийн үндсүүдийг мэддэг, үзэл суртлын хувьд ангилж чаддаг байх нь чухал.
- ~ Нийгмийн ардчилал нь зөвхөн нэг бус харин төрөл бүрийн онолын үндэслэл дээр суурилдаг.
- ~ Нийгмийн ардчиллын эдийн засгийн онолын төвд Кенсийн шаардлагын дагуу үүссэн зохицуулалттай капитализм оршдог.
- ~ Нийгмийн ардчилал нь Марксын капитализмын шүүмж, Смитийн тодорхойлсон зах зээлийн үр өгөөж болон үйлдвэрлэлийн бүтээмжийг ч бодлогодоо тусгадаг.
- ~ Аливаа эдийн засгийн дэглэм ямар ч тохиолдолд өрсөлдөөн ба өмч дээр суурилсан байх ёстой. Зах зээлд ямагт зохицуулалт хэрэгтэй бөгөөд төр нь эдийн засгийн хямралтай идэвхтэй тэмцэж ажилтнуудын хамтын нөлөөлөл, хамтын шийдвэрийг хуулиар хангах үүрэгтэй.

### 3. ЭДИЙН ЗАСГИЙН СИСТЕМҮҮД БА ЭДИЙН ЗАСГИЙН ДЭГЛЭМҮҮД

Энэ бүлэгт:

- ~ Нэг талаасаа зөрчилтэй, нөгөө талаасаа харилцан бие биенээ дэмжиж байдаг капитализм ба ардчиллын харилцааны тухай ярина.
- ~ Зохицуулалтын зэрэглэлээрээ хоорондоо ялгагдах капитализмын төрөл бүрийн хэв шинжүүдийг тайлбарлана.
- ~ “Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг” гэдэг ойлголтыг тайлбарлана.
- ~ Нийгмийн ардчиллын үзэл баримтлалын зүгээс харахад даяаршилд ямар эерэг талууд, ямар сүүдэртэй талууд байгаа талаар тайлбарлана.

#### 3.1. Капитализм ба ардчилал



Суперкапитализм” ардчиллыг сүйтгэж байна уу? гэдэг асуултыг “Менежерийн магазин” гэдэг эдийн засгийн сэтгүүл 2008 оны 3-р сарын дугаарын тэргүүн нүүрэндээ дэвшүүлж өвсний соргогийг даган нүүдэллэдэг царцааны зургийг тавьсан юм. Эхний өгүүлэлдээ даяаршсан зах зээлийн эдийн засаг ардчилалд итгэх итгэлийг бууруулж болзошгүй юм гэдэг асуудлыг дэвшүүлсэн юм. Улмаар олон иргэдийн хувьд даяаршсан эдийн засгаас<sup>6</sup> ашиг олно гэдэг итгэлээ гэж байгаа байдалд дүн шинжилгээ

хийсэн юм. Үүний улмаас иргэдийн эдийн засаг ба улс төрд итгэх итгэл үгүй болохдоо тулах юм биш үү?

“Менежерийн магазин” сэтгүүл нь уг өгүүллээрээ ардчилал ба капитализм хоорондын зарчмын зөрчилд олны анхаарлыг хандуулсан юм.

Түүхэн эх сурвалжийг нь авч үзвэл ардчилал ба капитализмын үүсэл хоорондоо нягт уялдаатай. Олон оронд ардчилал нь чөлөөт зах зээл үүсэн хөгжсөнтэй уялдаатайгаар байгуулагдсан байдаг. 18 ба 19-р зууны үеийн Европт чөлөөт өрсөлдөөн ба хувийн өмч дээр

*“Суперкапитализм”  
ардчиллыг сүйтгэж  
байна уу?*

*Ардчилал ба капитализм  
үүссэн түүхэн эх  
сурвалж хоорондоо  
нягт холбоотой.*

6 Зах зээлийн эдийн засаг эсхүл капитализм гэдэг энэ хоёр ойлголт нь хоорондоо ямар ялгаатай юм бэ? Энэ хоёр үгийн агуулга нь хоёулаа өмч ба өрсөлдөөн дээр суурилсан эдийн засгийн систем гэдэг ойлголтыг илэрхийлдэг. Хэллэгийн хувьд “зах зээлийн эдийн засаг” гэдэг үгийг либерал эдийн засгийн системийг дэмжигчид ихэвчлэн хэрэглэдэг бол зах зээлд шүүмжлэнгүй хандагсад ихэвчлэн “капитализм” гэдэг үгийг хэрэглэдэг байна. Энэ сурах бичигт дээрх хоёр ойлголтыг хоёуланг нь хэрэглэсэн бөгөөд үүнийг аль нэг чиг урсгалыг дэмжсэн гэдэг агуулгаар ойлгох хэрэггүй юм.

суурилсан эдийн засаг үүсэн хөгжсөнтэй холбоотойгоор хувь хүний эрх чөлөөний асуудал хүчтэй тавигдаж эхэлсэн. (2-р бүлгийн Адам Смитийн онолын тайлбартай харьцуулан үзнэ үү.) Энэ шаардлага нь эрх зүйн баталгаат байдал, хуулиар заавал хангагдах үндсэн эрхүүд, иргэдийн улс төрийн оролцоо ба төрд иргэдийн төлөөллийг хангах зэрэг бусад шаардлагуудыг дагуулсан юм. Шинэ цагийн анхны ардчилал болох АНУ-д **"No taxation without representation"** буюу Төрд бидний төлөөллийг хангахгүй юм бол бид татвараа төлөхгүй" гэдэг уриа гарсан юм. Өөрөөр хэлбэл эдийн засаг болон улс төрийн оролцоог нэгтгэх тухай шаардлага тавьсан юм. 1989 оны дараагаар посткоммунист орнууд эдийн засгийн либералчлал ба ардчилалд гар гараасаа барин хөл тавьсан юм.

Ардчилсан орнууд  
эдийн засгийн хувьд  
илүү амжилтанд хүрдэг  
үү?

Олон жилийн туршид ардчилсан орнууд ардчилсан бус системүүдтэй харьцуулахад эдийн засгийн хувьд илүү амжилтанд хүрдэг нь мэдээжийн хэрэг мэт харагдаж байлаа. Барууны орнуудын эдийн засгийн хангалуун чинээлэг байдал, зүүний блокийн эдийн засгийн бүтэлгүйтэл үүнийг нотлоод байгаа мэт харагддаг байлаа. Энэ хооронд ардчиллын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлээгүй ч капиталист эдийн засгийн системд эдийн засгийн өндөр өсөлтөнд хүрсэн улс орнууд байгаа нь тодорхой боллоо. Эдгээр орнуудын хамгийн тод жишээ бол Хятад улс юм. Капиталист орон болон хувирах явцдаа эдийн засгийн гайхамшигтай амжилтанд хүрсэн ч энэ процессын явцад ардчилагдаагүй. Бусад зарим улс оронд ч гэсэн эдийн засаг болон улс төрийн либералчлал зэрэгцэн явагдаж буй үйл явц ажиглагдахгүй байна. **"Economic Freedom of the World"** – "Дэлхий дахины эдийн засгийн энх тайван" сэтгүүлд нийтлэгдсэн эдийн засаг ба улс төрийн эрх чөлөөний индексүүд ч үүнийг нотолж байна. Уг индексүүд нь эдийн засаг ба улс төрийн эрх чөлөөг хангасан байдлаар нь улс орнуудыг ангилдаг. Эдийн засгийн эрх чөлөөг хамгийн сайнаар хэрэгжүүлж чадсан орнуудын эхний нэг, хоёрдугаар байрыг Хонгконг, Сингапур улс эзэлж байна. Мөн эзэрхэг капиталист системүүдтэй орнууд байсаар байна. Өдгөө оршин байгаа бүх ардчилсан орнууд зах зээлийн эдийн засаг дээр суурилдаг.

Энэ нь ардчилал ба капитализмын хооронд ямар ч зөрчил байдаггүй гэсэн үг биш юм. Ардчилал **"one man, one vote"** – "нэг хүн-нэг санал" гэдэг тэгш байдлын зарчим дээр суурилдаг. Өөрөөр хэлбэл "Санал бүр адил жинтэй" гэдэг зарчим дээр суурилдаг. Харин зах зээлийн эдийн

Капитализм ба  
ардчиллын зөрчилт  
харьцаа

засаг тэгш бус байдал дээр суурилдаг. Капиталист эдийн засгийн системд үйлдвэрлэгдсэн бялуу харилцан адилгүй хэмжээтэйгээр (том, жижиг) тэгш бус хувиарлагддаг. Дахин хувиарлалт хийх замаар хүн бүрт тэнцүү хэмжээний бялуу олгуулах оролдлогыг хийдэг ч хүн бүр тэнцүү хэмжээний бялуу авдаг болчих юм бол илүү их өмчтэй болох, өрсөлдөх сонирхол үгүй болно.

Тэгш бус байдал газар авсаар эдийн засгийн хүчирхэг актёрууд хориг тавих хэмжээний хүчтэй байр суурьтай болчихбол “гажуудалтай ардчилал”-д хүргэж болзошгүй юм. Улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэн Вольфганг Меркел энэ ойлголтыг “Эрх мэдэлд хүрэх замыг нээдэг ардчилсан, үүргээ сайн биелүүлдэг сонгуулийн системтэй, ардчиллын бусад элементүүд нь бүрдсэн ч бодитоор хэрэгжиж буй ардчилалд эрх чөлөө, тэгш байдлыг хангах, хяналтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагддаг функцын логик нь сааталтай учраас нэг буюу нэлээд хэдэн бүрэлдэхүүн хэсгүүд нь нэмэлт тулгууруудаа алдсаны улмаас ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжиж чаддаггүй ноёрхлын системүүдийг гажуудалтай ардчилал гэнэ.” гэж тодорхойлсон. (Меркел 2003 он, 66-р тал)

*Тэгш бус байдал  
“гажуудалтай  
ардчилал”-д хүргэдэг.*

Тэгэхлээр сонгууль явуулдаг, ардчиллын бусад элементүүд бүрдсэн ч бусад саад болдог хүчин зүйлсийн улмаас ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүйд хүрснийг гажуудалтай ардчилал гэж нэрлэдэг байх нь. Үүний нэг жишээ бол: Аль нэгэн эдийн засгийн актёр хамтын шийдвэрийн эсрэг хориг тавих хэмжээнд хүчирхэг болох явдал юм. Жишээлбэл хэн нэгэн хөрөнгө оруулагч хөрөнгөө эргүүлэн татна гэдэг дарамт үзүүлж байгаль орчин болон хөдөлмөрийн стандартуудыг бүрэн хэмжээнд мөрдөхгүй байх тухай улс төрийн шийдвэрийг тухайн оршин буй газар нутгийнхаа парламент, засгийн газраас гаргуулахаар хэмжээнд хүчирхэг болсон бол энэ нь ардчилсан зарчимд харшилж буй хэрэг.

*Ардчилалд саад  
учруулдаг хүчин зүйлс*

Нийгмийн ардчиллын үндэс хэмээх тэргүүн дэвтрийн 62-66 ба 88-р хуудсанд Томас Майерийн нийгмийн ардчиллын онолд ардчилал ба капитализмын зөрчилтэй харьцааг харуулсан.


*Т. Майерийн онолоор  
ардчилал ба зах зээлийн  
капитализмын харьцааг  
тодорхойлох нь*

4-р зураг ардчиллын парадоксыг харуулсан: Капитализм нь нэг талаасаа ардчилалыг байгуулах нэг нөхцөл юм. Нөгөө талаасаа хангалттай зохицуулалтгүй зах зээл бүх хүний нийгмийн оролцоог хангах үндсэн санаатай зөрчилдсөн, ингэснээр гажуудалтай ардчилалд хүргэх нөхцөлүүдийг бүрдүүлдэг.

*Ардчиллын парадокс*

Милтон Фридман: Зах зээлийн эдийн засаг ардчилалд хүргэдэг.

Үзэл баримтлалын энэхүү ялгаатай байдал, капитализмын ардчилалд учруулж болзошгүй эрсдэлүүдийг ухамсарласан байдлаараа нийгмийн ардчилал нь либертар ардчиллаас ялгаатай. Милтон Фридман нарын либертар эдийн засагчид зах зээлийн эдийн засаг улс төрийн эрх чөлөө ба ардчилалд хүргэдэг гэж баталдаг.



Эсрэг жишээ: Чили

Милтон Фридман өөрөө бодит амьдрал дээр түүний номлолын эсрэг жишээ болсон орныг нэрлэсэн байдаг. Фридман нь 1970-аад онд Чилийн цэрэг дайны бурангуй хунт дэглэмд зөвлөхөөр ажиллан олон хамтран зүтгэгчдийнхээ гайхширлыг төрүүлсэн юм. Дарангуйлагч Августа Пиночет эдийн засгийг эрс либералчлах Фридманы жорыг амьдралд хэрэгжүүлсэн юм. Гэтэл либертар эдийн засагчдын хүлээж байснаас эсрэг үр дүнд хүрч улс төрийн эрх чөлөөг хангах талаар огтхон ч амжилт гарсангүй. Ардчиллын тухай бүр дурсахын ч хэрэггүй үйл явдал болж. Харин эсрэгээрээ: Эдийн засгийн амжилт дарангуйлагч дэглэмийг бэхжүүлэн тогтворжуулж байлаа. Чили нь латин америкийн бусад орнуудаас сүүлдсэн ч дахин ардчилсан улс болсон юм.



Капитализм ба ардчиллын зөрчилт харьцаа улам ихээр олны анхаарлыг татаж эдийн засгийн сэтгүүлүүдийн тэргүүлэх сэдэв болж байгаа нь ямар учиртай юм бэ? Америкийн эдийн засагч ерөнхийлөгч Клинтоны засгийн газрын хөдөлмөрийн сайд асан Роберт Райх 2008 онд “Суперкапитализм - эдийн засаг бидний ардчиллын нэр хүндийг гутааж байна.” номоороо дээрх асуултанд хариулт өгсөн юм. Тэр дайны дараах үеэс 1980-аад оны хоорондох үеийг даруулгатай капитализмын бараг л “Алтан үе” байлаа хэмээн тодорхойлсон юм. (бараг л гэдэг үгээрээ тэр шүүмжлэх юмгүй гэсэн үг биш гэдэг санаагаа илэрхийлсэн.)

Роберт Райх үүнтэй холбогдуулан эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй, эдийн засагт эмэгтэйчүүд цөөнх байсан гэдгийг сануулсан байдаг. Дайны дараах үеийн барууны орнуудад үйлдвэрчний эвлэл, ажил олгогчид, засгийн газар нь зөвшилцөлд хүрснээр амьдралын стандартууд дээшилж нийгмийн доод стандартууд хангагдсан.

Үүнээс өмнөх жилүүдэд хэрэглэгдэж байсан “Laissez faire” буюу “төрийн оролцоогүй чөлөөт зах зээлийн эдийн засаг”-тай харьцуулахад асар том дэвшил байлаа. Даяаршсан эдийн засгийн “Суперкапитализм” -ын үед орлогын ялгаа дахин нэмэгдлээ. Ажилтнуудын эрх, нийгмийн стандартууд аюулд өртөж компаниудын нийгмийн хариуцлага суларч эхэллээ. Роберт Райх нь “Менежерийн магазин” сэтгүүл болон Томас Майертай төстэй “Зах зээлийн төвөөс зугатах хүчнүүд ардчиллын нэр хүндийг унагаж болзошгүй.” гэдэг дүгнэлтэнд хүрсэн байна. Роберт Райх зохицуулалт хийх, ажилтнуудын эрхийг хангах шаардлагуудыг хүчтэй болгох замаар зах зээлд ногдуулах нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй” гэж зөвлөсөн байдаг.

### 3.2. Зохицуулалттай ба зохицуулалтгүй капитализм

Энэхүү номын 2-р бүлэгт Смит, Маркс, Кенс нарын эдийн засагчдын онолын үндсэн дээр эдийн засгийн системүүдийн идеал хэв шинжүүдийг танилцуулсан билээ. Бодит ертөнц дээр олон төрлийн холимог хэв шинжүүд оршин байдаг. Петер А. Холл, Девид Соскисе

“Ардчилал ба капитализм” дахин олны анхаарлыг татах боллоо.

Суперкапитализм ба түүний үр дагавар

“Суперкапитализм” гэдэг үгийг даяаршлын нөхцөл дэх капитализмын хөгжлийг тодорхойлох зорилгоор Роберт Райх эдийн засгийн шинжлэх ухаанд нэвтрүүлсэн.

Зохицуулалтгүй ба зохицуулалттай капитализм

нар 2001 онд барууны аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад 2 үндсэн загвар байгааг тогтоож эдгээрийг “Varieties of Capitalism” буюу “Капитализмын хэв шинжүүд” номондоо зохицуулалтгүй ба зохицуулалттай капитализм гэж нэрлэсэн байна. Тэдний энэхүү үнэлгээ эдийн засгийн системүүдийн үнэлгээ, дүн шинжилгээнд томоохон хувь нэмрээ оруулсан.

Эдийн засгийн системүүдийн ялгааг дараах хамрах хүрээний дагуу тодорхойлсон байна:

- ~ Санхүүгийн систем
- ~ Хөдөлмөрийн харилцаа
- ~ Ерөнхий боловсрол - ба мэргэжлийн боловсролын систем
- ~ Компаниуд хоорондын харилцаа

### Зохицуулалтгүй капитализм

Либерал, зохицуулалтгүй капитализмыг дараах хамрах хүрээнүүдээр тодорхойлсон:

#### Санхүүгийн систем

Санхүүгийн систем: Компаниудын санхүүжилт зонхилон хөрөнгийн зах зээлээр (хувьцаагаар) дамжин хийгддэг. Энэ нь компаниуд “Shareholder -Value-Prinzip” буюу хувьцаа эзэмшигчдийн төлөө бүтээмжийг үйлдвэрлэх зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг. Хөрөнгийн эзэд аль болох түргэн хугацаанд өндөр ашиг олохын тулд эрсдэл өндөртэй компаниудад ч хөрөнгө оруулахад бэлэн байдаг.

#### Хөдөлмөрийн харилцаа

Хөдөлмөрийн харилцаа: Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь ихэвчлэн богино хугацаанд (hire and fire буюу авлаа-халагдлаа) үргэлжилдэг. Ажилтнуудыг ажлаас халагдахаас хамгаалах хуулийн хамгаалалт сул. Цалин хөлсний хэлэлцээр хувь хүмүүс ба компанийн хооронд эсхүл компанийн түвшинд хийгддэг. Ажил олгогчдын болон үйлдвэрчний эвлэлийн холбоод харьцангуй сул.

#### Ерөнхий боловсрол ба мэргэжлийн боловсролын систем

Ерөнхий боловсрол ба дээд боловсролын систем: Ихэвчлэн генералистуудыг бэлтгэдэг. Өөрөөр хэлбэл ихэвчлэн нийтлэг, ямар нэгэн нарийн мэргэжил олгох чиглэлээр бус ерөнхий мэдлэг, чадвар олгох сургалтуудыг явуулдаг. Үүнийгээ хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг нэмэгдүүлдэг, төрөл бүрийн мэргэжлийн дунд хөрвөх чадвар сайтай гэж тайлбарладаг ч нарийн мэргэжлийн боловсон

хүчний дутагдлыг бий болгодог сул талтай.

**Компаниуд хоорондын харилцаа:** Компаниуд хоорондын холбоос сул. (Жишээлбэл: Нэг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд нөгөө компанийн төлөөлөгч суулгах, мөн эсрэгээрээ гэх мэт харилцаа байдаггүй.) Мөн компаниуд хоорондын хамтын ажиллагаа сул. (Жишээлбэл: компаниуд судалгааны салбарт хамтарч ажилладаггүй.) Аж үйлдвэрийн салбарын холбоод нь компанийхаа лоббиг явуулахыг чухалчилдаг болохоос нийт нийгмийн өмнө үүрэг хүлээсэн актёрууд биш.

Уг систем нь зах зээлийн өөрчлөлтөнд хурдан бөгөөд уян хатан дасан зохицох чадвартай. Өөрөөр хэлбэл: Энэхүү үйлдвэрлэлийн загвар нь шинээр бий болж буй бүтээмж өндөртэй аж үйлдвэрүүдэд ээлтэй, харин ажилтнуудад илүү тогтворгүй, найдваргүй систем юм.

### Зохицуулалттай зах зээл

Зохицуулалттай зах зээл дараах хамрах хүрээгээр тодорхойлогддог:

**Санхүүгийн систем:** Санхүүжилт ерөнхийдөө банкны зээлээр дамжин хийгддэг. Энэ нь "Shareholder – Value - Modell"- буюу хувьцаа эзэмшигчдийн төлөө бүтээмжийг үйлдвэрлэдэг загвартай харьцуулахад илүү "тэвчээртэй" хөрөнгө тул удаан хугацааны дараа ашиг нь гарах салбарт хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлдэг. Гэхдээ компаниудын санхүүжилтийн энэ хэлбэр нь зах зээлд төдийлөн байр сууриа олоогүй, шинээр байгуулагдаж буй актёруудын санхүүжилтэнд хүрэх замыг бэрхшээлтэй болгодог. Компаниудын менежмент зах зээлээс гадна банк, ажилтнууд, төрийн актёруудын хяналтанд байж тэднээр үнэлүүлж байдаг. (Stakeholder-Modell)

**Хөдөлмөрийн харилцаа:** Цалингийн хэлэлцээр компани, аж ахуйн нэгжийн түвшинд бус харин секторын хэмжээнд явагддаг. (Нутаг дэвсгэрийн тарифын хэлэлцээр.) Хөдөлмөрийн харилцаа нь ихэвчлэн урт хугацаанд үргэлжилдэг. Тогтвортой байдал ба нийгмийн тэнцвэрт байдал эргэх холбоонд оршдог. Сайн зохион байгуулагдсан ажил олгогчид болон үйлдвэрчний эвлэлийн холбоодтой. Ажилчдын компанийн шийдвэр гаргалтанд оролцох оролцоо нь бодитойгоор хангагдсан байдаг.

Компаниуд хоорондын  
харилцаа

Санхүүгийн систем

Хөдөлмөрийн харилцаа

## Ерөнхий боловсролын сургууль ба мэргэжлийн боловсролын систем:

Дээд боловсролын сургалт нь компаниудын болон салбаруудын онцлогт тохирсон мэдлэг чадварыг олгодог. Ажилтнууд болон ажил олгогчдын тэргүүлэх холбоод мэргэжлийн боловсролын салбарын бодлогыг тодорхойлж байдаг. (Мэргэжлийн боловсролын дуал буюу хосолмол) системээр дамжуулан компаниуд- болон салбаруудын онцлогт тохирсон мэргэжлийн мэдлэг, чадварыг олгодог.

**Компаниуд хоорондын харилцаа:** Компаниудын хооронд хөрөнгийн харилцан оролцооны хэлбэрийн холбоос үйлчилдэг. Улс төрийн системд салбарын холбоод чухал үүрэг гүйцэтгэдэг. Зохицуулалтгүй капитализмтай харьцуулахад зохицуулалттай капитализмд тогтвортой сайн хангагдсан эдийн засгийн динамик болон уян хатан байдал сул байдаг. Уг системд нэгэнт бий болсон үйлдвэрлэлийн шугам болон процесс ихэвчлэн тогтвортой ажилладаг, зөвхөн бага хэмжээний хэсэгчилсэн өөрчлөлтүүд хийгддэг. Техник, технологийн шинэчлэлд тулгуурласан эдийн засгийн шинэчлэл жижиг алхмуудаар урагшилдаг. Шинээр асуудал тулгарахад уг систем зөвхөн удаанаар дасан зохицох чадвартай.

Эдгээр хоёр систем нь өөрийн гэсэн онцлог сөрөг болон эерэг талуудтай байдаг. Бүтээмж-болон өрсөлдөх чадварын хувьд нэг нь нөгөөгөөсөө зарчмын хувьд хол давуутай гэж хэлэх боломжгүй. Гэсэн хэдий ч дараах хоёр шалтгааны улмаас системийн ялгаатай талуудыг мэддэг байх нь мэдлэгт тустай:

1. Аналитик буюу задлан шинжлэхүйн түвшинд: Уг загварчлалын үндсэн дээр ямар учир шалтгааны улмаас төрөл бүрийн үйлдвэрлэлийн загварууд бий болдгийг тайлбарлаж болно. Ангелзахсений орнууд уян хатан хөдөлмөрийн зах зээлтэй, шинэ техник, технологи дээр суурилсан эдийн засгийн эрчимтэй үйлдвэрийн салбарт эрсдэлтэй хөрөнгө босгох боломж өндөртэй байдаг. Жишээлбэл: Мэдээллийн технологийн салбарт. Мэдээллийн технологийн салбарын тэргүүлэгч компаниуд болох Google, Microsoft, болон Start-up компанийн олон салбарууд АНУ-д үүссэн нь санамсаргүй тохиолдол биш юм. Зохицуулалттай капитализмтай Швед, Герман зэрэг орнууд өрсөлдөх чадвар хамгийн өндөртэй аж үйлдвэрүүд болох автомашины үйлдвэр, үйлдвэрлэлийн машины үйлдвэрүүдтэй. Зохицуулалттай зах зээлтэй орнуудад маш их хөрөнгө

шаардагддаг учраас удаан хугацааны төлөвлөлт шаарддаг бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг. Эдгээр аж үйлдвэрүүдэд техник технологийн үндсэн шинэчлэл хийгддэггүй ч байнгын хэсэгчилсэн сайжруулалт явагдаж байдаг. Эдгээр хүчин зүйлсийн улмаас компанидаа удаан хугацаагаар тогтвортой ажилладаг өндөр мэргэшсэн ажиллах хүчинтэй, “тэвчээртэй” хөрөнгө босгох боломж нь нээлттэй орнууд дээрх үйлдвэрүүдэд байршлын давуу талуудыг бүрдүүлдэг.

2. Норматив өнцгөөс харахад дээрх хоёр загварууд нь хоорондоо ялгаатай. Зохицуулалттай капитализмтай орнуудад нийгмийн ардчиллын үнэлэмжүүдийг хэрэгжүүлэхэд илүү дөхөмтэй байдаг. Хөдөлмөрийн харилцаа нь ихэвчлэн удаан хугацаагаар үргэлжилдэг тул “Hire-and fire буюу авлаа-халагдлаа” хөдөлмөрийн зах зээлтэй харьцуулахад ажилтнуудад илүү найдвартай байдлыг бүрдүүлдэг. Нөгөөтэйгүүр удаан хугацааны дараа ашгаа өгөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг компаниудад тааламжтай нөхцөлүүдийг бүрдүүлдэг, богино хугацаанд өндөр ашиг олох дарамтанд байдаггүй учраас хөдөлмөрийн ертөнц нь илүү тогтвортой байдаг.

Норматив түвшин

**Нийгмийн баримжаат зах зээл:** Зохицуулалттай капитализмын герман хувилбар нь дайны дараах үеэс “Нийгмийн баримжаат зах зээл” эсхүл ХБНГУ-ын засгийн газар дайны дараа Райн мөрний эрэг дээрх Бонн хотноо төвлөрч байсан тул “Райны капитализм” гэдэг ойлголтоор төлөвшсөн байна. Нийгмийн баримжаат зах зээл нь нэг талаас аж үйлдвэржилтийн эрин үеийн нийгмийн эрсдэлүүдийн эсрэг үзүүлсэн хариу үйлдэл, нөгөө талаас үндэсний социалистуудаас айсан айдсаас үүдэлтэй байлаа. Нийгмийн баримжаат зах зээл нь хазааргүй хүлэг мэт жолоодлогогүй капитализм, социалист эдийн засгийн дэглэм хоёрын дундуур гуравдагч замаар замнах гэсэн оролдлого юм. Социалист эдийн засгийн дэглэм нь дайны дараах үед чамлахааргүй хүчтэй байлаа. Дайны дараа батлагдан гарсан германы шинэ үндсэн хуулиар ямар нэгэн эдийн засгийн дэглэмийг байгуулах зорилтыг тавиагүй юм. Үндсэн хуулийн 15-р зүйлд үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэмшүүлэх боломжтой гэж заасан юм. Улс төрийн намууд ч зарим талаар капитализмыг шүүмжилсэн байр суурийг баримталж байлаа. Христосын Ардчилсан Холбоо Намын Нордрайн-Вестфален муж улсын холбоо 1947 онд батлагдсан Аахены хөтөлбөртөө “Христын социализмын төлөө байна” хэмээн зорилгоо тодорхойлж байлаа. ГСДН үндсэн бодисын аж үйлдвэрүүдийг төрийн мэдэлд шилжүүлэхийг шаардаж байлаа. Тэгэхлээр нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг нь германы ард иргэдийг зах зээлийн эдийн засаг ба ардчилалд итгүүлэх гэсэн оролдлого байсан юм.

Эдийн засагч Алфред Мюллер-Армак нийгмийн баримжаат зах зээлийн хөтөлбөр ба ойлголтын гол төлөөлөгч бөгөөд “Эдийн засгийн жолоодлого ба зах зээлийн эдийн засаг” бүтээлдээ: “Эдийн засгийн бодлогын гуравдагч хэлбэрийг тодорхойлохын тулд бид “Нийгмийн баримжаат зах зээл” гэж ярьж байна.

“... Зах зээлийн эдийн засаг нь ирээдүйн эдийн засгийн дэглэмийн тулгуур багана байх

болно гэж ойлгож байгаа учраас зөвхөн өөрийн гольдролоор хөгжих либерал зах зээлийн эдийн засаг бус харин ухамсартайгаар удирддаг, тэр ч байтугай нийгмийн тусын тулд удирддаг зах зээлийн эдийн засаг байх ёстой.” тул нийгмийн баримжаат зах зээлийг байгуулахыг зорьж байгаа юм.” гэж тайлбарласан байдаг.  
(Мюллер Армак 1947 он, 88-р тал)

Тодорхой хэлэх юм бол нэг талаас өрсөлдөөн, чөлөөт үнэ, үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчийг хангаж нөгөө талаас нийгмийн даатгал, татварын ачааллыг орлого нэмэгдэхийн хэрээр нэмэгдүүлэх замаар нийгмийн тогтвортой байдлыг хангана гэсэн санаа юм. Ингэхдээ төрийн үүргийг тодорхой заагаагүй. ХБНГУ байгуулагдсан эхний жилүүдэд зах зээлд оролцох төрийн оролцоог хязгаарладаг байлаа. Жишээ нь: Монополь бий болохоос сэргийлэх нь төрийн үүрэг байлаа. 1970-аад оноос эдийн засгийн сэргэлтийг удирдах хөтөлбөрүүд болон бусад хөтөлбөрүүдийн нөлөөгөөр төрийн эдийн засагт нөлөөлөх нөлөө нэмэгдсэн байна.

Эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг өсөн тэлж буй нийгмийн баримжаат төртэй холбож чадсан учраас райны капитализм дэлхий дахины анхаарлыг татаж эхэлжээ. Европын бусад орнууд уг загварыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах болсон юм. Европын үндсэн хуулийн төслийн 1-3 зүйлд Европын Холбооны зорилтыг нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийг байгуулах явдал гэж тодорхойлсон юм.

Людвиг Эрхардын “Бүх хүнд хангалуун чинээлэг амьдрал”-ыг амалсан амлалт нь 1970-аад оны газрын тосны хямрал, хоёр Герман улс нэгдсэнээс үүдэлтэй нэн ялангуяа хөдөлмөрийн зах зээл дээр шинэ хэлбэрийн нийгмийн асуудлууд үүссэнтэй холбоотойгоор хүн бүрийн амьдралд бодитойгоор хэрэгжиж чадаагүй юм. Харин шинэ залуу ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн өргөн хүрээтэй дундаж давхаргыг бий болгож чадсан юм.

Уг ойлголт олноо ихэд таалагдсан учраас өдгөө хүмүүсийн дуртай хэрэглэдэг хэллэг болсон юм. Роршахын сорил шиг дурын хөтөлбөрүүдийг уг ойлголт дээр тулгуурлах болсон байна.

Германы үйлдвэрчний эвлэлийн мөрийн хөтөлбөрт нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийг “түүхэн том дэвшил” гэж тодорхойлсон байдаг. Бүх металлын ажил олгогчдын холбооноос “Нийгмийн баримжаат зах зээлийн шинэ санаачилга” нэртэй байгууллагыг үүсгэн байгуулсан. Энэ хооронд улс төрийн бараг бүх урсгал нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг дээр суурилдаг ч нийгмийн бодлогын тэнцвэр, зохицуулалт ба зах зээлийн эдийн засгийг маш олон янзаар тайлбарладаг.

### 3.3 Даяаршлын эрин үеийн шинэ ерөнхий нөхцөлүүд

“Дэлхий хавтгай болсон” гэдэг нэртэй ном 2006 онд хэвлэгдэн гарсан юм. Энэ зүйрлэлээр ямар утгыг илэрхийлэхийг зорив оо? Уг номын зохиогч Томас Фридман даяаршлын улмаас дэлхийн эдийн засгийн өрсөлдөөн дэлхий дахинд эрс хурцадсан байдалтайгаар шинэ эрин үеийн босгыг алхан орлоо гэдэг санаагаа илэрхийлсэн юм.

Улс орнуудын улс ардын аж ахуй гадаад ертөнцөөс тусгаарлан бие

Даяаршилын улмаас  
“Дэлхий хавтгай болсон”

Даяаршлын хөдөлгөгч  
хүчнүүд

даан хөгжих бололцоогоор маш хомс. Дэлхий дахинд өрсөлдөөн нэгэн хавтгай дээр явагдах болсон. Фридман даяаршлын олон хөдөлгөгч хүчнүүдийг нэрлэсэн:

~ 1950-аад оноос хойш олон улсын хэлэлцээрүүдийн үр дүнд худалдааны саадуудыг алхам алхмаар зайлуулсан. Дэлхийн худалдааны байгууллага (WTO) түүний өмнөх байгууллага (GATT) –ын байгуулсан хэлэлцээрүүдийн үр дүнд гаалийн татвар буурч импортын хязгаарлалтуудыг хүчингүй болгосон. 1970-аад оноос хойш улс орнуудын мөнгөн тэмдэгтүүдийн хөрвөх ханш харьцангуй чөлөөтэй болсон. Европын Холбоо болон NAFTA (АНУ, Канад, Мексик) –ын бүс нутгийн чөлөөт худалдааны бүсүүдэд худалдааны бараг бүх хязгаарлалтуудыг чөлөөлсөн. Латин Америкийн Мерсосурын Холбоо болон Зүүн өмнөд азийн ASEAN холбоо дээрхтэй адил төстэй нөхцөлүүдийг бүрдүүлэхийг зорьж байна.

~ Өмнө нь Европ, АНУ, Япон дэлхийн зах зээл дээр давамгайлах хүчнүүд байсан бол шинээр олон орнууд дэлхийн зах зээл дээр гарч ирсээр байна. 1970-аад оноос хойш Хятад улс өмнө нь гадаад ертөнцөөс тусгаарлаж байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаа дэлхийн зах зээл болон зах зээлийн эдийн засагт улам бүр нээлттэй болгосоор байна. Үүний үрээр эдийн засгийн өсөлт нь эрс нэмэгдэж дэлхий дахины экспортлогч гүрнүүдийн дунд Германы дараа хоёрдугаар байрыг эзэлж байна. 1989 оны өөрчлөлтийн дараагаар хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд болон Зүүн Европ зах зээлийн эдийн засагт шилжиж дэлхийн худалдаанд өрсөлдөж байна. Үүний дараахан Энэтхэг, гадагшаа хаалттай, хүчтэй зохицуулалт бүхий зах зээлээ либералчилж эхэлсэн юм. Мөн эдийн засгийн либералчлалаа Хятадын эдийн засгийн өсөлттэй уялдуулж эхэллээ. Ингэснээр хоёр тэрбум хүн шинээр дэлхий дахины өрсөлдөөнд орж ирлээ.

~ Техникийн шинэчлэл дээрх хоёр бодлогоор зохицуулах процессыг улам эрчимжүүлсэн юм. Шилэн кабелийн техник нэвтэрснээр олон улсын телефон ярианы үнийг секундыг хэд хуваасны өртөгтэй тэнцэх хэмжээнд бууруулж Энэтхэгийн утсаар ярих төвүүд АНУ-аас дуудсан дуудлагыг төвөггүй хүлээн авах бололцоотой болсон юм. Интернетээр дамжуулан захиалгыг секундын дотор Хамбургаас Шанхайд дамжуулах бололцоо бүрдлээ. Парис хотноо байрлах

1. Худалдааны саадыг зайлуулсан.

2. Босгоноос доогуур байсан орнуудын эзлэх байр дээшилсэн.

3. Техникийн шинэчлэл

компанийн хэрэглэх компьютерийн программыг энэтхэгийн Вангалоре хотноо боловсруулах боллоо. Нягтлан бодох төвийг Лондонгоос Прагад шилжүүлэх бололцоотой боллоо. Орчин үеийн логистик (тээвэр, холбоо) эд ангиуд нь дэлхий ертөнцийн олон өнцөгт үйлдвэрлэгддэг иж бүрэн үйлдвэрлэлийн сүлжээнүүдийг байгуулж нэгтгэн угсраад дэлхийн өнцөг булан бүрт худалдаалах бололцоог бүрдүүллээ. Усан онгоцоор тээвэрлэх тээвэрлэлтийн зардал буурч нисэх онгоцоор аялах нь тансаг хэрэглээний ангилалд багтдагаа болилоо.

*Мэдлэгт суурилсан эдийн засагтай орнууд даяаршлаас хожигсад байх болно.*

Даяаршлаас хэн хожих бэ? Мэдлэгт суурилсан эдийн засагтай орнууд хамгийн ихээр хожиж (ашиг олж) байна. Мэдлэгт суурилсан эдийн засаг гэж судалгаанд нь их хөрөнгө оруулалт шаарддаг эдийн засгийн салбаруудыг сайн хөгжүүлж чадсан, дэлхийн зах зээлийг асар том хэмжээний борлуулалтын зах зээл болгон эзэгнэж чадсан орнуудыг хэлнэ. Ямар учраас тэр бэ? iPod –ын судалгааны зардал асар өндөр ч гэлээ нэгж бүтээгдэхүүнд ноогдох өртөг харьцангуй хямд тул олон саяар нь дэлхийн зах зээл дээр борлуулдаг. Тодорхой газар нутгаар хязгаарлагдсан зах зээлтэй байх нөхцөлд судалгааны өндөр өртгийг нөхөх бололцоогүй юм. Компютерийн программ, нэг ширхэг дууны эсхүл киноны хуурцагийг нэг л удаа үйлдвэрлэсэн бол борлуулалтын зах зээл том байх тусмаа авчрах ашиг нь өндөр байна.

*Өндөр өртөгтэй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдэд даяаршлын нөлөөлөх нөлөө.*

Зохион бүтээлтийн өртөг өндөртэй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдэд нэгэн адил нөлөөлнө. Автомашины шинэ загварыг таваас арван жилийн урт хугацаанд өндөр өртөгтэйгээр зохион бүтээдэг. Хийн хөдөлгүүр зэрэг шинэ технологүүд шинээр үйлдвэрлэгдсэн машинуудын борлуулалтын зах зээл том байх нөхцөлд л ашгаа өгнө. Шинэ технологийн хөгжилд асар их хөрөнгө оруулалтыг хийдэг Япон, Германы автомашин үйлдвэрлэгчид даяаршлаас асар их ашиг олсон. Ерөнхийд нь дүгнэхэд мэргэжлийн боловсролын түвшин өндөртэй, судлаачид, оюуны бүтээлч хөдөлмөрийг өндөр үнэлдэг орнууд даяаршлаас хожигсад болж байна.

*Даяаршлын бөөнөөр үйлдвэрлэгдэг бүтээгдэхүүнүүдэд нөлөөлөх нөлөө.*

Харин даяаршил бөөнөөр буюу үй олноор нь үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнүүдэд өөрөөр нөлөөлж байна. Нэхмэл цамц үйлдвэрлэдэг фабрикийн үйлдвэрлэлийн өртөг үйлдвэрлэлийн хэмжээ өсөхийн хэрээр нэмэгддэг. Ажилтнуудын мэргэжлийн өндөр ур чадвар, дэд бүтцийн хөгжлийн улмаас бий болдог өрсөлдөөний



давуу талууд үйлдвэрлэхэд хялбар, судалгаа болон шинэ технологийн хөгжилд төдийлөн үүрэг гүйцэтгэдэггүй бүтээгдэхүүнүүдэд бараг нөлөөлдөггүй. Иймээс бөөнөөр үйлдвэрлэдэг үйлдвэрүүд нүдний өмнө өндөр цалинтай орнуудаас бага цалинтай орнууд руу алга болж байна. Нэхмэлийн үйлдвэр өмнө нь Европын хамгийн томд тооцогдох салбарын нэг байлаа. Гэтэл одоо нэртэй дизайнеруудын загварын институт төдийхөн энд тэндэхийн буланд үлдсэн байна. Бөөний үйлдвэрлэл Энэтхэг, Бангладеш, Хятад зэрэг орнууд руу шилжсэн байна.

Энэ нь мэдлэгт суурилсан эдийн засагтай орнууд буюу шинэ технологийн хөгжил, оюуны бүтээлч хөдөлмөрийг өндөр үнэлдэг орнууд мөн хямд өртгөөр бөөний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орнууд хоёулаа ашиг олох боломжтой гэсэн үг юм. Энэ нь ч амьдрал дээр биелэлээ олсон. Герман дэлхийн худалдаанд тэргүүлэгч экспортлогч гүрний хувьд өндөр өртөгтэй автомашинууд, тоног төхөөрөмжээ дэлхий дахинд экспортлож байна. Итали болон францын дизайнерууд тансаг хэрэглээний хувцсыг дэлхий дахинд гаргаж байна. Америкийн программ хангамжийн компаниуд Microsoft, Google фирмүүдийн бүтээгдэхүүн Хятад, Орос улсад эх нутгаасаа дутахгүй эрэлт хэрэгцээтэй байна. Нөгөө талаар мэдлэгт суурилсан эдийн засагтай орнууд хямд өртгөөр бөөнөөрөө үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүнүүдийн импортоос ашиг олж байна. Талх шарагч, оймс, IKEA-мебель зэрэг Хятад, Зүүн Европ болон бусад цалингийн зардал багатай орнуудад үйлдвэрлэгдэж байгаа бүх бүтээгдэхүүнүүд өнгөрсөн хорин жилийн хугацаанд аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудын худалдан авах чадвартай харьцуулахад хямдарсан байна.

### **Аливаа хөгжил бүхэнд сөрөг талууд байдаг:**

1. Нийгмийн бүх гишүүд даяаршлаас ижил хэмжээгээр хождоггүй. Олон хүмүүс огт хожихгүй байхад зарим нь зохих ёсоор хожиж байна. Европын нэхмэлийн фабрикт ажиллаж буй ажилтан фабрик нь бага цалинтай орнуудад шилжиж үйлдвэрлэлээ явуулахаар хааж байхад хөрш мэдээллийн технологийн компани захиалгаа дийлэхгүй байгааг хараад баярлах нь юу л бол. Хангалуун амьдралын түвшин өмнө нь чинээлэг байсан орнууд болон хөгжиж буй орнуудын хувьд бүхэлдээ дээшилсэн. 1990-ээд оноос хойших хорин жилийн дотор дэлхий дахинд эдийн засгийн өсөлт урьд өмнө байгаагүйгээр нэмэгдсэн. Зөвхөн Хятадад 1970-аад оноос хойш дөрвөн зуун сая

*Даяаршлын давуу талууд*

*Даяаршлын сүүдэртэй талууд*

*Орлогын ялгаа улам бүр нэмэгдэж байна.*

хүний амьдрал НҮБ-аас тодорхойлсон туйлын ядуурлын түвшингээс дээшилсэн байна. Зарим хэсгийнх нь хөдөлмөр эрхлэлтийн харьцаа туйлын хүнд байгаа ч гэсэн. Үүний зэрэгцээгээр хангалуун амьдралын хувиарлалт урьд өмнө хэзээ ч байгаагүй хэмжээгээр тэгш бус байдалтай болсон байна. Нэн ялангуяа хөгжиж буй орнуудад, мөн хангалуун амьдралтай орнуудад ч орлогын ялгаа улам бүр нэмэгдсээр л байна.

Олон улс даяар  
дагаж мөрдөх  
нийгмийн стандартууд  
боловсруулагдаагүй  
байна.

2. Дэлхийн худалдааны либералчлал нь олон арван жилийн туршид явагдаж буй хөшүүн процесс юм. Тийм ч учраас зохицуулалтууд нь улам бүр хумигдаж буй “сөрөг даяаршил” нь “**эерэг даяаршлын**” процессоос хамаагүй хурдан явагдаж байна. Эерэг даяаршил нь шинээр, шаардлагатай болж буй стандартуудыг нэвтрүүлэх тухай ойлголт юм. Жишээлбэл: Уур амьсгалыг хамгаалах тухай Киотогийн протоколд өдгөө 15 жилийн дараа ч дэлхийн бүх улс орнууд элсэн ороогүй байна. Элсэн орсон улс орнууд ч уг протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна. Дэлхий дахинаа мөрдөх ёстой нийгмийн стандартууд жишээлбэл Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас боловсруулан гаргасан ажилтнуудыг хамгаалах нормууд хууль мэт дагаж мөрдөгдөхгүй байна. НҮБ-аас батлан гаргасан нийгмийн болон эдийн засгийн үндсэн эрхүүдийн тунхаглалуудыг олон улсын эрхзүйн хүрээнд дагаж мөрдөх ёстой ч бодитоор заавал хэрэгжүүлэх зааварчилгаа болж төдийлөн чадаагүй юм. Эдгээр үндсэн эрхүүдийг бодитоор хэрэгжүүлэх хүртэл урт замыг туулах хэрэгтэй болох нь.

Өрсөлдөөний дарамт  
нийгмийн – болон  
байгаль орчны  
стандартуудыг  
бууруулахыг шаардаж  
байна уу?

Даяаршлын сэтгэл зовоож байгаа нэг зүйл нь “**race to the bottom**” буюу хамгийн доогуур нийгмийн-болон байгаль орчны стандартуудыг тавихын төлөө өрсөлдөж буй явдал юм. Харин энэ өрсөлдөөнийг няцаах нотолгоо бол нийгэм болон байгаль орчны стандартуудыг хамгийн өндөрт тавьдаг орнуудын улс ардын аж ахуй өрсөлдөх чадвараар хамгийн өндөрт байдаг. Үүний жишээ бол татвараар санхүүждэг үлгэр жишээ болохуйц байгаль орчны хатуу стандартуудтай, дэлхий дахинд хамгийн өргөн хүрээтэй хүний сайн сайхны төлөө системүүдийг байгуулж чадсан скандинавын орнууд юм.

Скандинавын орнуудын  
эсрэг жишээ

Өндөр өртөг заавал өрсөлдөөнд саад болох албагүй гэдгийг Финланд, Швед, Норвеги, Дани зэрэг шилдэг боловсролын систем, судалгааны өндөр бүтээмж, дээд зэрэглэлийн дэд бүтэц, үр өгөөжтэй хээл хахуулиас ангид захиргааны бүтэцтэй, нийгмийн энх тайвныг хангаж чадсан орнууд харуулж байна. Өндөр хөгжилтэй нийтийн

сайн сайхны төлөөх төр нь нээлттэй зах зээлийн нөхцөлд ч өрсөлдөх чадвар, хангалуун амьдралыг дэмжиж чаддаг. Гэхдээ энэ нь тодорхой нөхцөлүүд биелэгдсэн байхыг шаарддаг: Хэрэв бүх орон өртгөөсөө илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлээд эхэлбэл даяаршлаас хохирох болно. Эцэст нь хэлэхэд хамгийн өндөр стандартуудтай орнууд даяаршлаас хамгийн ихээр хожих болно. Энэ нь стандартаа хатуу тогтоочихбол автоматаар ашиг нэмэгдэнэ гэсэн санаа биш юм.

Даяаршил нийгмийн ардчилалд ямар шаардлагуудыг тавьж байна бэ?

- ~ Капитализм ба ардчилал нь хоорондоо нягт холбоотойгоор үүссэн.
- ~ Капитализм нь ардчиллыг доройтуулдаг тэгш бус байдлыг бий болгодог. Тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх арга замыг нийгмийн ардчилал олох ёстой.
- ~ Зохицуулалттай капитализм нь нийгмийн ардчиллыг хөгжүүлэхэд илүү давуу талтай загвар юм. Зохицуулалттай капитализм нь зохицуулалтгүй капитализмтай харьцуулахад нийгмийн тэнцвэрт байдлыг илүү хангаж чадсан, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь урт хугацаанд үргэлжилдэг эдийн засгийн дэглэм юм.
- ~ Даяаршил нь дэлхий дахинд эдийн засгийн дэвшил, өндөр хурдацтай өсөлтийг авчирсан юм. Гэхдээ шинэ хэлбэрийн нийгмийн асуудлуудыг авчирсан юм.

## 4. НИЙГМИЙН АРДЧИЛЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА

Энэхүү бүлэгт:

- ~ Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тодорхойлно.
- ~ Нийгмийн ардчиллын үнэт зүйлс болох Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдэл -ийг нэрлэнэ.
- ~ Үндсэн эрхүүдийг тодорхойлно. Нийгмийн ардчилал үндсэн эрхүүдийг бодит нөлөөтэй байлгах, хангах нөхцөлүүдийг бүрдүүлэхийг зорьдог.
- ~ Эцэст нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг тодорхойлогч тогтвортой байдал, нийгмийн тэнцвэрт байдал, эдийн загийн хурдацтай хөгжлийн зарчмуудыг танилцуулна. Нийгмийн ардчилал нь үнэт зүйлс, үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэхийг зорьдог тул дээрх зарчмууд дээр тулгуурласан эдийн засгийн бодлогыг явуулах ёстой.

### 4.1. Үнэт зүйлс

Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдэл нь нийгмийн ардчиллын үндсэн үнэт зүйлс мөн. Нийгмийн ардчилал нь эдгээр үнэлэмжүүд хэрэгжсэн нийгмийг байгуулахыг зорьж байна. Нийгмийн ардчиллын эдгээр үнэт зүйлс нь ач холбогдлын хувьд эн тэнцүү, нэг нь нөгөөгийнхөө хэрэгжих нөхцөлийг бүрдүүлдэг харилцан шүтэлцээтэй бөгөөд харилцан бие биенээ дэмжиж, мөн хязгаарлаж байдаг.

Нийгмийн ардчиллын үнэт зүйлсийг “Нийгмийн ардчиллын үндсүүд” сурах бичигт дэлгэрэнгүй тодорхойлж, тэдгээрийн үүсэл, ач холбогдлыг тодорхой тайлбарласан учраас энэ дэвтэрт товч тодорхойлолтуудыг өгөх болно.

Эрх чөлөөг эдэлнэ гэдэг нь яаж амьдрахаа өөрөө шийдэх эрхтэй байна гэсэн үг юм. Энэ нь нэн түрүүнд төр болон нийгмийн зүгээс хүссэнээрээ хүний эрхэнд халдахгүй байх эрх чөлөө юм. Гагцхүү эрх чөлөөгөө эдлэхэд шаардагдах эдийн засаг болон нийгмийн нөхцөлүүд хангагдсан нөхцөлд л эрх чөлөө жинхэнэ утгаараа хангагдана.

Эрх чөлөө, шударга ёс,  
эв санааны нэгдэл

Эрх чөлөө: Яаж  
амьдрахаа өөрөө  
шийдэх эрх

Шударга ёс нь бүх хүмүүсийн хүний ёсоор амьдрах нөхцөлийг хангах үндэс бөгөөд хүн бүр хуулийн өмнө тэгш байхыг шаардаад зогсохгүй хүн бүрт нийгмийн баялаг, нийгмийн хамгааллаас гэр бүлийн байдал, нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, хүйсээс үл хамааран тэгш хувь хүртээхийг шаарддаг.

Эв санааны нэгдэл нь нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгнийхээ төлөө байж харилцан туслалцахад бэлэн байдлыг илэрхийлдэг. Социалдемократ Ёоханнес Рау эв санааны нэгдэл бол нийгмийг тогтоон барьж байдаг цавуу юм гэж хэлсэн байдаг.

Дээрх гурван үнэт зүйлс нь их сонирхолтой түүхтэй. Эдгээр нь соён гэгээрлийн үеэс эхтэй. Эхэн үедээ хувьсгалч урианы нэг байлаа. “Эрх чөлөө, Тэгш байдал, Ахан дүүсийн ёс” гэдэг шаардлагууд нь 1789 оны францын хувьсгалыг тодорхойлж байлаа. 18-р зууны дунд үеэс хойш удаа дараагийн ажилчны хөдөлгөөнүүд дээрх шаардлагуудыг тавьдаг байлаа. Фердинанд Лассаллийн удирдлага дор 1863 онд ГСДН-ын үндсийг тавьж эхлэхдээ ажилчид далбаан дээрээ “ Эрх чөлөө, Тэгш байдал, Ахан дүүсийн ёсон” гэдэг шаардлагуудыг хатгаж байлаа. ГСДН нь 1959 оны Годесбергийн мөрийн хөтөлбөртөө “Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдэл”-ийг тунхагласан германы анхны улс төрийн нам юм. Хорин жил орчмын дараагаар 1978 онд Христосын Ардчилсан Холбоо Нам анхны мөрийн хөтөлбөртөө хэдийгээр харилцан адилгүй ойлголт дээр суурилсан ч гэсэн эдгээр гурван үнэт зүйлсийг тунхагласан юм.

Өдгөө эдгээр гурван үнэт зүйлс хувьсгалч хөдөлгөөнүүдийн шаардлага байхаа больж харин улс төрийн нөлөө бүхий бүх хөдөлгөөнүүд бүгдээрээ хүлээн зөвшөөрсөн байна. Бүгдээрээ хүлээн зөвшөөрсөн учраас бүх улс төрийн намууд “Эрх чөлөө, Шударга ёс, Эв санааны нэгдэл” гэдэг үнэт зүйлсийн хувьд нэгдсэн зөвшилд хүрсэн гэж үзэх нь үнэнд нийцэхгүй.

Улс төрийн урсгалуудын хооронд үнэт зүйлстэй холбоотой ялгаа дараах хоёр түвшинд байсаар байна:

### 1. Үнэт зүйлсийн тухай ойлголтууд

Үнэт зүйлс тус бүрийг өөр өөрөөр тайлбарлах боломжтой. Жишээлбэл: Эрх чөлөөний тухай ойлголт хүн бүрт адилгүй байдаг. Либерал урсгалууд сөрөг эрх чөлөө гэж нэрлэгддэг төрийн зоргоороо авирлахаас хувь хүнийг хамгаалах эрхүүд, хувийн өмчийн баталгааг

*Шударга ёс: Хувь хүртэх болон аюулгүй байдал*


*Эв санааны нэгдэл: Нэг нь нийтийнхээ төлөө, нийт нь нэгнийхээ төлөө*

*Түүхэн эх сурвалж*

**Бусад эх сурвалжууд:**  
Товиас Гомберт  
(2008 он) Нийгмийн ардчиллын үндсүүд,  
Нийгмийн ардчиллын сурах бичиг .1-р дэвтэр Бонн хот, 9-43 хуудас

*Үнэт зүйлсийн тайлбаруудын зөрүүтэй байдал*

онцгойлон чухалчилж үздэг бол нийгмийн ардчилал илүү өргөн хүрээнд зөвхөн хамгаалах эрхийг хангаснаар эрх чөлөө бодитойгоор баталгааждаггүй, харин хүмүүсийн материаллаг байдал тодорхой түвшинд хангагдсан нөхцөлд хангагдах боломж нь нээгддэг эерэг эрх чөлөөний эрхүүдийг нэгэн адил хангах нь шийдвэрлэх ач холбогдолтой гэж үздэг. Нийгмийн ардчиллын онолын үүднээс бодит эрх чөлөө нь жишээлбэл: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбон авч үзвэл иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хуулиар баталгаажуулах нь хангалтгүй, харин иргэн бүрт чанартай боловсрол олгох замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ бодитойгоор өөртөө ашигтайгаар хэрэглэх боломжоор хангах ёстой гэж үздэг.



Зураг 5. Сөрөг болон эерэг эрх чөлөөний эрхүүд

## 2. Үнэт зүйлс хоорондын харьцаа

Үнэт зүйлс тус бүрийн тайлбар төдийгүй тэдгээрийн хоорондын харьцаа чухал ач холбогдолтой. Үнэт зүйлсийг тэгш эрхтэйгээр авч үзэх үү? Эсхүл аль нэгэн үнэт зүйлст илүү ач холбогдол өгөх үү? гэдэг нь асар том ялгаатай. Үүнийг улс төрийн либерализмын нэгэн жишээн дээр тайлбарлая. Либерал үнэт зүйлсийн ойлголтонд эрх

Үнэт зүйлсийн ач холбогдлыг өөр өөрөөр үнэлдэг.

чөлөө хамгийн чухал үнэлэмж байдаг. Эрх чөлөө, өрсөлдөөний эрх чөлөө, эсхүл өмчтэй байх эрх чөлөөнд ерөнхийдөө шударга ёсны хэрэгжилтээс илүү ач холбогдол өгдөг. Учир нь шударга ёс өмчтэй байх эрх чөлөөг хязгаарладаг гэж үздэг. Нийгмийн ардчилал аль нэгэн үнэт зүйлд бусдаас илүү ач холбогдол өгдөггүй. Нийгмийн ардчилал бүх үнэт зүйлст эн тэнцүү ач холбогдол өгөхийг чухалчилдаг.

Энэ нь: Германы улс төрийн нөлөө бүхий бүх урсгалууд Эрх чөлөө-Шударга ёс-Эв санааны нэгдэл гэдэг гурван үнэт зүйлс дээр суурилдаг ч бодит байдал дээр эдгээрийн цаана ихэвчлэн харилцан адилгүй ойлголттой байдаг.

#### 4.2. Үндсэн эрхүүд

Үнэт зүйлс нийгмийн ардчиллын эдийн засгийн чиг хандлагыг тогтооход ямар ач холбогдолтой юм бэ? гээд бодохлоор хоёр асуудал гарч ирдэг.

1. Үнэт зүйлсийн талаархи маргаан эцэс төгсгөлгүй. Улс төрийн өөр өөр урсгалууд, өөр өөр соёлууд үнэт зүйлсийн цаана өөр өөр агуулгыг төсөөлдөг. Тэгэхлээр үнэт зүйлс нь эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тогтоох өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг үндэслэл болж чаддаггүй.

2. Үнэт зүйлс маш өндөр хийсвэр түвшинд хэрэглэгддэг. Эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлох ёстой юм бол маш тодорхой суурьтай байх ёстой. Үнэт зүйлс нь эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тогтоох нарийн тодорхой үндэслэл болоход дангаараа хангалтгүй.

Нийгмийн ардчиллын үнэт зүйлс нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг тодорхойлоход чухал ерөнхий хүрээг тогтоож өгдөг. Энэхүү хүрээг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавал биелэгдэх үндэслэл дээр суурилж нягт нямбай, тодорхой шаардлагуудаар дүүргэж өгөх ёстой.

Дээрх шаардлагуудыг нийгмийн ардчиллын өмнөх үеийн сэтгэгчид судалсаар ирсэн. Улс төрийн шинжлэх ухааны эрдэмтэн Томас Майер болон бусад эрдэмтэд дээрх шаардлагад "Нийгмийн ардчилал нь

*Үнэт зүйлс дээр тулгуурлан эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тогтооход хоёр асуудал тулгардаг.*

*Үнэт зүйлсийн талаарх төгсгөлгүй маргаан*

*Үнэт зүйлс нь маш хийсвэр ухагдахуунууд мөн.*

*Харьцуулалтын цэг: НҮБ-ын хүний эрхийн пакт*

Олон соёл болон улс  
орнуудыг хамарсан  
байдал:

Тодорхой бөгөөд  
ойлгомжтой

1966 он: НҮБ-ын  
хоёр пакт

зөвхөн үнэт зүйлс дээр суурилоод зогсохгүй үндсэн эрхүүд дээр суурилах ёстой” гэдэг саналыг дэвшүүлсэн юм. Майер нь нийгмийн ардчиллын онолын харьцуулалтын үндсэн цэг юу бэ? гэдэг асуултанд НҮБ-ын хүний эрхийн пактаар тодорхойлогдсон үндсэн эрхүүдийг нэрлэсэн байдаг. “Нийгмийн ардчиллын үндсүүд” сурах бичигт энэ талаар дэлгэрэнгүй тайлбар өгсөн.

Олон үндэслэлүүд нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын чиг хандлагыг тодорхойлохдоо НҮБ-ын пакт дээр суурилах нь зүйтэй гэдгийг баталж байна.

~ НҮБ -ын пактууд нь дэлхий дахинд хамгийн түгээмэл, хуульчлагдсан, олон соёл, улс орнуудыг хамарсан үндсэн эрхүүдийн эх сурвалж тул хүмүүсийн хамтын амьдралын эх сурвалж мөн.

~ НҮБ-ын пактууд хүн нэг бүрийн эдийн засгийн эрхүүдийг маш ойлгомжтой бөгөөд тодорхой томъёолсон байдаг.

Ийм ч учраас НҮБ-ын пактаар тодорхойлогдсон үндсэн эрхүүдийг илүү нарийн тодорхойлж эдгээр нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогод ямар ач холбогдолтой бэ? гэдгийг болон нийгмийн ардчилал үндсэн эрхүүд дээр суурилснаараа бусад улс төрийн урсгалуудаас юугаараа ялгарах бэ? гэдгийг тодорхойлох хэрэгтэй юм.

1966 онд НҮБ нь хүний эрхийн тухай хоёр пакт боловсруулсан юм.

### 1. НҮБ-ын иргэний эрхийн пакт

Иргэний болон улс төрийн эрхийн пактад (**Иргэний пакт буюу Civil-pakt**) юуны өмнө сөрөг эрх чөлөөний эрхүүд гэж нэрлэгддэг хувь хүний эрх чөлөөнд төр болон нийгмийн зүгээс дур зоргоороо хөндлөнгөөс оролцохоос хамгаалах эрхүүдийг тодорхойлсон. Эдгээрт: жишээлбэл хувийн эрх чөлөө ба аюулгүй байдлыг хангах эрх (9-р зүйл) эсхүл саад тотгоргүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх эрх (19 -р зүйл), чөлөөтэй бөгөөд нууцаар саналаа өгөх эрх (29 -р зүйл) зэрэг багтана.

### 2. НҮБ-ын нийгмийн (социал) эрхийн пакт

Эдийн засаг, социал, соёлын эрхүүдийн тухай пакт нь эерэг эрхүүд гэж нэрлэгддэг төр болон нийгмийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга



хэмжээнүүдийн үрээр хувь хүмүүст олгогддог, хувь хүмүүсийг дэмждэг эрхүүдийг нэрлэдэг. Эдгээрт жишээлбэл: Хөдөлмөрлөх эрх (6-р зүйл), шударга, аюулгүй, эрүүл хөдөлмөрлөх нөхцөлөөр хангуулах эрх (7-р зүйл), чөлөөт үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх (8-р зүйл), аюулгүй нийгэмд амьдрах эрх (9-р зүйл), чөлөөтэй сурч боловсрох эрх (13-р зүйл) зэрэг багтана.

Энэ хооронд дэлхий дахинд иргэний эрхийн пактад 151 орон, социал эрхийн пактад 148 орон элсэн ороод байна. Гэхдээ болгоомжтой бай: Эдгээр пактуудад системийн хувьд эрх чөлөөний суурь эрхүүдийг зөрчиж буй улс орнууд ч гарын үсгээ зурсан байна. Дээрх тунхаглалуудаар тодорхойлсон “Айдас, зовлонгоос ангид байх чөлөөт хүний идеал”-д хүрэхэд НҮБ-ын пактын хэлбэр төдий хүчин төгөлдөр байдал хангалтгүй гэдэг нь тодорхой юм. Эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлага, эрх зүйн хэрэгжилт хоёрын хооронд ихэвчлэн асар хол зөрүү байдаг.

Түүнээс гадна социал эрхүүдийн пактаар тодорхойлогдсон эрхүүд нь улс орнуудад үндсэн эрхүүдийг нэн даруй хэрэгжүүлэх үүргийг ногдуулдаггүй харин үндсэн эрхүүдийг алхам алхмаар хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байр суурийг баримтлах үүргийг ногдуулдаг. Ингэснээр төрд зарчмын хувьд хэлбэр төдий хангагдсан үндсэн эрхүүдийг бодитойгоор хангах, дэмжихэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах үүргийг ноогдуулдаг.

Нийгмийн ардчиллын зорилт бол: НҮБ-ын пактаар тодорхойлогдсон улс төрийн, иргэний, социал, эдийн засаг, соёлын үндсэн эрхүүдийг дэлхий дахинд зөвхөн хэлбэр төдий хүчин төгөлдөр байлгах бус харин бодитойгоор нөлөөтэй байх хэмжээнд хангах явдал мөн. Нийгмийн ардчилал нь мөн чанартаа дэлхий дахинд эерэг болон сөрөг эрх чөлөөний эрхүүдийг тууштайгаар хэрэгжүүлэх хөтөлбөр юм.

Эерэг болон сөрөг эрх чөлөөний эрхүүдийг хооронд нь харьцуулан нэг нь нөгөөгөөсөө илүү гэдгийг батлах боломжтой юу? Үнэхээр бүгдээрээ адилхан чухал юм уу? Эсхүл аль нэг нь нөгөөгөөсөө илүү чухал ач холбогдолтой юу? Жишээлбэл: Оскар Лафонтайне нэг удаагийн шууд ярилцлагын үеэр “Африк тивд ДОХ-аар өвчилсөн өвчтөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байгаад ч яах юм билээ? гэдэг асуулт тавиад бөөн маргаан дэгдээж байлаа.

*НҮБ-ын пактын эрх зүйн шаардлага ба эрх зүйн хэрэгжилт нь ихэвчлэн хоорондоо асар зөрүүтэй байдаг.*

*Нийгмийн ардчилал: НҮБ-ын пактыг хэрэгжүүлэх*

*Эрх чөлөөний эрхүүдийг хооронд нь харьцуулж нэг нь нөгөөгөөсөө илүү гэдгийг батлах боломжтой юу?*

(“Өдрийн толь 2008 оны 8-р сарын 5) Тэгэхлээр эрх чөлөөний эрхүүд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан бие биенээ гөвж байх боломжтой зөвхөн хангалуун чинээлэг амьдралтай хүмүүст л хэрэгтэй болж байна уу? Ганц сонин худалдаад авчих мөнгөгүй ядуу хүнд хэвлэлийн эрх чөлөө ач тусаа өгөх үү?

Сөрөг ба эерэг эрх чөлөөний эрхүүд нэг нь нөгөөгийнхөө хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг харилцан шүтэлцээтэй.

Энэтхэгийн эдийн засгийн философич Амартая Сен Нобелийн шагнал хүртсэн бүтээлдээ “Ардчилсан, чөлөөт хэвлэлтэй орнуудаас өнөөг хүртэл өлсгөлөнгийн зовлонд нэрвэгдсэн орон нэг ч байхгүй байна.” гэдэг дүгнэлтэнд хүрсэн байна. (Сен 1999 он) Зарчмын хувьд хүн бүрт тухайн улс оронд байгаа хүнсний нөөцөөс тэгш хувь хүртэх боломж нээлттэй бус байснаас өлсгөлөнд нэрвэгддэг гэдэг утгаараа ихэвчлэн хувиарлалтын асуудал байдаг. Иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх чадвартай, дахин сонгогдохыг хүсч байгаа засгийн газар чөлөөт хэвлэлийнхэн олны сонорт хүргээд байхад нийгмийн хурцадмал асуудлыг чихнийхээ хажуугаар өнгөрүүлээд сууж чаддаггүй. Сен эрх чөлөө нь нийгмийн тэнцвэрт байдалд хүргэдэг гэж үздэг. Сен улмаар төр ба нийгэм нь хүмүүст хувийн хариуцлагаа ухамсарласан үйл ажиллагаа явуулах, эрх чөлөөгөө эдлэх нөхцөлүүдийг бүрдүүлж өгөх ёстой гэдэг дүгнэлтэнд хүрсэн. Өөрөөр хэлбэл: Нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол зэрэг амьдралын баталгаа, амин зуулгын баталгаажих доод түвшин хангагдсан нөхцөлд л эрх чөлөө бодитоор хангагддаг гэсэн үг юм.

Билли Брандт:  
“Зовлон ба айдсаас  
ангид байх нь эрх  
чөлөө ”

Иргэний болон социал үндсэн эрхүүд, эерэг ба сөрөг эрх чөлөөний эрхүүд нь харилцан бие биенийхээ хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг тул нэгээр нь нөгөөг нь үгүйсгэх боломжгүй юм. Билли Брандт намын даргын сонгуульт ажлаа хүлээлгэн өгөх үдэлтийн арга хэмжээн дээр хэлсэн үгэндээ уг харилцан шүтэлцээг онцлон “Хэрэв хэн нэгэн нь надаас энх тайван бүхнээс чухал гэдгийг бүгд мэднэ. Гэхдээ та өөр бас нэг чухал зүйлийг нэрлэнэ үү? гэж асуувал би огтхон ч эргэлзээгүйгээр “Эрх чөлөө” гэж хариулах болно. Гэхдээ цөөнхийн бус харин олонхийн эрх чөлөө. Сэтгэл зүрхээ чагнан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг. Мөн зовлон ба айдсаас ангид байх эрх чөлөөг ч би нэрлэх болно. (Брандт 1987 он :32) Билли Брандт үүгээрээ нэг талаас төр ба нийгмийн зүгээс санаан зоргоор хүмүүсийн хувийн амьдралд орохгүй байх, дарлагдахгүй байх эрх чөлөө буюу сөрөг эрх чөлөөний эрхүүд, нөгөө талаас материаллаг

байдлын хувьд баталгаатай амьдрах эрх чөлөө буюу эерэг эрх чөлөөний эрхүүд баталгаажсан байх ёстой гэдгийг онцолсон юм. Ийнхүү дэлхий дахинд үндсэн эрхүүд бодитоор хэрэгжиж байх ёстойг тунхагласнаараа нийгмийн ардчилал нь либертар ардчиллаас ялгаатай.

### **Нийгмийн ардчилал ба либертар ардчилал**

Нийгмийн ардчилал болон либертар ардчилал нь шинжлэх ухааны идеал хэв шинжүүд бөгөөд бодит хэлбэрээрээ оршин байгаа жишээ дэлхийн аль ч оронд бараг байхгүй. Гэхдээ ардчиллын төрөл бүрийн загваруудтай өөрийн орны ардчиллыг харьцуулан үзэж хөгжлийн түвшнээ тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой.

Либертар ардчилал, нийгмийн ардчилал нь хоёулаа либерал ардчиллын загвар дээр суурилдаг учраас түүхэн эх сурвалж нь нэг юм.

- ~ Эрх зүйт төрт, олон ургальч ардчилал
- ~ Улс төрийн эрх мэдэл нь үндсэн хуулийн дагуу шилждэг.
- ~ Ардчилсан олонхийн зарчмаар зохион байгуулагдсан ард түмний тусгаар тогтнол

Эдгээр загварууд нь хоорондоо эерэг ба сөрөг эрх чөлөөний эрхүүдтэй харьцуулсан харьцаагаар тодорхой ялгагддаг. Либертар ардчилал эерэг эрх чөлөөний эрхүүдийг хангах нь сөрөг эрх чөлөөний эрхүүдийг хязгаарлаж эцэстээ тэр ч байтугай сөнөөх аюултай гэж үздэг. Нийгмийн ардчилал нь эерэг ба сөрөг эрх чөлөөний эрхүүд нь хэлбэр төдий биш харин хүчин төгөлдөр байж бодитоор нөлөөлж байх ёстой тул тэдгээрийг эн тэнцүү харгалзах ёстой гэж үздэг.

Эрх чөлөөний эрхүүд зөвхөн хэлбэр төдий хүчин төгөлдөр байх ёстой гэж либертар ардчилал санал болгодог ч нийгмийн ардчиллын онолын дагуу эдийн засгийн тэгш бус байдал бий болсноос дараах үр дагаварт хүргэдэг:

- ~ Хараат болон захирагдах харьцаа үүсдэг.
- ~ Хүний ёсоор ажиллах амьдрах боломжгүй хөдөлмөрийн харилцааг үүсгэдэг.
- ~ Төрт улсын иргэдийн улс төрийн эрх тэгш бусаар хангагддаг.  
(Майерын 2005 оны Б. 15-тай харьцуулж үзнэ үү.)

*Ардчиллын төрөл  
бүрийн загварууд*

*Түүхэн эх сурвалж нь  
нэгтэй...*

*Эрх чөлөөний эрхүүд  
хэлбэр төдий хүчин  
төгөлдөр байх нь  
хангалтгүй.*

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн жишээн дээр тодорхой болно: Либертар үзэл баримтлалын үүднээс авч үзэхэд: Төр иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах талаар юу ч хийхгүй байхад л хангалттай. Жишээ нь: Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл, нийтлэлд цензур тавихгүй байхад л үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх бүрэн хангагдана гэж үздэг. Харин нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс авч үзэхэд төр цааш нь нэгэн чухал шийдвэрлэх алхмыг хийх үүрэгтэй. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тэгш бөгөөд бодит боломжийг идэвхтэй дэмжих ёстой. Өөрийн гэсэн хүнд хэлүүштэй үзэл бодлоо бүрдүүлэхийн тулд мэдлэг чадвартай байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ өөртөө ашигтайгаар хэрэглэж чадна гэдэг утгаар нь бүх хүмүүсийг мэдээлэлд хүрэх тэгш боломжоор хангаж сайн боловсрол олгох ёстой. Түүнээс гадна олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хэлбэрээр хувийн өмч эзэмшиж буй хүмүүсийн өмчлөх эрхийг зөвхөн өөрийнхөө үзэл бодлыг бусдынхаас илүүтэйгээр олон нийтэд хүргэх давуу тал болгон ашиглахгүй байх хэмжээнд зохицуулалт хийж өгөх ёстой. Өмчлөх эрхээ ийнхүү буруугаар ашиглавал өмчид нийгмийн үүрэг ногдуулах тухай хуулийг зөрчихөд хүргэнэ. Өмчид нийгмийн хариуцлага ногдуулах нь нийгмийн ардчиллын нэгэн чухал онцлог юм. Харин либертар үзэл баримтлалын үүднээс авч үзвэл өмчийн эрх чөлөөнд ийнхүү хөндлөнгөөс халдах нь байж болшгүй зүйл юм.

*Нийгмийн болон либертар ардчиллын зорилтуудын тухай төсөөлөл харилцан адилгүй.*


Хэдийгээр нийгмийн ардчилал болон либертар ардчилал нь түүхэн эх сурвалж нэгтэй ч харилцан адилгүй таамаглал дээр суурилдаг тул эдийн засгийн дэглэмийн зорилтуудын хувьд эрс зөрүүтэй төсөөлөлд хүргэдэг.

Эдгээрийн дотроос чухал ялгаа нь жишээлбэл зах зээлийн талаарх харилцан адилгүй ойлголт юм. Либертар ардчилал зах зээлийг эрх чөлөөний илэрхийлэл гэж үздэг учраас зах зээлийг өөрийнх гольдролоор хөгжүүлэхийг эрхэмлэдэг.

*Зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах шаардлагатай.*

Харин нийгмийн ардчилал нь ямар ч зохицуулалтгүй чөлөөт зах зээл нийгмийг бүхэлд нь хүсээгүй үр дүнд хүргэж болзошгүй гэдгийг онцолдог. 2008 оны санхүүгийн зах зээлийн хямрал бол үүний нэгэн жишээ юм. Иймээс нийгмийн ардчилал бодлогоор ерөнхий нөхцөлүүдийг тогтоох, төрийн зохицуулалт хийх замаар зах зээлд нийгмийн хариуцлага ногдуулах ёстой гэж үздэг.

Нийгмийн ардчилал ба либертар ардчилал нь түүхэн талаас нь авч үзвэл хоёулаа либерал ардчилал дээр суурилдаг боловч эдийн засгийн бодлогын хувьд хоорондоо эрс ялгаатай:



Нийгмийн ардчиллын зах зээлийн тухай ойлголтыг ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт тодорхой томъёолсон байдаг:

(Зах зээл нь бидний хувьд чухал, эдийн засгийн зохицуулалтын бусад хэлбэрээс давуутай хэрэгсэл мөн. Өөрийн гольдролоор хөгжих зах зээл нь нийгэм болон эдийн засгийн хувьд сохортой адил. Зах зээл нь өөрийн зохицуулалтаар төрийн үйлчилгээг зохистой хэмжээгээр нийлүүлэх чадваргүй юм. Зах зээлийн эерэг нөлөөг бэхжүүлэхийн тулд хуулийн зохицуулалтаар, хориг арга хэмжээ авах чадамж бүхий төр, өндөр чадамжтай хууль, шударга үнэ тогтоолт хэрэгтэй.)

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 17-р тал)

### 4.3. Эдийн засгийн бодлогын зарчмууд


Нийгмийн ардчиллын үнэт зүйлс ба үндсэн эрхүүд нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогод чухам ямар ач холбогдолтой юм бэ?

Үнэт зүйлсийг хэрэгжүүлж, үндсэн эрхүүдийн бодит нөлөөллийг хангахын тулд нийгмийн ардчиллын бодлого нь дараах гурван зарчмыг мөрдлөгө болгох ёстой гэдэг таамаглалыг дэвшүүлж байна:

- ~ Өсөлт
- ~ Нийгмийн тэнцвэрт байдал
- ~ Тогтвортой байдал

Нийгмийн ардчиллын зорилтуудыг хангахын тулд эдгээр гурван зарчмыг эдийн засгийн бодлогод тэгш эрхтэйгээр харгалзан үзэх ёстой. Ийнхүү дээрх гурван зарчмыг тэгш эрхтэйгээр харгалзан үздэг байдлаараа нийгмийн ардчилал нь зөвхөн нэг дээр нь төвлөрдөг консерватив, либертар үзлийг баримтлагсад болон зүүний популистуудаас ялгардаг. Зөвхөн эдгээр гурван зарчмыг нэгэн зэрэг эн тэнцүү хэмжээнд мөрдлөгө болгож чадсан нөхцөлд л чанартай өсөлт бий болж олны тусын төлөө, тогтвортой дэвшилд хүрч чадна.

Эдийн засгийн бодлогын аливаа арга хэмжээнүүдийг эдгээр гурван зарчмуудыг нэгэн зэрэг хангаж чадаж байна уу? үгүй юу? гэдгээр нь хэмжиж болно. Тэгэхлээр эдгээр зарчмууд нь энэ утгаараа нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын үнэлгээний хэмжүүр юм.



## Өсөлт

НҮБ-ын пактад “Хүн айдас ба зовлонгоос ангид амьдрах ёстой.” гэж заасан байдаг. “Хүн ” гэдэг үгийг хэрэглэсэн байдаг. Цаашилбал “ эдийн засаг, нийгэм, соёлын байнгын хөгжил, бүх хүмүүсийг бүтээлч ажлын байраар хангах” тодорхой зорилтуудыг тодорхойлсон байдаг. Зовлонгоос ангид байх эрх чөлөөг хангахын тулд материаллаг үндсэн баталгаа заавал хангагдсан байхыг шаарддаг. Хүн бүрийн үндсэн эрхүүдийг хангах нөхцөлийг бүрдүүлэх хангалуун амьдралын доод түвшинг баталгаажуулах хэмжээний нийгмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн байх ёстой. Үүний тулд нэг талаас хувь хүн бүрийн хангалуун амьдрал, нөгөө талаас олон нийтийн зардал буюу төсвийн зарлагын эх үүсвэр болох нийгмийн материаллаг баялгийн нөөцийг хангалттай хэмжээнд бүрдүүлэх нийгмийн хангалуун амьдралын тодорхой түвшин баталгаажсан байх ёстой.

**Эдийн засгийн өсөлт:** Дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэх, өөрөөр хэлбэл улс ардын аж ахуйн үйлдвэрлэсэн нийт бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхийг эдийн засгийн өсөлт гэнэ. Зарчмын хувьд өсөлтийг нэгтгэн тодорхойлдог тул эдийн засгийн зогсонги байдалд орсон нөхцөлд өсөлт Тэг-тэй тэнцлээ гэж ярьдаг. Үйлдвэрлэл буурахад өсөлт хасах руу орлоо гэж тэмдэглэдэг. Үнэ өссөн ч үйлдвэрлэл өсөөгүй тохиолдолд эдийн засгийн нэрлэгдэх (номинал) өсөлт эерэг утгатай гардаг. Харин бодит өсөлтийг тооцохдоо үнийн өсөлтийг хасан тооцдог:

(Эдийн засгийн нэвтэрхий толь 2009 он)

Зөвхөн эдийн засаг өсөлттэй байх нөхцөлд нийгэм чөлөөт, шударга, эв санааны нэгдэлтэй байдаг. Хангалуун амьдралын баталгаат түвшин нь чөлөөт, шударга, эв санааны нэгдэлтэй нийгэм оршин байх үндэс мөн. Энэхүү хангалуун амьдралын баталгаат түвшин нь эдийн

засгийн өсөлтөөр үйлдвэрлэгдэж баталгаажиж байх ёстой. Зөвхөн үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр хувь хүмүүсийн болон нийгмийн хангалуун амьдралын түвшинг нэмэгдүүлэх орон зай бий болдог. Эдийн засаг бууралттай байх үетэй харьцуулахад улс ардын аж ахуйн өсөлт тогтвортой байх нөхцөлд улс орнуудын нийгмийн бүтээгдэхүүний хувиарлалт илүү шударга, үнэнч байдаг гэдгийг түүх харуулж байна. Тэгэхлээр өсөлт нь нийгмийн ардчиллын дээр дурьдсан үнэлэмж болон зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөл юм.

Тэгэхлээр өсөлт гэж чухам юуг хэлэх бэ? Нийгмийн ардчилалын

НҮБ-ын нийгмийн эрхийн пакт “Айдас, зовлонгоос ангид байх эрх чөлөө”

Эдийн засгийн өсөлтийн баталгаат доод түвшин нь чөлөөтэй, шударга, эв санааны нэгдэлтэй нийгэм оршин байх нөхцөл мөн.

Өсөлтийн ямар ойлголт тохирох бэ?

зөв өсөлтийн тухай ойлголт сүүлийн хэдэн арван жилийн дотор өөрчлөгдсөн байна.

Социал демократ эдийн засагч, сангийн сайд агсан Карл Шиллерийн удирдлага дор 1967 онд "Байнгын, тогтмол өсөлтийг" "улс төрийн бодлогын цөм хэмээн тодорхойлж тогтвортой байдал ба өсөлтийн хуулиар баталгаажуулсан юм. Үүний зэрэгцээгээр ажилгүйдэл, ханшийн уналтыг бага түвшинд байлгах, гадаад эдийн засгийн тэнцвэрийг хангах "Шидэт гурвалжин" хэмээх нэртэй эдийн засгийн зорилтуудыг томъёолсон юм. Уг бодлогыг хэрэгжүүлэхэд Кенсийн онолын дагуу төрд эдийн засгийн савлагааг тэнцвэржүүлэх, эдийн засгийн бууралтаас сэргийлэх үүрэг ногдоно.

#### Хамбургийн хөтөлбөрт "өсөлт"-ийг тодорхойлсон

нь: "Бүх хүмүүст хангалуун амьдрал ба амьдралын өндөр чанарыг баталгаажуулах нь социал демократ бодлогын зорилтууд байсаар ирсэн, байх ч болно. Өнгөрсөн хугацаанд дэвшлийг юуны өмнө тоон өсөлт хэмээн ойлгож ирлээ. Өнөөгийн цаг уурын эрчимтэй өөрчлөлт, экосистемд учирч буй хэт ачаалал, дэлхийн хүн амын өсөлт, биднээс хөгжлийн шинэ, ирээдүйд тохирсон чиг хандлагыг тогтоохыг шаардаж байна. Бид эрин цаг үедээ тохирсон хариултыг өгч чадах эсэхээс хөгжил маань дэвшил болж чадах эсэх нь хамаарах болоод байна. Бид эдийн засгийн хурдацтай өсөлт, нийгмийн шударга ёс, экологийн хариуцлагыг нэгтгэсэн тогтвортой дэвшилд хүрэхийн төлөө байна. Үүний тулд нөөцийг ариг гамтай зарцуулдаг чанартай өсөлтийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Хүмүүст амьдралынхаа эх үүсвэрийг мөлжлөгө, айдсаас ангид сайн хөдөлмөрийн үрээр бүрдүүлэх боломжийг хангаж өгөх ёстой. Хүн бүр нийгмийн нөөц баялгаас шударгаар хувь хүртэх боломжоор хангагдсан байх ёстой. (Хамбургийн хөтөлбөр 2007 он. 42-р тал)

1967 оны Тогтвортой байдал ба өсөлтийн хууль "Байнгын ба зохистой өсөлт"

Үүний зэрэгцээгээр 1972 онд нийтлэгдсэн "өсөлтийн хязгаар" хэмээх нөлөө бүхий судалгаа өсөлт нь түүхий эдийг хэрэглэж, байгаль орчны бохирдуулж байж бий болдог юм гэдэг ойлголтыг өөрчилсөн. Уг судалгааны нөлөөгөөр ер нь өсөлтийг байнга өндөр байлгахын төлөө эрмэлзэх хэрэгтэй юм уу? Эсхүл удаан хугацааны туршид өсөлтийг тогтмол өндөр байлгах боломжтой юу? гэдэг асуултууд зайлшгүй гарч ирж байна.

2000 он: Лиссавоны стратеги: Өсөлтийн тухай зөрүүтэй ойлголтууд

Энэ хооронд өсөлтийг нэмэгдүүлэх төрөл бүрийн хөтөлбөрүүд боловсруулагдаж технологийн шинэчлэл, экологийн шинэчлэл, нийгмийн эв нэгдлийг хооронд нь уялдуулах оролдлогуудыг хийжээ. Энэхүү бодит байдлын дунд 2000 онд социал демократ засгийн газрын тэргүүнүүдийн удирдлага дор Европ тивийг арван жилийн дотор дэлхийн хамгийн өндөр өрсөлдөх чадвартай, хамгийн эрчимтэй эдийн засагтай орчин болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн Лиссавоны стратеги гэж нэрлэгддэг нэгэн хөтөлбөр боловсруулагдсан юм.



Өсөлтийн тухай ойлголт байнга өөрчлөгдсөөр иржээ. 1960-аад оны үед өсөлт бахархал болж байсан бол 1970-аад оны үед өсөлтөд илүү шүүмжлэлтэй хандах болжээ. Энэ хооронд өсөлтөнд хандах шинэ хандлага бий болж нөөцийг ариг гамтай хэрэглэн нийгмийн дэвшилд хүрэх зорилгыг дэвшүүлсэн чанарын өсөлтийн тухай ойлголтыг дэлгэрчээ. Ийнхүү шинэ хандлага бий болсноор өсөлтийг тогтвортой байдал болон нийгмийн тэнцвэрт байдалтай холбох, тэдгээрийн хоорондын тэнцвэрт байдлыг тогтоох боломжийг олгосон байна.

### Нийгмийн тэнцвэрт байдал

Нийгмийн ардчилалын үзэл баримтлал нь нийгмийн тэнцвэрт байдлыг эдийн засгийн бодлогын зарчим болгон хэрэгжүүлэхийг шаарддаг. Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах нь эдийн засагт ч ашигтай.

Нийгмийн ардчиллын үнэт зүйлс болон үндсэн эрхүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг хүн бүхэн нийгмийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэгдсэн эдийн засгийн бодлогыг явуулахыг эрмэлзэх ёстой. Шударга ёс, Эрх чөлөө, Эв санааны нэгдэл хэмээх үнэт зүйлс төдийгүй НҮБ-ын пактаар тодорхойлсон үндсэн эрхүүдийн хэрэгжилт нь нийгмийн тэнцвэрт байдлыг хангах түвшинд ойртуулж байдаг. Нийгмийн тэнцвэрт байдлыг хангахын тулд жишээлбэл “Зохистой амьжиргаа”-ны түвшинг баталгаажуулах шаардлагатай болдог. Зохистой амьжиргааны түвшинг хангахын тулд нийгэмд “Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс илүү таагүй хөдөлмөрийн нөхцөлд ажиллуулахгүй байх, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй ижил хөдөлмөр хийсэн бол ижил цалин олгох” зэрэг зарчмуудыг хангаж “хангалттай хэмжээний хүнс тэжээл, хувцас хунар, орон байраар хангах”, “Сурч боловсрох эрх”, “Хувь хүн өөрийн авъяас чадвараа бүрэн хөгжүүлэх” нөхцөлөөр хангахыг шаарддаг.

Нийгмийн ардчилал нь зах зээл, нийгмийн болон ардчилсан амьдралд амжилт олж чадаж байна уу? үгүй юу? гэдгээс нь үл хамааран хүн бүрийн хүний ёсоор амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэх хэмжээний материаллаг байдал хангагдсан, **эв нэгдэлтэй нийгмийг** байгуулахыг зорьдог. Нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс авч үзэхэд эдийн засгийн өсөлт нь нийгмийн ардчиллыг хэрэгжүүлэх нэгэн чухал нөхцөл мөн боловч харин үндсэн зорилт нь биш бөгөөд нийгмийн тэнцвэрт байдал, шударга ёсны зарчмуудыг

*Нөөцийн ариг гамтай хэрэглээ ба нийгмийн дэвшилд чиглэсэн чанарын өсөлтийн тухай ойлголт*

*НҮБ-ын нийгмийн пакт: “Зохистой амьжиргаа”*

харгалзан үзэх ёстой. Эрчимтэй, өндөр бүтээмжтэй эдийн засгаас олж буй ашиг шударгаар хувиарлагдах ёстой. Хувиарлалт шударга байх нөхцөлд хүмүүс амьжиргааныхаа төлөө айх айдсаас ангид, сайн хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааныхаа эх үүсвэрийг бүрдүүлэн, нийгмийн баялгийн өсөлтөөс шударгаар хувь хүртэх нөхцөлүүд нь баталгааждаг.

Үндсэн хуулинд  
нийгмийн тэнцвэрт  
байдлыг хангах ёстой  
гэж заасан.

Германы эдийн засгийн дэглэмд болон үндсэн хуулийн 19-р зүйлд нийгмийн тэнцвэрт байдал хангагдсан байх ёстой гэж заасан байдаг. Холбооны Бүгд Найрамдах Герман улс бол нийгмийн баримжаат Холбооны улс мөн тодорхойлсон байдаг. Түүнээс гадна 14-р зүйлд өмчийн нийгмийн холбоосыг "өмчид хариуцлага ногдоно. Өмчийн хэрэглээ нь нийтийн сайн сайхны төлөө үйлчлэх ёстой." гэж тодорхойлсон байдаг.

Өмчид нийгмийн  
хариуцлага ногдуулах  
нь: Жишээ

Орон сууцны байшингуудыг өмчлөгч нь тэдгээрийг мөнгө хүүлэх хэлбэрээр ашиглаж болохгүй, харин хүн амьдрах зохистой хэмжээнд байлгаж түрээслэх үүрэгтэй. Компанийн менежер нь хувьцаа эзэмшигчдэд өгөх ногдол ашгийг хариуцаад зогсохгүй ажлын байруудыг хадгалах, байгаль орчныг хамгаалах зэрэг хариуцлагыг нийгмийн өмнө хүлээдэг. Нийгмийн хангалуун чинээлэг амьдралаас бусдаас их хувь хүртэж байгаа хүн бүр үүнийхээ хариуд нийгмийн төлөө хүртэж буй хувь хэмжээтэйгээ дүйцэхүйц их зүйлийг хийх ёстой. Өмчид нийгмийн хариуцлага ногдуулах нь нийгмийн ардчиллын мөн чанарыг илэрхийлэгч шинж мөн.

Нийгмийн тэнцвэрт  
байдал ба бүтээмжийн  
зарчим хоёрын  
хоорондын зөрчил

Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах шаардлага ба зах зээлийн эдийн засгийн бүтээмжийн зарчим хоёр хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш үү? Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах шаардлага нь эрчимтэй эдийн засаг, өсөлтийг бий болгох үндсэн нөхцөл болох бүтээмжийг нэмэгдүүлэх эрмэлзлийг бууруулдаг уу? Эдгээр асуултууд нь өсөлтийг дэмжих бодлого, нийгмийн тэнцвэрт байдлыг хангах шаардлагын хооронд бодит зөрчил байна гэдгийг харуулж байна.

Родрик: Нийгмийн  
тэнцвэрт байдал  
хангагдсан нөхцөлд  
бүтээмж өсдөг

Гэтэл нийгмийн тэнцвэрт байдал ба өсөлтийг дэмжсэн эдийн засгийн бодлогын хооронд бас нэгэн урвуу хамаарал байдаг ажээ: Нийгмийн тодорхой суурь бүрдсэн нөхцөлд л үйлдвэрлэлийн бүтээмж болон өсөлтийг нэмэгдүүлэх боломж бүрддэг. Нийгмийн тэнцвэрт байдлын зохистой доод түвшин хангагдсан нөхцөлд л бүтээмжийг нэмэгдүүлэх боломж бүрддэг. Америкийн эдийн засагч Дэни Родрик нийгмийн

аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж чадсан орнууд л эдийн засгийн өндөр амжилтанд хүрч чаджээ гэдгийг баталсан. Өөрөөр хэлбэл нийгмийн баталгаат байдал нь хангагдсан хувь хүмүүсийн бүтээмжийг нэмэгдүүлэх идэвх чармайлт дээшилдэг.

Нийгмийн байдал нь баталгаажсан хүмүүс нийгмийн байдал нь баталгаажуулаагүй хүмүүстэй харьцуулахад хувьсал өөрчлөлтөнд гар бие оролцож, эрсдэлийг даван туулж шинэ зүйлийг эхлүүлэхэд илүү зоригтой байдаг. (Родрик 1997 он, 178-р зүйлтэй харьцуулж үзэх)

Дээрх уялдаа холбоог эсэргүүцэгчид цөөхөн байдаг. Мюнхен хотноо байрладаг эдийн засагт ойр байдаг эдийн засаг судлалын институтын ерөнхийлөгч “Эв санааны нэгдэл нь залуу хүмүүст эрсдэлтэй боловч өндөр амжилтанд хүрэх боломжтой амьдралын боломжуудыг туршин үзэх аюулгүй байдал, өөртөө итгэх итгэлийг өгдөг. Тийм ч учраас би нийгмийн баримжаат төртэй байхын тулд бид төлөх ёстойгоосоо илүү өндөр үнийг бүх зүйлд төлж байна гэдэг шүүмжлэлд итгэдэггүй. Харин ч эсрэгээрээ нийгмийн баримжаат төр л манай улсыг дайны дараах үеийн эдийн засгийн үсрэнгүй хөгжилд хүргэсэн үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлтийн томоохон хувийг бий болгож чадсан гэж би боддог юм. (Синн 1986, 566-577).

**“Нийгмийн тэнцвэрт байдал”-ыг  
Хамбургийн хөтөлбөрт:**

Германд орлого ба хөрөнгийн хувиарлалт шударга бус байна. Социалдемократууд бид татварын бодлогоороо дамжуулан тэгш бус байдлыг хязгаарлаж тэгш боломжийг дэмжих болно. Бид үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлтийг дэмжсэн, ханшийн бууралттай уялдаатай цалингийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө байна. Бид ажилтнуудыг хөрөнгөжүүлэхийн төлөө байна. Компанийн хөрөнгөнөөс ажилтнуудад хувь эзэмшүүлэх замаар тэдэнд орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох төдийгүй компанийн амжилтаас шударгаар хувь хүртээх боломж нээгдэнэ гэж бид үзэж байна. Ингэснээр эдийн засгийн шинэчлэлт эрчимжиж үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдэх болно. (Хамбургийн хөтөлбөр 2007 он, 43-р тал)

Ийм ч учраас нийгмийн ардчилал нь өсөлтийг дэмжсэн эдийн засгийн бодлого, нийгмийн тэгш байдлын хоорондын тэнцвэрт байдлыг хангахыг зорьж байна. Үүний нэг тод жишээ бол: Швед орон. Улс орнуудын жишээ хэмээх 6-р бүлэгт нийгмийн тэнцвэрт байдлыг өндөр түвшинд хангасан нь Шведийн эдийн засгийн өндөр амжилтанд хүрэх нөхцөлийг бүрдүүлсэн гэдгийг тодорхой харуулах болно.

*Нийгмийн баримжаат төрийн онолыг шүүмжлэгчид хүртэл “Нийгмийн баримжаат төр нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг” гэдгийг хүлээн зөвшөөрдөг:*

*Өсөлтийг дэмжсэн эдийн засгийн бодлого ба нийгмийн тэнцвэрт байдлын хоорондын тэнцвэрийг хангах нь*

## Тогтвортой байдал

Тогтвортой байдал нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын гурван үндсэн зарчмуудын нэг юм. Тогтвортой байдал нь экологи, эдийн засаг, нийгмийн цар хүрээг хамардаг.

*“Тогтвортой байдал”  
гэдэг ойлголт ойн аж  
ахуйгаас гаралтай.*

Тогтвортой байдлыг эхэн үедээ экологийн асуудалтай ихэвчлэн холбодог байлаа. Бодит амьдрал дээр ч тогтвортой байдлын тухай эхний эргэцүүлэл экологийн асуудалтай холбогдож байлаа. “Тогтвортой байдал” гэдэг ойлголт анх ойн аж ахуйгаас гаралтай. Ойн шинжлэх ухааны эрдэмтэн Георг Людвиг Хартиг 18-р зуунд “Ойн нөхөн сэргэх чадвараас илүү тооны модыг огтолж болохгүй” гэдэг шаардлагыг тавьж байлаа. Өнөө үед экологийн тогтвортой байдлыг хангах шаардлага биднээс “хойч үеийнхний оршихуйн үндэс болсон байгаль орчноо аль болох унаган төрхөөр нь, бүрэн бүтэн байлгахыг” шаардаж байна. Нөөцийг ариг гамтай зарцуулах, дэлхийн дулаарлаас сэргийлэх, ан амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, байгаль орчны ачааллыг хязгаарлах нь өнөөгийн чухал зорилтууд болоод байна. НҮБ-ын нийгмийн эрхүүдийн пактад тодорхойлсон үндсэн эрхүүдийн хүрээнд “байгаль дэлхий бол хүн бүрийн оршихуйн үндэс учраас байгаль орчны эрүүл ахуйг сайжруулах бүхий л зорилтууд”-ыг (13-р зүйл) хэрэгжүүл гэдэг зааварчилгааг өгч ач холбогдлыг нь онцлон тэмдэглэсэн байдаг. Зөвхөн хойч ирээдүйн оршихуйн анхдагч орчин алдагдана гэдэг утгаараа бус чухам энд, одоо хүмүүст уух цэвэр усны нөөц, эрүүл агаар хэрэгтэй учраас амьдралын чухал зорилтууд юм.

Нийгмийн ардчиллын өмнөх үеийн төлөөлөгчид тогтвортой байдлын ач холбогдлыг өндрөөр үнэлсэн байдаг:

Дэлхийн хүн амын өнөөгийн үсрэнгүй өсөлт цаашид хэвээрээ үргэлжилж, хүн төрөлхтөн дахин нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн нөөцийг улам хурдацтайгаар хүссэнээрээ хэрэглэсээр байвал нэгэн сайхан өдөр эх дэлхийг маань сүйрэлд хүргэх бус уу? гэдэг асуулыг бид тавих ёстой. Бидний хүүхдүүд, ач, зээ нар маань болох хойч үеийнхнийг сайн сайхан амьдруулахын тулд бид хүслээ хязгаарлахад, шаардлагатай үед хүрсэн түвшнээсээ ухрахад бэлэн байх ёстой.

(Густаф Хайнеман 1972 он)

*1972 он, Густаф  
Хайнеманы Тогтвортой  
байдлын талаар  
дэвшүүлсэн санаа*

1983 онд НҮБ дээрх асуудлаар Брандтландын комиссыг байгуулж (тухайн үеийн Норвегийн ерөнхий сайдын нэрээр нэрлэгдсэн) уг комиссоос дараах санааг дэвшүүлсэн юм:

*1983 он, Брандланд-ын  
комисс*

“Өнөө үеийнхний хэрэгцээг хойч үеийнхэн хэрэгцээгээ хангаж чадахгүй байх эрсдэлд хүргэхгүйгээр хангаж чадах хөгжлийг л урт хугацааны хөгжил гэнэ.

(Хауфын ишлэл татсанаар 1987 он, 46-р тал)

“Тогтвортой байдал”-ын тухай ойлголт нь экологийн цар хүрээний зэрэгцээ эдийн засгийн цар хүрээг хамардаг. 1998 онд нийтлэгдсэн Германы Бундестагийн Инкүетегийн комиссын “Тогтвортой байдлын хөтөлбөр: Удирдамжаас хэрэгжилт хүртэл” нэртэй төгсгөлийн илтгэлд “Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийг хадгалахын тулд бид өнөөгийн эдийн засгийг ирээдүй хойч үеийнхэн маань хангалуун чинээлэг амьдралаа үйлдвэрлэх нөхцөлөөр хангагдсан байх хэмжээнд бүрдүүлэх ёстой. Үүнийг бид эдийн засгийн тогтвортой байдал гэж ойлгож байна.” гэж онцлон тэмдэглэжээ. Үүний тулд төсвийн зардал, нэн ялангуяа нийгмийн баримжаат төрийн зардлын санхүүжилтийн эх үүсвэрийн удаан хугацааны найдвартай байдлыг хангаж боловсрол, судалгаа, дэд бүтцийн салбарт удаан хугацааны дараа ашгаа өгөх хөрөнгө оруулалтыг хийх ёстой.

Дэлхий дахиныг хамарсан санхүүгийн зах зээлийн хямрал нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нь ямар өндөр ач холбогдолтой бэ? гэдгийг харууллаа. Тогтвортой байдлыг хангах шаардлагыг анхаарлын гадна орхигдуулсан, богино хугацаанд их ашиг олох эрмэлзэл нь зөвхөн зарим нэгэн компаниудыг дампууралд хүргээд зогсохгүй, нийт улс ардын аж ахуйг тогтворгүй байдалд хүргэх аюултай.

Тогтвортой байдлыг хангах шаардлага нь мөн нийгмийн цар хүрээг

ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт” Тогтвортой байдал-ыг тодорхойлсон нь:

Тогтвортой байдлын зарчмыг хангахын тулд “Ирээдүй хоч үеийнхний байр суурин дээрээс сэтгэх, зөвхөн өнөөдрийг харсан явцуу сэтгэлгээг тэвчих, эдийн засгийн давамгай байдал, цэвэр компанийн эдийн засгийн логигоор удирдуулах явдлыг халах хэрэгтэй. Нийт нийгмийн тусын тулд бодлогоо боловсруулах, ардчилсан олон талт байдал, экологийн тэнцвэрийг урт хугацаанд хангах, нийгмийн нэгдэл, соёлын оролцоог хангахад социал демократ бодлого чиглэгдэж байна. (Хамбургийн хөтөлбөр 2007 он, 17-р тал)

хамардаг: Нийгмийн тогтвортой байдалнь нийгмийн бүх гишүүдэд удаан хугацаагаар хувь хүртэх боломжийг бүрдүүлж, нийгмийн доторхи зөрчлүүдийг удаан хугацаагаар тэнцвэржүүлэхийг шаарддаг. Тэгэхлээр нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд нийгмийн бүх гишүүдийн нийгмийн оролцоо ба үндсэн хэрэгцээг тогтвортой хангах шаардлагатай аж.

Тогтвортой байдлын эдийн засгийн цар хүрээ

Сэрэмжлүүлэх жишээ:

Хамбургийн хөтөлбөр: “Тогтвортой байдлыг хангах шаардлага” нь биднээс ирээдүй хойч үеийнхний байр суурин дээрээс сэтгэх” –хийг шаардаж байна.

## Чанарын өсөлтөнд хүрэхийн тулд гурван зарчмыг тэгш эрхтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай.

Гурван зарчим хоорондоо зөрчилдөг үү?

Өсөлт, нийгмийн тэнцвэрт байдал, тогтвортой байдлын эдгээр гурван зарчмыг нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлого тэгш эрхтэйгээр хэрэгжүүлэх ёстой байдаг. Гэтэл ийм боломж байна уу? Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах шаардлага нь тухайн нийгмийн өсөлтийн боломжийг хязгаарладаггүй гэж үү? Түүхий эдийг хэрэглэж байж л өсөлтөнд хүрдэг болохоор өсөлт тогтвортой байдлыг хязгаарладаггүй гэж үү? Тэгэхлээр эдгээр гурван зарчим нь зөрчилтэй харьцаанд оршдог мэт харагдаж байна. Тэгэхлээр зөрчилт харьцаанд оршдог эдгээр гурван зарчмуудыг тэгш эрхтэйгээр яаж хэрэгжүүлэх юм бэ?

Билли Брандт дээрх зорилтыг эрэгцүүлсний үндсэн дээр 1973 онд өсөлт ба тогтвортой байдлын зарчмуудын жишээн дээр тайлбар өгсөн байдаг:

Өсөлт ба Тогтвортой байдлын харьцааны талаар Билли Брандтын өгсөн тайлбар

Хувь хүн бүр цаашилбал нийгэм бүхэлдээ байгалийн өртөг дээр амьдарч таарахгүй. Хэрэв тэгвээс манай байгаль орчны хөгжил хүмүүнлэг бус болно. (...) Дуу чимээ, агаар, усны бохирдол зэрэг сөрөг үр дагаврууд бодит байдал дээр эдийн засгийн хөгжлийн давуу талуудад эргэлзэхэд хүргэж байна. Гэхдээ би зөвхөн өсөлт ба үйлдвэрлэлийн бүтээмжийг хязгаарласнаар дээрх байдлаас гарах гарц байна гэж богино бодох хэрэггүй гэдгийг анхааруулж байна. Эдийн засгийн өсөлт ба эдийн засгийн зарчим нь хүний тусын төлөө зарцуулагдаж байх ёстой гэдэг үүднээс хандаж эхлээд Хаана? Хэрхэн? Юуны төлөө? эдийн засгийн өсөлтөд хүрэхийг зорьж байна бэ? гэдэг асуултанд хариулах ёстой. Хүмүүс бид өөрсдөө дээрх "харьцаанууд"-ын эрхшээлд орох бус харин бид эдгээр харьцаануудыг эрхшээлдээ байлгахын тулд илүү ихээр оюун ухаанаа дайчилж, шаардлагатай бол илүү их тэвчээр, зүтгэл гарган ажиллах хэрэгтэй."

("Билли Брандт, Засгийн газрын тайлбар, 1973 оны 1-р сарын 18)

Үндсэн асуултууд:  
Өсөлтийг хаана, хэрхэн,  
юуны төлөө ашиглах  
бэ?

Ийнхүү хэлснээрээ Брандт ямар ч аргаар хамаагүй, хамгийн гол нь эдийн засаг өсөлттэй байх нь чухал гэдэг байдлаар өсөлтөнд хандах бус харин өсөлтийг хаана, хэрхэн, юуны төлөө нэмэгдүүлэх ёстой бэ? гэдгийг байнга, гүнзгий эргэцүүлэн бодож байх ёстой гэдгийг сануулсан. Өсөлт хэний ашиг тусын төлөө үйлчлэх бэ? Хэн өсөлтөөс ашиг олох бэ? Тэгэхлээр нийгмийн ардчилалд мухар сохроор өсөлтийн төлөө зүтгэх бус харин нийгмийн тэнцвэрт байдал ба тогтвортой байдлыг тэгш эрхтэйгээр харгалзан үздэг чанарын өсөлт хэрэгтэй.

Брандтын хэлсний дагуу өсөлтийн ашиг тусын талаар илүү гүнзгий

эргэцүүлэн бодвоос дээрх гурван зарчим хоорондоо зөрчилтэй харьцаанд оршдогоос гадна нэг нь нөгөөгийнхээ хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх боломжтой ажээ.

Энэ сэдвийн эхний хэсэгт нийгмийн тэнцвэрт байдал нь эдийн засгийг эрчимтэй байлгах нэгэн нөхцөл юм гэдгийг тодорхой харуулсан. Мөн экологийн тогтвортой байдал ч эдийн засгийн өсөлтийг дэмждэг. Жишээлбэл: Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарууд германы эдийн засгийн өсөлтийн хамгийн чухал хөдөлгүүрүүдэд тооцогдож ажлын байруудыг өндөр түвшинд найдвартай хадгалж байгаа нь дээрх харилцан шүтэлцээг тодорхой харуулж байна. 7-р бүлэгт экологид ээлтэй аж үйлдвэрийн бодлогыг үүнтэй төсөөтэй жишээн дээр тайлбарлана.

Өсөлт, нийгмийн тэнцвэрт байдал, тогтвортой байдлын гурван зарчмыг гурвууланг нь эн тэнцүү хэмжээнд мөрдлөгө болгох шаардлага нь нэгэн том сорилт төдийгүй бас нэгэн том боломж гэдгийг харуулж байна. Эдгээр гурван зарчмыг тэгш эрхтэйгээр мөрдөх шаардлагын хэрэгжилтийг дахин дахин шалгаж, шинэчилсэн хэлэлцээрийг тогтмол явуулж байх шаардлагатай. Энэ нөхцөлд

ГСДН-ын Хамбургийн хөтөлбөрт: “Чанарын өсөлтийг тодорхойлсон нь”

“Бид эдийн засгийн динамик, нийгмийн шударга ёс, экологийн ухаалаг бодлогыг нэгтгэсэн тогтвортой дэвшилд хүрэхийн төлөө ажиллаж байна. Чанарын өсөлтөөр бид ядуурал, дарлал мөлжлөгийг арилгаж, бүх хүнийг хангалуун чинээлэг амьдрал, сайн хөдөлмөрөөр хангаж, цаг уурын аймшигт өөрчлөлтийг сөрөн зогсож чадна. Ирээдүй хойч үеийн оршихуйн үндэс болсон байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр амьдралын чанарыг сайжруулахын төлөө байна. Үүний тулд бид шинжлэх ухаан, техникийн дэвшлийн үрээр бий болж буй боломжуудыг хүмүүсийн сайн сайхны төлөө үйлсэд ашиглах болно.”

(Хамбургийн хөтөлбөр 2007 он. 5-р тал)

хөдөлшгүй үнэн гэж байдаггүй. Зөвхөн эдгээр гурван зарчмыг нэгэн зэрэг мөрдлөгө болгож чадсан нөхцөлд чанарын өсөлт гарах ба чанарын өсөлтөөс нийгэм бүхлээрээ хожих болно.

*Тогтвортой байдал  
эдийн засгийн өсөлтийг  
дэмждэг. Жишээ нь:  
экологт ээлтэй аж  
үйлдвэрийн бодлого  
(7-р бүлэг)*

*Өсөлт, нийгмийн  
тэнцвэрт байдал,  
тогтвортой байдлын  
харилцан шүтэлцээнээс  
чанарын өсөлт гардаг.*

#### 4.4. Тойрон аялал: Чанарын өсөлтийг хэмжих нь

Экологийн дэвшил=  
Дотоодын нийт  
бүтээгдэхүүнтэй  
тэнцэх үү?

Эдийн засгийн дэвшлийг тоон утгаар илэрхийлэх боломжтой юу? Эдийн засгийн хөгжлийг тоон утгаар илэрхийлэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг тоон хэмжигдэхүүн бол дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) юм. ДНБ бол тухайн жилд тухайн оронд үйлдвэрлэгдсэн нийт бүтээгдэхүүн болон үйлчилгээний нийлбэр дүн юм. Хэрэв ДНБ өсвөл бид эдийн засаг өсөлттэй байлаа гэж ярьдаг. Хэрэв эдийн засаг зогсонги байдалд орох юм уу? багасвал эдийн засгийн бууралттай байлаа гэж ярьдаг. ДНБ-ний ач холбогдлыг багаар үнэлж болохгүй: Аливаа нийгмийн улсын төсөв, ажилгүйдлийн бууралт, хангалуун чинээлэг амьдрал бүгдээрээ эдийн засгийн өсөлтөөс хамаардаг.

ДНБ-ний сохор  
толбонууд

Эдийн засгийн дэвшлийг ДНБ-ээр хэмжихэд олон тооны сохор толбонууд үүсдэг. Нэн ялангуяа нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс харахад ДНБ нь зөвхөн нийт үйлдвэрлэлийн хэмжээг илэрхийлдэг тул учир дутагдалтай. ДНБ дараах асуултуудад ямар ч хариулт өгдөггүй.

1. Хувиарлалт

~ Үйлдвэрлэгдсэн нийт ДНБ хэрхэн хувиарлагдаж байна бэ? Хувиарлалт шударга явагдаж байна уу? Хүн амын тун бага хэсэг нийгмийн баялгийн дийлэнх хэсгийг хүртэж байна уу? Ямар шалгууруудыг үндэслэн хувиарлалт явагдаж байна бэ? Зайлшгүй хэрэгтэй хүмүүст ногдож байна уу? Бүтээмжийн хэрээр үү? Эсхүл нийгмийн давхаргын дагуу юу? гэдэг асуултанд хариулт өгч чаддаггүй.

2. Байгаль орчин

~ Үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлж буй дарамт хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна уу? Байгаль орчныг хамгаалахад хөрөнгө оруулалт хийж байна уу? Эсхүл өсөлтийг байгалийг тонон дээрэмдэх замаар үйлдвэрлэж байна уу?

3. Тогтвортой байдал

~ Ямар замаар өсөлтийг үйлдвэрлэж байна бэ? Өсөлтөөс олсон ашиг юунд зарцуулагдаж байна? Өсөлтийг хэрэглээ болон төрийн өрөөр худалдан авч байна уу? Эсхүл урт хугацааны өсөлтийг хангахын тулд дэд бүтэц, боловсрол, судалгаанд хөрөнгө оруулалт хийж байна уу?

4. Хөлсгүй хөдөлмөр

~ Мөнгөөр хэмжигддэггүй бүтээмжийг оруулж оруулан тооцсон уу? Илүү их хөдөлмөрлөсөн учраас ДНБ өсөв үү? Сайн дурын болон гэр бүлийн хөдөлмөрийг албан хөдөлмөрт шилжүүлсэн тооцсон байхад ямар учраас ДНБ өсөв? Нийт үйлдвэрлэгдсэн ДНБ -ны хэмжээ хэвээрээ байгаа юм биш үү?



Дээрх асуултуудад хариулт өгөхийн тулд зөвхөн улс ардын аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээнээс илүү өргөн хүрээтэй мэдээлэл өгч чадах эдийн засгийн дэвшлийг тодорхойлох иж бүрэн ойлголт болон олон талт өсөлтийн ойлголтыг нэвтрүүлэх хэрэгтэй.

| Өсөлтийн тухай сонгодог ойлголт  | Өсөлтийн тухай өргөтгөсөн ойлголт                                                 |
|----------------------------------|-----------------------------------------------------------------------------------|
| Эдийн засгийн бүтээмжийн нийлбэр | Эдийн засгийн бүтээмжийн нийлбэр<br>Нийгмийн тэнцвэрт байдал<br>Тогтвортой хөгжил |

Өсөлтийг илүү өргөн хүрээнд тодорхойлох оролдлогуудыг дэлхийн банкны Нобелийн шагналт эдийн засагч Херман Дэли болон бусад эдийн засагчид хийж бодит дэвшлийг тооцох аргачлал болох **“Genuine Progress Indicator”** буюу **“Тогтвортой эдийн засгийн хангалуун амьдралын индекс”**-ийг боловсруулсан юм. Уг аргачлалд эдийн засгийн үйл ажиллагааны бодит өртөг ба ашгийг илэрхийлэх факторуудаар баяжуулсан. /Лаун 2003 он/ ДНБ-ний зэрэгцээ индикатор болгон оруулж буй факторууд нь жишээлбэл: нийгмийн орлогын хувиарлалт, хөлсгүй болон сайн дурын хөдөлмөр, боловсролын өсөлт, гэмт хэрэг, чөлөөт цаг, нөөцийн хэрэглээ, байгальд орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, олон нийтийн дэд бүтцэд оруулж буй хөрөнгө оруулалт зэрэг юм. GPI болон бусад ижил төстэй индикаторуудыг тооцох нь маш бэрхшээлтэй бөгөөд эдгээрийн бүрэлдэхүүн, үнэлгээ нь маргаантай, эцэслэн тогтоогдоогүй байна. Эдгээр тооцоонууд ихээхэн шүүмжлэлд өртдөг, шүүмжлэлүүд нь үндэслэлтэй ч гэлээ өнөөг хүртэл хэрэглэж ирсэн ДНБ гэх мэт үзүүлэлтүүдийн тооцох аргачлалуудын сул талыг илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

**“Redefining Progress”** гэдэг төрийн бус байгууллагаас [www.rprogress.org](http://www.rprogress.org) хаягаар Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын GPI –г тогтмол хэвлэн нийтэлж байна. GPI үзүүлэлтээр хэмжсэн дэвшил ДНБ-ний өсөлтөөс таамаглаж буй нэлээд доогуур байгаа нь харагдаж байна. Нэн ялангуяа байгаль орчин үзүүлж буй сөрөг нөлөө, нийгмийн шударга бус байдлыг оруулан тооцосны дараагаар зарим орны GPI өсөлт байтугай бууралттай гарчээ.

ДНБ-нээс өөр үзүүлэлтээр эдийн засгийн дэвшлийн хэмжих эрэл үргэлжилсээр байна: Францын ерөнхийлөгч Саркози өндөр түвшний

Өсөлтийн тухай  
зөрүүтэй ойлголтууд

“Genuine Progress Indicator GPI индекс”

Бусад эх сурвалжууд:  
Михаел Даудерштаedt  
2007 Нийгмийн  
бүтээмж үү? эсхүл  
дахин хувиарлалт үү?  
Бүтээгдэхүүний үнийг  
нэмэгдүүлэх шинэ  
бодлогын сорилтууд  
Берлиний Бүгд  
Найрамдах Улс 3/2007

мэргэжилтнүүдээс бүрдсэн комиссыг томилж амьдралын чанар, нийгмийн дэвшил, байгаль орчны үзүүлэлтүүдийн индикаторуудыг боловсруулах үүрэг өгчээ. Комиссын судалгааны үр дүнг засгийн газрын ирээдүйн үйл ажиллагаанд харгалзан үзэх гэнэ.

## 5.УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХАРЬЦУУЛАХУЙ

Товиас Гомбарт

Энэхүү бүлэгт:

- ~ Бундестагт суудалтай улс төрийн таван намын хөтөлбөрийг эдийн засгийн бодлогын байдлаар нь харьцуулна.
- ~ Зохицуулалттай ба зохицуулалтгүй эдийн засгийн загварууд дээр үндэслэн тэдгээрийн дэвшүүлсэн зорилтуудад дүн шинжилгээ хийнэ.
- ~ Нийгмийн ардчилалын үзэл баримтлалд загвар болгон төсөөлсний дагуу тэдгээрийг чанарын өсөлтөд хандах хандлагынх нь дагуу ангилна.

Ямар намыг эдийн засгийн бодлого боловсруулах чадамж хамгийн өндөртэй гэж үздэг бэ? Ямар нам хөдөлмөрийн зах зээлийн асуудлуудыг хамгийн сайн шийдвэрлэж чадах бэ? Ямар нам нийгмийн бодлогын салбарт хамгийн сайн хөтөлбөртэй бэ? Эдгээр асуултуудын дагуу явуулдаг дүн шинжилгээний хариултыг Бундестагийн сонгууль бүрийн өмнөх орой танилцуулдаг. Зарим нэг савлагааг эс тооцвол ерөнхийдөө хөрөнгөтний намуудыг эдийн засгийн бодлогын чадамжаар илүү гэж үнэлдэг. Харин нийгмийн бодлогын чадамжаар зүүний чиглэлийн намуудыг илүү гэж үздэг. Улс төрийн намуудад өгдөг зарчмын үнэлгээ харьцангуй тогтвортой, улс төрийн намуудын ерөнхий чиг хандлагуудыг нотолж байдаг. Энэ үнэлгээ үнэнд нийцэж байна уу? Хариулт нь : Тийм бас үгүй.

Улс төрийн намуудыг барууны болон зүүний хэмээн ангилдаг дээрх үнэлгээ хязгаарлагдмал хүрээнд тухайн намын чиг хандлага, үндсэн фокусыг илэрхийлж байдаг. Гэсэн хэдий ч дээрх асуултуудад бүрхэг зүйл олон байгаа юм. Эдгээр асуултууд нь намуудын эдийн засаг ба нийгмийн бодлогын чадамж болон намуудын бодлогын чадамжуудын хоорондын уялдааг илэрхийлдэггүй. Эдийн засгийн бодлогын чадамжийг зөвхөн хязгаарлагдмал хүрээнд эдийн засгийн бодлогын үйл ажиллагааны үндэслэлийг хэрхэн гаргаж байгаагаар нь хэмжих нь дэндүү явцуу тул илүү өргөн хүрээнд авч үзэх ёстой бөгөөд нийгмийн бодлого болон бодлогын бусад салбаруудтай авцалдаж байх ёстой гэдгийг бодолцох ёстой. Эдийн засгийн бодлого нь нийгмийн бодлого мөн тул үүргээ гүйцэтгэх чадамжтай эдийн засаг нь ямагт нийгмийн системийн өмнө хариуцлага хүлээж нийгмийн бүх салбаруудтай авцалдаж байх ёстой. Хэрэв бид улс төрийн намуудын

эдийн засгийн бодлогын хөтөлбөрүүдийг шинжлэн судлахыг зорьж байгаа бол нийт хөтөлбөрийг заавал нийтэд нь судалж дараа нь тухайн намын нэгдсэн хөтөлбөрийн дунд төсөөлж буй, хүрэхийг эрмэлзэж буй эдийн засгийн системийн ролийг авч үзэх ёстой. Ингээд чигийг заагч луужингийн заасан зүгт хамтдаа аялцгаая: Чиг хандлагыг тогтоохын тулд зөвхөн хүрэхийг эрмэлзэж буй эдийн засаг бус харин гарааны цэгийг мөн тодорхойлох ёстой. (Өмнөх бүлгүүдэд бид энэ талаар бичсэн.)

Улс төрийн намуудын бодит байдлын дүн шинжилгээ ба хүрэх зорилтуудын хөтөлбөрүүдийн хооронд том зөрүү байгаа нь намуудын хөтөлбөрөөс тодорхой харагддаг. Дараах дэд бүлгүүдэд улс төрийн намуудын эдийн засгийн бодлогын бүлгүүдийг танилцуулж зохицуулалттай ба зохицуулалтгүй эдийн засгийг тодорхойлдог категориудын дагуу тайлбарлах болно.<sup>7</sup>

### 5.1. Хамбургийн хөтөлбөр - Германы Социал Демократ Намын (ГСДН) мөрийн хөтөлбөр

ГСДН 2007 онд Хамбургийн хөтөлбөрөө баталсан. Уг хөтөлбөр нь 2007 оныг хүртэл баримталж ирсэн мөрийн хөтөлбөрүүдийн чиг шугамын үргэлжлэл юм. Эдийн засгийн бодлогын төсөөллийн чиг шугам нь 1959 онд батлагдан гарсан Годесбергийн хөтөлбөртэй харьцуулахад бага зэргийн өөрчлөлт орсон ч хэвээр хадгалагдан үлдсэн байна. Бидний хувьд “Өрсөлдөөнийг аль болох чөлөөтэй байлгаж, төрийн зохицуулалтыг зөвхөн шаардагдах хэмжээнд” байлгах зарчмыг баримтлах болно. (43-р хуудас)

Үндсэн төсөөллийн хувьд юуны өмнө зохицуулалттай эдийн засаг байх бөгөөд төр ба зах зээлийн хоорондын харьцаа нь зэрэгцэн орших харьцаа бус харин улс төр давуу эрхтэй байна. Тэгэхлээр эдийн засгийн бодлогын төсөөллийн дагуу “зохицуулагч төр” нь зөвхөн “шаардагдах” хэмжээнд зохицуулагчийн үүргийг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл бодлогоор зохицуулалт хийх “Шаардлага” байдаг гэдэг үүднээс асуудалд ханддаг. Ямар учраас “зохицуулагч төр” байх ёстой юм бэ?

Зохицуулагч төртэй байх шаардлага ба төрийн зохицуулалтын хязгаарууд нь дараах хоёр үндсэн ойлголтоос эхтэй: Нэг талаас зохицуулалтгүй эсхүл хангалттай зохицуулалтгүй зах зээлийн гажуудлыг судалдаг. Нөгөө талаас ардчилсан социализмыг байгуулах

---

7 Энд дээр тайлбарласан категориудыг товчилсон. “Компаниуд хоорондын харилцаа” гэдэг категориыг намуудын хөтөлбөрт бараг хэрэглэдэггүй эсхүл зөвхөн дурьдаад өнгөрдөг учраас энд уг ойлголтыг дурьдалгүй орхилоо.

зорилт юм. Ардчилсан социализмын баталгаа нь гагцхүү зохицуулагч төртэй идэвхтэй, ардчилсан нийгэм юм. ГСДН -д ногдуулж буй нийгмийн бодлогын үүргийг хэрхэн хэрэгжүүлэх тухай төсөөллөө ГСДН уг хөтөлбөрөөрөө илэрхийлж буй хэрэг юм.

Хамбургийн хөтөлбөр нь зах зээлийн нөлөө ба гажуудлуудыг нэгтгэн тодорхой дүгнэлт өгсөн юм. “Бидний хувьд зах зээл нь шаардлагатай бөгөөд эдийн засгийн зохицуулалтын бусад хэлбэрүүдээс давуутай хэрэгсэл юм. Өөрийн гольдролоороо хөгжих зах зээл нь нийгэм, экологийн хувьд сохортой адил. Чөлөөт зах зээл нь төрийн үйлчилгээг зохистой хэмжээгээр нийлүүлэх чадваргүй байдаг. (17-р хуудас). Зах зээл сайн дураараа нийгэм, эдийн засаг, экологийн хариуцлага хүлээдэггүй, харин зах зээлд нийгмийн хүрээлэл тогтоож бодлогоор зохицуулалт хийх замаар зах зээлд хариуцлага ногдуулах боломжтой. Өнөөгийн даяаршсан зах зээлийн нөлөө болох баян хоосны ялгаа, экологийн хямралыг зах зээл шийдэх нь байтугай улам нэмэгдүүлж байна. Бүтээмжийн үйлдвэрлэлээс бүх хүн хувь хүртэх ёстой л юм бол зохицуулалт, нийгмийн хэлэлцээрүүд, удирдлага зайлшгүй нэн даруй шаардлагатай.

Ардчилсан социализмыг байгуулах нь бидний хувьд чөлөөт, шударга, эв санааны нэгдэлтэй нийгмийг байгуулах зорилт бөгөөд түүнд хүрэх

#### “Тэгш байдлыг хангах” зорилт

Бид амьжиргааны баталгааг хангах эх үүсвэр болсон хөдөлмөрт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхт, шударга оролцоог хангахын төлөө байна. Эмэгтэйчүүд зонхилон эрхэлдэг хөдөлмөр нь ихэвчлэн бага цалинтай байдаг. Ижил хөдөлмөрт ижил цалин олгох хэрэгтэй. (...) Эмэгтэйчүүдийн тэгш оролцоог компаниуд, захиргаа, шинжлэх ухаан, судалгаа болон хяналтын бүтцүүдийн удирдах түвшинд хангахын тулд хуулийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 41-р хуудас)

нөлөөлдөг байх зорилтын төсөөллийг зөвхөн Германд бус даян дэлхийд хэрэгжүүлэхийн төлөө байна. Зорилтын төсөөлөл нь уг зорилтод төрийн заавраар биш, харин төр ба иргэний нийгмийн байгууллагуудын актёрууд хамтран ажилласны үр дүнд хүрэх болно гэдэг хөгжлийн сэтгэлгээн дээр суурилсан. “Бид дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө баттай зогсож ардчилсан бодлогод давуу эрхийг олгох нь зүйтэй хэмээн үзэж бодлогыг зөвхөн төрийн бодлогын хүрээнд авч үздэг явцуу сэтгэлгээг халж бодлогын оролцоог үл тоомсорлохын эсрэг байна. Бодлого зохицуулалтад нийгмийн

нь бидний урт хугацааны даалгавар мөн. Бидний үйл ажиллагааны зарчим бол нийгмийн ардчилал мөн. (16-р зүйл). Одоогийн байгаа нөхцөлийн дүн шинжилгээн дээр үнэт зүйлс ба тэдгээр нь хүн бүрийн амьдралд хязгаарлалтгүй хэрэгжиж

холбоод, тэдгээрийн сүлжээ, хүмүүсийн чөлөөт, сайн дурын үйл ажиллагаа хамаарагддаг гэдгийг үл тоомсорлогчдын эсрэг зогсох болно.

Онцгой тохиолдолд даяаршил, хүйсийн тэгш байдлыг хангах, Европын Холбооны өсөн нэмэгдэж буй ач холбогдлыг орчин үеийн эдийн засгийн бодлогод тулгарч буй сорилтууд хэмээн нэрлэдэг. Зах зээлийн эдийн засгийн зохицуулалттай хэлбэрийг дээр дурьдсан зах зээлийн гажуудлыг залруулж зорилтын төсөөллийг хэрэгжүүлэхийн тулд цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай.

**Компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах зорилт**

“Улс үндэстний төр зах зээлд нийгмийн болон экологийн ерөнхий нөхцөлийг тогтоож өгөх боломжгүй болсон нөхцөлд Европын холбоо тэдгээрийг тогтоож өгөх ёстой. (...) Улс үндэстний хил хязгаарыг давсан эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж буй нөхцөлд ажилтнуудын эрх ашиг тухайн улсын хилээр хязгаарлагдах ёсгүй. Ийм ч учраас бид европын компаниудад компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангаж, бэхжүүлэхийн төлөө байна. Европын түвшинд тарифын автономит байдлыг бэхжүүлж хэрэгжүүлэхийн тулд улс орнуудын хил хязгаарыг дамнасан тарифын хэлэлцээрүүд, тарифын гэрээг байгуулахад шаардагдах европын нэгдсэн эрх зүйн орчинг бүрдүүлэхийн төлөө байна.”

(Хамбургийн хөтөлбөр 2007:26,28)

**Санхүүгийн систем:** Хөрөнгө болон санхүүгийн зах зээлүүдийн нөлөөг Хамбургийн хөтөлбөрт бие даасан бүлэг болгон оруулсан. Уг бүлэгт компаниудын санхүүжилт ба удирдлагын нийгмийн ач холбогдол нэмэгдэж буйг (Германд мөн адил) харуулсан. “Бид хөрөнгийн зах зээлүүдийн чадавхийг чанарын өсөлтөнд ашиглахыг зорьж байна.” (46-47 хуудас) . Гэхдээ сөрөг талууд болон улам бүр нэмэгдэж буй хямралын эрсдэлийг анхаарлын гадна орхиж болохгүй. “Санхүүгийн зах зээл нь богино хугацаанд өндөр ашиг олохын төлөө ажилладаг улс оронуудад санхүүгийн зах зээл нь компаниудын урт хугацааны өсөлтийн стратегид аюул учруулж улмаар ажлын байруудыг үгүй хийдэг. Бид хөрөнгө оруулагчдын хувьцааны эрхийг баталгаажуулах замаар богино хугацаанд их ашиг олох төсөлд биш харин урт хугацааны дараа ашгаа өгөх төсөлд хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчдын сонирхлыг дэмжих болно. Бидэнд богино хугацаанд өндөр ашиг олох нэг талт зорилтуудаараа компаниудын удаан хугацаанд оршин тогтнох байдалд саад учруулдаг хөрөнгө оруулагчид, сангуудын үйл ажиллагааг зохицуулах тоглоомын дүрэм хэрэгтэй байна. Таваар болон санхүүгийн зах зээлүүдийн олон улсын сүлжээ хүчээ авч буй нөхцөлд тэдгээрийн үйл ажиллагааг олон улсын түвшинд зохицуулах зохицуулалтын ач холбогдол ч өсч байна.” (47) Үүний зэрэгцээ санхүүгийн зах зээлийн удаан хугацаанд, тогтвортой ажиллах нөхцөлийг хангахын тулд мөн жижиг, дунд

үйлдвэрүүдийн хувьд чухал хүчин зүйл болох, түүнчлэн бүс нутгийн эдийн засагт голлох ач холбогдолтой байж болох хадгаламжийн кассууд, хоршооллын банкуудыг дэмжих шаардлагатай байна.

**Хөдөлмөрийн харилцаа:** ГСДН ажилчны хөдөлгөөний уламжлалыг хадгалахын төлөө байна. ГСДН-ын бодлого ажилтнуудын эрхийг хангах, сайжруулахад чиглэгддэг. Үүний тулд эдийн засгийн үндсэн журмын хүрээнд өнөөгийн зохицуулалтыг хэвээр хадгалах шаардлагатай. Тарифын автономит байдлыг хангаж нутаг дэвсгэрийн тарифын гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Тарифын гэрээнд оролцогч талуудын шийдвэр гаргах эрхийг компани, аж ахуйн нэгжийн түвшинд шилжүүлж болохгүй. Хуулиар тогтоодог цалингийн доод хэмжээ нь тарифын автономит байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх ёстой. Компаниудын “дотоод ардчилал” –ыг бэхжүүлэх зарчмыг хэрэгжүүлж компанийн ажилтнуудын зөвлөл ба төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт ажилтнуудын оролцоог бэхжүүлэх шаардлагатай. Хөдөлмөрийн харилцаанд ажилтнуудын эрх ашигт шууд болон шууд бус байдлаар эерэгээр нөлөөлөх ёстой хоёр саналыг Хамбургийн хөтөлбөрт дэвшүүлсэн. Ажилтнуудын компанийн хөрөнгөнд оролцох оролцоог ажилтнуудын оролцоо бүхий санг компаниас гадуур байгуулах хэлбэрээр нэмэгдүүлэх, ажилгүйдлийн даатгалыг мэргэжил дээшлүүлэх, гэр бүлийн шалтгаанаар ажлаасаа чөлөө авсан ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг хөдөлмөрийн даатгал болгон өргөжүүлэх замаар ажилтнуудын байр суурийг ажил олгогчдын өмнө бэхжүүлэх саналууд юм.

**Мэргэжил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтын систем:** Мэдлэг олгох талыг нь төр хариуцдаг, дадлага ур чадвар олгох талыг нь ажил олгогч хариуцдаг хосолмол мэргэжлийн сургалтын системийг хэвээр нь хадгалах шаардлагатай. Мэргэжлийн сургалтыг санхүүжүүлдэг эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан санхүүжилтийн системийг байгуулах шаардлагатай. Ингэснээр сургалтын орон тоог өнөөгийнхөөс нэмэгдүүлэх боломж нээгдэнэ. Эхний мэргэжил олгох сургалт үнэ төлбөргүй хэвээрээ байна. Зарим төлбөртэй сургалтыг төлбөргүй болгоно. Харин мэргэжил дээшлүүлэх сургалтыг мэргэжлийн сургалтын гуравдагч багана хэмээн үзэж ач холбогдлыг нэмэгдүүлэх болно.

**Аж үйлдвэржилтийн бодлого:** Төр ба нийгмийн зүгээс бодлогоор дэмжиж буй шинэ зах зээлүүдийг (жишээлбэл сэргээгдэх эрчим хүч, үйлчилгээ ба эрүүл мэндийн салбар, мөн орон нутгийн гар урлал) зэргийг тэргүүлэх зах зээл гэж нэрлэлээ. Олон нийтийн /төрийн мэдлийн/ дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх нь чухал үүрэг гэж үзсэн.

Хамбургийн хөтөлбөрийг бүхэлд нь чанарын өсөлтийг дэмжих хөтөлбөр гэж нэрлэж болно. Нийгмийн тэнцвэрт байдал, экологийн тогтвортой байдал, өсөлтийг эн тэнцүү дэмжихэд уг хөтөлбөр чиглэгдсэн.

## **5.2 Германы ерөнхий зарчмууд - Христосын Ардчилсан Холбоо Намын (ХАХН) хөтөлбөр**

ХАХН мөн 2007 онд мөрийн хөтөлбөрөө шинэчлэн баталсан. Уг хөтөлбөрийн цөм нь нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийг амжилтанд хөтлөх ирээдүйн загвар мөн гэж тодорхойлсон явдал юм. (....) ХАХН нь нийгмийн баримжаат зах зээлийн төлөө нам мөн. ХАХН коллективизмын социалист болон бусад хэлбэрүүдээс татгалзана. Мөн цэвэр өөрийн гольдролоороо хөгждөг, зах зээлд бүхнийг даатгасан, бидний эрин үеийн асуудлуудад хариулт өгөх чадваргүй хазааргүй капитализмаас татгалзана. Нийгмийн баримжаат зах зээл нь дахин нэгдсэн герман улсын хувьд ч даяаршлын эрин үед ч бидний зорилт хэвээрээ байх болно.” (46 –р хуудас.)

Коллективизмаас татгалзсан байдал нь “компанийн эздийн нийгэмлэг”-ийг бэхжүүлэх зорилт дээр дахин давтагдаж нийгмийн баримжаат зах зээлийн цөм бөгөөд гарааны цэг нь “ХАХН нь эрх чөлөөтэй, нийгмийн хариуцлагатай компанийн эздийн нийгэмлэгийн төлөө байна. Компаниудын эзэд болон удирдлагууд нь ирээдүйн баталгаатай ажлын байруудыг бий болгож тэдний алдар хүнд, соёлын хэв шинж нь Герман орны нэр хүндийг дэлхий дахинд өргөж байна. Компанийн эздэд амжилттай үйл ажиллагаа явуулахад шаардагдах чөлөөт орон зай, тохиромжтой ерөнхий нөхцлүүд, сонирхол татахуйц боломжуудыг бүрдүүлж өгөх ёстой.” (49-р хуудас)

Тэдний сэтгэлгээний үндсэн санаа нь ГСДН-ынхаас эрс ялгаатай, дэвшүүлж буй зорилтууд, зорилтуудад хүрэх арга зам нь өөр гэдэг



нь эндээс харагдаж байна. ХАХН нь чөлөөт, нийгмийн хариуцлагатай компанийн эздийн нийгэмлэг ба ёс суртахууны болон нийгмийн хариуцлагатай байхыг уриалдаг бол ГСДН бүх хүмүүсийн үндсэн эрхүүдийг хангахын тулд зохицуулалт, ардчилсан оролцоог хангахыг уриалдаг. Ингэснээр ХАХН -ын хувьд эдийн засгийн нийгэм болон ажилтнуудын өмнө хүлээх нийгмийн хариуцлагыг компанийн эздийн хувь хүний хариуцлагаа ухамсарлах ухамсарт даатгадаг.

Ингэснээр ХАХН-ын хувьд бодлогын гүйцэтгэх үүрэг илт буурсан: “Нийгмийн баримжаат зах зээл нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн өрсөлдөөний дэглэм мөн. Нийгмийн баримжаат зах зээлийн бодлого нь хэв журмыг сахиулах бодлого юм. (49-р хуудас) Тэгэхлээр: “Үйлдвэрлэл ба гэрээний эрх чөлөөг хангах, зах зээлийг саад тотгороос хамгаалах, зах зээлд ноёлж буй компаниуд эрх мэдлээ буруугаар ашиглахаас сэргийлэх, зах зээлийн ид тод байдлыг хангах, өрсөлдөөний шударга нөхцөлд зах зээлүүдийг олон улсад нээлттэй болгох. (49 ,52-р хуудас харьцуулах) зэрэг үүргийг төр хүлээнэ.

Ингэснээр зах зээлийн эдийн засгийн харьцаанд төрийн үүргийг либерал ойлголтын үндсэн зарчмуудын үндсэн дээр тодорхойлсон ч зарим нэг зохицуулалтын бүрэлдэхүүн хэсгүүдийг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсэн байна.

**Санхүүгийн систем:** Олон улсын хөрөнгө болон санхүүгийн зах зээлүүдийн ач холбогдол улам бүр нэмэгдэж буйг эерэгээр үнэлж Германд хөрөнгө оруулалт хийх боломжийг онцлон тэмдэглэж “Хөрөнгө оруулалтын боломж хайж буй сангууд, Private-Equity-Fonds буюу хувийн сангууд нь компаниудын өрсөлдөх чадвар болон техник, технологийн дэвшилд суурилсан эдийн засгийн шинэчлэлийг нэмэгдүүлэхэд Германд хувь нэмрээ оруулах боломжтой. (52-р хуудас) Юуны өмнө хувийн хөрөнгө оруулагчдын бүлгийн зах зээлийн эрх мэдэл эрсдэл дагуулах магадлалтай гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ ХАХН-ын үзэж буйгаар өдгөө үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудыг ашиглан “итгэж болох зохицуулалтын ерөнхий хүрээг” тогтоож ил тод байдлыг хангах боломжтой ажээ. (52-р хуудас )

**Хөдөлмөрийн харилцаа:** ХАХН-ын хөдөлмөрийн нөхцөлийг тогтоох чиглэлээр явуулж буй бодлого нь христын сүмийн нийгмийн ёс зүй дээр суурилдаг. (50-р хуудас). Тэгэхдээ хувь хүний өөрийгөө

хөгжүүлэх ёстой гэдэг шаардлагыг тавьж: “Компаниуд амжилттай ажиллахын тулд тэдэнд сайн боловсролтой, бүтээлч, санаачлагатай ажилтнууд хэрэгтэй. Сайн боловсрол, мэргэжил дээшлүүлэх сургалт нь ажилтнуудын хөдөлмөр эрхлэх, бүтээмжийг дээшлүүлэх баталгаа болно. Ажилтнуудад өөрсдийн мэдлэг чадвараа өргөн хүрээнд амжилттай хөгжүүлэх боломж олгохын тулд тэдэнд шийдвэр гаргалтанд оролцох боломж, хариуцлага, чөлөөтэй ажиллах, сэтгэх орон зайг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Үүний зэрэгцээ ажилтнуудад хувийн амьдралаа төлөвлөх боломж олгохын тулд тэдэнд хөдөлмөрийн болон нийгмийн эрх зүйн үндсэн баталгаа хэрэгтэй. Тэд нийгмийн хангалуун чинээлэг амьдралаас зохистой хувь хүртэх эрхтэй. (50-р хуудас) Хөдөлмөрийн харилцаанд хамтын хамгаалал, хамтын зохицуулалтын хэлбэрийг дэмжихээс элүүтэй шүүмжлэлтэй ханддаг. Иймээс тарифын автономийг хэвээр хадгалахын төлөө байдаг боловч тарифын гэрээнд оролцогч талуудаас салбарын тарифын хатуу заалт бүхий гэрээнээс ухралт хийж “Хариуцлагынхаа тодорхой хэсгүүдийг компаниудад шилжүүлэх”-ийг шаарддаг. (58-р хуудас) “Компанийн түвшинд хөдөлмөрийн төлөө нэгдэл” байгуулахыг хуулиар нэгэнт зөвшөөрсөн тул компаниудын дотоод журам, дүрмүүдийг тарифын хэлэлцээрүүдээс хүчтэй болгох хэрэгтэй гэж үздэг. Эрх мэдлийг ийнхүү шилжүүлбэл хөдөлмөрийн эрх зүйн мэргэжлийн байгууллагуудын хүрээнд халуухан маргаан өрнөж байгаа хөдөлмөрийн эрхийг хувьсгалчлах оролдлоготой ойролцоо үр дүнд хүрэх аж. Компаниудын шийдвэрт ажилтнуудын оролцоог хангахыг дэмждэг боловч цаанаа компанийн түвшний хэлэлцээрийг тарифын хэлэлцээрээс илүү хүчтэй болгох зорилтыг агуулж буй.

**Мэргэжлийн боловсрол ба мэргэжил дээшлүүлэх систем:** ХАХН ч мөн адил “Олон улсын өрсөлдөөнд байршлын давуу талыг бий болгодог, залуучуудын ажилгүйдлээс сэргийлэх хамгийн шалгарсан арга” гэж үздэг тул мэргэжлийн сургалтын дуал буюу хосолмол сургалтыг дэмждэг. (38-р хуудас). Хувийн болон төрийн өмчийн ажил олгогчдоос “Төрийн албадлагаар бус харин хариуцлагаа ухамсарлах ухамсар, зорилтот материаллаг сонирхлынхоо үүднээс” сургалтын орон тоог нэмэгдүүлэхийг шаарддаг. (39-р хуудас). Улсын дээд сургуульд суралцагсдаас “нийгмийн хэт ачаалал үүсгэхгүй байх хэмжээний сургалтын төлбөр”-ийг авах нь зүйтэй гэж үздэг.

Ерөнхийдөө ХАХН нь компанийн эздийн хариуцлагаа ухамсарлах

ухамсар дээр суурилсан нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийг хамгаалагч нам гэдэг имижийг хөтөлбөрөөрөө дамжуулан илэрхийлжээ. Эдийн засгийн бодлогын хувьд либерал үндсэн сэтгэлгээн дээр суурилсан зохицуулалтыг задлах олон талт саналуудыг дэвшүүлжээ.

### 5.3. “Ирээдүй ногоон байх болно.”

#### Холбоотон 90\Ногоонтнууд намын мөрийн хөтөлбөр

Холбоотон 90\Ногоонтнууд нам нь 2002 онд мөрийн хөтөлбөрөө боловсруулан гаргасан. Энд харьцуулж буй хөтөлбөрүүдийн дотор цаг хугацааны хувьд хамгийн удаж буй хөтөлбөртэй нам юм. Үндсэн санаа нь нийгмийг нийгмийн болон экологийн баримжаат зах зээлийн эдийн засаг болгон өөрчлөх, нарны эрчим хүч ашиглалтын эрин болгох зорилтыг дэвшүүлсэн юм. Экологийн нөөцийг тонон дээрэмдэх явдал нь ирээдүйн хамгийн том асуудал байх болно хэмээн тодорхойлжээ. Нийгэмд хийх шаардлагатай өөрчлөн байгуулалтыг зөвхөн байгаль орчны бодлогод төдийгүй, нийгмийн бодлогод өргөн хүрээтэй үр дагаврыг авчрах, нөхцөлүүдийг шаардах төслийн хэлбэрээр боловсруулсан.

Нийгмийн бодлогын зүгээс авч үзэхэд Холбоотон 90\Ногоонтнууд нам өөрийн либерал, (гэхдээ зах зээлийн либерал биш) төсөөллөөрөө бусад намуудаас ялгарахыг хүссэн нь илт. “Иймээс өнөөг хүртэл оршин буй компаниудын ашигтай ажиллагааг хангахад чиглэгдсэн нийгмийн баримжаат зах зээл нь өөрт ногдож буй хууль ёсны шаардлагуудыг биелүүлж чадахгүй байгаа учраас нэн даруй илүү боловсронгуй болгох шаардлагатай. Нийгмийн асуудлыг зөвхөн төрийн байгууллагын үйл ажиллагаагааны хүрээнд хязгаарлаж болохгүй. Нийгмийн хүчнүүдийн эрх чөлөөг хангахгүй бол, иргэдийн нийгмээ өөрчлөх идэвх санаачлагыг дэмжихгүй бол, нийгмийн дээд давхаргынхан доод давхаргынхаа өмнө үүрэг хүлээхгүй бол нийгмийн эв санааны нэгдэл хүнд сурталд хүлэгдэх болно. Бид төрийн хэрэгслүүдээр иргэний нийгмийг дэмжихийн зэрэгцээгээр төрийг хязгаарлах болно. Энэ бодлогоороо бид социалист төрийн, корсерватив, зах зээлийн либерал бодлогын загваруудаас ялгаатай загварыг хэрэгжүүлэх болно. (43-р хуудас). Ийнхүү Холбоотон 90\Ногоонтнууд нам нь экологи, нийгэм, соёлын ашиг сонирхлуудыг хангасан” зохицуулалтын ерөнхий нөхцөлүүдийг тогтоохыг шаардаж байна. (46-р хуудас)

**Санхүүгийн систем:** Холбоотон 90\Ногоонтнууд нам нь санхүүгийн системийн өнөөгийн хэлбэрт шүүмжлэлтэй ханддаг. Тэдний гол зорилт нь “Зах зээлд ноёлогч даяаршлын тавцан дээр тоглогчдын” эрх мэдлийг таслан зогсоох явдал. “Тийм ч учраас бид нэг талаас ардчиллын өмнө хариуцлага хүлээх ерөнхий нөхцөлүүдийг тогтоох, нөгөө талаас экологийн мэдээлэл, боловсролыг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй техник, бүтээгдэхүүнүүдийг сонирхох эдийн засгийн сонирхлыг бий болгох, түүнчлэн аж үйлдвэрийнхэнтэй тохиролцоонд хүрэхийн төлөө байна. (27-р хуудас) . Үүний тулд тэд зах зээлд хариуцлага ногдуулахын ач холбогдлыг өндрөөр үнэлж байна: “Эдийн засгийн даяаршил, ба энэхүү процессыг бодлогоор удирдах, даяаршилд хариуцлага ногдуулах явдал учир дутагдалтай байгаа тул энэ цоорхойг нөхөхийн төлөө байна. Европын Холбоо нь өнөөгийн хамгийн өргөн хүрээг хамарсан улс орнуудын хамтын хариуцлагын бүтэц бөгөөд энэ бүтцийг бий болгохын төлөө улс орнууд тусгаар тогтнолынхоо зарим хэсгийг өгөхөд хүрсэн юм. Европын Холбоо нь өнөөгийн эдийн засгийн бодлогынхоо шинэ либерал хандлагыг орхиж даяаршилд нийгмийн болон экологийн хариуцлага ногдуулахад олон улсын тавцан дээр илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэй байна. (17-р хуудас). Уг шаардлага даяаршлын эдийн засагт ч мөн тавигдаж байна. Олон улсын байгууллагуудыг цаашид хөгжүүлж санхүүгийн үндэстэн дамжсан үйл ажиллагаанд нийтээрээ хуульчлан дагаж мөрдөх журам, стандартуудын доод түвшинг нэвтрүүлэх шаардлагатай байна. (59-р хуудас). Ногоонтнуудын эдийн засгийн бодлогод бүс нутгийн эдийн засгийг дэмжих нь чухал асуудал боловч амьдралын дундаж түвшинг баталгаажуулахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг байнга харьцдаг банкууд, хадгаламжийн кассуудыг дурьдалгүй орхисноороо ГСДН-аас ялгаатай байна. (54-р хуудас харьцуулна уу.)

**Хөдөлмөрийн харилцаа:** Холбоотон 90\Ногоонтнууд намын хөдөлмөрийн харилцаанд дэвшүүлсэн гол зорилт нь “Аль болох олон хүмүүсийг эдийн засгийн амьдралын ухамсарт актёрууд” болгох явдал юм. (47-р хуудас). Энэ зорилтод хүрэхийн тулд компанийн ажилтнуудын хүчтэй зөвлөл, тарифын автономит байдал, тарифын гэрээнд оролцогч талуудыг (түншүүдийг) хүчтэй хэвээр байлгах хэрэгтэй гэжээ. Үүний зэрэгцээ “Эдийн засгийн хөгжлийн болон хөдөлмөр эрхлэлтийн бүтцийн улам бүр нэмэгдэж буй ялгаатай байдал нь бүс нутгийн хүрээнд болон салбаруудын онцлогт тохирсон хоорондоо ялгаатай тарифын шийдвэрүүдийг шаардаж байна” гэсэн атлаа (48-р хуудас) нутаг дэвсгэрийн тарифын гэрээг чухал ач

холбогдолтой гэж дурьдсан байна. Ингэснээр аажимдаа тарифын нэгдсэн гэрээний чиглэлд ойртож уг гэрээгээр зохицуулагдаагүй үлдсэн хөдөлмөрийн харилцааны асуудлуудыг илүү уян хатан, хувь хүмүүс ба компаниудын хооронд байгуулагдах салбарын онцлогт тохирсон, бүс нутгийн салбарын гэрээгээр нөхөх байдлаар зохицуулах бололтой. Холбоотон 90\Ногоонтнууд нам нь ГСДН-ын нэгэн адил "Үйлдвэрлэлийн хөрөнгөнд /үйлдвэрлэлийн хэрэгсэлд/ хүн амын оролцоог нэмэгдүүлэх" –ийн төлөө байна. (131-р хуудас). Уг зорилтод хүрэхийн төлөө компаниудад дотоод зохицуулалт хийх хэрэгтэй юу? Эсхүл компаниуд дундын нэгдсэн сан байгуулах замаар шийдэх үү? гэдгийг зориудаар нээлттэй орхижээ. Үүний зэрэгцээ компанийн хөрөнгөнд ажилчдын оролцоог нэмэгдүүлэх, компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах шаардлагуудыг нэгийг нь нөгөөгөөр нь үгүйсгэхгүйгээр хэлэлцэхийг шаардсан атлаа аж ахуйн нэгжүүд, компаниудын шийдвэрт ажилчдын оролцоог хангахдаа хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагад нийцүүлэхийг шаарджээ. "(131-р хуудас). Нийгмийн ямар шаардлага, хэрэгцээ байгаа талаар хөтөлбөртөө дурьдалгүй орхисон байна.

**Мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтын систем:** Мэргэжлийн сургалтын салбарт Холбоотон 90\Ногоонтнууд нам өнөөгийн тасралтгүй суралцагч нийгэмд хүн бүр боловсролын намтраа өөрийн хүссэнээр бичүүлэх боломжоор хангагдсан байх ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл хүссэнээрээ суралцах боломжоор хангагдсан байх ёстой гэжээ. (99-р хуудас). Тэд юуны өмнө богино хугацаатай эхний сургалтаар мэргэжил олгоод дараагийнх нь мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг эхний сургалт дээр суурилан явуулж байх "Барилга угсрах" хэлбэрийн сургалтын системийг санал болгосон байна. Эхний суурь сургалт буюу мэргэжил олгох сургалт нь тогтвортой байдлыг хангана гэдэг утгаараа (мэргэжлийн болон мэргэжлээс гадуур суурь мэдлэгийг олгох) үндсэн мэдлэг чадварыг олгоход чиглэгдэнэ. (100-р хуудас). Аж ахуйн нэгжүүд өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах нарийн мэргэшлийг олгох хариуцлагыг хүлээнэ. Тэд энэхүү байр сууриа ГСДН, ХАХН-уудтай харьцуулахад тодорхой тайлбарлалгүйгээр орхижээ. Германы мэргэжлийн сургалтын хосолмол системийг хэвээр хадгалах уу? Аж ахуйн нэгжүүд хариуцлага хүлээдэг хэвээрээ байх уу? гэдэг асуулт нээлттэй үлдэж байна. (Компаниуд мэргэжлийн сургалтын санхүүжилтийг хийж санхүүгийн болон мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтран сургалтын агуулгыг тодорхойлох хариуцлага

хүлээх үү?) Насан туршдаа суралцах боломж бий эсэх, хэрэв бий бол энэхүү боломжийг санхүү болон зохион байгуулалтынх нь хувьд хэрхэн баталгаажуулах бэ? гэдэг асуултыг мөн нээлттэй орхиж зөвхөн хувийн болон олон нийтийн (төсвийн) санхүүжилтийн хоорондын тэнцвэрт байдал хангагдаж байх ёстой гэдэг зааварчилгааг тарифын хэлэлцээрт оролцогч талуудад өгөөд орхисон байна. (103-р хуудас)

Бүхэлд нь авч үзвэл Холбоотон 90\ Ногоонтнууд намын хөтөлбөр нь үндсэндээ тогтвортой байдлыг хангахад чиглэгджээ. Төр болон эдийн засгийн хоорондын харьцааны асуудалд тодорхой хэлбэл зохицуулалттай зах зээл ямар байх ёстой бэ? гэдэг асуултанд либерал зорилт (Жишээлбэл: Зохицуулалтын ерөнхий хүрээ тогтоож өгөх, харин боловсролын системд хувь хүмүүсийн оруулах хувь) болон социалдемократ шийдлүүдийн холимогийг санал болгосон байна. Энэ нь эцэстээ хэрэгжих боломжтой нийгмийн загвар болж чадах эсэх нь эргэлзээтэй юм.

#### **5.4. Германы Чөлөөт Ардчилсан Намын (ГЧАН) Биесбадены хөтөлбөрийн үндсэн зарчмууд**

ГЧАН нь Бундестагт суудалтай таван намуудын дотор хамгийн эртний хөтөлбөртэй улс төрийн нам юм. Уг хөтөлбөрийг 1997 онд "Биесбадены ерөнхий зарчмууд" нэртэйгээр баталжээ. ГЧАН-ыг бусад намуудаас ялгарах онцлог нь хэлбэрэлтгүй либерал үзэл баримтлалтай нам юм. ГЧАН нь зохион байгуулалтай либерализмын намын хувьд ухаалаг бодлого, олон талт байдал, өрсөлдөөнийг шүтэж төрд бүхнийг даатгах, төрийн хөндлөнгийн оролцооноос татгалзах замаар дэвшилд хүрэхийг эрмэлзэгч нам гэдгээрээ бусад улс төрийн намуудаас эрс ялгардаг. (6-р хуудас). Төрийн үүрэг нь ГЧАН-ын шүүмжлэлийн бай төдийгүй улс төрийн шийдлийн тулах цэг нь юм. "Хүнд сурталт төрийн эдийн засаг" нь "хүнд суртлын хаалтуудаараа" эдийн засаг ба нийгмийн чөлөөт, уян хатан хөгжлийг боогдуулдаг. "Либералууд хамгийн шилдэг нийгмийн болон экологийн чиг хандлага бүхий төрийн эдийн засгийн оронд хамгийн шилдэг нийгмийн болон экологийн үр дүнтэй зах зээлийн эдийн засгийг байгуулахыг зорьж байна." (6-р хуудас) Либералууд нэн тэргүүнд төрийн зүгээс зах зээлд хөндлөнгөөс оролцохыг зогсоох, ашиг сонирхлын бүлгүүдийн эрх мэдлийн нэгдлийг зогсоох замаар эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлж улмаар "Нийгмийн бүтээмжийг нэмэгдүүлэх" боломжтой гэж үзэж байна. (14-р хуудастай харьцуулах). Хувьчлах шаардлагыг үндсэн

хуульд тусгах, аливаа сонгон шалгаруулалтанд хувийн болон төрийн өмчийн компаниуд ойролцоо санал өгсөн тохиолдолд хувийн эдийн засагт давуу тал олгож байх тухай заалт оруулах санал дэвшүүлсэн нь уг шаардлагаа дахин батлах гэсэн оролдлого юм. (30-р хуудас, харьцуулах). ГЧАН нь эдийн засгийн үндсэн зорилтоо “Нийгмийн болон экологийн баримжаат зах зээлийн эдийн засаг” -ийг байгуулах гэж тодорхойлсон байна. Тэгэхдээ ГЧАН нь ХАХН болон Холбоотон 90\ Ногоонтнууд намаас эрс өөрөөр эдийн засгийн зорилтоо тодорхойлсныг тэмдэглэх нь зүйтэй.

**Санхүүгийн систем:** Санхүү болон хөрөнгийн систем чөлөөтэй байх ёстой гэдэг энэхүү товч томъёолол нь ГЧАН-ын байр суурийг тодорхой илэрхийлдэг. Зах зээлийн тусын тулд хүчирхэг Европын Холбоо нь өрсөлдөх чадвараа хадгалан үлдэх ёстой бөгөөд 1997 оны байр суурьнаас харахад Либералуудын хувьд “Либералууд ард түмний өмчтэй байхын оронд өмч эзэмшигч ард түмэнтэй болохыг хүсч байна. Өмчтэй болох боломж нь бүтээмжийг нэмэгдүүлэх сонирхлыг идэвхжүүлж нийгмийн аюулгүй байдлыг хангаж хариуцлага хүлээхэд бэлэн байдлыг дэмждэг. Өмчтэй болох боломж нь эрсдэл хүлээхэд бэлэн байх шинэ соёл ба бие даасан байдлын шинэ соёлыг нутагшуулах нэгэн нөхцөл юм. (15-р хуудас). Компанийн эздийн хувийн хөрөнгийн санхүүжилтийн суурийг хувийн мөнгөөр болон хөрөнгийн зах зээлээр дамжуулан мөн “өрсөлдөөний хязгаарлалт”-ыг сулруулах замаар нэмэгдүүлэх ёстой гэсэн нь тэдний энэ санааг давхар нотлож байгаа юм. “Төр зөвхөн эмх журмыг сахиулах үүрэгтэй: “Германы болон Европын эдийн засгийн олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг бусдаас илүү байлгахын тулд Европын тогтвортой нэгдсэн мөнгөн тэмдэгттэй байх шаардлагатай. Олон улсын валютын сан дотоодын зах зээлийг үгүй хийж байна. (25-р хуудас). ГЧАН-ын эдийн засгийн бодлогын үндсэн зорилт нь хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлүүдийг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татахад чиглэгддэг.

**Хөдөлмөрийн харилцаа:** ГЧАН хөдөлмөрийн харилцааны салбар дахь өөрчлөлтийн саналаа нэгэн өгүүлбэрт багтаан оновчтой илэрхийлсэн: “Хамтран ажиллагсдаас хамтран эзэмшигчид бий болох ёстой.” (15-р хуудас). Үйлдвэрлэгч хөрөнгөнд эзэлж буй өмчлөлийн квот буюу ажиллагсдын эзэмшлийн хувийг дээрх зорилтод хүргэхийн тулд эрс нэмэгдүүлэх шаардлагатай. ГЧАН “Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах асуудалд “албан тушаалтнуудын

оролцоог хангаж байна” хэмээн шүүмжлэлтэй ханддаг. Үүний цаана компаниудын ажилтнуудын зөвлөлөөр дамжуулан хамтын шийдвэрийг хангахын эсрэг байна уу? Төлөөлөн удирдах зөвлөлүүдээс ажилтнуудыг хасах, хязгаарлах сонирхол нуугдаж байна уу? эсхүл сайжруулах сонирхол байна уу? гэдгийг намын хөтөлбөрөөс олж мэдэх боломжгүй байна. Мөн үйлдвэрлэгч хөрөнгөнд хамтран ажиллагсдын ( ажилтнуудын) оролцоог бий болгох шаардлагад компани, аж ахуйн нэгжийн шийдвэрт ажилтнуудын нөлөөлөх боломжийг хэрхэн бүрдүүлэх бэ? гэдэг асуудлыг нээлттэй орхисон байна. Бие даасан хамтран эзэмшигчдийг төрүүлэх санаа нь “компани ба хувь хүмүүсийн хооронд”-ын нэг бүрчлэн гэрээ байгуулна гэсэн санаа бололтой. Гэтэл нутаг дэвсгэрийн тарифын гэрээнээс илэрхий татгалзаж байгаа мөртлөө ажилтнуудын оролцоог ямар хэлбэрээр зохион байгуулахаа компаниуд өөрсдөө шийдэх эрхийг нь олгох, (14-р хуудас) нээлттэй болгох ерөнхий горимыг (хуулиар) бүрдүүлж өгөх ёстой гэжээ. ГЧАН -ын саналууд нь бүхэлдээ Германы хөдөлмөрийн эрх зүйн салбарт хувьсгал хийхийг шаардаж байгаа бөгөөд ингэлээ гээд цаад санааг нуун далдлах боломжгүй юм. Зарчмын (хуулиар тогтоосон ) нээлттэй болгох журмууд нь тарифын автономит байдлыг хангах үндсэн зарчимд аюул учруулах болно. Аж ахуйн нэгжүүдийн дотоод журамд давуу байдал олгох буюу тэдгээрийг илүүд үзэх нь өнөөг хүртэл мөрдөгдөж ирсэн эрхзүйн пирамидын оройг суурь болгон эргүүлэх болно. Эрх зүйн пирамид нь нэг талаас хуулиуд болон тарифын гэрээний заалтуудыг аж ахуйн нэгж, хувийн тохиролцооноос илүүд үзэх нөгөө талаас ажилтнуудын эрх ашигт илүү нийцтэй байх (ажилчдад таатай байх нөхцөлийг сонгох журмыг) зарчмаар хөдөлмөрийн харилцааны асуудлыг шийдвэрлэхийг шаарддаг. Эрх мэдлийг компаниудад шилжүүлснээр бий болсон эрх мэдлийг хэрхэн хянах бэ? гэдэг асуултыг бүхэлд нь нээлттэй орхисон байна.

**Мэргэжлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх сургалтын систем:** ГЧАН-ын мэргэжлийн сургалт болон мэргэжил дээшлүүлэх сургалтын системийн талаар дэвшүүлсэн зорилтууд нь маш ерөнхий. Энд хөдөлмөрийн харилцааны нэгэн адил “Нээлттэй байдал, өрсөлдөөн” –ийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ гэжээ. “Хүнд суртлын дарамт, дүрэм журмын зохицуулалтыг “бууруулж хувийн секторын компани, аж ахуйн нэгжүүдийн өгч буй саналыг илүү дэмжиж зөвшөөрөл олгох хэрэгтэй” гэжээ. (24-р хуудас). Үүнээс өөр тодорхой санал дэвшүүлээгүй бөгөөд “бүх салбарт мэргэжлийн боловсролын уян



хатан дасан зохицох чадварыг нэмэгдүүлж улам боловсронгуй болгох” шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна. ГЧАН-ын хөтөлбөр нь бүхэлдээ зохицуулалтгүй зах зээлд шилжих тухай шаардлага юм. Бараг л бүх асуудлыг төрийн болон хүнд суртлын дарамтаас үүдэлтэй гэж үзээд бараг л бүх зах зээлд илүү эрх чөлөө олгосноор бүх асуудал шийдэгдэнэ гэжээ. Албадлагаас (мөн төрийн албадлагаас) ангид байх эрх чөлөөг эрх чөлөө гэнэ хэмээн тодорхойлжээ. Уг хөтөлбөр либерал радикал шинжтэй тул либералчлах бүх хүсэлтийг нэгийг ч орхигдуулалгүй багтаасан гэж хэлж болно.

#### 5.5. “Зүүний нам” –ын “Хөтөлбөрийн үндсэн зорилтууд”

Ардчилсан Социализмын Нам болон Хөдөлмөр ба нийгмийн шударга ёс-сонгуулийн хувилбар намаас үүссэн “Зүүний нам” нь жинхэнэ хөтөлбөртэй болж хараахан амжаагүй байна. Гэхдээ Хөдөлмөр ба Шударга ёсны Сонгуулийн Хувилбар Нам болон Зүүний намын хамтарсан Их хурлаас “Хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг” –ийг баталсан байна. Уг баримт бичгийг Ардчилсан Социализмын Нам нь 2007 оны 3-р сард баталсан бөгөөд (Улс төрийн намуудын тухай хуулийн шаардлагыг хангахын тулд) хуулиар намын хөтөлбөртэй байхыг шаарддаг учраас уг заалтанд нийцүүлэн гаргасан хэлбэр төдий хөтөлбөр юм. Агуулгын хувьд нь авч үзвэл энэхүү “хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг” нь хөтөлбөрийг орлож чадахгүй бөгөөд харин бусад үзэл баримтлалуудаас юугаараа ялгаатай юм бэ? гэдэг асуултанд хариулт өгөхөд чиглэгджээ.

“Зүүний нам” –ын үндсэн зорилт нь “чөлөөлөгдсөн капитализм” –ын нэгэн хувилбар болох “эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан шинэчлэлт банийгмийг туйлбартай ардчилах” хувилбарыг хэрэгжүүлэх явдал юм. (1-р хуудас): “Ардчилал, Эрх чөлөө, Тэгш байдал, Шударга ёс, Интернационализм, Эв санааны нэгдэл нь бидний үнэлэмжийн үндсэн чиг хандлага юм. (...) Эрх чөлөө ба нийгмийн аюулгүй байдал, ардчилал, социализм нэг нь нөгөөгийнхөө хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг харилцан шүтэлцээтэй. (2-р хуудас). Үүний тулд эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хамтын өмчлөлд шилжүүлэхэд үндсэн хуулиар олгогдсон боломжийг ашиглаж хувийн болон олон нийтийн өмч дээр суурилсан “үр ашигтай, ардчилсан эдийн засаг”-ийг байгуулах боломжтой гэжээ.

“Зүүний Нам” бодлогын болон чиг хандлагын өөрчлөлт”-ийг өргөн хүрээнд хийх санаачилгыг гаргасан байна. Энэ өөрчлөлтийг хэр өргөн хүрээнд хийх ёстой бэ? гэдгийг “Хөтөлбөрийг үндэслэх баримт бичиг” -ээс багцаалах боломжгүй, бодлогын ямар жигүүр тэргүүлэх байр суурь эзэлж бодлогоо хэрэгжүүлэхийг хүлээхээс өөр аргагүй бололтой.

**Санхүүгийн систем:** Олон улсын санхүү ба хөрөнгийн зах зээлийн нөлөөг “Зүүний нам” -аас өнөөгийн нийгмийн хямрал ба тэгш бус байдлыг үүсгэж буй чухал хүчин зүйл гэж үнэлсэн байна. “Даяаршлын санхүүгийн зах зээлээр дамжин хөрөнгийн ашиг олох боломж дэлхий дахинд ямар ч хязгаарлалтгүй болжээ. (...) Хөрөнгийн хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг улам нэмэгдүүлж байгаа нь гэр бүл, хүмүүсийн хамтын амьдралын хэлбэрүүдийг сүйтгэж байна. (...) Шинэ либерал капитализм нь ардчиллыг хумьж байна. Олон улсын санхүүгийн сангууд, үндэстэн дамнасан концернууд, даяаршсан капитализмын олон үндэстний байгууллагууд болох Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэгт асар их эрх мэдэл төвлөрч байна. Тэд ардчилсан хяналтын гадна оршиж байна. (5-р хуудас). “Зүүний нам” -ын үзэж буйгаар санхүүгийн системийг шинэчлэн байгуулах хэрэгтэй байна. Үүний тулд тэд нэг талаас “Санхүүгийн зах зээлийн ардчилсан хяналт”, нөгөө талаас зах зээлд эзэлж буй давуу талаа буруугаар ашиглахгүй байхад тавих хяналтыг чангаруулах замаар “Хувийн эдийн засгийн эрх мэдлийн төвлөрлийг сааруулах” –ыг шаардаж байна. Үүний зэрэгцээгээр эдийн засгийн эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан зохион байгуулалтыг (хоршоолол) дэмжих (11-р хуудас), төрийн албаны секторыг хөгжүүлэх, (8-р хуудас), “хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд” (9-р хуудас) -ээр санхүүгийн системийг өргөжүүлэх хэрэгтэй.

**Хөдөлмөрийн харилцаа:** “Зүүний нам” нь хөдөлмөр гэдэг ойлголтыг зөвхөн талхаа олж идэх арга гэдэг утгаар ойлгохгүй: “Бид эрэгтэй, эмэгтэй бүх хүн амьжиргааны эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдсан нийгмийг байгуулахын төлөө байна. Орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөр, гэр бүл, хамтын амьдралын хүрээн дэх хөдөлмөр, нийгмийн дэвшилд хүрэхийн төлөөх хөдөлмөр болон соёл, нийгмийн амьдралд оролцох оролцоо хүн бүрт нээлттэй байх ёстой.” (7-р хуудас). “Зүүний нам”

өнөөгийн хөдөлмөрийн харилцаанд үйлчилж буй хуулийн болон тарифын зохицуулалтыг илүү чангаруулахын төлөө байна. Үүний тулд тарифын автономит байдлыг хангахын зэрэгцээ “Амьжиргааны баталгаажих доод түвшинг хангах цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох”, “Ажилтнуудыг ажлаас халагдахаас хамгаалах хууль” -ийг чангатгах, “Бүх ажилтнуудын компанийн шийдвэр гаргалтанд оролцох оролцоо” -г нэмэгдүүлэх, “Тарифын гэрээний нийтээр дагаж мөрдөх байдал” –ыг чангатгахыг шаарджээ. Компаниудын шийдвэр гаргалтанд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд компанийн ажилтнуудын зөвлөлд ажилтан ба ажил олгогчдын тэгш оролцоог хангахыг мөн шаардсан байна. (13-р хуудас). Улс төрийн ажил хаялт хийх эрх өдгөөг хүртэл энх тайвныг сахиулах үүргээ биелүүлэх гэрээний улмаас хэрэгжихгүй ирснийг хэрэгжүүлэх цаг нь болсон гэж үзжээ. (13-р хуудас). Эдгээр жишээнүүд “Зүүний нам” эдийн засгийн салбарт нийгмийн болон төрийн зохицуулалтын төлөө байгааг харуулж байна.

#### **Мэргэжлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх сургалтын систем:**

Мэргэжлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх сургалтын салбарт нийгмийн тэгш бус байдал хүчтэй нөлөөлж байгаа тул өргөн хүрээтэй оролцоог нэмэгдүүлэхийн тулд боловсролын системийг өөрчлөх хэрэгтэй гэжээ. Мэргэжил олгох сургалтын хүрээнд “Мэргэжил эзэмших үндсэн эрх”-ийг хэрэгжүүлэхийг шаардсан байна. “Ажил олгогчид мэргэжил олгох сургалтын өмнө хүлээх хариуцлагаа булзааруулахыг оролдож байгааг таслан зогсоох ёстой. Бид аль болох бүх нутаг дэвсгэрийг хамарсан, сонголтын өргөн боломж бүхий мэргэжил олгох сургалтын орон тоог санал болгохын төлөө байна. Үүний тулд бидэнд хууль ёсны эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан санхүүжилтийн хувиарлалтын тогтолцоо хэрэгтэй байна. (17-р хуудас). Мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтыг төрөөс дэмжих ёстой. (17-р хуудас)

Ерөнхийд нь аваад үзэхэд “Зүүний нам” нь бусад улс төрийн намуудтай харьцуулахад төрийн хүчтэй оролцоог шаардсан байна. Гэхдээ зарчмын хувьд, хөтөлбөрөөс ойлгож болох хэмжээнд зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн хүрээнд үйл ажиллагаа явуулахын төлөө байгаа нь ойлгогдож байна. Гэхдээ зах зээлийн ямар загварын төлөө байна гэдгээ албан ёсоор илэрхийлээгүй байна. “Зүүний нам” юуны өмнө хоёр үндсэн чиг хандлагын хүрээнд ерөнхий хүрээнээс хальсан байна: Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг нийтийн эзэмшилд шилжүүлэхийг шаардсан байна. Хэр хэмжээнд нийгэмших

ёстой юм? Ямар хэлбэрээр явагдах ёстой юм? гэдэг талаар нэг ч үг дурьдалгүй орхижээ. Харин төрд тавьж буй дээрх шаардлагууд биелэгдэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төрийн санхүүжилтийг хэрхэн зохион байгуулах, хангалуун амьдралын хангалттай түвшинг хэрхэн үйлдвэрлэх талаар цөөхөн хэдэн өгүүлбэр бичжээ. Аль нэгэн намын хөтөлбөрт санхүүжилт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө цогц хэлбэрээрээ багтсан байх албагүй ч хөтөлбөрт дэвшүүлсэн саналуудыг бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө байгаа бол дээрх асуудлууд чухал ач холбогдолтой юм.

#### **5.6. Улс төрийн намуудын хөтөлбөрийг нийгмийн ардчиллын зорилтуудын хүрээнд үнэлэх нь**

Нийгмийн ардчилал нь энэ дэвтрээр толилуулж буй концепцийн / хөтөлбөрийн/ хүрээнд 1966 онд НҮБ-аас батлагдан гарсан үндсэн эрхүүдийн пактаар тодорхойлогдсон, эдүгээг хүртэл дэлхийн олон улс элсэн ороод байгаа үндсэн эрхүүдийн хэрэгжилтийг хэлбэр төдий шаардах эрх болон бодит нөлөөллийг хангахад чиглэгддэг. Нийгмийн ардчиллын норматив шаардлагуудыг хангахад зохицуулалттай зах зээл (скандинавын орнуудад хэрэгжүүлж буй) хамгийн дөхөмтэй гэдгийг өмнөх бүлгүүдэд өгсөн тайлбарууд харуулсан билээ.

Эдийн засгийн бодлогын хөтөлбөрт Симон Баут, Христиан Крелл нар өсөлт, нийгмийн тэнцвэрт байдал, тогтвортой байдал хэмээх энэхүү гурван зорилт нь нийгмийн ардчиллын үзэл баримтлалд хамгийн ихээр ойртуулах юм гэдгийг танилцуулсан. Тэгэхлээр улс төрийн намууд ямар арга хэлбэрээр зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг үргэлжлүүлэх, эсхүл өөрчлөхийг хүсэж байна бэ? гэдэг асуултын хүрээнд намуудын хөтөлбөрийг харьцуулан үзэх шаардлагатай болж байна.

Бундестагт суудалтай таван намын хөтөлбөр нь “Хэтийн зорилтын тайлбар” –ын шинжтэй бөгөөд тухайн нам улс төрийн эрх мэдэлд хүрсэн нөхцөлд германы эдийн засаг-нийгмийн системийг ямар чиглэлд хөгжүүлэхийг зорьж байна бэ? гэдэг талаар мэдээлэл өгөхөд чиглэгдэж байгаа юм. Улс төрийн намууд эрх мэдэлд хүрсэн нөхцөлд хөтөлбөрөө хэр зэрэг баримтлах бэ? гэдэг асуултыг зориудаар нээлттэй орхиё. ХАХН, ГЧАН-ын 2008 оны санхүүгийн зах зээлийн хямралд үзүүлсэн хариу үйлдэл болон бодлогын саналууд нь намын хөтөлбөрийн чиг шугам, тухайн намаас явуулж буй улс төрийн үйл

ажиллагаа хоёр хоорондоо байнга яв цав тохирч байх албагүй гэдгийг харуулсан. ГЧАН төр хүчтэй байхыг шаардаж ХАХН өөрийн эдийн засгийн либерал жигүүрийн эсрэг зогсож томоохон хэмжээний зээлийн баталгаа гаргах, зээл өгөх бодлого баримталж байлаа.

Бүхэлд нь авч үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Зохиогчдын хувийн үнэлгээ үр дүнд зохих хэмжээнд нөлөөлсөн гэдгийг дурьдах нь зүйтэй:

~ ХАХН хямралын нөхцөлд зохицуулалттай зах зээлийн түвшнийг өнөөгийнхөөс бууруулах нь зүйтэй гэж үзэж байна. Эдийн засгийн либерал сэтгэлгээний ололттой талуудыг компанийн эдийн хувийн ёс суртахуунтай хослуулж байна. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах болон хамтын удирдлагын бүхий л хэлбэрээс татгалзах, бууруулах, эсхүл илүү уян хатан болгохын төлөө байна.

~ ГЧАН зохицуулалтгүй, либералчлагдсан зах зээлийн эдийн засгийн төлөө байна. Тэд санал болгож буй нийгмийн загвараа ямар учраас “нийгмийн болон экологийн баримжаат зах зээлийн эдийн засаг” гэж нэрлэх болсныг хөтөлбөрөөс нь олж мэдэх боломжгүй байна.

~ Холбоотон 90\Ногоонтнууд нам зохицуулалттай зах зээлийн төлөө байгаа бөгөөд тэд өнөөгийн нийгмийг “нарны нийгэм” болгон өөрчлөн байгуулах зорилтыг дэвшүүлжээ. Үүний тулд тэд либерал төсөөллийн зарим нэгэн элементүүд, иргэний нийгмийн элементүүд, хамтын удирдлагын элементүүдийг хөтөлбөртөө нэгтгэсэн байна. Холбоотон 90\Ногоонтнууд намын хөтөлбөр нэлээд олон жилийн өмнө боловсруулагдсан тул зохицуулалттай эдийн засгийн тодорхой төсөөлөл нь ойлгомжтой бус байна.

~ “Зүүний нам” зах зээлийн зохицуулалтыг онцгой ач холбогдолтой хэмээн үнэлээд төр нь хувь хүмүүсийг хамгаалах үүрэгтэй гэж үзсэн байна. Тус намын хөтөлбөр дараах хоёр хэлбэрээр бидний үнэлгээний хүрээнээс хальсан байна: Нэг талаас хөтөлбөрт тусгагдах үндсэн санааг тодорхойлоод орхисон. Хоёрдугаарт “Зүүний нам” зах зээлийн эдийн засгийг нийгмийг хөгжүүлэх өөрсдийн загвар гэж үзэж буй эсэх нь тодорхой бус байна.

~ ГСДН-ын хөтөлбөрөөс тус нам зохицуулалттай зах зээл, түүнийг өргөжүүлэхийн төлөө байна гэдэг нь тодорхой харагдаж байна. НҮБ-ын үндсэн эрхийн пактаар

тодорхойлогдсон эрх чөлөөний эрхүүдийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн зохицуулалттай зах зээлийг өргөтгөнө. Энд мөн нийгмийн удирдлага ба зах зээлийн зохицуулалт хоорондоо зохицож байх ёстойг дурьджээ. Хөтөлбөрт юуны өмнө тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн даяаршил, эдийн засгийн процессын уян хатан байдал зэрэг салбарууд болон тэдгээрийн нийгмийн баталгааг авч үзсэн байна.

Улс төрийн намуудыг дээр дурьдсан эдийн засгийн бодлогын гурван үндсэн зорилтуудын хэрэгжилтийг хэрхэн таамаглаж буй байдлаар нь барууны болон зүүний чиглэлийн намууд гэж хуваадаг.

ХАХН, ГЧАН өсөлтийг дэмжих бодлогод илүү чухал ач холбогдол өгч бусад зорилтуудыг түүний дараа тавьдаг. “Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах” зорилтоос татгалзсан эсхүл эргэлзсэн байдлаар ханддаг.

Холбоотон 90\Ногоонтнууд намынхан нийгмийн болон экологийн баримжаат зах зээлийг “нарны нийгмийн чиглэлд өөрчлөн байгуулах” зорилтоороо экологийн тогтвортой байдлыг хангах зорилтод илүү ач холбогдол өгч буй нь илт. “Нийгмийн тэнцвэрт байдлыг хангах” зорилтыг дэмждэг ч “чанарын өсөлтөнд хүрэх” зорилтод төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа нь харагдаж байна.

“Зүүний нам”-ын хөтөлбөр “нийгмийн тэнцвэрт байдлыг хангах” зорилтод чиглэгдэж байгаа нь тодорхой харагдаж байна.

ГСДН дээрх гурван зорилтыг гурвууланг нь тэгш эрхтэйгээр, тэнцвэртэйгээр хангахыг зорьдог.



Эхэнд тавьсан асуултаа эргэж нэг харъя: Улс төрийн намуудыг нийгмийн болон эдийн засгийн бодлогын чадамжаар нь хатуу хуваах оролдлого нь хэт хуумгай байдал бөгөөд энэхүү ангилал нь бодлогын үнэлгээнд төдийлөн ач холбогдолгүй зүйл юм. Гэхдээ улс төрийн намуудын хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ нь улс төрийн намууд эдийн засгийг нийгмийн хүрээнд хэрхэн зохион байгуулах, зах зээлд хэрхэн нийгмийн хариуцлага ногдуулах талаар өөр өөр төсөөлөлтэй байдаг гэдгийг харууллаа. Өргөн хүрээг хамарсан энэхүү судалгаа нь иргэд улс төрийн намуудын ертөнцөд өөрийн чиг хандлагыг тогтоож өөрөө шийдвэрээ гаргах хэрэгтэй гэдгийг харуулж байна.

## 6. ЭДИЙН ЗАСГИЙН ДЭГЛЭМҮҮД: УЛС ОРНУУДЫН ЗАГВАРУУД

### Энэхүү бүлэгт:

- ~ Өмнөх бүлгүүдэд үзсэн зохицуулалттай ба зохицуулалтгүй капитализмын хэв шинжүүдийн ялгаатай байдал дээр суурилан Девид Соскисе, Петер А. Холл нарын боловсруулсан онолын дагуу эдийн засгийн төрөл бүрийн системүүдийг хооронд нь харьцуулна.
- ~ Уг судалгаа нь санхүүгийн систем, хөдөлмөрийн харилцаа, боловсролын систем, компаниуд хоорондын харилцаа зэрэг нийгмийн салбаруудын хүрээнд хийгдсэн.
- ~ АНУ, Их Британи, Герман, Швед, Япон орнуудыг судалгаанд хамруулсан.
- ~ Сонгон авсан орнууд зохицуулалттай болон зохицуулалтгүй зах зээлийн нийтлэг хэв шинжүүдийг багтаасан. АНУ зохицуулалтгүй идеал хэв шинжид, Швед улс зохицуулалттай зах зээлийн идеал хэв шинжид хамгийн их ойртсон орнууд юм.
- ~ Эдийн засгийн төрөл бүрийн загварууд нь нээлттэй зах зээлийн өнөөгийн эрин үед ч зэрэгцэн орших боломжтой. Эдгээр нь өөр өөр урьдчилсан нөхцөл хангагдсан байхыг шаарддаг бөгөөд Нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс авч үзэхэд өөр өөр дүгнэлтэд хүрч байна.

### 6.1. АНУ<sup>8</sup>

Симон Баут

Зохицуулалтгүй зах  
зээлийн эдийн засгийн  
хэв шинжүүдийг  
хамгийн тодоор  
илэрхийлэгч орон.

АНУ нь зохицуулалтгүй зах зээлийн эдийн засгийн хэв шинжийг хамгийн ихээр агуулсан орон юм. (Майер 2001 он, 150-р хуудас). АНУ нь зах зээлийн либерализмын уламжлалыг хадгалагч, төрийн оролцоо ба индивидуалист үзэлд тээнэгэлзсэн байдлаар ханддаг уламжлалтай. Америкийн эдийн засгийн систем нь хэрэглэгчдэд үйлчлэх, хөрөнгө чинээг арвижуулах зорилтуудад гол анхаарлаа хандуулдаг тул уг байдал нь нийгмийн үндсэн эрхүүдийн хэрэгжилтийг хязгаарлаж байдаг. (Гиплин 2001 он, 150)

Гэхдээ энэ хандлага хөгжлийн үе шат бүхэнд өөр өөр байжээ. 1930-аад оны үед ерөнхийлөгч агсан Франклин Рузвельт “New Deal” хэмээх эдийн засгийн хүчтэй зохицуулалтыг шаардсан өргөн хүрээтэй эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн юм. Мөн 1960-аад онд ерөнхийлөгч агсан Линдон В. Жонсон “Ядууралтай дайн зарлаж” (“War

8 АНУ болон Германы жишээний дийлэнхийг Томас Майерын номноос (2005а: 279-282) авлаа. Түүний бүтээлээс ашиглах эрхийг бидэнд өгсөн зохиогчид талархлаа илэрхийлье.



on poverty”) мөн зах зээлийн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлж байлаа. Гэхдээ бодит байдал дээр хөгжлийн эдгээр шатанд ч АНУ-ын эдийн засаг бүхэлдээ маш зохицуулалтгүй байжээ. Харин 1980-аад онд ерөнхийлөгч агсан Рональд Рейган, ерөнхийлөгч асан Жорж Буш нар зориудаар эдийн засгийн зохицуулалтыг сулруулах бодлогыг явуулсан юм.

### Санхүүгийн систем

Америкийн компаниуд ихэвчлэн хөрөнгийн зах зээлээс санхүүждэг. Биржид бүртгэлтэй компаниудаас санхүүгийн балансаа олон нийтэд тогтмол хэвлэн нийтэлж байхыг шаарддаг учраас санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд маш ил тод байдаг. Хувьцаа эзэмшигчдийн богино хугацаанд өндөр ашиг олох сонирхол компанийн стратегийг үндсэндээ тодорхойлж байдаг. Энэ хэлбэрийг **Shareholder-Value-Prinzip** буюу /Компаний шийдвэрт хувьцаа эзэмшигчдийн сонирхол давамгайлна./ гэж нэрлэдэг.

Хувьцаа эзэмшигчид тухайн компанийг ашиг олох боломжтой гэж үнэлсэн эсэхээс хөрөнгийн зах зээл дээр гарч чадах эсэх нь хамаардаг. Компаниудын нэгдэл, аль нэг компани бусад компанийг худалдан авах процессын зохицуулалт бусад орнуудтай харьцуулахад харьцангуй сул. Ийм ч учраас америкийн компаниудын удирдлага аль болох богино хугацааны дотор аль болох их ашиг олох дарамтын дор үйл ажиллагаагаа явуулдаг. Ашиг орлого муутай ажилласан нөхцөлд менежментийн багийг ажлаас халах, хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийг нь хураан авах, эсхүл өөр компаниуд компанийг нь худалдан авах зэрэг үр дагаварт хүргэдэг.

### Хөдөлмөрийн харилцаа

АНУ-д Хөрөнгө болон хөдөлмөрийн холбоод нь нийгмийн өмнө хариуцлага хүлээсэн актёрууд гэхээсээ илүү салбарын ашиг сонирхлын төлөөх лобби байгууллагуудын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай харьцуулахад үйлдвэрчний эвлэл ба ажил олгогч эздийн байгууллагууд нь ерөнхийдөө сул тул нөлөө бүхий дээвэр байгууллага бараг байдаггүй. Гэхдээ зарим салбарт зөвхөн тодорхой бүлгүүдийн эрх ашгийг төлөөлдөг, тавьсан шаардлагуудаа хэрэгжүүлж чаддаг хүчтэй үйлдвэрчний байгууллага байдаг. Жишээлбэл: Калифорнид маш сайн зохион байгуулалттай, улс төрд төдийгүй ял шийтгэл эдлэх хугацааны зохицуулалтанд нөлөөлж чаддаг шоронгийн харгалзагч нарын үйлдвэрчний байгууллага байдаг.

*Хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүждэг.*

*Богино хугацаанд өндөр ашиг олох дарамт*

*Ажил олгогчид ба ажилтнуудын холбоод нийт нийгмийн өмнө үүрэг хүлээхээс илүү компанийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг*

Ажилтнуудыг ажлаас  
халагдахаас хамгаалах  
хамгаалалт бараг  
байхгүйтэй адил.

Гэхдээ тухайн үйлдвэрчинд харъяалагдаж байгаа гишүүдийнхээ эрх ашгийг нийтийн ашиг сонирхлоос дээгүүр тавьдаг. Ажлаас халагдахаас хамгаалах хуулийн хамгаалалт АНУ-д бараг байхгүйтэй адил. Ийм ч учраас хөдөлмөрийн харилцаа нь богино хугацаанд үргэлжилдэг хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, аж ахуйн нэгжүүдийн түвшинд явагддаг цалингийн хэлэлцээрүүдээр тодорхойлогддог. Зохицуулалттай зах зээлийн эдийн засагт хэрэглэгддэг нутаг дэвсгэрийн тарифын гэрээнүүд АНУ-д сүүлийн жилүүдэд улам бүр нөлөөгөө алдаж буй үйлдвэрчний эвлэлээс хамааран бараг сураггүй болжээ.

Үйлдвэрчинд халгаатай  
бодлого явуулсны  
улмаас үйлдвэрчний  
эвлэл суларсаар байна.

Роверт Райх үйлдвэрчний эвлэлийн ийнхүү эрс хүч суларсан байдлыг дараах хоёр хүчин зүйлээс хамааралтай гэж үзсэн байна. (1955 онд нийт ажилчдын 33% нь үйлдвэрчний эвлэлийн гишүүн байсан бол 2006 онд 8% болтлоо буурсан). Нэг талаас компаниуд, нөгөө талаас засгийн газар үйлдвэрчинтэй илт дайсагнасан бодлого явуулсантай холбоотой. Жишээлбэл: Ерөнхийлөгч агсан Рональд Реаган 1981 онд ажил хаялт зарласан нисэх хөдөлгөөн зохицуулагчдыг насан туршдаа мэргэжлээрээ ажиллахыг хориглох шийтгэл ногдуулж байлаа.

### **Дунд сургуулийн – болон мэргэжлийн боловсролын систем**

Бүхэлд нь авч үзвэл АНУ-ын маш уян хатан хөдөлмөрийн зах зээлийг нарийн мэргэжлийн гэхээсээ илүү компаниуд болон салбаруудын хүрээнд ашиглаж болохуйц ерөнхий мэдлэг олгодог боловсролын систем нь дэмжиж байдаг. Ажилтнуудыг эдийн засгийн өсөлтийн байдлаас шалтгаалан төдийлөн саадгүйгээр богино хугацааны дотор ажилд авч мөн халж болдог. (Hire und Fire) Хөдөлмөрийн зах зээл нь харьцангуй зохицуулалтгүй, хөдөлмөрийн зах зээл дээрх давалгаа хүчтэй байдаг тул америкийн ажилтнууд дараагийн ажил мэргэжилдээ ч ашиглаж болохуйц ерөнхий мэдлэг олгодог боловсролын системд хөрөнгө оруулалт хийхдээ дуртай байдаг. Ажил олгогч эздийн холбоодын зохицуулалт сул, хэлбэр төдий байдаг тул аж үйлдвэрийн салбарын онцлог шаардлагыг хангасан нарийн мэргэжил олгох сургалтын хөтөлбөрүүд дээр хамтран ажиллаж чаддаггүй. Америкийн ажилтнууд нарийн мэргэжил эзэмшихээсээ илүү эдийн засгийн өсөлт асар түргэн хугацаанд нөлөөлдөг гэдэг утгаар нь үйлчилгээний салбарт ашиглахад тохиромжтой ерөнхий мэдлэг олгодог сургалтанд хамрагдахыг илүүд үздэг. Иймээс олон компани, салбарууд нарийн мэргэжлийн боловсон хүчнээр дутмаг байдаг.

Ерөнхий мэдлэг олгодог.

Төсвөөс санхүүждэг шинжлэх ухааны салбаруудад санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байдаг учраас зарим хэсгийг нь зэвсэглэлийн салбарт төрийн татаас олгох хэлбэрээр санхүүжүүлдэг. Эдийн засагт өндөр ашиг авчирсан техник технологийн дэвшлүүдийг армийн салбарт зохион бүтээж иргэний зориулалтаар ашигласан байдаг. Жишээлбэл хиймэл дагуулын техникийн хүрээнд эсвэл мэдээллийн технологийн салбарт зохион бүтээгдсэн онгоцны үйлдвэрлэл гэх мэт. (Райх 2008 он)

Судалгааны салбарт зэвсэглэлийн үйлдвэрээр дамжуулан төрийн татаас олгодог.

Америкийн компаниуд нь зохицуулалттай зах зээлтэй Швед, Герман зэрэг орнуудын бусад компаниуд болон төр, үйлдвэрчний эвлэлтэй өрсөлдөхөөсөө илүү хамтран ажиллахын төлөө байдаг компаниудтай харьцуулбал хоорондоо илүү хатуу өрсөлдөөнд байдаг. (Хинчман 2006 он, 350-р хуудас). Компаниудын хоорондын харилцаа маш сул.

Компаниуд хоорондын харилцаа.

| АНВ                                                   |               |                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-------------------------------------------------------|---------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг хүнд ногдох ДНБ 2007 оны байдлаар                 | 38.000 Евро   | Нэг хүнд ногдох ДНБ-нийг худалдан авах чадварын стандартаар илэрхийлсэн үзүүлэлт нь Европын Холбооны (ЕХ) 27 улсын дунджаар нэг Еврогийн худалдан авах чадварыг илэрхийлдэг. (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                      |
| Эдийн засгийн дундаж өсөлт 1990-2005 оны байдлаар     | 2.1%          | Нэг хүнд ноогдох эдийн засгийн дундаж өсөлтийн хэмжээ (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2007\08 он 227-р хуудас)                                                                                                                                                                               |
| Төрийн өр (төсвийн алдагдал) 2004 оны байдлаар        | 63.4%         | ДНБ-нд эзлэх хувиар илэрхийлэгдэх төрийн өр (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                                                                                                       |
| Бүтээмжийн тэнцэтгэл 2007 оны байдлаар                | -5.4%         | Таварын нийт экспорт ба импортын зөрүүг ДНБ-нд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: D&G Country Risk Services)                                                                                                                                                                        |
| Хөдөлмөр эрхлэлтийн коэффициент 2007 оны байдлаар     | 71.7% (65.9%) | Хөдөлмөрийн насны буюу 15-64 насны хүний бүх хүний (Эмэгтэйчүүдийг оролцуулан) тоог нийт хүн амын тоонд харьцуулсан харьцаа (Эх сурвалж :ЕХ-ны статистик)                                                                                                                                       |
| Ажилгүйдлийн коэффициент                              | 4.6%          | Хөдөлмөрийн насны нийт хүн амын тоонд ажилгүйчүүдийн эзлэх хувийг харьцуулсан харьцаа (Олон улсын стандарт ) (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                                      |
| Орлогын тэгш бус байдлыг GINI-коэффициентээр хэмжих   | 40.8%         | Орлогын тэгш бус байдлыг илэрхийлэх үзүүлэлт. 100%-ийг тэгш бус хувиарлалтын дээд хэмжээ гэж үзнэ. (Хүний хөгжлийн индекс 2007\08 он, 281-р хуудас)                                                                                                                                             |
| Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн орлогын тэгш бус байдал | 63%           | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээд олсон орлогыг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2007\08 он 330-р хуудас)                                                                                                                                                |
| Ядуурлын индекс                                       | 15.4%         | Ядуурлын индекс олон төрлийн үзүүлэлтээс бүрддэг. (Хүн амын дундаж наслалт, бичиг үсэгт тайлагдсан иргэдийн эзлэх хувь, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ...) 0 –ядуурлын хамгийн доод түвшин, 100 –ядуурлын хамгийн дээд түвшин) (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2007\08, 241-р хуудас) |
| Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг        | 12.4%         | Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтанд орсон ажилтнуудын тоог нийт хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Ж.Биссер 2006 он), Union Membership Statistics 24 countries, Monthly Labor Review, vol.129,no1, J.38-49)                                                |

Компаниуд хоорондын  
холбоос сул.

Банкууд болон компаниуд төлөөлөн удирдах зөвлөлдөө бусад банк, компанийн төлөөллийг оролцуулдаггүй. АНУ-д эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөөг хангах үзэл давамгайлах болсон цагаас хойш төр зөвхөн зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад жишээлбэл: компаниуд зах зээлд эзэлж буй давуу эрхээ буруугаар ашиглахгүй байхад хяналт тавих хэлбэрээр л оролцох болсон. Картелийн эсрэг эрхийн дагуу төр нь компаниудыг тодорхой салбарт жишээлбэл: бүтээгдэхүүний үнийн талаар тохиролцоонд хүрэхээс сэргийлэх үүрэгтэй ажээ.

### АНУ-ын талаархи нэгдсэн дүгнэлт

Зах зээлийн эдийн  
засаг нь ерөнхийдөө  
зохицуулалтгүй.

АНУ-ын зах зээлийн эдийн засаг нь ерөнхийдөө зохицуулалтгүй тул компаниуддаа хөдөлмөрийн зах зээлийн хөгжилд уян хатан дасан зохицох боломжийг олгодог ч богино хугацааны дотор зах зээлийн өөрчлөлтөнд дасан зохицох дарамтын дор үйл ажиллагаагаа явуулдаг. Америкийн хөдөлмөрийн харилцааны систем нь хөрөнгө мөнгө ихээр шаарддаг, ажиллах хүчнийг удаан хугацаагаар тогтвортой ажиллуулахыг шаарддаг үйлдвэрлэлийн стратегийн хөгжилд үр өгөөж муутай. Харин үүний оронд эрсдэлтэй хөрөнгө шаардсан мэдээллийн технологи зэрэг шинэ технологийн салбарууд болон ерөнхий мэдлэг, чадвартай ажилтнуудыг цалин багатай ажиллуулдаг үйлчилгээний салбар зэрэгт илүү тааламжтай нөхцөлийг бүрдүүлдэг.

Хувийн эд баялаг, олон  
нийтийн ядууралтай  
зэрэгцэн оршдог.

Дээр тайлбарласан эдийн засгийн системээрээ АНУ нь европын орнуудтай харьцуулахад илүү өндөр эдийн засгийн өсөлтөнд хүрсэн байна. 1990-ээд оноос АНУ-ын эдийн засаг дунджаар 3% өссөн бол европын орнуудынх 2.2% өссөн байна. Гэхдээ энэхүү хангалуун амьдралын ашиг АНУ-д асар их зөрүүтэй, тэгш бус хувиарлагддаг. 1950 -аад оны үед компанийн удирдлагад ажиллагсдын цалин ажилчдынхаа цалингаас 25 дахин илүү байсан бол өдгөө 350 дахин их болсон байна. (Райх 2008 он. 144) АНУ-д улсын төсвийн ядмаг санхүүжилт уламжлал болон тогтсоноор хувийн өмч цэцэглэн хөгжиж харин төр нь ядуурч хувийн баян тансаг амьдрал, ард иргэдийн дийлэнхийн ядуу зүдүү байдалтай зэрэгцэн оршдог. Энэ байдал нь зарим талаараа АНУ-ын нийтийн эзэмшлийн дэд бүтэц бусад орнуудтай харьцуулахад муу байдгийн шалтгаан юм. (Хинчман 2006 он, 352)

Барак Обама  
сонгогдсоноор  
татварын ачаалалд  
өөрчлөлт орох уу?

2008 оны Барак Обамагийн сонгууль “өөрчлөлт”–“Change” гэдэг уриан дор явагдсан юм. Олон үйл явдал бодлогын бодитой

өөрчлөлт хийгдэнэ гэдгийг харуулж байна: (Баут 2007, 2008 он). АНУ-ын ардчилсан намын эдийн засгийн чиг хандлагыг урьдчилан таамаглагч, түүчээ тогоруу Улиям Галстон 2008 оны 6-р сард “How Big Government Got Its Groove Back” нэртэй судалгааны материалаа нийтэлсэн байна. Түүний таамаглаж буйгаар: “Төр аль болох бага хэмжээнд зохицуулалт хийж, хөндлөнгөөс оролцохгүй байх ёстой гэдэг үзэл суртал үеэ өнгөрөөсөн байна. Өдгөө хүчтэй зохицуулалт, төрийн квотыг нэмэгдүүлэх “хүчтэй засаглалын” – “Big Government” –ийн эрин үе ирээд байна.” гэжээ. (2008 он)

## 6.2. Их Британи

Христиан Крелл

Их Британийг капитализмын пионер гэж олонтаа бичдэг. Их Британид аж үйлдвэржилт, чөлөөт худалдаа, либерализм, бусад орнуудаас түрүүлж хөгжсөн юм.

Эрт хөгжсөн болохоор өөрийн гольдролоороо хөгждөг хазааргүй капитализмын сөрөг талууд ч бүр эрт илэрч байжээ. 19-р зууны дунд үед Фридрих Энгельс хараат хөдөлмөр эрхлэгсдийн хүмүүн бусын амьдралын болон хөдөлмөрийн нөхцөлийн жишээг “Английн хөдөлмөрийн анги”-иас иш татдаг байсан нь санамсаргүй тохиолдол биш юм.

Энгельсийн судалгаа хийж байсан үетэй харьцуулахад британийн капитализмд үндсэн өөрчлөлтүүд явагдсан нь мэдээжийн хэрэг юм. Гэхдээ хэвшил болон үлдсэн зүйлс ажиглагддаг. Британийн эдийн засгийн дэглэм өдгөө ч онцгой либерал хэвээрээ. Олон улсын капитализмын харьцуулсан судалгаагаар Их Британийн капитализмыг зохицуулалтгүй, либерал зах зээлийн эдийн засаг гэж тодорхойлсон байдаг. Дараах дэд бүлгүүдэд британийн капитализмын хэв шинжийн чухал цар хүрээнүүдийг тодорхойлох болно.

### Санхүүжилтийн систем ба өмчлөгчдийн бүтэц

Британийн капитализмд компанийн сүүлийн жилүүдийн ашиг орлогын байдал түүний санхүүжилтэнд шийдвэрлэх үүрэгтэй. Британийн компаниуд санхүүжилтэндээ хувьцаа болон санхүүгийн маш эрчимтэй зах зээлийн “тэвчээргүй” мөнгийг ашигладаг. Ийм ч учраас өндөр ашигтай байх нь хөрөнгөнд хүрэх үүдийг нээх оньс юм. Үүгээрээ байнга харилцдаг банк нь удаан хугацааны туршид компаниудтай хамтран ажиллаж харилцагч компани, тэдгээрийн

Капитализмын пионер...

...түүний сүүдэртэй талууд

Зохицуулалтгүй, либерал зах зээлийн эдийн засаг

Санхүүжилт санхүү болон хувьцааны зах зээлээр дамжин хийгддэг.

стратегии, бүтцийн талаар тодорхой мэдээлэл тогтмол авч байдаг Германы эдийн засгийг удаан жилийн туршид тодорхойлж байгаа эдийн засгийн системээс ялгаатай юм. Нэгдсэн Эзэнт гүрэнд хөрөнгө оруулагчид, санхүүжүүлэгчид нийтэд нээлттэй үнэлгээний шалгууруудыг үндэслэн хөрөнгө оруулах, эсэхээ шийддэг. Шийдвэр гаргалтанд тухайн компанийн ашиг олох магадлал хамгийн чухал шалгуур нь болдог.

Өмчлөгчдийн бүтэц:  
Санхүүгийн болон  
хувийн хөрөнгө  
оруулагчид томоохон  
хувийн эзэлдэг.

Британийн өмчлөгчдийн бүтэц нь зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн эзэмшигчдийн харьцаанаас үндсээрээ ялгаатай байдаг. Зохицуулалттай зах зээлийн компани, корпорацуудын оролцоонд (жишээлбэл: бусад компаниуд, банкууд, төсвийн салбарт хөрөнгө оруулалт хийхдээ) хөрөнгө оруулагчдын удаан хугацааны, стратегийн сонирхол давамгайлдаг бол Их Британид эрс өөр байдаг. Британийн компаниудын эзэмшигчдийн 80 орчим хувь нь санхүүгийн болон хувийн хөрөнгө оруулагчид байдаг бөгөөд тэдний гол сонирхол аль болох өндөр ашиг олоход л чиглэгддэг.

Богино хугацаанд өндөр ашиг олох зорилгоор дайсагнагч компаниа худалдан авч өөрөөр хэлбэл өрсөлдөгчөө худалдан авах замаар залгихад зах зээлийн санхүүжилт нь хангалттай, санхүүгийн зах зээлийн бүтэц нь тохиромжтой учраас зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад илүү хялбар байдаг.

Богино хугацаанд  
хэрэгжих боломжтой  
гэдэг шалгуур тавигддаг.

Аль болох өндөр ашиг олох зорилт нь компанийн дээрээсээ доош чиглэсэн захиргааны дотоод бүтэцтэй хосолдог. (Захиргаадалтыг хамгийн хялбар хэрэгжүүлэх бүтэцтэй). Энэ нь нэг талаас британийн компаниудад шинэ, өндөр ашигтай зах зээлийн чиглэлд богино хугацааны дотор бүтцийн өөрчлөлт хийх, бага ашиг авчирдаг арилжааны салбаруудаас хурдан хугацаанд гарах боломжийг олгодог. Нөгөө талаас дээр дурьдсан нөхцөлүүд нь британийн эдийн засгийг **"short – terminism"** буюу богино хугацаанд хүрч болох зорилтод чиглэгдсэн алсын хараагүй стратегитай байхад нөлөөлдөг.

### Хөдөлмөрийн харилцаа

Хөгжлийн зарим үе шатуудад британийн үйлдвэрчний эвлэл маш хүчтэй мэт харагддаг байлаа. "Winter of discontent" гэж нэрлэгддэг үйл явдал бол үүний нэг жишээ юм. 1978\1979 онуудад улс орон даяар өрнөсөн ажил хаялт британийн олон нийтийн амьдралыг гацаанд оруулж байлаа. Хог хаягдахгүй, олон нийтийн тээврийн

Өнгөцхөн харахад  
үйлдвэрчний эвлэл нь  
хүчтэй мэт харагддаг.

хэрэгслүүд зогсож, нас барагсдыг ч оршуулж чадахгүйд хүрч байлаа. Харин бодит байдал дээр олныг хамарсан ажил хаялтууд болдог ч энэ нь үйлдвэрчний эвлэл хүчтэй байгаагийн илэрхийлэл биш юм. Хүчтэй, сайн зохион байгуулалттай үйлдвэрчний эвлэл ажилчдын эрх ашгийг ажил хаялтаар бус харин гэрээ хэлэлцээрийн аргаар хамгаалах чадамжтай байдаг. Ийм ч учраас “Winter of discontent” нь хүчтэй үйлдвэрчний илэрхийлэл гэхээсээ илүүтэйгээр үйлдвэрчний эвлэл хэлэлцээрт орох чадвараар дутмаг байгаагийн илэрхийлэл байлаа.

Британийн үйлдвэрчний эвлэл нь олон улсын түвшинд харьцуулахад сул үйлдвэрчний тоонд ордог. Энэ нь британийн үйлдвэрчний эвлэл дотоодын зөрчил ихтэй, тархай бутархай байдагтай холбоотой. 1990-ээд онд 300 гаруй үйлдвэрчний байгууллага ажиллаж байлаа. Үйлдвэрчний байгууллагууд нь салбарын хүрээнд бус мэргэжлийн бүлгээр байгуулагддаг учраас нэг компанид олон үйлдвэрчний эвлэлүүдийн төлөөлөл байдаг. Британийн үйлдвэрчний эвлэл сул байдгийн хоёрдох шалтгаан нь: Их британид болон бусад зохицуулалтгүй либерал зах зээлд түгээмэл байдаг компанийн ажилчдын зөвлөл болон ажилчдын төлөөллийн бусад хэлбэрүүдийг заавал байгуулах, шийдвэр гаргалтанд оролцуулах үүргийг компаниудад хуулиар ногдуулдаггүйтэй холбоотой юм. Компанийн шийдвэр гаргалтанд ажилчдын оролцоог хангах, Германы уул уурхайн салбарт хэрэгжүүлдэгтэй адилхан хууль эрх зүйн орчин байхгүй. Гуравдугаарт: Их Британид үйлдвэрчний эвлэлийн эрхүүдийг Тетчерийн консерватив засгийн газрын үйл ажиллагааны үр дүнд (1979-1990 он) системтэйгээр хязгаарласан юм.

Дээрх шалтгаануудын улмаас үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг өдгөө ийм доогуур байгаа юм. Их Британид үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтанд орсон буюу үйлдвэрчний гишүүд хөдөлмөрийн насны хүн амын дөнгөж 30% -ийг эзэлж байна. Харин төрийн байгууллагуудад үйлдвэрчний гишүүнчлэл хувийн сектортай харьцуулахад харьцангуй өндөр байдаг.

Ажилчдын нэгэн адил ажил олгогчдын зохион байгуулалт харьцангуй сул байдаг. Тавьсан шаардлагуудаа хэрэгжүүлэх чадвартай хүчтэй ажил олгогчдын байгууллага бараг байхгүйтэй адилхан. Ажил олгогч эздийн байгууллагуудын ач холбогдол буурсаар байна.

*Үйлдвэрчний эвлэл нь маш тархай бутархай.*

*Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг бүхэлдээ доогуур байдаг.*

Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоодог бөгөөд цалингийн хэлэлцээр компаниудын түвшинд явагддаг.

Дээрх бүтцүүдийн улмаас тарифын хэлэлцээрүүд ихэнхдээ компанийн түвшинд эсхүл ажил олгогч, ажилтан хоёрын хооронд шууд хийгддэг хэлэлцээрээр тарифыг тогтоодог. 1999 оноос хойш нутаг дэвсгэрийн хэмжээнд цалингийн доод хэмжээг тогтоодог болжээ. Ямар ч тохиолдолд доод хэмжээнээс доогуур цалин олгож болохгүй.

Ажилтнуудыг ажлаас халагдахаас хамгаалах хуулийн хамгаалалт маш сул.

Зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад компаниуд хоорондын болон ажилтан ба компани хоорондын харилцаа нь зах зээлийн хүчнүүдээс хүчтэй хамаардаг. Ажилтнууд компанид зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад богино хугацаагаар ажилладаг учраас компанийнхаа төлөө гэдэг сэтгэл, холбоос султай байдаг. Ажилтнуудыг ажлаас халахад саад тотгор багатай. Нэг талаас үйлдвэрчний байгууллага нь сул тул үр нөлөөтэй саад хийж чаддаггүй. Нөгөө талаас ажилтнуудыг ажлаас халагдахаас хамгаалах хууль эрх зүйн хамгаалалт сул. Үүний хамт өндөр мэргэжилтэй ажилчид уян хатан хөдөлмөрийн зах зээл дээр шинээр ажил олоход хялбар байдаг.

Компаниуд дээрээсээ доош чиглэсэн удирдлагын бүтэцтэй байдаг.

Британийн компаниуд зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад шатлан захирах буюу дээрээсээ доош чиглэсэн удирдлагын бүтэцтэй байдаг. Удирдах зөвлөлийн дарга (Chief Executive Officer) нь давамгайлах байр суурьтай байдаг бөгөөд уг бүтцийн дагуу хөдөлмөр зохион байгуулалт нь хийгддэг. Ийм ч учраас мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнууд баг бүрдүүлэн ажиллах хэлбэр германтай харьцуулахад ховор. Уламжлалт, удаан хугацаагаар дагаж мөрдөгддөг ажлын хувиарлалт энд хэвшил болсон байдаг. (Вүүд 2001 он, 250-р хуудас)

### Мэргэжил олгох ба мэргэжил дээшлүүлэх сургалтын систем

Их Британийн уян хатан хөдөлмөрийн зах зээл дээр нарийн мэргэжил олгоход төдийлөн ач холбогдол өгдөггүй. Чухам ямар учраас ажил олгогчид ажилтнуудад нарийн мэргэжил олгоход ач холбогдол өгдөггүй бэ? гэдгийг тэдний байр суурин дээрээс ойлгоход хялбар. Дунджаар авч үзэхэд ажилтнуудын нэг компанид ажиллах хугацаа харьцангуй богино байдаг тул хувь хүнд хөрөнгө оруулалт хийх нь үр өгөөжөө өгөхгүй байх аюултай, нөгөөтээгүүр өрсөлдөгч компаниудад ашигтай болж магадгүй. Хоёрдугаарт: Хөдөлмөрийн зах зээлийн дэндүү уян хатан байдал нь богино хугацааны дотор өндөр мэргэшсэн ажилчдыг ажилд авах шаардлага гарлаа гэхэд

Ерөнхий мэдлэг олгодог.



дараа нь мөн богино хугацааны дотор тэднийг халах шаардлага гарч болзошгүй байдаг.

Ажилчид өөрсдөө дурын компанид ажиллах боломжийг бүрдүүлнэ гэдэг утгаар нь нарийн мэргэжил эзэмшихээсээ илүүтэйгээр тэртэй тэргүй нэг компанид ажиллах хугацаа богино байдаг тул бусад компаниуд, салбарт хөрвөх чадвартай учраас илүү ерөнхий мэдлэг, чадвар олгох мэргэжлийг сонгох сонирхолтой байдаг.

#### Их Британи

|                                                                   |                  |                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|-------------------------------------------------------------------|------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг хүнд ногдох ДНБ 2008 оны байдлаар                             | 29.200 Евро      | Нэг хүнд ногдох ДНБ худалдан авах чадварын стандартаар, Vг үзүүлэлт нь Европын Холбооны (ЕХ) 27 гишүүн орнуудын дунджаар нэг Еврогийн худалдан авах чадвартай тэнцдэг. (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                         |
| Эдийн засгийн дундаж өсөлт 1990-2007 оны байдлаар                 | 2.4%             | Нэг хүнд ногдох эдийн засгийн дундаж өсөлт, үнэ тогтвортой байхад (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2009 он, 99-р хуудас)                                                                                                                                                                                                   |
| Төрийн өр (Төсвийн алдагдал) 2008 оны байдлаар                    | 52.0%            | Төсвийн алдагдлыг ДНБ-нд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Холбооны санхүүгийн яам, 2009 оны 12-р сарын мэдээ, 99-р хуудас)                                                                                                                                                                                     |
| Бүтээмжийн тэнцэтгэл                                              | -1.7%            | Таварын нийт экспорт ба импортын зөрүүг ДНБ-нд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Олон улсын валютын сан, Дэлхийн эдийн засгийн мэдээ 2009 оны 10-р сар, 187-р хуудас )                                                                                                                                          |
| Хөдөлмөр эрхлэлтийн квот 2008 оны байдлаар                        | 71.5%<br>(65.8%) | 15-64 насны нийт хөдөлмөр эрхлэгсдийн (эмэгтэйчүүдийг оролцуулан) тоог нийт хүн амын тоонд харьцуулсан хувь (Эх сурвалж: Европын Холбооны статистик)                                                                                                                                                                         |
| Ажилгүйдлийн квот                                                 | 5.6%             | Ажилгүйдлийн тоог хөдөлмөрийн насны буюу 15-64 насны нийт хүн амын (эмэгтэйчүүдийг оролцуулан) тоонд харьцуулсан хувь: Олон улсын стандарт хэмжээ, (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                             |
| Орлогын тэгш бус байдлыг Gini-коэффициентаар илэрхийлсэн үзүүлэлт | 36%              | Орлогын тэгш бус байдлыг илэрхийлэх тоон үзүүлэлт ( 100%-орлогын тэгш бус байдлын дээд хэмжээ.) (Эхсурвалж:Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                                                      |
| Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн орлогын тэгш бус байдал             | 67%              | Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсийг эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлстэй харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009,195-р хуудас)                                                                                                                                                                              |
| Ядуурлын индекс 2009 оны байдлаар                                 | 14.6%            | Ядуурлын индекс нь олон төрлийн үзүүлэлтүүдээс бүрддэг. (Хүн амын дундаж наслалт, бичиг үсэгт тайлагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж,... гэх мэт) 0 - ядуурлын хамгийн доод түвшин, 100 - ядуурлын хамгийн дээд түвшин. (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл, 2009 он, 180-р хуудас) |
| Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг                    | 28%              | Хөдөлмөрийн насны хүн амд үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтанд орсон үйлдвэрчний гишүүдийн эзлэх хувь (Эх сурвалж: Ж.Биссер, Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын статистик)                                                                                                                       |

Мэргэжлийн боловсролд тавигдах дээр дурьдсан шаардлагын улмаас: Британийн компаниудын үйлдвэрлэлийн бүтээмж жишээлбэл: германы компаниудтай харьцуулахад харьцангуй доогуур байдаг. Либерал зах зээлийн эдийн засаг нь бүхэлдээ боловсруулалт нь хялбар, стандартчилагдсан үйлдвэрлэлийн арга дээр төвлөрдөг.

### **Компаниуд хоорондын харилцаа**

Компаниуд хоорондын харилцаа нь зах зээлийн харилцаа ба давж заалдах боломжтой, хэлбэр төдий эрх зүйн харилцаан дээр суурилдаг. Компаниудын хоорондын холбоос бараг байхгүйтэй адил сул. Технологийн шилжилт, шинэчлэл техник эсхүл шинжлэх ухааны салбарын өндөр мэргэшсэн боловсон хүчнээр дамжин хэрэгждэг. Мөн эрдэмтэд, инженерүүд судалгааны институтээс компаниуд руу болон эсрэгээрээ шилжих шилжилт сонгодог зохицуулалттай зах зээлтэй харьцуулахад илүү элбэг тохиолддог. Компаниуд дундын хамтарсан судалгааны байгууллагууд, удаан хугацаагаар оршин тогтнодог хамтын ажиллагааны сүлжээ мөн ховор тохиолддог.

### **Үнэлгээ ба нэгдсэн дүгнэлт**

Британийн капитализмын хэв шинж нь эх газрын буюу европын эдийн засгаас илүүтэйгээр АНУ-ын эдийн засгийн системтэй маш төсөөтэй. Британийн капитализмын давуу талууд нь хөдөлмөр эрхлэлтийн хувь харьцангуй өндөр, ажилгүйдлийн хувь доогуур байдаг. Сөрөг талууд нь гэвэл британийн компаниуд АНУ, Германы компаниудтай харьцуулахад бүтээмж нь доогуур, богино хугацаанд ашиг олоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг. Эдийн засгийн эрчимтэй бууралтын үед маш уян хатан хөдөлмөрийн зах зээлийн дараагийн нэг сул тал нь гарч ирдэг: Ажилтнуудыг богино хугацааны дотор олноор нь ажлаас халж болдог тул ажилгүйчүүдийн тоо асар хурдацтай нэмэгддэг.

Ангиллын энэхүү судалгааны үр дүн хэзээ ч төгс байдаггүй, байнга өөрчлөгдөж байдаг гэдгийг анхаарах нь чухал. Цэвэр мажертори сонгуулийн систем ба төвлөрсөн төрийн бүтэц дээр суурилсан Их Британийн улс төрийн систем нь тухайн сонгуулиар сонгогдсон засгийн газарт өргөн хүрээтэй бүтцийн өөрчлөлт хийх боломжийг олгодог.

### 6.3.Герман Симон Баут

Герман бол зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн нийтлэг шинжийг агуулсан орон. (Майер 2005а, 280-р хуудас) бөгөөд удаан хугацааны туршид эдийн засгийн хурдацтай хөгжил, улс төрийн тогтвортой байдал, нийгмийн тэнцвэрт байдлыг хослуулж чадсан үлгэр жишээ загварт тооцогдож байлаа. (Эглэ 2006 он, 273-326-р хуудас). Ажилгүйдэл нэмэгдэж буй байдал, 1990-ээд оны эдийн засгийн зогсонги байдлын улмаас германы загвар сайны жишээ болон гялалзахаа байж британийн "Эдийн засагч" сэтгүүлд германы эдийн засгийг Европын өвчтэй эр гэж нэрлэсэн байна. Сүүлийн жилүүдийн эдийн засгийн үсрэнгүй өсөлт дээрх шүүмжлэлийг няцааж буй мэт харагдаж байсан ч санхүүгийн зах зээлийн хямрал Германд хүнд сорилт болжээ.

#### Санхүүжилтийн систем

Германы компаниудын санхүүжилтэнд хөрөнгийн зах зээлээр дамжин хийгддэг санхүүжилт тун бага хувийг эзэлдэг. Тэгэхлээр компаниудын удирдлага нь зөвхөн зах зээлээс үнэлэгдээд зогсохгүй компаниудад байнгийн үйлчилгээ үзүүлдэг банкууд, бусад компаниуд, ажилтнуудын төлөөлөл, төрийн актёруудаас үнэлэгдэж байдаг. Энэ холбоо хувь хүмүүс хоорондын мэдээлэл солилцоо, харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Компаниудын санхүүжилт зонхилон банкны зээлээр дамжин хийгддэг. Зээл авахад компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийн зэрэгцээ тухайн компанийн нэр хүнд, сүлжээ чухал үүрэгтэй. Хөрөнгө оруулагчид компанийн нэр хүнд, үйл ажиллагааны арга барилын тухай мэдээллийг ойрын харьцааны сүлжээгээр олж мэддэг.

Ийнхүү "тэвчээртэй" хөрөнгөнд нэвтрэх боломж нь богино хугацаанд олох ашгаас хамааралгүй тул компаниудад удаан хугацааны дараа ашгаа өгөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийх өндөр мэргэшсэн хамт олноо эдийн засгийн хямралын үед ч аваад үлдэх бололцоо олгодог. Германы компаниудын менежментийн баг ойрын хугацааны ашиг, өөрийн компанийн хувьцааны үнийн хэлбэлзэлд тэр даруйд нь хариу үйлдэл үзүүлээд байдаггүй нь дээрх харилцаанаас үүдэлтэй гэж ажиглагчид үздэг. Татварын болон бусад хуулийн зохицуулалтууд, компаниудын харилцааны өргөн хүрээтэй сүлжээнүүд нь дайсагнагч компаниа худалдан авах замаар өрсөлдөгчөө буулган авах явдалд

*Герман улс  
зохицуулалттай зах  
зээлийн эдийн засагтай.*

*Компаниудын  
санхүүжилт банкуудаар  
дамжин хийгддэг.*

*"Тэвчээртэй" хөрөнгөнд  
нэвтрэх боломж*

туйлын болгоомжтой хандахад хүргэдэг. Компаниуд ба банкуудын ажил хэргийн нягт уялдаа нь зах зээлд шинээр хөл тавигчдын хөрөнгөнд нэвтрэх боломжийг хүндрэлтэй болгож нэгэнт байр сууриа эзэлсэн компаниудад тааламжтай нөхцөлийг бүрдүүлдэг учраас “Банкны картел” үүсгэж байна гэдэг шүүмжлэлд өртдөг. (Бари \Шмидт 1996 он). Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн салбарын компаниудын ажил хэргийн уялдаа суларч, олон улсын оролцоо өсөж буй хандлага харагдаж байна. Дараагийн бүлэгт энэ талаар тайлбарлах болно.

### Тойрон аялал:

#### “Герман улс Хувьцаат компани” төгсгөл болох уу?

1990-ээд оноос хойш эхний үед улс төрийнхний анхаарлаас холуур, алгуурхнаар, гэхдээ байнгын эрс өөрчлөлт явагдаж ирснийг Герман Улс Хувьцаат компанийн задрал гэж нэрлэж байна. “Герман Улс Хувьцааткомпани” гэдэг томъёолол нь Германы банкууд ба аж үйлдвэр нь хоорондоо ажил хэргийн нягт холбоонд байдаг уламжлалыг илэрхийлж байгаа юм. Эдгээр холбоос нь эзэнт улсын үеэс эхтэй. Энэхүү ажил хэргийн нягт холбоо нь германы компаниудыг гадагшаа хаалттай, дотооддоо тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлдэг байлаа. Даяаршлын дарамтын дор компаниуд, тэдгээрийн үйлчлүүлдэг банкууд хоорондын сүлжилдсэн харилцан оролцоо нь (нэг компани нөгөө компанийхаа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх, нөгөөдөх нь мөн адил) нэн ялангуяа германы компаниуд даяаршсан хөрөнгийн зах зээлд оролцохыг хүсэж буй тохиолдолд саад болж болдог. (Эгле 2006:291)

Ийм учраас компаниуд хоорондын нэн ялангуяа банкууд, аж үйлдвэрийн хөрөнгийн харилцан оролцоо нь сүүлийн жилүүдэд илэрхий буурах хандлага ажиглагдаж байна. Германы компаниуд илүү мэргэшиж олон улсын оролцоо нь нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд германд компаниуд хоорондын холбоос, нэн ялангуяа банк ба аж үйлдвэрийн хоорондын холбоо сулрах хандлага ажиглагдаж байна. Энэ процесс нь даяаршил Германы эдийн засгийн системийг хэрхэн өөрчилж байгааг харуулж байна.

Коелн хотноо байрладаг нийгмийн судалгааны Макс-Планк институтын он цагийн дараалал нь 1996 он гэхэд маш нягт байсан хөрөнгийн холбоо, сүлжээ сүүлийн үед илэрхий суларсныг баталж байна.

Хөрөнгийн холбоос суларсны улмаас германы компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлд илүү нээлттэй болсоор байна. Герман улс зохицуулалттай капитализмын загвараас зохицуулалтгүй капитализмын чиглэлд бага зэрэг хөдөлж эхлээд байна. Германы уламжлалт Маннесман компанийг британийн гар утасны Vodafone компани 2001 онд худалдан авсан нь өмнө нь төсөөлөгдөшгүй хэрэг байсан бол өнөөдөр Дакс фирмийн 30 гаруй салбар олон улсын компаниудын мэдэлд шилжээд байна. Зуун солигдох үед зөвхөн гуравхан Дакс компани байлаа. Мөн энэ хугацаанд Германд гадаадын шууд хөрөнгө оруулалт гурав дахин нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ олон улсын зах зээл дээрх германы оролцоо ч нэмэгдсэн байна.

2008 он, Лотар Крмпел Нийгмийн судалгааны Макс-Планкийн институт, [www.mpifg.de/people/lk](http://www.mpifg.de/people/lk), Монополийн комиссын тоо баримтууд, <http://www.monopolkommission.de>

Өмнө нь бусад компаниудын оролцооны хувийг худалдахад худалдан авагчдын сонирхлыг бууруулдаг байсан, аж үйлдвэр ба банкуудын холбоосыг гагнаж байсан гадагшаа нээлттэй зарладаг ашигт ногдуулдаг 53%-ийн татварыг өөр ямар нэгэн орлох татваргүйгээр тэглэсэн нь компани ба аж үйлдвэрийн холбоос сулрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Германы компаниуд дахь олон улсын компаниудын оролцоо болон шууд хөрөнгө оруулалтууд нэмэгдэх хандлага хэвээр байна. Гэхдээ өдгөө “sovereign-wealth-funds” буюу төрийн сан ба Private-Equity-Fonds буюу хувийн өмчийн сангийн дээрх нээлттэй байдлыг хязгаарлах хэрэгтэй эсэх талаар маргаан өрнөж байна.

Герман Улс ХК-ын задралын тэнцэтгэл холимог байдалтай байна. Нэг талаас хөрөнгө оруулалт болон техник-технологийн дэвшил хэлбэрээр орж ирж буй олон улсын хөрөнгөнд нээлттэй байдал нь германы компаниудын өрсөлдөх чадвар хэвээрээ байж дэлхийн зах зээл дээр байр сууриа бэхжүүлэхэд нь хувь нэмрээ оруулсан байна. Нэгж бүтээгдэхүүнд ногдох цалингийн зардал европын бусад орнуудтай харьцуулахад дорвитой буурсан байна. Экспортын хэмжээ арван жилийн дотор 50% хүртэл нэмэгдсэн байна. Энэ нь бусад хөрш орнуудынхаас хол түрүүлсэн үзүүлэлт юм. (Эх сурвалж: Economist Intelligence Unit 2006). Нөгөө талаас ашигтай ажиллах дарамт, богино хугацааны чиг хандлага нэмэгдэж буй нь хөдөлмөрийн харилцааны

*Зохицуулалтгүй загвар  
луу ойртох хандлага  
ажиглагдаж байна.*

*Олон улсын хөрөнгийн  
урсгалын давуу болон  
сөрөг талууд*

найдвартай байдал суларч байгаагаар илэрч байна.

Германы компаниудыг Private-Equity буюу хувийн өмчийн нийгэмлэг, Hedge-Fonds буюу эрсдэлээс хамгаалах сангууд худалдан авах эрсдэл нэмэгдэж буйтай холбогдуулан царцааны нүүдлийг гараа тосон хүлээж аваад байгаа юм биш үү? гэсэн мэтгэлцээн өрнөж байна. Эдгээр хөрөнгө оруулагч нийгэмлэгүүдийг богино хугацаанд ашиг олохоос өөр зүйл сонирхохгүй байна хэмээн шүүмжилж байна.

Эдийн засгийн салбарын эрдэмтэн судлаачдын зөвлөлөөс 2005 оны нийт эдийн засгийн хөгжилд өгсөн үнэлгээндээ энэ талаар "Германд өрнөж буй эдийн засгийн хөгжлийн тухай мэтгэлцээнд компаниудад учирч болзошгүй эрсдэлүүд чухал байр эзэлж байна. Богино хугацаанд өндөр ашиг олох зорилготой санхүүгийн хөрөнгө оруулагчид компаниудад хувь эзэмших болсноор өөрсдийнхөө оролцоог дараа нь зарж борлуулахад хялбар болгохын тулд компаниудыг задалж, нөөцийг тарамдуулж эцэст нь компаниудыг сулруулаад орхих бий гэдэг сэрэмжлэл их байна." гэж тэмдэглэжээ. Энэхүү үнэлгээ, сэрэмжлүүлгийн хариу үйлдэл болгож 2008 онд эрсдэлийг хязгаарлах тухай хууль батлагдан гарсан юм. Уг хуулийн дагуу хөрөнгө оруулагчид санхүүгийн хэрэгслүүдийнхээ (мөнгөний) эх сурвалж болон зорилгоо нээлттэй мэдүүлэх ёстой болж байгаа юм. (Эрдэмтэн судлаачдын зөвлөл 2005 он, 35-р хуудас)

### **Хөдөлмөрийн харилцаа**

Германы үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг нь олон улсын түвшинд харьцуулахад дундаж түвшинд байна. Бүх ажиллагсдын 23% нь үйлдвэрчний гишүүнчлэлтэй байна. (2003 он, 109-р хуудас)

Тарифын автономит  
байдал

Салбарын тарифын  
хэлэлцээрүүд хийгддэг.

Тарифын автономит байдал үйлчилдэг учраас үйлдвэрчний эвлэлийнхэн цалингийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийг тогтооход хүчтэй нөлөөлж чаддаг. (Эгле 2006 он, 14 ) Үйлдвэрчний эвлэл болон ажил олгогчдын холбоонууд нь салбарын түвшинд байгуулагддаг. Жишээлбэл: Металлын үйлдвэрт нэг талаас ИГ Металл үйлдвэрчний эвлэлийн холбоо, нөгөө талаас Нийт Металл ажил олгогч эздийн холбоо үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь тарифын хэлэлцээрийн зохицуулалт металлын салбарын хязгааруудын хүрээнд хийгдэх бөгөөд нь ингэснээр аж үйлдвэрийн нэг салбарт ажиллаж буй ажилтнууд ижил хэмжээний цалин авах нөхцөлийг баталгаажуулдаг

гэсэн үг юм. Ийнхүү нэг салбарт ажиллаж буй ажиллагсад ижил хэмжээний цалин авах баталгаа хангагдсанаар компаниудын хооронд өндөр мэргэшсэн ажилтнууд олж авахын төлөө цалингийн өрсөлдөөн зарлах явдал хаагддаг. (Хассел 2006 он, 14)

Герман улс нь бусад олон улс орнуудтай харьцуулахад хөдөлмөрийн зохион байгуулалт болон боловсон хүчний асуудлаар компанид ажиллаж буй ажилтнуудын оролцоог хангах чиглэлд харьцангуй дэвшилд хүрсэн. Компанийн засаглалын тухай хуулиар компанийн ажилчдын зөвлөл хэдэн гишүүнтэй байх, ямар эрх мэдэлтэй байх, ямар нөхцөлд огцруулах бэ? гэдгийг тогтоож өгсөн. 500-аас дээш ажилтантай хөрөнгийн нийгэмлэгүүд заавал компанийн шийдвэр гаргалтанд ажилтнуудынхаа оролцоог хангах тухай хуулийг мөрдөх ёстой. Энэ нь компанийн ажиллагсад төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөгчөө суулгаж болно гэсэн үг юм.

### **Боловсролын систем**

Германы олон компаниудын иж бүрэн үйлдвэрлэлийн систем нь ихэнхдээ нарийн мэргэшсэн өндөр чадвартай ажиллах хүчнийг шаарддаг. Энэ шаардлагыг практикт ойр, мэргэжлийн өндөр түвшний мэдлэг чадвар олгодог мэргэжил олгох дуал буюу хосолсон систем хангаж чаддаг гэдэг нь амьдралаар батлагдсан. (Эгле 2006 он, 287) Мэргэжлийн сургалтын хосолсон систем нь "Германы капитализмын цөм нь болсон байгууллага" юм. (Хассел 2006 он, 13). Мэргэжлийн сургалтанд хамрагдагсад харьцангуй маш бага цалин авдаг ч зарчмын хувьд залуучуудыг чадварлаг ажилтан болчихоод хөдөлмөрийн зах зээл дээр хөл тавих нөхцөлийг бүрдүүлдэг тул герман нь OECD –Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын дунд залуучуудын ажилгүйдлээр хамгийн сүүлийн байранд ордог. (Залуу ажилгүйчүүдийн тоог бүх насанд хүрсэн ажилгүйчүүдийн тоонд харьцуулсан харьцаа) (Хассел 2006 он:15)

Бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр мэдлэг чадвартай ажилтнууд ерөнхий мэдлэг чадвартай тул халж солиход хялбар бусад орны ажилтнуудтай харьцуулахад хэлэлцээрт амжилт олох магадлал өндөртэй, эрх мэдэлтэй байдаг. Өндөр чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь нарийн мэргэжлийн ажилтнуудаас хараат байдлыг үүсгэдэг. Улам өргөн хүрээтэй болж буй ажилтнуудын шаардлагаас хамгаалах, мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнуудыг бусад компаниуд илүү нөхцөл амлах замаар булаан авахаас сэргийлэхийн

*Компанийн шийдвэр  
гаргалтанд ажилтнуудын  
оролцоог хангах тухай  
хууль*

*Дуал буюу мэргэжил  
олгох хосолсон  
сургалтын системийн  
агч холбогдол*

тулд германы компаниуд аж үйлдвэрийн харилцааны системд ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийнхний хооронд явагддаг зохицуулалттай тарифын хэлэлцээрийг аж үйлдвэрийн секторуудын хүрээнд байгуулдаг уламжлалтай. Ингэснээр нийт аж үйлдвэрийн секторт ойролцоогоор ижил түвшний мэргэжлийн ур чадвартай ажилтнууд ижил хэмжээний цалин авах нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь аж үйлдвэрийн тодорхой секторт нарийн мэргэжил эзэмшсэн ажиллах хүчнийг өөр компаниуд урвуулан авах явдлыг бэрхшээлтэй болгодог.

*Мэргэжлийн  
боловсролын системд  
бэрхшээл учруулж  
байна.*

Дараах гурван шалтгааны улмаас мэргэжлийн боловсролын дуал системд аюул учирч байна: Нэгдүгээрт: Эдийн засгийн өсөлтийн байдлаас хамаардаг. Эдийн засгийн үсрэнгүй өсөлтийн үед мэргэжлийн сургалтанд хамрагдагсад хямд, уян хатан ажиллах хүч болдог учраас компаниуд дуртайяа авч ажиллуулдаг. Харин эдийн засгийн зогсонги байдлын үед сургалтын орон тоо дутагдаж эхэлдэг. Энэхүү дутмаг байдал нэлээд удаан хугацаагаар үргэлжилбэл тухайн жилийн төгсөгчдөөс гадна сургалтын орон тоо гарахыг хүлээж байсан өмнөх жилүүдийн төгсөгчид нэмэгддэг учраас сургалтын орон тооны төлөөх өрсөлдөөн хүчтэй болдог. Хоёрдугаарт: Компаниуд мэргэжилтэй ажилтан бэлтгэх хариуцлагаасаа аль болохоор зайлсхийдэг болж байна. Гуравдугаарт: сурсан, мэдсэнээ ашиглах хугацаа улам бүр богиноссоор байна. Ямар ч мэргэжлээр насан туршдаа ажиллах боломж бараг үгүй болжээ. Германы мэргэжил дээшлүүлэх ба шинээр мэргэшүүлэн сургах орон тоо бага, хөгжлөөр сул тул хөдөлмөрийн ертөнцөд өндөр хурдацтай явагдаж буй хувьсал өөрчлөлтөд дасан зохицож, цаг үедээ тохирсон хариулт өгөх тал дээр хоцрогдолтой хэвээр байна.

### **Компаниуд хоорондын харилцаа**

Германы томоохон компаниудын менежментийн багт чухал шийдвэрүүдийг дангаараа гаргах боломж бараг байхгүй. Үүний оронд банкууд, бусад компаниуд, ажилтнууд, төрийн актёруудын төлөөллийг багтаасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, сүлжээний зөвшөөрлийг авах шаардлагатай болдог. Үүний үр дүнд компанийн шийдвэр хувьцаа эзэмшигчдийн богино хугацаанд өндөр ашиг олох сонирголоор тодорхойлогддоггүй. Харин нийгмийн олон тооны /Staboholder/ -уудын сонирхлын бүлгүүдийн ашиг сонирхлыг харгалзан үздэг.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас германы улс төрийн эдийн

*Компанийн удирдлагууд  
олон талын ашиг  
сонирхлыг харгалзан  
үзэх шаардлагатай  
болдог.*



засагт төрийн үүргийг: “Төр нь эдийн засагт хамгийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж, чадавхийг дээд зэргээр нэмэгдүүлэх үүрэгтэй.” гэж тодорхойлсон байна. Төрийн зүгээс эдийн засагт шууд нөлөөлөх боломж нь холбооны улсын бүтэц, Холбооны банк, Холбооны картелийн газар зэрэг олон тооны хараат бус байгууллагуудаар хязгаарлагдаж байдаг тул төрийн зохицуулалтаас гадуур байдаг, зах зээлд даатгасан эдийн засгийн бодлогын салбаруудын өөрийгөө зохицуулах, удирдахад дэмжлэг үзүүлэхийн тулд нийгмийн бүлгүүд, төрийн байгууллагуудтай төстэй байгууллагуудтай хамтран ажиллах актёруудын сайн дурын зохион байгуулалтыг дэмжих, тэдгээрийг шаардагдах, үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн хэрэгслүүдээр хангах хэлбэрүүдийг хөгжүүлсэн байна. Европын төв банк (ЕТБ) түүний мөнгөний хараат бус байдал болон европын өрсөлдөөнийг зохицуулах комиссарууд улс төр ба эдийн засгийн зарчмуудыг дагаж мөрддөг. Эдгээр зарчмуудыг ХБНГУ мөн дагаж мөрддөг учраас ямар нэгэн гажуудал гардаггүй. Үүнээс гадна төр нь нийгмийн нийт бүтээгдэхүүний томоохон хэсгийг үндсэн хуулиар тогтоосон “амьдралын тэгш нөхцөлийг” -г холбооны бүх улсуудад баталгаажуулахын тулд нийгмийн хамгааллын системд зарцуулдаг. Төр нь тэгш байдлыг хангах үүргээ биелүүлэхийн тулд “Бүс нутгийн дахин хувиарлалтын систем”-ийг хөгжүүлсэн юм. (Стреек 1995 он)

### Үнэлгээ

Германы эдийн засгийн систем нь ангелсаксоний орнуудын зах зээлийн эдийн засаг ба скандинавын нийтийн сайн сайхны төлөөх төрийн дундах зам юм. (Шмидт 2000 он)

Германд бусад орнуудтай харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь: ихэвчлэн удаан хугацаанд үргэлжилдэг: Дунджаар авч үзэхэд германы ажилтнууд арваас дээш жил нэг ажил олгогчийн компанид ажилладаг бол Их Британид найман жил, АНУ -д долоон жил ажилладаг байна. (Стреек 1995 он) Хөдөлмөрийн харилцаа нь хамтын ажиллагаан дээр тулгуурласан, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар өндөр байх нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлдэг. Бүтээмж өндөр байх нь ажилтнуудад өндөр цалин хөлс өгөх, ажлын цагийг богиносгох нөхцөлийг бүрдүүлдэг. (Хассел 2006 он)

Тийм ч учраас германд цалингийн зөрүү төдийлөн их биш бөгөөд бусад орнуудаас ялгаатай нь мэргэжилтэй ажилтнууд дундаж давхаргад хамрагддаг. Германы дундаж давхарга ч бусад орнуудтай харьцуулахад хүн амын өргөн хүрээг хамардаг. Германы хүн амын

*Герман улсыг  
Скандинавын орнууд ба  
АНУ-тай харьцуулах нь:*

66% нь дундаж давхаргад хамрагддаг бол Британичуудын 26%, Америкчуудын 44% нь дундаж давхаргад хамрагддаг. (Роессел 2005 он) 1990-ээд оноос эхэлсэн эдийн засгийн хямралуудын нөлөөгөөр германы загвар ч шүүмжлэлд өртөх болсон юм. Нэн ялангуяа 2005 оны Бундестагийн сонгуулийн өмнө Консервативчууд хонгилын эцэст гэрэл харагдаж байна уу? гэдэг мэтгэлцээнийг өрнүүлсэн юм. Тэдний хэлж буйгаар бол герман олон улсын тавцан дээр өрсөлдөх чадваргүй болж байгаа гэнэ. Тэдний муу амласнаар болсонгүй, Герман улс олон улсын тавцан дээр өрсөлдөх чадвар сайтай гэдгээ олон жил дараалан баталж экспортоор дэлхийд тэргүүлсээр байна. Энэ нь автомашины үйлдвэр, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн иж бүрэн үйлдвэрлэлийн процессоор үйлдвэрлэгдэн гарч буй бүтээгдэхүүний чанар өндөр байдагтай холбоотой. Германы аж үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын нийт ажиллагсдын дунд эзэлж буй хувь OECD буюу олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн бусад орнуудтай харьцуулахад тогтмол арваас дээш хувьтай байна. (Эгле 2006 он:292)

| Герман                                                    |               |                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-----------------------------------------------------------|---------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг хүнд ногдох ДНБ 2008 оны байдлаар                     | 29.100 Евро   | Нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын стандартаар илэрхийлсэн үзүүлэлт. Үг үзүүлэлт нь Европын Холбооны (ЕХ)-ны 27 гишүүн орны дундажаар нэг Еврогийн худалдан авах чадвартай тэнцэнэ. (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                 |
| Эдийн засгийн дундаж өсөлт 1990-2007 оны байдлаар         | 1.4%          | Нэг хүнд ногдох эдийн засгийн жилийн дундаж өсөлт, үнэ тогтвортой байхад (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2009 он, 195)                                                                                                                                                                                     |
| Төрийн өр (Төсвийн алдагдал)                              | 65.9%         | Төсвийн алдагдлыг ДНБ-ний хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Холбооны сангийн яам, 2009 оны 12-р сарын мэдээ, 99-р хуудас)                                                                                                                                                                              |
| Бүтээмжийн тайлан 2008 оны байдлаар                       | 6.4%          | Таварын экспорт ба импортын зөрүү ДНБ-ний хувиар (Эх сурвалж: Олон улсын валютын сан, Дэлхийн эдийн засгийн мэдээ 2009 оны 10-р сар, 187-р хуудас)                                                                                                                                                            |
| Хөдөлмөр эрхлэлтийн квот 2008 оны байдлаар                | 70.7% (65.4%) | Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоог (эмэгтэйчүүдийг оролцуулан) хөдөлмөрийн насны 15-64 насны хүмүүсийн бүх хүн амын тоонд харьцуулсан харьцаа (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                   |
| Ажилгүйдлийн квот 2008 оны байдлаар                       | 7.3%          | Хөдөлмөрийн насны бүх хүн амд ажилгүйчүүдийн эзэлж буй хувь (Олон улсын стандарт) (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                                                                               |
| GINI-коэффициентээр илэрхийлэгдэх орлогын тэгш бус байдал | 28.3%         | Орлогын тэгш бус хувиарлалтыг илэрхийлэх үзүүлэлт 100%-орлогын тэгш бус байдалын дээд хязгаар (Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                                                   |
| Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн орлогын тэгш бус байдал     | 58%           | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээд олж буй орлогыг эрэгтэйчүүдийн орлоготой харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                                        |
| Ядуурлын индекс                                           | 10.1%         | Ядуурлын индекс нь хүн амын дундаж наслалт, бичиг үсэгт тайлагдсан хүмүүсийн бүх хүн амд эзэлж буй хувь хэмжээ, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг. (0-ядуурлын хамгийн доод хэмжээ, 100- ядуурлын дээд хэмжээ) (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2007\08,241-р хуудас) |
| Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг            | 19.9%         | Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтанд орсон хөдөлмөр эрхлэгсдийн эзэлж буй хувь (Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын тайлан)                                                                                                                                                    |

## 6.4. Япон

Вернер Паша

Япон улс бол зохицуулалтай зах зээлийн нийтлэг жишээ юм. Зохицуулалттай зах зээлийн хүрээнд Халл\Соскисе нарын судалгааны дагуу (2001-34) тус улсын эдийн засгийн зохицуулалт нь бүлэглэлүүдээр (аж үйлдвэрийн) дамжин хийгддэг. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа салбар дамнасан эдийн засгийн холимог концернуудаар дамжин хийгддэг гэсэн үг юм. Энэхүү бүлэглэлүүдийг Японд Кайретсү гэж нэрлэдэг.

Япон нь германтай төстэй эдийн засгийн хангалуун байдал ба нийгмийн тэнцвэрийг нэгэн зэрэг хангаж чадсан үлгэр жишээ орны тоонд багтаж байлаа. (Кебенхөрстер\Паша\Шире 2003 он)

1990-ээд оны хямралын үеэс энэхүү үлгэр жишээч байдал хөөс мэт замхарсан юм. Хөөсөн эдийн засаг төгсгөл болсноос уг хямрал үүсчээ. (Англи хэлний bubble-буюу хөөс гэдэг үгнээс хөөсөн эдийн засаг гэдэг ойлголт гарсан.) Мөнгө хүүлэх эдийн засаг хөөс мэт хагарсан гэсэн санаа юм. Эхний ээлжинд алгуурхнаар эхэлсэн бол дараагаар нь зах зээлийн либерал шинэчлэл эрчимтэй явагдаж эхэлсэн юм. Нэн ялангуяа ерөнхий сайд Козүмигийн засгийн газрын үед (2001-2006 онд) шинэчлэл эрчимтэй явагдсан юм.

### Санхүүжилтийн систем

Дайны дараах үеэс японы компаниудын санхүүгийн систем банкууд дээр суурилах болсон юм. Компаниудын санхүүжилтийн хамгийн чухал хэрэгсэл нь олон арван жилийн туршид банкны зээл байлаа.

Дайны дараах он жилүүдэд хөрөнгийн хомсдолын улмаас төв банкнаас хэр хэмжээний зээл авч чадаж байна гэдгээс бусад банкуудын чадамж нь хамаарч байлаа. Төв банкаар дамжуулан шууд замаар банкуудад, шууд бус замаар компаниудад нөлөөлөх төрийн нөлөө нэмэгдэж байлаа.

Бүхэлд нь авч үзвэл уг системээс том компаниуд хожиж байлаа. Стратегийн чухал зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд төрийн зүгээс томоохон компаниудад бага хүүтэй зээлийг олгож байлаа. Төрийн

*Япон нь германтай нэгэн адил эдийн засгийн хангалуун байдал ба нийгмийн тэнцвэрийг нэгэн зэрэг хангаж чадсан үлгэр жишээ орны тоонд багтаж байлаа.*

*Компаниудын санхүүжилт банкуудаар дамжин хийгддэг.*

дэмжлэгийн үрээр хөрөнгө оруулалтын хувь нэмэгдэж, эдийн засгийн өсөлт эрс нэмэгдсэн юм. Дээрх эерэг хөгжлөөс компанийн ажилтнууд ч хожсон юм. (Аоки\Саксонхаус 2000)

1970-аад оноос байдал өөрчлөгдөж эхэлсэн юм. Эдийн засагт олон улсын оролцоо нэмэгдэж компаниудын санхүүжилт либералчлагдсаны улмаас банкууд болон компаниуд төртэй холбож байсан нягт холбоосноос салж чадсан юм. Нэн ялангуяа томоохон компаниудад хөрөнгийн зах зээлээр дамжин санхүүжилтэнд хүрэх боломж нээгдсэн юм. Энэхүү хувьслын өөр нэг хүсээгүй үр дагавар бол дээр дурьдсан 1980-аад оны сүүлчээр хөөсөн эдийн засаг хагарсан явдал байлаа. (Амикс 2004 он) 1997 онд "Big Bang" буюу "Их үсрэлт" нэртэй багц арга хэмжээ батлагдсан юм. Нээлттэй болон ил тод байдлыг бий болгосноор япон улс санхүүжилтийн идэвхтэй бүс болох ёстой байлаа. 2003 оноос хойш л банкны салбарт хөөс хагарсны хожуу үр дагаврыг арилгаж чадсан юм.

### Хөдөлмөрийн харилцаа

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь удаан хугацаагаар үргэлжилдэг хөдөлмөрийн системийн эхлэл бүр дайны өмнөх үед тавигдсан бөгөөд уг харилцаа дайны дараа л жинхэнэ үр шимээ өгч эхэлсэн байна. (Демес 1998 он) Компанийн олж буй ашгаас хамааран цалинг тогтмол нэмэгдүүлэх, хагас жил тутамд шагналт цалин олгох, нийгмийн хамгааллын түвшинг нэмэгдүүлэх, мэргэжлээрээ ахин дэвших боломжоор хангах зэрэг нь мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнуудыг удаан хугацаагаар компанитай нь холбож өгдөг байлаа.

Энэхүү систем нь компаниудад итгэл даах чадвартай, удаан хугацаагаар компанийн ашгийн төлөө ажиллах, компаниа гэх сэтгэлтэй ажилтнуудын уян хатан ажиллагааг хангаж өгдөг. Гэвч эхний ээлжинд томоохон компаниудад тогтмол ажилладаг эрэгтэй ажилтнуудад ашгаа өгдөг. Эдгээр нь хөдөлмөр эрхэлж буй хүн амын гуравны нэг орчим хувийг л бүрдүүлж байлаа.

Энэ харилцааны сүүдэртэй тал бол ажилтнуудын компаниасаа хараат байдал асар өндөр, тэр ч байтугай эздийн ажиллуулах сонирхолтой ажилтнууд ч гэсэн ихээхэн хараат байдаг. Ажилтнуудын мэргэжлийн туршлага компанитайгаа маш холбоотой байдаг. Төрөл бүрийн компаниудын хооронд шилжих боломж хомс, илүү цагаар ажиллах, гэр бүлтэй ажилтнуудын хувьд гэр бүлдээ цаг гаргах боломжоор муу байдал нь бараг л зайлшгүй гарах үр дагавар юм.

Японд хөдөлмөрийн  
харилцаа удаан  
хугацаагаар  
үргэлжилдэг.

Сүүдэртэй талууд...

Харин эерэг тал нь бол японд орлогын ялгаа нүдэнд харагдахуйц ил, тэр ч байтугай менежментийн багийн удирдлага, жирийн ажилтнуудын орлогын ялгаа төдийлөн их биш байдаг.

Японд дайны дараах жилүүдэд компаниудын үйлдвэрчний эвлэл байгуулагдаж эхэлсэн юм. Компанийн удирдлага, үйлдвэрчний эвлэлийн хооронд байнга зөрчил үүсдэг боловч ихэвчлэн нэг зүгт харж хамтын эрх ашгийн төлөө нэгдэж чаддаг байлаа. Жижиг компаниудад ажилтнуудын эрх ашгийг хамгаалах үйлдвэрчин байгуулах эсхүл тогтмол бус хөдөлмөр эрхэлдэг хүмүүс эрх ашгаа хамгаалах боломжоор хомс байдаг. Бүхэлд нь авч үзвэл хөдөлмөр эрхлэлтийн харилцааны төрөл нэмэгдэж ажилтнуудын үйлдвэрчний эвлэл байгуулах сонирхол буурч байгаагийн улмаас үйлдвэрчний нөлөө буурч байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа удаан хугацаагаар үргэлжилдэг систем ч өөрчлөгдөж байна. (Хаак 2006 он). Дээрх байдал 1990-ээд оны хямралын жилүүдэд эхний ээлжинд өндөр настай, өндөр цалинтай ажилтнуудыг хамарсан юм. Тогтмол бус хөдөлмөр эрхлэлтийн харилцаанууд жишээлбэл: хагас өдрөөр хөдөлмөр эрхлэгсэд, шаардлагатай үед өөр компаниас ажилтан авч ажиллуулдаг компаниудын эзлэх хувь мэдэгдэхүйц өссөн юм. 2003 оноос хойш эдийн засаг амжилттай байсан ч дундаж цалин төдийлөн нэмэгдээгүй байна.

### **Дунд сургууль - болон мэргэжил олгох сургалтын систем**

19-р зууны сүүлчээс төр ерөнхий боловсролыг улсын сургуулиудаар дамжуулан олгох болсон байна. Энэ хооронд бараг бүх залуучууд есөн жилийн заавал олгох дунд сургуулийн боловсрол эзэмшиж байна. Дунд сургуулиуд нь идэвх, тэвчээр суулгах, нийгмийн ухамсар суулгах, үндсэн мэдлэг олгох, бүтээлч бие даасан хувь хүн болгон хөгжүүлэх зорилготой. (Мюнх\Эсвайн 1998 он) Ингэснээр дунд сургууль төгсөгчид нь өөрийн компанидаа шаардагдах мэдлэг чадварыг өөрсдөө олгодог компаниудад хамгийн тохиромжтой ажиллагсад юм.

Нэг компанид зарчмын хувьд олон төрлийн ажил хийгддэг. **“Job rotation, training on the job”** Тэгэхдээ тухайн компаниас олж авсан мэдлэг чадвар тухайн компанидаа ажиллахад л зориулагдсан байдаг учраас өөр компанид шилжин ажиллах боломж бараг байдаггүй. Боловсролын системийн дараагийн нэг онцлог бол залуучуудыг сурлагын чанараар нь ангилдаг явдал юм. Энэхүү шүүлтүүрийн дагуу цалин өндөртэй томоохон компаниуд хамгийн шилдэг төгсөгчдийг

*Компанийн  
үйлдвэрчний эвлэл*

*Ерөнхий мэдлэгийг төр  
олгож...*

*....компаниуд нарийн  
мэргэжил эзэмшүүлдэг.*

шилэн авдаг бол шилдэгт шалгарч чадаагүй сурагчид бага цалинтай компаниудад мэргэжил эзэмших ёстой болдог.

Нэлээд хэдэн жилийн өмнөөс идэвх зүтгэл сайтай ч бүтээлч сэтгэлгээ муутай ажилтнуудтай компани техникийн болон зохион байгуулалтын дэвшлийн оргилд байх зорилтыг биелүүлэх боломжгүй гэдэгт сэтгэл зовних явдал нэмэгдсэн байна. Үүний зэрэгцээ зөвхөн залуу ажиллагсдыг ажиллуулах эрмэлзэл асар хурдан насжиж буй нийгмийн бодит байдалтай зохицохгүй болоод байна. Иймээс дунд сургуулиуд болон их сургуулиуд бүтээлч санаачилгатай бие даасан хувь хүнийг хөгжүүлж дунд насныхан болон ахимаг насныханд зориулсан сургалтын орон тоог бий болгох хэрэгтэй болоод байна. Үүний зэрэгцээгээр компаниуд ажилд авах уламжлалт хэлбэр, зөвхөн компанийн хүрээнд мэргэжил олгох арга хэмжээнүүдээс салахыг оролдож байна. Гадаадад боловсрол эзэмшсэн төгсөгчдийг ажилд авах, өндөр боловсролтой эмэгтэйчүүдийг менежментийн багт ажиллуулах зэрэг нь томоохон сорилтууд болж байна.

### **Компаниуд хоорондын харилцаа**

Японы компаниудын хооронд олон талт холбоосууд байдаг. Зарим ажиглагчид үүнийг сүлжээний эдийн засаг гэж нэрлэдэг. (Линкольн\Герлах 2004 он) Митсүвиши, Сумитомо зэрэг босоо бүтэцтэй холимог концернууд нь олон салбар дамнасан үйл ажиллагаа явуулдаг. Боловсон хүчнээ солилцох, хөрөнгө болон бусад механизмуудаар хоорондоо холбогдсон байдаг. Компаниудын бусад бүлэглэлүүдтэй өрсөлдөхийн тулд өрсөлдөөний давуу талуудыг бий болгохын зэрэгцээ салбар дамнасан мэргэжлийн давуу талуудаа хэвээр хадгалж чаддаг.

Хэвтээ хэлбэрээр байгуулагдсан компаниудын бүлэглэлүүд нь бүтээмжийн үйлдвэрлэлийн дагуу гинжин холбоосыг үүсгэдэг. Тоёота компанийн жишээн дээр авч үзвэл эх компани нь эцсийн угсралт дээр чанарыг баталгаажуулах үүргийг хүлээж, стратегийн асуудлыг хариуцдаг бол нийлүүлэгчдийн эхний бүлэг системийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийн үйлдвэрлэлийг хариуцдаг. Эдгээрийн доод талын түвшинд байрлах жижиг нийлүүлэгчид нэгж бүрэлдэхүүн хэсгүүдийг үйлдвэрлэдэг. Иймэрхүү пирамид хэлбэрийн нийлүүлэгчдийн бүтэц нь уян хатан ажиллагаатай, өндөр чанартай, олон талтай байдаг ч эдийн засгийн өсөлт бэрхшээлтэй байх үед доод түвшнүүдэд байрлах жижиг компаниуд хамгийн хүнд ачааг үүрдэг.

Банк ба компаниуд хоорондын зээлд тулгуурласан санхүүгийн системээс бусад харилцаанууд үүсдэг. Дайны дараах үед банкууд нь компаниудын үйлчлүүдэг банк гэдэг утгаараа хяналтын үүргийг гүйцэтгэж байсан тул хувьцаа эзэмшигчдээс илүү ач холбогдолтой байлаа. Японы компанийн удирдлагын систем нь дотооддоо менежментийн дээрээс доошоо чиглэсэн бүтцийн, гаднаас банкны хяналтад байдаг онцлогтой. (Диркс\Отто 1998 он) Аль нэг компанийн үйл ажиллагаа доголдолд орох нөхцөлд банкууд системийн хямралаас сэргийлэхийн тулд туслалцаа үзүүлдэг байлаа. Үүний хариуд төр харьцангуй сул банкуудад ч баталгаа гаргаж өгдөг байв. Банкууд ба компаниудын хоорондын хувь хүмүүсээр дамжсан холбоос, зарим тохиолдолд хариуцсан төрийн албан хаагчаар дамжуулан удаан хугацааны стратегийг хэрэгжүүлэх боломж нээгддэг. Эсрэгээрээ эргэлзээтэй тохиролцоонд хүрэх, хээл хахуулийн асуудал ч гарч ирэх талтай.

Энэ хооронд дээрх систем томоохон дарамтанд ороод байна. Олон улсын хөрөнгийн зах зээлээс хараат байдал өсөхийн хэрээр компаниудаас харилцаа болон компанийн удирдлагын хэлбэрээ илүү ил тод болгохыг шаардаж байна. Ингэснээр японы компаниуд барууны компаниудын нэгэн адил богино хугацааны дотор шийдвэр гаргаж үйл ажиллагаагаа явуулах дарамтанд орсны улмаас тэдний хүчтэй байдгийн нууц болох удаан хугацааны харилцан итгэлцсэн хамтын ажиллагааны давуу талаа алдах аюул тулгараад байна.

### Үнэлгээ

Дайны дараах үед бүлэглэлүүд дээр суурилсан, зохицуулалттай капитализм нь японы аж үйлдвэрийн секторын хүчирхэг талуудыг үр ашигтайгаар хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой нөхцөлүүдийг бүрдүүлж байлаа. Өргөн хүрээнд стандартчигдсан аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарыг алхам алхмаар сайжруулж, чанарын өндөр түвшинд олноор нь үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн бүтээмжийг тогтмол дээшлүүлэн дэлхийн зах зээл дээр гаргаж чадсан юм. Банкны санхүүжилт ба хяналт нь урт хугацааны стратегийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байлаа. Нөлөө бүхий компаниудын бүлэглэл нь стратегиа хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийн бүрдүүлэлтийг зохион байгуулж ажилсаг ажилтнууд стратегийг хэрэгжүүлж байв. Боловсролын систем нь ажилсаг залуу ажилтнуудыг олноор нь бэлтгэж өгдөг байлаа.

Дээрх механизм зарим нэг нийгмийн болон бодлогын асуудлуудыг

*Банкууд компаниудад  
хяналт тавьдаг.*

*Аж үйлдвэрийн  
үйлдвэрлэлийн үр  
ашгийг нэмэгдүүлэх...*

*...харин нийгмийн  
болон бодлогын  
асуудлууд*

үүсгэж байлаа. Жишээлбэл: Том ба жижиг компаниудын хоорондын ялгаа ихсэж, хувь хүмүүсийн хөгжих боломж хавчигдмал, тодорхой хэмжээний хээл хахуульд автах байдал гарч байсан ч бүхэлд нь авч үзвэл иргэдийн дийлэнх нь нийт эдийн засгийн үсрэнгүй өсөлтөөс хувь хүртэж байлаа.

Даяаршил, техникийн болон зохион байгуулалтын дэвшлийн улмаас дээрх систем хөгжлийн дээд хязгаартаа хүрсэн ч нийгмийн тэнцвэрт байдал хангалттай хэмжээнд хангагдаж чадахгүй байгаа нь засгийн газрыг ихээхэн дарамтанд оруулах болж Козүмигийн зах зээлийн шинэчлэл дууссаны дараагаар засгийн газрын тогтворгүй байдлын нэг шалтгаан болоод байна.

Энэ хооронд японы эдийн засгийн систем зохицуулалтгүй, англоамерик хэв шинжийн загварын хэм хэмжээнд ойртож байна уу? гэдэг асуудал хүчтэй яригдаж байна. (Доре 2000 он, Паша 2004 он, Стреек\Амамура 2003 он). Гэхдээ япон улс зохицуулалтгүй капитализмын зам руу хазайхгүй гэдэг нь харагдаж байна. Үүний хамгийн тод жишээ бол компаниудын удирдлагад явагдаж буй хөгжил юм. Нэн ялангуяа зохицуулалтгүй загварын нийтлэг шинж болох банкууд ба хөрөнгийн зах зээлд чиглэсэн бодлого явуулах, зах зээлээс хамааралтай боловсон хүчний бодлого, удирдлагын бүтцүүдийг нийтэд нээлттэй болгох зэрэг үзэгдэл өнөөг хүртэл бараг дэлгэрээгүй байна. Төрөл бүрийн компаниудад зохицуулалтгүй зах зээлийн гэхээсээ илүү завсрын хэлбэрүүд давамгайлж байна. Жишээлбэл: Ерөнхийдөө дайны дараах үеийн уламжлалыг хэвээр хадгалсан загварт илүү нээлттэй боловсон хүчний бодлогыг оруулах гэх мэт. (Аоки\Тияажима 2007 он) Шинэ, зоримог нийтлэг систем хараахан төлөвшөөгүй байна.



## Япон

|                                                                  |                  |                                                                                                                                                                                                                                                                                         |
|------------------------------------------------------------------|------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг хүнд ногдох ДНБ<br>2008 оны байдлаар                         | 27.800 Евро      | Нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын стандартаар илэрхийлсэн үзүүлэлт. Үг үзүүлэлт нь Европын Холбооны (ЕХ) гишүүн 27 орны дунджаар нэг Еврогийн худалдан авах чадварыг илэрхийлдэг. (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                            |
| Эдийн засгийн дундаж өсөлт 1990-2007 оны байдлаар                | 1.0%             | Нэг хүнд ногдох эдийн засгийн жилийн дундаж өсөлт, үнэ тогтвортой байх нөхцөлд (Хүний хөгжлийн индекс 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                                            |
| Төрийн өр (Төсвийн алдагдал) 2008 оны байдлаар                   | 173.1%           | Төсвийн алдагдлыг ДНБ-ний хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Холбооны сангийн яам, 2009 оны 12-р сарын дэлхийн эдийн засгийн мэдээ, 99-р хуудас)                                                                                                                                  |
| Бүтээмжийн тэнцэтгэл 2008 оны байдлаар                           | 3.2%             | Таваарын нийт экспорт ба импортын зөрүүг ДНБ-ний хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Олон улсын валютын сан, 2009 оны 10-р сарын дэлхийн эдийн засгийн мэдээ 187-р хуудас)                                                                                                         |
| Хөдөлмөр эрхлэлтийн квот 2008 оны байдлаар                       | 70.7%<br>(59.7%) | 15-64 насны (эмэгтэйчүүдийг оролцуулан) хөдөлмөрийн насны бүх хүмүүсийн тоог нийт хүн амын тоонд харьцуулсан харьцаа (Эх сурвалж: ЕХ-ны стандарт)                                                                                                                                       |
| Ажилгүйдлийн квот 2008 оны байдлаар                              | 4.0%             | Хөдөлмөрийн насны хүн амын дунд ажилгүйчүүдийн эзэлж буй хувь (Олон улсын стандарт) (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                                                       |
| GINI-коэффициентээр илэрхийлэгдэх орлогын тэгш бус байдал        | 24.9%            | Орлогын тэгш бус хувиарлалтыг илэрхийлэх үзүүлэлт, 100% -тэгш бус байдлын дээд хязгаар, (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                       |
| Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн орлогын тэгш бус байдал            | 45%              | Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн орлогыг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 186-р хуудас)                                                                                                                                             |
| Ядуурлын индекс                                                  | 11.6%            | Ядуурлын индекс нь хүн амын дундаж наслалт, бичиг үсэгт тайлагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зэрэг олон үзүүлэлтүүдээс бүрддэг. 0- ядуурлын доод түвшин, 100-ядуурлын дээд түвшин, (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009 он 180-р хуудас) |
| Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг 2003 оны байдлаар | 18.3%            | Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн дунд үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтад орсон буюу үйлдвэрчний гишүүдийн эзлэх хувь (Эх сурвалж: Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын статистик)                                                                 |

## 6.5.Швед

Эрик Гургдиес

“Эв санааны нэгдлийн  
цалингийн бодлоготой”  
бүх нийтээрээ  
хөдөлмөр эрхлэх  
бодлого

### Рээн-Мейеднерийн загвар

Шведийн эдийн засгийн бодлого Рээн-Мейеднерийн загвар дээр суурилдаг. Уг загварыг үйлдвэрчний эвлэлийн эдийн засагчид болох Геста Рээн, Рудолф Мейеднер нарын нэрээр нэрлэсэн юм. Эдгээр хоёр эдийн засагч 1951 онд хөдөлмөр эрхлэхийг хүссэн хүн бүрийг ажлын байртай байлгах “эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлоготой” хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг ханшийн уналтыг гааруулахгүйгээр хэрэгжүүлэх нийт эдийн засгийн загварыг боловсруулсан юм.

Үндсэн санаа нь: Дэлхийн эдийн засгийн тааламжтай өсөлт эсхүл үндэсний эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд хөдөлмөр эрхлэхийг хүссэн хүн бүрийг ажлын байраар хангах зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Бусад тохиолдолд нийт эдийн засгийн эрэлтийг байнга өндөр байлгах боломжгүй юм гэж үзэж байлаа. Эдийн засгийн салбаруудын өсөлтийн хурдац харилцан адилгүй тул нийт эдийн засгийн эрэлт удаан хугацааны туршид өндөр байх нөхцөлд асар хурдан хугацааны дотор ажиллах хүчний хомсдолтой секторуудыг бий болгоно. Тэгсэн хэдий ч өсөлт өндөр хэвээр байх тул ажиллах хүчний хомсдолтой салбарууд бусад салбарын ажиллагсдыг урвуулан авах хэрэгтэй болно. Бүх нийтээрээ ажлын байртай байх нөхцөлд зөвхөн илүү цалин амалснаар бусад салбарын ажиллагсдыг урвуулан авах боломжтой учраас өндөр цалин амласан секторуудын бүтээгдэхүүний үнэ өсөх үр дагаварт хүргэнэ. Худалдан авах чадварын тэнцвэрт байдлыг хангахын тулд бусад салбаруудыг дагаад цалингаа нэмэгдүүлэхээс өөр аргагүй байдалд хүрч эцэстээ нийт эдийн засгийн хөгжилд ханшийн уналтыг бий болгоно.

Эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого: Шведийн ажилчны үйлдвэрчний эвлэл дайны дараах үеэс “Эв санааны нэгдлийн зарчим дээр тулгуурласан цалингийн бодлого”-ыг хэрэгжүүлж ирсэн нь давхар хүндрэл учруулж байгаа юм. Уг бодлого хоёр үндсэн зорилготой. Нэг талаас “Ижил ажилд ижил цалин олгох” шаардлагыг хэрэгжүүлэх, ингэхдээ хөдөлмөрийн дундаж бүтээмж өсөхийн хэрээр нийт цалинг нэмэгдүүлдэг. Нөгөө талаас төрөл бүрийн хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн цалингийн зөрүүг ерөнхийд

нь бууруулах зорилготой. Дор нь байрлах түвшингүүдээс төвлөрсөн цалингийн хэлэлцээрүүд давуу эрхтэй байх нөхцөлд эдгээр зорилтууд биелэгдэнэ.

Энэхүү “эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого”-ын үр дүнг ханшийн уналтаар тавиад туучихгүй байхын тулд Рээн-Мейеднерийн загварт төсвийн илүүдлээр нийт эдийн засгийн эрэлтийг өндөр түвшинд барьж байх төсвийн санхүүгийн маш хатуу бодлогыг баримтлахыг зөвлөдөг.

Эдийн засгийн бодлогын дээрх хөтөлбөр нь бүтээмж багатай компаниудыг давхар хамгаалалтанд авахыг шаарддаг: Нэг талдаа бүтээмж багатай компаниудын өртөг ба үнийн бүтэц муу байдаг учраас эрэлт нь төдийлөн сайнгүй тул борлуултын бэрхшээлтэй учирдаг. Нөгөө талдаа “эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого” нь бүх салбар, бүх компаниудаас хөдөлмөрийн бүтээмжийн дундаж хөгжилтэй уялдуулан цалин нэмэгдүүлэх шаардлага тавьдаг тул тэртэй тэргүй асуудалтай байдаг өртөг ба өрсөлдөөний байдлыг хурцатгаж байдаг.

Гэтэл нөгөө талд өндөр бүтээмжтэй компаниудад давхар таатай нөхцөлийг бүрдүүлдэг: Нэг талдаа өндөр бүтээмжтэй компаниудын бүтээгдэхүүний өртөг бага, өртөг нь бага учраас үнийн тааламжтай нөхцөлтэй байдаг тул тэдний бүтээгдэхүүн эрэлт өндөртэй байдаг. Нөгөө талдаа дундаж бүтээмжид чиглэгдсэн тарифын хэлэлцээрийг явуулахдаа өндөр бүтээмжтэй үйлдвэрлэлийн хувиарлалтын орон зайг зориудаар чөлөөтэй орхидог. Ингэснээр эдгээр компаниуд өндөр бүтээмжийн ажлын байруудыг шинээр бий болгох хөрөнгөө босгох боломжтой болдог.

Төсвийн санхүүгийн хязгаарлалттай бодлого ба “эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого” хоёрыг хослуулах бодлогын хохирогсод нь бүтээмж муутай компаниуд, эдгээр компаниудад ажиллаж буй ажилтнууд байдаг. Харин энэ бодлогоос үүдэлтэй ажилгүйдлийг олон нийтийн асуудал бус харин олон нийтийн дасан зохицох үүрэг гэж ойлгодог. Үүний дараах он жилүүдэд байнга хөгжиж, боловсорч байдаг “шилэгдмэл хөдөлмөрийн зах зээл” бий болсон байна. Олон талтай, өргөн хүрээтэй сургалтын арга хэмжээнүүд, нэг газраас нөгөө газарт шилжих тохиолдолд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг арга хэмжээнүүдийн үрээр ажилгүй болсон хүмүүс, анх удаа болон тодорхой хугацаанд тасалдсаны дараа дахин ажил

*Рээн-Мейеднерийн загварын эерэг болон сөрөг талууд*

*Бүтээмж багатай компаниудад дарамт болдог.*

*Харин хөдөлмөрийн бүтээмж сайтай компаниудад тааламжтай нөхцөлийг бүрдүүлдэг.*

*Ажилгүйдлийг олон нийтийн дасан зохицох үүрэг гэж ойлгодог.*

хайж байгаа хүмүүс илүү өндөр бүтээмжийн ажлын байранд ажилд орохоор, өөрөөр хэлбэл илүү өндөр цалин авах боломжтой ажилд орохын тулд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдахыг хичээх болсон байна.

*Шведийн загварыг  
өндөрөөр үнэлдэг.*

Рээн-Мейеднерийн загварын төсвийн санхүүгийн хязгаарлалттай бодлого, "Эв санааны нэгдлийн зарчим дээр суурилсан цалингийн бодлого", "Шилэгдмэл хөдөлмөрийн зах зээл" -ийн бодлого нь шведийн зах зээлийг байнга шинэчлэгдэж бүтцийн өөрчлөлтөнд дасан зохицож байх чиглэлд хөгжихийг шаардаж байна. Уг загвар 1960-аад оноос хойш их бага хэмжээгээр шведийн эдийн засгийн бодлогын залуур болсоор ирсэн. Бүхэлд нь авч үзвэл шведийн эдийн засгийн загвар нь "Хөтөлбөрийн хувьд хаалттай, бодлогын хувьд өндөр хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн" загвар юм. "Судалгаанд хамрагдсан бусад орнуудтай харьцуулахад хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь асар өндөр бөгөөд түүнд ойртож очсон нэг ч орон байхгүй байна." (Шарф 1987 он 119) гэдгийг Фритц У. Шарф 1987 онд Герман, Их Британи, Австри, Шведийн социалдемократ эдийн засгийн бодлогыг харьцуулан судлах явцдаа тогтоосон байна. Түүний дээрх үнэлгээ өнөөдөр ч хүчин төгөлдөр хэвээрээ байна. Дотоод зах зээл маш багатай, (Арван сая хүрэхгүй хүн амтай) даяаршлын олон хэлбэрийн бэрхшээлтэй тулгарч байгаа хэрнээ өрсөлдөх чадвар сайтай эдийн засгаараа дэлхийн зах зээл дээр байр сууриа хадгалж чадсан төдийгүй шинэ таваар болон сүүлийн үед үйлчилгээний солилцоог улам бүр эрчимжүүлж ахиц олж байна. Сүүлийн үед ДНБ-нийхээ тал хувийг экспортонд гаргаж байна.

### **Санхүүжилтийн систем ба өмчлөгсдийн бүтэц**

Шведийн компаниудын санхүүжилт олон төрлийн элементүүдээс бүрддэг. Санхүүжилт нь эхний ээлжинд харилцагч банкууд дээр суурилдаг. Санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр нь хувьцааны зах зээл юм. Шведийн бусад орнуудад байхгүй нэг онцлог бол шведийн компаниуд нь харилцан бие биенийхээ хувьцааг эзэмшдих харилцаа элбэг тохиолддог. Шведийн компаниудын санхүүжилтийн нэг онцлог бол алсыг харсан хөрөнгө оруулалт элбэг байдаг. Шведийн санхүүжилтийн систем нь удаан хугацааны туршид германы "райны капитализм" гэж нэрлэгдэж байсан загварын санхүүжилтийн системтэй төсөөтэй.

### **Боловсролын систем**

Дэлхийн эдийн засгийн даяаршлын эрин үед өрсөлдөх чадвар

*Хөрөнгийн зах зээлээс  
хараат бус*

*Боловсролын гацаанд  
орохоос сэргийлдэг.*

өндөртэй эдийн засагтай байхад хамгийн хэрэгтэй “Түүхий эд” бол боловсрол юм байна гэдгийг шведүүд бүр эртнээс олж мэдсэн байна. Шведэд мэргэжлийн боловсролыг гимназийн дээд шатанд олгодог. Бараг бүх сурагчид мэргэжлийн сургалтанд сайн дураараа хамрагддаг. Дээд боловсрол олгох сургалтын зэрэгцээ нарийн мэргэжил олгох 14 үндэсний хөтөлбөртэй.

Шведийн боловсролын бодлогын үндсэн зарчим нь боловсролыг гацаанд орохоос аль болохоор сэргийлэх явдал байсаар ирсэн, байх ч болно. Иймээс нарийн мэргэжил олгох сургалтуудыг ерөнхий эрдмийн сургалтуудаар баяжуулснаар хүссэн дээд сургуульдаа сурах эрх авах боломжийг бүрдүүлдэг. 2006 оны байдлаар дээрх хэлбэрийн сургалтанд хамрагдаж дээд сургуульд суралцах эрхээ авсан сурагчид нийт дээд сургуульд элсэгчдийн 94.6%-тай тэнцэж байлаа.

Өөр нэг онцлог бол ажилтнууддаа мэргэжлээрээ ажиллаж байх хугацаандаа дахин дахин суралцах олон талт боломжийг бүрдүүлж өгдөг. Үүний цаад шалтгаан бол нэгэнт бий болсон ажлын байрыг хамгаалах нь шведийн эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилт юм. Тийм ч учраас олон улсын тавцан дээрх өрсөлдөөнд илүү амжилт олж буй өндөр бүтээмжтэй, өрсөлдөх чадвар өндөртэй ажлын байруудыг эзлэхийн тул хүмүүсийг аль болохоор чадавхижуулахын төлөө байдаг. Үүний тулд нийт хүн амдаа, ерөнхий болон нарийн мэргэжлийн сургалтын арга хэлбэрүүдийг хослуулсан сургалтыг санал болгодог.

### **Хөдөлмөрийн харилцаа**

Социалдемократ улс төрчдийг тийм ч амархан засгийн газрын албан тушаалуудаас зайлуулчихгүй нь нэгэнт ойлгомжтой болсон тул ажил олгогчид үйлдвэрчний эвлэлийнхнийг 1938 оны Saltjobbaden-үндсэн хэлэлцээрийн дагуу тэнцүү эрхт хэлэлцээрийн түнш гэж хүлээн зөвшөөрөх болсон юм.

Уг хэлэлцээрийн дагуу төрийг хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтаас аль болох хол байлгах ёстой. Хэлэлцээрийн уг заалт батлагдсанаас хойш 30 гаруй жилд саад тотгоргүй хэрэгжиж байсан юм. Хөдөлмөрийн зах зээл дээр элдэв зөрчилдөөнгүй, цалингийн хөгжлийг тарифын нэгдсэн гэрээгээр удирдаж байлаа. Хөдөлмөрийн зах зээлийн харилцааг зохицуулах хууль гэж бараг байсангүй.

Энэхүү найрсаг хамтын ажиллагааны үе дууссаны дараагаар 1970-

*Үйлдвэрчний  
эвлэлийнхэн ба ажил  
олгогчид тэгш эрхт  
түншүүд мөн.*

аад оны эхээс 1998 оныг хүртэл зөрчилтэй үе эхэлсэн юм. Цалингийн нэгдсэн хэлэлцээрийн систем алхам алхмаар задарсаар байлаа. Нэн ялангуяа Европын холбоонд элссэнтэй холбогдуулан тогтвортой байдлыг хангах шаардлагатай тулгарсан тарифын хэлэлцээрт оролцогч түншүүд тарифын хэлэлцээрийн үндэслэлийг шинэчлэх ёстой гэдэг бодолтой болсон байна. Социалдемократ засгийн газрын санаачилгаар 1998 онд аж үйлдвэрийн үйлдвэрчний эвлэлийнхэн, ажил олгогчдын хооронд аж үйлдвэрийн тарифын гэрээ гэж нэрлэгддэг гэрээг байгуулсан юм.

Аж үйлдвэрийн тарифын гэрээ дараах үндэслэлүүд дээр суурилдаг: Нэгдүгээрт гэрээгүй болон зөрчил ихтэй үеийг аль болох богино байлгах зорилгоор зохицуулалтын механизмтай болох оролдлогыг хийсэн. Энэ шалтгааны улмаас хуучин гэрээг дуусахаас өмнө шинэ гэрээг байгуулах хэлэлцээрийг эхэлдэг байх ёстой. Хоёрдугаарт олон нийтийн захиалгаар, намчирхдаггүй маргаан таслагчид "европын нэгдсэн нормчлолд ойртсон гэрээ"-г байгуулахад нөлөөлөх үүрэгтэй оролцдог. Эцэст нь буюу гуравдугаарт экспортод чиглэсэн өрсөлдөгч секторуудын цалинг удирдах /бусад салбарын цалинг дагуулах/ үүргийг дахин сэргээх хэрэгтэй гэж үзсэн. Аж үйлдвэрийн тарифын гэрээний чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг хожим нь төрийн албаны секторт нэвтрүүлсэн юм.

Шведийн үйлдвэрчний эвлэл нийгэмдээ хүчирхэг байр суурийг эзэлдэг. Нийт хөдөлмөр эрхлэгсдийн 70 гаруй хувь нь үйлдвэрчний гишүүн. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог мөн үйлдвэрчний эвлэлээр дамжуулан хангадаг учраас үйлдвэрчний эвлэлийг улам хүчирхэг болгодог. Үйлдвэрчний эвлэл болон компанийн ажилтнуудын зөвлөл нь салангид байдаг германы загвар шведэд танил бус.

Германд компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог компанийн түвшинд хангах тухай хууль байдаг бол шведэд хуулийн бус хүрээнд хангагддаг. Шведэд үйлдвэрчний эвлэлийнхний хэлэлцээрт орох эрхүүдээр дамжуулан компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах замыг сонгосон байдаг. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах хүрээнд зөрчил үүссэн тохиолдолд тарифын хэлэлцээр дуусгавар болоогүй буюу хэрэгжилтийн шатандаа байх үед ч ажил хаялт хийх эрх нь нээлттэй байдаг зохицуулалтыг хийж өгсөн.

## Компаниуд хоорондын харилцаа

Шведэд зөвхөн үйлдвэрчний эвлэл төдийгүй ажил олгогчдын зохион байгуулалтын зэрэг өндөр байдаг. Хэлэлцээрт оролцогч талууд ийнхүү хоёулаа хүчирхэг байх нь ажил олгогч ба үйлдвэрчний хоорондын тохиролцоонууд амжилттай хэрэгжих нэгэн чухал нөхцөлийг бүрдүүлдэг. Шведийн бас нэгэн онцлог бол компаниуд хоорондын хөрөнгийн оролцоон дээр суурилсан холбоос хүчтэй байдаг. Зах зээлийн харилцааны зэрэгцээгээр эцэстээ олон талт мэдээллийн сүлжээ нь өөрийн хөрөнгийг бусад компаниудад оруулах, мөн компаниудын хамтын ажиллагааны хүрээнд шинэ технологи нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

## Дүгнэлт

Энэ сурах бичгийн хүрээнд судалгаанд хамрагдсан орнуудын дунд Швед улс зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн идеал хэлбэрт хамгийн ихээр ойртож байгаа юм. Шведийн эдийн засгийн онцлог бол ажил олгогчид болон ажилтнууд тарифын хэлэлцээрийн зохион байгуулалтанд идэвхтэй хамтран ажилладаг, хөдөлмөрийн зах зээлийн хоёр тал олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг болох мэргэжлийн боловсрол олгох сургалтын салбарт нягт хамтран ажилладаг, компаниудын санхүүжилт харилцагч банкуудаар дамжин хийгддэг, харилцан бие биенийхээ хувьцааг эзэмшдэг, компаниудын мэдээллийн сүлжээ өөрийн хөрөнгийг бусад компаниудад оруулах нөхцөлд нээлттэй байдаг, дээрх мэдээллийн сүлжээг шинэ технологи нэвтрүүлэх, компаниуд хоорондын хамтын ажиллагааг бий болгоход мөн ашигладагт оршино.

Швед улс нь зохицуулалттай эдийн засгийн системийг нийтийн сайн сайхны төлөөх төр, эдийн засгийн өндөр өсөлт, хангалуун амьдралын шударга хувиарлалт, ажилгүйдлийн доогуур түвшинтэй хослуулж чадсаныг онцлон тэмдэглүүштэй. Ингэснээр Швед нь АНУ, Их Британи, Герман, Япон улстай харьцуулахад нийгмийн ардчиллын шаардлагуудыг хэрэгжүүлэхэд хамгийн дөхөмтэй орон юм.

*Зохицуулалттай зах  
зээлийн идеал  
хэлбэрт ойр.*

## Швед

|                                                                                |               |                                                                                                                                                                                                                                                                                      |
|--------------------------------------------------------------------------------|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нэг хүнд ногдох ДНБ 2008 оны байдлаар                                          | 30.100 Евро   | Нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын стандартаар илэрхийлсэн үзүүлэлт. Үг үзүүлэлт Европын Холбооны (ЕХ)-ны гишүүн 27 орны дунджаар нэг еврогийн худалдан авах чадварыг илэрхийлдэг. (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                         |
| Эдийн засгийн дундаж өсөлт 1990-2007 оны байдлаар                              | 2.3%          | Нэг хүнд ногдох эдийн засгийн жилийн дундаж өсөлт, үнэ тогтвортой байхад (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2009 он , 195-р хуудас)                                                                                                                                                  |
| Төрийн өр (Төсвийн алдагдал) 2008 оны байдлаар                                 | 38%           | Төрийн өрийг ДНБ-нд эзлэх хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Холбооны сангийн яамны 2009 оны 12-р сарын мэдээ, 99-р хуудас )                                                                                                                                                   |
| Бүтээмжийн тэнцэтгэл 2008 оны байдлаар                                         | 7.8%          | Таваарын нийт экспорт ба импортын зөрүүг ДНБ-ний хувиар илэрхийлсэн үзүүлэлт (Эх сурвалж: Олон улсын валютын сан, 2009 оны 10-р сарын дэлхийн эдийн засгийн мэдээ 187-р хуудас)                                                                                                      |
| Хөдөлмөр эрхлэлтийн квот 2008 оны байдлаар                                     | 74.3% (71.8%) | 15-64 насны хөдөлмөрийн насны бүх иргэдийн тоог (эмэгтэйчүүдийг оролцуулан) нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт (Олон улсын стандарт) (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                             |
| Ажилгүйдлийн квот 2008 оны байдлаар                                            | 6.2%          | Хөдөлмөрийн насны хүн амын дотор ажилгүйдлийн эзэлж буй хувь хэмжээ (Олон улсын стандарт) (Эх сурвалж: ЕХ-ны статистик)                                                                                                                                                              |
| GINI-коэффициентээр илэрхийлэгдэх орлогын тэгш бус байдал                      | 25.0%         | Орлогын тэгш бус байдлыг илэрхийлэх үзүүлэлт 100%-тэгш бүс байдлын дээд хязгаар (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009 он, 195-р хуудас)                                                                                                                                            |
| Эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээд олж буй орлогын тэгш бус байдал | 67%           | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлээд олж буй орлогыг эрэгтэйчүүдийнхэд харьцуулсан харьцаа (Эх сурвалж: Хүний хөгжлийн индекс 2009, 186-р хуудас)                                                                                                                                         |
| Ядуурлын индекс                                                                | 6.0%          | Ядуурлын индекс нь хүн амын дундаж наслалт, бичиг үсэгт тайлагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж зэрэг олон хүчин зүйлсээс бүрддэг. 0-ядуурлын доод түвшин, 100- ядуурлын дээд түвшин (Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэл 2009, 180-р хуудас) |
| Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулалтын зэрэг                                 | 70.8%         | Хөдөлмөр эрхлэгсдийн дунд үйлдвэрчний зохион байгуулалтанд орсон үйлдвэрчний гишүүдийн эзлэх хувь (Эх сурвалж: Ж.Биссер, Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын тайлан)                                                                                       |



## 7. ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙ БОДЛОГО: ПРАКТИК ЖИШЭЭНҮҮД

Нийгмийн сэтгэл зүйч Курт Левин “Сайн онол шиг практикт хэрэглэхэд хялбар зүйл үгүй.” гэдэг үгийг хэлсэн юм. Өмнөх бүлгүүдэд үзсэн эдийн засаг ба нийгмийн ардчиллын онолын асуудлуудын практик ач холбогдлыг тодруулахын тулд энэ бүлэгт тэдгээрийг практикт хэрэглэж буй жишээнүүдийг дурьдлаа.

Энэхүү төгсгөлийн бүлэгт онол практикийн холбоог бодлогын зөрүүтэй талбаруудаас практик жишээн дээр тайлбарласан байгаа. Эдгээр жишээнүүд намуудын эдийн засгийн бодлогын төслүүдэд нийгмийн ардчиллын үнэт зүйлсийн хувьд хэрхэн тусгалаа олж байгаа болон тэдгээр нь эдийн засгийн бодлогын зарчмууд дээр хэрхэн суурилж байгааг харуулах болно.

Нийгмийн ардчиллын үзэл баримтлалд хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь бодлогын үндсэн салбар, олон салбарт хэрэгжүүлж буй бодлогуудын хөндлөн огтлолцлын цэг учраас энэхүү цуврал бичгүүдийн бүх дэвтэрт тайлбар хийгдсэн тул хөдөлмөрийн зах зээлийн бодлогын тухай тусгай дэвтэр байхгүй болно. “Эдийн засаг ба нийгмийн ардчилал” хэмээх энэхүү дэвтэрт хөдөлмөрийн зах зээлийн бодлого онцгой чухал байр эзлэх нь ойлгомжтой. Зохиогч “сайн хөдөлмөр”, ба “цалингийн доод хэмжээ” гэдэг хоёр практик жишээн дээр хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг тайлбарлахыг оролдсон.

Бидний сурах бичгийн цуврал нь олон зохиогчид өөрсдийнхөө өнцгөөс харж бичсэн бүлгүүдээс бүрдэж байгаа юм. Эдгээр жишээнүүд нь нөхцөл байдал, нийгмийн харилцаанууд байнга өөрчлөгдөж байгаа энэ цаг үед хөдөлшгүй эцсийн хариулт болж чадахгүй нь ойлгомжтой юм. Харин шинэ санаа сэдэл өгөх, эргэцүүлэн бодоход дэмжлэг өгөх зорилготой жишээг орууллаа.

Энэхүү бүлэгт дараах практик жишээнүүдийг танилцуулах болно:

- ~ Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого, техник, технологийн шинэчлэлд тулгуурласан өөрчлөлт, өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг тэргүүлэх зах зээлийг төрийн туслалцаатайгаар хэрхэн бий болгох бэ?
- ~ Улсын төсвийн талаар: Ямар тохироо бүрдсэн нөхцөлд хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд улсын төсвийн зээл авах нь ашигтай бэ?
- ~ Хувьчлалын талаар: Хувьчлал ямар давуу талуудыг авчрах бэ? Хувьчлалыг бодлогоор хэрхэн зохион байгуулах бэ? Ямар нөхцөлд хувьчлалаас татгалзах нь зүйтэй бэ?
- ~ Сайн хөдөлмөр ба компанийн шийдвэр гаргалтанд ажилтнуудын оролцоог хангах талаар: Эдгээр хоёр салбар нь хоорондоо нягт холбоотой, нийгмийн ардчиллын үндсэн зорилт мөн.
- ~ Цалингийн доод хэмжээний талаар: Жендерийн тэгш байдлыг хангах шаардлагуудыг биелүүлэх, хөлс багатай, хүнд нөхцөлтэй хөдөлмөрийн харилцааг бууруулахын тулд цалингийн доод хэмжээг тогтоодог.

## 7.1. Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого

Тогтвортой ирээдүйд чиглэсэн  
өсөлтийн бодлого<sup>9</sup>

Петер Франц, Флориан Майер, Стефан Тидов

21-р зууны эдийн засгийн хөдөлгөгч хүч нь экологи мөн. Эрчим хүч ба түүхий эдийн эрэлт өнгөрсөн жилүүдэд тогтмол өссөөр ирсэн бөгөөд цаашид ч өссөөр л байх болно. Ирэх дөчин жилд өдгөө дэлхий дээр амьдарч буй зургаан тэрбум хүмүүсийн тоо есөн тэрбум орчим болон нэмэгдэх болно. Аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад амьдарч буй хүмүүсийн тоо дөрвөн тэрбумд хүрч даруй гурав дахин нэмэгдэх болно. Ингэснээр аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэгдэж буй хэрэглээний бүтээгдэхүүний эрэлт ч эрс нэмэгдэх болно. Багцаалж буйгаар бол зөвхөн Бразили, Орос, Энэтхэг, Хятадын худалдан авах чадвар сайтай, өндөр хэрэглээтэй дундаж давхаргын иргэдийн тоо ойрын гурван жилд хоёр дахин нэмэгдэнэ. Харин манай гариг ертөнцийн түүхий эд, барилга барих, тариалан эрхлэх талбайн хэмжээ хязгаарлагдмал нөөцтэй. Агаар болон ус нь үнэт нөөц мөн. Эрчим хүч нэгэн адил барагдашгүй шавхагдашгүй нөөц биш тэр дундаа уламжлалт эрчим хүчний үүсгүүрүүд. Гэтэл бид өдгөө уламжлалт эрчим хүчний үүсгүүрээс гарган авч буй эрчим хүчээр хэрэглээний дийлэнх хувийг хангаж байна.

<sup>9</sup> Экологи ба эдийн засгийн нягт уялдааны талаархи бусад мэдээллийг Холбооны байгаль орчны яам ба Холбооны байгаль орчны газрын хамтарсан эмхэтгэлд 2009 онд анх удаа нийтэлсэн. Үг мэдээллийг [www.umweltwirtschaftsbericht.de](http://www.umweltwirtschaftsbericht.de)-аас авна уу.

**Товчхон:** Эдийн засгийн болон экологийн сорилтууд хоорондоо улам бүр ойртсоор, холбоотой болсоор байна. Байгаль орчин ба эдийн засгийг хооронд нь сөргөлдүүлэн тавьдаг цаг үе улиран одож зөвхөн нийт эдийн засгийн өнцгөөс харахад бус компанийн эдийн засгийн өнцгөөс харахад экологид тавигдаж буй шаардлагууд эдийн засагт улам илүү тулгамдаж байна. Дэлхийн банкны тэргүүлэх улс ардын аж ахуйч асан ноён Николас Штерн хазааргүй хүлэг мэт довтлон ирж буй цаг уурын эрчимтэй өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээнүүдийн зардал даяаршлын нийт бүтээгдэхүүний 20 орчим хувьтай тэнцэх болно гэдэг таамаглалыг дэвшүүлсэн байна.

Эдийн засаг ба экологийн харьцаан дахь энэхүү өөрчлөлт нь бодлогод шууд нөлөөлдөг. Арай хэтрүүлэгтэй хэлбэл: Байгаль хамгаалах бодлого нь эдийн засгийн бодлого болон хувирч байна. Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогын стратеги нь энэхүү хөгжлийн шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд эрчим хүч ба нөөцийн асуудал нь үндэсний болон даяаршлын түвшинд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хамгийн чухал түлхүүр асуудал болжээ гэдэг дүгнэлтэнд хүрсэн байна.

➤ Тогтвортой өсөлтийн бодлого нь техник, технологийн шинэчлэл дээр тулгуурласан эдийн засгийн шинэчлэл, өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн зорилт болж байна.

Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого нь тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд байгаль орчин ба эдийн засгийн шинэчлэлийн стратегийг байгаль орчин, эдийн засгаар дагнасан стратегитай холбон хэрэгжүүлж байна. Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого нь бидний амьдарч буй эрин үеийн сорилтуудад үзэл суртлын хариулт өгөхгүй, харин прагматик, дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн замыг зааж өгөх болно.

Үндсэндээ бол дараах хоёр асуудал байгаа юм: Эхнийх нь бид тогтвортой байдлыг хангахын тулд эдийн засгаа өөрчлөх хэрэгтэй. Энэ нь үйлдвэрлэлийн бүтцийн асуудал буюу эрчим хүч, нөөцийн үр ашигтай хэрэглээний асуудал юм. Уг зорилтод хүрэхийн тулд эрчим хүчнийхээ хэрэглээг үр ашигтай болгоод зогсохгүй нөхөн сэргээгдэх түүхий эдийн хэрэглээнд шилжих ёстой. Өдгөө бид шатах материалыг газрын тосноос биш биомассаас гарган авч чаддаг болсон. Тэр ч байтугай хуванцар, орчин үеийн бусад материалуудыг гарган авч байна. Мөн эрчим хүчний бодлогын хувьд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр нар, салхи, ус, дэлхийн гүний дулаан, биомассыг илүү өргөн

хүрээтэйгээр хэрэглэх, тэдгээрийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй байна. Одоо, ирээдүйд энэ бодлогод өөр хувилбар байхгүй. Хязгаарлагдмал түүхий эдийн нөөцөөр өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангахтай холбоотой тулгамдаад байгаа бүтцийн хүндрэлээс гарах, өсөлт ба нөөцийн хэрэглээний хамаарлыг таслахын тулд үүнээс өөр зам хүн төрөлхтөнд байхгүй. Гэхдээ байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогоор зөвхөн эдийн засгийн дээрх өөрчлөлтийг хийгээд зогсохгүй, хоёрдугаарт уг өөрчлөлттэй холбогдон гарч ирэх боломжуудыг эдийн засагт үр ашигтайгаар ашиглахыг хүсч байна. Дэлхийн өнцөг булан бүрт эрчим хүч улам бүр үнэтэй болж, түүхий эдийн нөөц улам бүр хомсдож байгаа өнөө үед ногоон технологид өргөн боломж нээгдэж эдгээр нь зүй ёсоор ирээдүйн тэргүүлэгч зах зээл болох юм. Өндөр үр ашигтай, байгаль орчинд ээлтэй технологи тэргүүлэгч технологи болж байна.

Компаниудын зөвлөхүүдийн үзэж байгаагаар байгаль орчны технологийн зах зээл нь өнөөгийн байдлаар дэлхийн зах зээл дээр аль хэдийн 1.000 тэрбум Евротой тэнцэх хэмжээний эзлэхүүнийг эзэлж байна. 2020 он гэхэд урьдчилан таамаглаж буйгаар 2.000 тэрбум ба түүнээс давах тул хоёр дахин ба түүнээс ч илүүтэйгээр нэмэгдэх төлөв харагдаж байгаа аж. Герман улс байгаль орчинд ээлтэй таваарын үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлж мөн технологийн бусад олон салбарт дэлхийн зах зээлд анхдагч болж байна. Энэ нь герман улс ирээдүйд ногоон зах зээлээс ашиг олох гарааны сайн нөхцөлөө бүрдүүлж чадсан гэсэн үг юм. Үүний тулд технологийн салбарт тэргүүлэх байр сууриа алдахгүй байх хэрэгтэй. Бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн процесст өндөр шаардлага тавьдаг байгаль орчны хатуу бодлого явуулсны үр дүнд шинэчлэлийн зүтгэх хүч болох эдгээр боломжууд гарч ирдэг гэдгийг бидний туршлага харуулж байна.

Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд дээрх хоёр салбарыг хооронд нь өнөөгийнхөөс илүү нягт холбохыг шаардаж байна. Үүний тулд төрийн зүгээс шаардлага өндөртэй, заавал биелүүлэх зорилтуудыг тодорхойлж, зөв ерөнхий нөхцөлүүдийг тогтоож өгөх ёстой. Төр пионер нь байж шаардлагатай нөхцөлд зам заагч болж чадсан улс орон урагшлан хөгжих болно. Зах зээл улам бүр өөрчлөгдөж буй бодит байдалд хариу үйлдэл үзүүлсээр байгаа боловч дэндүү удаан байна. Өнөөг хүртэл зах зээл нь тулгарч буй сорилтууд, тэдгээртэй хамт гарч ирж буй боломжуудын алийг нь

ч урьдчилан харж чадаагүй. Бид цаг уурын өөрчлөлтийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг ухаалгаар тусган авч чадах юм бол уг өөрчлөлтийн хурдацыг сааруулах ажлын тулгын чулууг хожимдолгүй тавихад цөөн жилийн хугацаа л үлдээд байна. Бодлогын ерөнхий зарчмын асуудлаархи үр дүнгүй мэтгэлцээнд дэмий урсгах цаг бүр ч бага үлдээд байна. Байгаль орчин ба эдийн засгийн шинэчлэлийн салбарт зах зээл ба төрийн урагшгүй бодлогыг ухаалгаар холбож бодлогын олон төрлийн хэрэгслүүд ба санаануудаас прагматик холимог (микс) гарган авах шаардлагатай байна. Үүний тулд төр нь эдийн засгийн шинэчлэлтийг хурдасгаж, байгаль орчинд ээлтэй технологүүд хэрэглээнд орж нийгэм, эдийн засгийн эрчим хүч түүнчлэн нөөцөд ариг гамтай хэрэглээнд түлхэц өгөх, өсөлт ба хөдөлмөр эрхлэлтийг нэгэн зэрэг дэмжих нөхцөлийг хангах тохироо бүрдэхүйц бодлогын болон эдийн засгийн хэрэгслүүдийг хослуулах ёстой.

➤ **Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогын зарчмууд**

Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд олон төрлийн зорилтуудыг хооронд нь холбож өгөх хэрэгтэй болдог.

**1. Нийлүүлэлт болон эрэлтийн хэрэгслүүдийг чадварлагаар хослуулах хэрэгтэй.** Нийлүүлэлт эсхүл эрэлтийг дэмжих бодлогуудыг ихэвчлэн хооронд нь сөргөлдүүлэн эвлэршгүй эсрэг тэсрэг зүйл мэтээр тайлбарладаг. Гэтэл техник, технологийн дэвшилд суурилсан эдийн засгийн шинэчлэлийн судалгаа нь нийлүүлэлтийг дэмжсэн ерөнхий нөхцөлүүдийг эрэлтийг идэвхжүүлэх бодлоготой хооронд нь уялдуулж чадсан үед л шинэ технологийг нэвтрүүлэх, мөн зах зээл дээр гаргах хамгийн тохиромжтой нөхцлийг бүрдүүлдэгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн нийлүүлэлт ба эрэлтийг нэгэн зэрэг дэмжсэн бодлого явуулж чадсан нөхцөлд л амжилтанд хүрдэг.

**2. Тооцоолох боломжтой ерөнхий нөхцөлүүд тавих нь хатуу шаардлагууд бүхий зорилтууд дэвшүүлэхтэй эн тэнцэхүйц ач холбогдолтой.**

Компаниуд ямар нөхцөлд ажиллаж байгаагаа мэддэг байх ёстой. Тийм учраас бодлого боловсруулагчдад дураараа аашлах боломж байдаггүй. Гэсэн хэдий ч компаниуд төлөвлөлтийн найдвартай байдлаа хангахын тулд өнгөрсөн үеийнхээ амжилтан дээр сандайлан амран суугаад байх эсхүл "ирээдүйн сорилт" -ыг анхаарч үзэхгүй байж болохгүй гэдэг нь ойлгомжтой. Өрсөлдөөн хэзээ ч нойрсдоггүй.

Ази тивийн эдийн засгийн үсрэнгүй өсөлт зах зээлд хүч түрэн орж ирж байгаа энэ үед өрсөлдөөн бүр ч эрчимтэй явагдаж байна. Удаан хугацааны, таамаглаж болохуйц хатуу зорилтууд нь төлөвлөлт ба эдийн засгийн хурдацтай өсөлтийн тэнцвэрийг хангах бодлогын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Үүний өөр нэг жишээ бол байнга техникийн хамгийн шинэлэг, шилдэг түвшинд байх зорилт бүхий топ-тэргүүлэгчд байх зорилт юм. Энэ зорилт нь компаниудаас чадах бүхнээ хийж, нэвтрүүлж болох бүхнийг нэвтрүүлэх, тэгэхдээ түвшингээ байнга дээшлүүлж байхыг шаарддаг.

**3. Үнэ үнэнийг хэлдэг байх ёстой. Өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд зохиомлоор бууруулж болохгүй.** Үнэ бол мөчиг тачиг байдлын заагаар огтолдог хутга бөгөөд үнийг бага байлгахын тулд байгаль орчны бодит байдал буюу нөөцийн хэрэглээг удаан хугацаагаар харгалзахгүй орхиж хэрхэвч болохгүй. Гадаад өртөгийн үнэлэмж, үүргээ гүйцэтгэх чадамжтай зах зээл нь байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлогын эргэлтийн болон тулах чухал цэг юм. "Бодит өртөг" -ийн үнэлгээ тогтоох нь урьдын нэгэн адил практик дээр хялбар бус. Жишээлбэл олон улсын өрсөлдөөний нөхцөлийг үл харгалзан үнэ тогтоох, ирээдүйд нэмэгдэх өртгийг өнөөгийн үнэнд шингээх аль аль нь амаргүй.

**4. Судалгаа нь технологит нээлттэй байхын зэрэгцээ дэвшлийг зорилттойгоор дэмжигч гэрэлт цамхаг байх ёстой.** Маргааш ямар дэвшилтэт технологи гарч ирэхийг өнөөдөр хэн ч мэдэхгүй учраас бодлого зарчмын хувьд шинэ технологит нээлттэй байх ёстой. Бүхнийг нэг газрын зурган дээр багтаах албагүй. Ийм ч учраас технологийн дэвшлийг дэмжих бодлого нь хатуу зорилтууд дээр суурилах ёстой. Харин тавьсан зорилтууддаа хүрэх технологийн шийдлийн стратегийг тодорхойлдоггүй. Нөгөө талаас зах зээл дангаараа хөгжүүлэх боломжгүй ч асуудал шийдвэрлэх өндөр чадамжтай технологийн тодорхой шугамууд байдаг. Иймээс төрийн зүгээс туршилтын пилот төслүүд, бэлэг тэмдгийн өндөр ач холбогдолтой төслүүдийг хэрэгжүүлэх замаар зах зээлийн судалгаа болон технологийн бодлогод дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

**5. Хэвтээ хавтгай дээрх зорилтууд, салбарын бодлогууд нь харилцан бие биенээ нөхдөг байх ёстой.** Нийт эдийн засгийг байгаль орчинд ээлтэй эдийн засгийн эрчимжүүлэлтийн давалгаанд татан оролцуулахад түлхэц өгөх хэлбэрээр ерөнхий нөхцөлүүдийг бодлогоор тогтоож өгөх шаардлагатай. Энэ нь зөвхөн байгаль

орчны бодлогын зохицуулалтын асуудал биш бөгөөд өрсөлдөх чадвартай, татварын тааламжтай нөхцөлтэй, эдийн засгийн бодлого төлөвлөлтийн асуудал юм. Энэ зорилтод хүрэхийн тулд үүнээс гадна бүтээмж өндөртэй, орчин үеийн байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэд бүтэц болон мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтнууд хэрэгтэй. Хэвтээ хавтгай дээрх зохицуулалт чухал үүрэгтэй. Гэхдээ бүтцийн өөрчлөлтүүдийг секторын хүрээнд буюу босоо хавтгайд хийх шаардлагатай салбарууд гарч ирсээр байх болно. Үүний тулд тэргүүлэх технологи болон аж үйлдвэрийг зорилттойгоор дэмжих хэрэгтэй. Үүнд нягт холбоотой, эрх мэдэл бүхий зах зээлийн бүтцийг эвдэх амаргүй, технологийн үсрэнгүй хөгжлийг дан ганц ерөнхий нөхцөлүүдээр дамжуулан удирдах боломжгүй, олон улсын өрсөлдөөнд урт хугацааны стратегийн сонирхол төдийлөн нөлөөлдөггүй зэрэг шалтгаан байна. Нөөцийг ариг гамтай хэрэглэх зорилтын хүрээнд аж үйлдвэржсэн нийгмийг өөрчлөн байгуулахын тулд технологийн дэвшлийг нэвтрүүлэгч компанийн эзэдтэй байх нь хангалтгүй тул пионер болохыг эрмэлзэгч төрийн дэмжлэг хэрэгтэй. Өөрчлөн байгуулалтыг хийхийн тулд сайн хөдөлмөр хийдэг, чадварлаг ажилтнууд, эрэлтээрээ дамжуулан шинэчлэлийн эрч хүчийг “дороос нь” дэмжиж өгдөг идэвхтэй хэрэглэгчид хэрэгтэй. Эцэст нь хэлэхэд хувьсан өөрчлөгдөж буй эх дэлхийнхээ өмнө тулгараад байгаа сорилтуудыг даван туулах, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх замаар замнахын тулд бүх актёрууд хүчээ нэгтгэх хэрэгтэй байна.

Улс төр ба эдийн засгийн тавцан асар их өөрчлөгдсөн байна. Ерөнхий нөхцөлүүд эдийн засаг ба байгаль орчны бодлогын уялдаа урьд өмнөхөөс илүү чухал болж байгааг харуулж байна. Герман улсын баталгаатай ирээдүйг хангахын тулд сайн боловсрол дээр суурилсан тогтвортой бүтээгдэхүүн ба үйлчилгээг үйлдвэрлэдэг байгаль орчин ба нийгэмд ээлтэй аж үйлдвэр хэрэгтэй байна. Байгаль орчинд ээлтэй аж үйлдвэрийн бодлого баталгаатай ирээдүйн тулгын чулууг тавих болно.

## 7.2. Төсвийн бодлого

Бид Германд ямар өртөй бэ?

Михаел Даудерштаedt<sup>10</sup>

Төсвийн алдагдал 1.5 тэрбум Еврод хүрээд байна. Төрийн үйлчилгээ татварын ихээхэн хэсгийг залгиж эсвэл нэмж өр тавихад хүргэж байна. Төсвийн алдагдал бидний тавьсан өрийг төлж барагдуулахаас өөр

<sup>10</sup> Энэ текстийг 2008 оны санхүүгийн хямралын үед хэвлэгдсэн “Бид Германд ямар өртөй бэ?” гэдэг нийтлэлээс авлаа.

аргагүй байдалд орох хойч үеийнхөнд дарамт учруулах бололтой. Олон түмний дунд төсвийн алдагдлыг цаашид нэмэгдэхийг зогсооход чиглэсэн олон хөтөлбөрүүд хэлэлцэгдэж байна. (Өрийн тормос гэдэг хэллэг бидний ярианд нэвтэрчээ.) Эдгээр хөтөлбөрүүдийн үндсэн санаа нь европын тогтвортой байдал ба өсөлтийн багцуудын үндсэн философитой тохирч байгаа бөгөөд удаан хугацаанд, эдийн засгийн сэргэлтийн давтамж өнгөртөл шинээр өр бараг тавихгүй байх хэрэгтэй гэсэн санаа юм. Санхүүгийн ухаалаг бодлого нь төсвийг эрүүлжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, өрийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийг идвэхжүүлэх хувилбарт саад учруулахгүй байх ёстой.

Бодлогын болон эдийн засгийн байдлын хувьд төсвийн алдагдлын хоёр өөр хүрээг хооронд нь ялгаж өгөх шаардлагатай.: Эдгээр нь эдийн засгийн байдал муудсанаас үүссэн төсвийн алдагдал ба эдийн засгийн өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд тавьсан удаан хугацааны өр. Олонхи эдийн засагчид эдгээр хоёр хүрээний дунд төсвийн алдагдлыг авч үздэг. Тэдгээрийн хамрах хүрээг өөр өөрөөр тодорхойлох зэрэг маргаантай асуудал мэдээж байдаг.

#### ➤ **Өр тавьж эдийн засгийн өсөлтөнд хүрэх нь зөв зам мөн үү?**

Эдийн засгийн бууралтын үед төсвийн орлого буурдаг бол төсвийн зарлага нэмэгддэг. Жишээлбэл: Нэн ялангуяа ажилгүйдлийн даатгал нэмэгддэг. Зарчмын хувьд орлого хомсдож зарлага нэмэгдэх үед үүссэн мөнгөний дутагдал бусад үед байнга хэлбэлзэж байдаг эрэлтийг тогтворжуулдаг. Энэхүү автомат тогтворжуулагчийг орчин үеийн төсвийг бэхжүүлэх хөтөлбөрүүдийн ихэнх нь түүний дотор Европын тогтворжуулах болон өсөлтийн багцуудад зүй зохистой гэж үздэг. Герман улс 1967 онд батлагдан гарсан тогтвортой байдал ба өсөлтийн тухай хуулинд эдийн засгийн бууралтын давтамжийн эсрэг чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлэхээр заасан ч энэ нь бодит байдал дээр (de facto) давтамжтай давхацсан бодлого болж хувирсан юм.<sup>11</sup> Эдийн засгийн бууралтын үед мөнгөний дутагдалд ордог тул сандарч мэгдэн хэмнэх оролдлого хийдэг байсан нь эдийн засгийн бууралтыг улам гүнзгийрүүлж мөн удаашруулж байлаа. Харин эдийн засгийн өсөлтийн үед төсвийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэггүй байснаас өр бүхэлдээ нэмэгдсээр байлаа.

Эдийн засгийн сэргэлтийн идэвхтэй бодлого нь төсвийн зардлыг эдийн засгийн өсөлт ба бууралтын давтамжийн эсрэг үйлчлэхээр

<sup>11</sup> Солоу Уяарлосз нар дээрх аймшигтай шийдвэрийг гаргажээ.



зохицуулдаг байх ёстой. Идеал хэлбэр нь хэдийгээр мөнгөний дутагдал ба өрийг нэмэгдүүлдэг ч гэсэн хувийн секторын сул эрэлтийг нөхөхийн тулд эдийн засгийн бууралтын үед төсвийн зардлыг нэмэгдүүлдэг байх ёстой. Үүнийг эдийн засгийг дэмжих бодлогын үүднээс авч үзэхэд төрийн хөрөнгө оруулалт уу? Хэрэглээ юу? гэдгээс үл хамааран хөрөнгө оруулалт мөн тул хөрөнгө оруулалт нэмэгдэхэд өсөлт нэмэгддэг. Хөрөнгө оруулалтын нөлөөгөөр бий болсон өсөлт илүү тогтвортой байдаг. Харин эдийн засгийн их өсөлтийн жилүүдэд хүсээгүй үр дагавар болох хэт хөөрөгдлийг гаргуулахгүй байх, улсын төсвийг бэхжүүлэхийн тулд дээрх зардлыг бууруулах хэрэгтэй.

Германы үндсэн хуульд (115-р зүйл) эдийн засгийг сэргээх бодлогын ерөнхий нөхцөлүүдийг тогтоодог. Улсын зээллэг нь зөвхөн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зориулагдах ёстой. Уг заалт нь олон жилийн дараа ашгаа өгөх төслүүдийг санхүүжүүлэх нь төсвийн нэг жилийн дотор эргэн төлөгдөх боломжгүй тул төсөвт ачаалал болно гэдэг санаанаас үүдэлтэй зохицуулалт юм. Ирээдүй хойч үеийнхэнд үр ашгаа өгөх төслүүдийг өнөө үеийнхэн бид бүгдийг нь төлж барагдуулах албагүй. Ингэснээр улсын төсөв дээр хувийн төсөв, эсхүл компанийн ирээдүйд ашиг авчирна, эсхүл ирээдүйд өртөг бууруулна гэдэг зорилгоор хөрөнгө оруулалтын зээл аван санхүүжүүлдэгтэй гэдэгтэй адилхан логикийг хэрэглэж байгаа юм. (Жишээлбэл: Ирээдүйд түрээсийн орлого авчирна, эсхүл түрээсийн зардлыг хэмнэнэ гэдэг зорилгоор байшин барих буюу худалдан авахтай адил.)

Дээрх логикийг улсын төсөв дээр хэрэглэхэд илүү өргөн хүрээтэй болдог: Ирээдүйд төсвийн орлогыг ямар эх үүсвэрээс нэмэгдүүлэх боломжтой бэ? эсхүл ямар төрлийн зардал буурах бэ? Ямар ч тохиолдолд өсөлтийг нэмэгдүүлэх бүх арга хэмжээнүүд эцэстээ орлогыг нэмэгдүүлдэг. “Бодит хөрөнгө оруулалт” гэдэг ойлголтоор илэрхийлэгдэж буйгаас илүү олон хүчин зүйл үүнд хамаардаг. Ирээдүйд гарах зардлыг гаргуулахгүй байхад чиглэсэн бүх арга хэмжээг хөрөнгө оруулалтанд хамруулна. (Урьдчилан сэргийлэх тарилга хөтөлбөр)

Ямар тохиолдолд өр зүй зохистой байх бэ? Зээл авагч эсхүл өр тавигч нь төр үү? эсхүл хувийн сектор уу? гэдгээс үл хамааран өсөлтийг дэмжих бүх хөтөлбөрүүд зээлээр эсхүл өрөөр санхүүждэг. Өсөлтгүй

буюу ердийн орлогоор ердийн үйлдвэрлэлээр үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүнийг л худалдан авах бололцоотой. Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд шаардагдаж буй нэмэлт хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зээл авах хэрэгцээ гардаг. Идеал нөхцөлд олсон ашгаараа (тухайн компаниас цалинждаг хүмүүсийн цалин, орлогыг бууруулахгүйгээр) нэмэлт бүтээгдэхүүний борлуулалтыг хэрэгжүүлдэг. Төсөвт байгууллагууд болон компаниуд эдийн засгийн бууралтаас үүдэлтэй гутранги байдлаасаа болоод ямар ч нөхцөлд өр тавихгүй гэсэн байр суурийг баримтлах нөхцөлд өсөлтийн процессыг эхлүүлэхийн тулд төр хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Эсрэгээрээ эдийн засгийн үсрэнгүй өсөлтийн үе шатанд (жишээлбэл 2007 он хүртэл АНУ-ын эдийн засаг эрчимтэй хөгжиж байсан шиг) зээллэг хэтрэхээр бодит эдийн засгийн өсөлтийн боломжоос давах нөхцөл үүсдэг.

Энэ системд мөнгөний бодлого нь зээлийг бодит хэмжээнд хязгаарлах үүрэгтэй. Өр хэт их байх нь (төр, компани, төсөвт байгууллагууд уу? гэдгээс үл хамааран) хөрөнгийн үнийн хөөрөгдөлд хүргэж эсхүл эрэлт эрс буурахад хүргэж бодит өргөн хүрээт өсөлт бус харин нийлүүлэлт зогсонги байх үед үнийн өсөлт үүсэх байдалд хүргэнэ.

## ➤ Өр хэд хүрэхэд өр хэтэрлээ гэж үзэх бэ?

Тэгэхээр хэр хэмжээнд өр тавьж болох юм бэ? Олон олон өсөлтийн үе шат, мөн бидний өнөөгийн дэлхийн эдийн засагт өсөлт өрийн хямралаар төгсдөг. Ихэнхдээ төр өрөнд ороод дуусахгүй, санхүүгийн зах зээлийн хямрал залгадаг. Төдийлөн ойлгомжтой бус нэг зүйл бол өсөлттэй нэгэн зэрэг өссөн хөрөнгийн үнэ (үл хөдлөх хөрөнгө, хувьцаа зэрэг) бодит ашгийн хүлээлт, мөнгө хүүлэх хэт зоригоос давдаг үзэгдэл юм. Эцэстээ бодит эдийн засаг нь үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт ба чөлөөт, үл эрхлэх үйлдвэрлэлийн хүчин зүйлсээрээ дамжуулан системийн үйл ажиллагааны орон зай ямар байх бэ? гэдгийг тогтоодог. Үүнд ханшийн уналт ба гадаад тэнцэтгэл чухал хүчин зүйлс юм. 1997 оны Азийн хямрал, 2000 оны дот ком-хөөс, 2008 оны намрын санхүүгийн зах зээлийн хямралын дараа бүгдээрээ ухаан сууцгаасан. Зөвхөн үнэ бага зэрэг өссөн, төлбөрийн тэнцэтгэл хасах зааснаас өөр муудсан зүйлгүй мэт харагдаж байхад ажлын байр ба орлогыг нэмэгдүүлсэн эдийн засгийн үсрэнгүй өсөлтийг хэн сааруулахыг хүсэх юм бэ? Цэвэр зээлийн тухайн үеийн хэмжээнээс үл хамааран эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор

эсхүл олон нийтийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд зээл олгогдож байсан ч хугацаа хэтэрсэн зээлийн дүнг сонссон хүн бүрийн сэтгэл тавгүйтмээр. Төр төсвийн орлогын нэлээд хувийг өр төлөхөд зарцуулдаг тул хугацаа хэтэрсэн зээл нь төрийн үйл ажиллагааны чадамжийг хязгаарладаг. Хугацаа хэтрэх тутам хүү нь нэмэгдэх нөхцөлтэй зээл улам их хүндрэл учруулдаг. Төрд мөнгөө зээлүүлсэн эздийн зээлийн орлогыг төр хараат хөдөлмөр эрхлэгсдийн төлсөн татвараас төлдөг тул төрийн өр нь хөрөнгө эзэмшигчдэд ашигтай дахин хувиарлалт юм. Эцэстээ бол төрийн өр нь бидний хүүхдүүд, ирээдүй хойч үеийнхэнд дарамт учруулна гэдэг үндэслэл нь хамгийн бодитой юм.

► **Өнөө бид баян амьдарвал бидний хойч үе ядуу амьдрах болно.**

Өр үнэхээр бидний хойч үед дарамт болох уу? Олон хүн зүгээр л нэг багцаалсан дүгнэлт, бодит байдалтай төдийлөн нийцэхгүй гэж батлахыг оролддог. Бидний дараагийн үе бидний тавьсан өр болон хөрөнгийг өвлөн авна. Төрийн өр нийт дүнгээрээ нийгмийн үеүдийн хооронд шилжихгүй нь үнэн ч гэлээ хойч үеийн хувиарлалтын системд нөлөөлөх болно. Бидний өнөө тавьсан өрийг татвар төлөх замаар буцаан төлөх хойч үеийнхэн төрд мөнгөө зээлүүлсэн гэж бодож буй тэр иргэдийн өмнө өртэй хэвээрээ л байх болно. Төр ба татвар төлөгч нийгэм удаан хугацааны туршид өрийн тодорхой түвшин хэлбэрээр үүрсээр л явах ачааны хэмжээ нь үндсэндээ зээлийн хүүгийн хувь хэмжээ, нэрлэгдэх өсөлтийн харьцаанаас хамаардаг. Эдийн засаг нь зээлийн хүүгийн хувь хэмжээнээс хурдан өссөн тохиолдолд төрийн өрийн бодит жин буурна. ( ДНБ-ний хувь хэлбэрээр) Төрийн ачаалал буурах явдал 1950-1975 оны хооронд удаан үргэлжилсэн эдийн засгийн өсөлтийн үеэс хойш ховор үзэгдэл болоод байна. Уг хамаарал зээлийн хүүг өндөр байлгах бодлого нь юуны өмнө хөрөнгө эзэмшигчдэд ашигтай гэдгийг харуулж байна. Өндөр хүү нь өрийн шаардлагын бодит үнэлэмжийг нэмэгдүүлдэг, нэмэгдүүлдэггүй юм гэхэд тогтворжуулдаг.

Өнөөгийн бидний үе хойч үеийнхний хангалуун амьдралын төлөө жаахан ч гэсэн сайн зүйл хийе гэвэл хойч үеийнхэндээ өр үлдээхгүй байх хэрэгтэй. Харин хойч үеийнхний үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Боловсрол, судалгаа, хөгжилд хийж буй хөрөнгө оруулалт үүний жишээ юм. Хэрэглээнээс татгалзах нь хэрэгтэй зүйл мөн юм бол өсөн нэмэгдэж буй нөөцийн өртөг (жишээлбэл үерээс хамгаалах) нь үйлдвэрлэлийн бүтээмжийг

бууруулдаг тул нөөцийг ариг гамтай хэрэглэх хэлбэрээр хэрэглээнээс татгалзах ёстой. Хувиарлалт тэгш бус байгаа нөхцөлд баян орнууд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийхгүйгээр төсвийн хэмнэлт хийвэл аюултай, зогсоох аргагүй хөрөнгийн үнийн хөөрөгдөл хүчээ авах болно.

Герман улс дангаараа дотоод эдийн засгийнхаа хүрээнд хангалуун амьдралын түвшингээ хөрөнгө хураах замаар хойч үедээ шилжүүлэх боломжгүй. Энэ нь өрөө төлөхгүй явсаар байгаад хойч үедээ ядуурлыг шилжүүлчихье, өөрсдөө баян амьдарчихъя гэдэгтэй адилхан бүтэхгүй. Энэ нь бид зөвхөн гадаад орнуудаас зээл авч өр тавьсан, гадаадад хөрөнгө хураасан нөхцөлд л бүтнэ. Хэрвээ бүх өрөө гадаадад тавих боломж гардаг юм гэхэд мөнгөө зээлүүлсэн гэдэгтээ итгэгсдэд үйлчлэхийн тулд бид ирээдүйд импортоор авч байгаагаасаа илүүг экспортод гаргах дарамтанд орох болно. Герман улс сүүлийн жилүүдэд гадаадад хөрөнгө хураасан шигээ ирээдүйд хураасаар байх юм бол санхүүгийн зах зээлийн хямрал тохиолдоход агаарт замхарч салхинд хийсч одсон мэт алга болж үнэ нь эрс буурна. Үүнийг 2008 оны хямралын үеэр олон хөрөнгө оруулагчид биеэрээ амслаа. Харин импортолж авснаасаа илүүг экспортлох нь германы хувьд дарамт гэхээсээ илүү зорилт мэт ойлгогдсоор ирсэн. (Эдийн засгийн бодлого ч экспортыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг.)

### ➤ Олон нийт хэмнэсээр хувийнхан хожсоор байх уу?

Дээрх бүх жишээн дээр эцэстээ төрийн өр үү? эсхүл компанийн болон төсөвт байгууллагын өр үү? гэдэг нь чухал үүрэгтэй. Германд төрийн өрийг л дарамт гэж үздэг болохоос хувийн өр нэмэгдэж байвал (ихэвчлэн компаниудын өр) харин ч бүр ололт амжилтанд тооцдог. Гэтэл хойч үеийнхэн маань 1.5 миллиард Еврогийн эрсдэл багатай төрийн өрийг өвлөн аваад зогсохгүй компаниудын 2.5 миллиард Еврогийн найдваргүй өрийг ч бас өвлөн авах болно.

Хувийн өрийг төдийлөн асуудалгүй өр гэж үздэг бодит байдал удаан хугацааны туршид ноёрхож ирсэн нь өмнө нь төрийн өмчид байсан шуудан, цахилгаан холбоо, төмөр зам, авто зам зэрэг секторуудын хувьчлалын давалгаанд нөлөөлсөн. Хувьчилж авахын тулд авсан зээлийг аюул учруулж болзошгүй төрийн өр биш баярлаж бахархуштай хувийн хөрөнгө оруулалт гэж үзэж байна. Цаад учир нь тэдгээрийн дахин хувиарлалт бидний үед биш хойч үед хийгдэх ёстойд л байгаа юм. Энэ удаад төрийн өрийн хүүг

төлөгчид нь татвар төлөгчид биш, харин үйлчлүүлэгчид байх болно. Өөрөөр хэлбэл үнээр дамжуулан, жишээлбэл "түрээс" төлөх эсхүл цалинг бүтээмжтэй уялдуулан нэмэхгүй байх хэлбэрээр компанийн үр ашгийг нэмэгдүүлэх үүрэгтэй хөдөлмөр эрхлэгсэд байх болно. Гэтэл хувийн секторт ч нэгэн адил үйлдвэрлэлийн бүтээмжийг бодитойгоор нэмэгдүүлсэн нөхцөлд л хангалуун амьдралын түвшин дээшилдэг хамаарал үйлчилдэг.

Тэгэхээр бид Герман оронд удаан хугацааны тогтвортой өсөлтийг бий болгоход шаардагдах хөрөнгө оруулалтанд шаардагдах өрийг тавих зоригтой байх өртэй ажээ. Үүний тулд тоног төхөөрөмж, эрүүл мэнд, боловсрол, судалгаа, хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Экспортын илүүдлээр гадаадад хөрөнгө хуримтлуулах, эсхүл "ирээдүйн баталгааг" хуримтлалын тогтолцоогоор хангах боломж дотооддоо болон гадаад оронд өнөө үед бидний хийж буй хөрөнгө оруулалт үр ашгаа өгсөн нөхцөлд л бүрдэх юм. Хөрөнгө оруулагчдын ашиг тусын тулд нийгэмд өгөөжгүй дахин хувиарлалт хийгдэж буйг үл харгалзан дүгнэхэд дээрх хөрөнгө оруулалтаас олж буй ашиг нь улс ардын аж ахуйн өсөлтийн хувиас өндөр байх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээ зээлийн хүүгийн хувь хэмжээнээс өндөр гарсан нөхцөлд хойч үеийнхэн бидний үеийн тавьсан өрийн дарамтаас чөлөөлөгдөх боломжгүй юм.

### 7.3. Хувьчлалын эрсдэл ба боломж

Симон Баут

Өмнө нь олон нийтийн эзэмшилд байсан хөрөнгийг хувьчлах нь бидний эрин үеийн эдийн засгийн бодлогын зөрчилтэй сэдэв юм. Уг зөрчил төр ба хувийн эдийн засгийн харьцаа ямар байвал зохилтой бэ? гэдэг үндсэн асуудлыг тойрон үүсдэг байна. Германы төмөр замын хувьчлалыг тойрсон халуухан маргаан нь энэ сэдвийн хүрээнд гарсан улс төрийн тодорхой шийдвэрүүдээс хальсан, илүү өргөн хүрээтэй тодорхой хэлбэл нийтийн тусын төлөө, амьдрах орчны баталгаат байдал, төрийн хүлээх үүргийн зарчмын төсөөллүүдийн хүрээнд үндэслэл нотолгоо солилцох хэлбэрээр өрнөж байна. ГСДН-ын гишүүдийн дунд төмөр замыг хувьчлахын төлөө, хувьчлалыг эсэргүүцсэн олон өөр байр суурь байгаа нь хувийн эдийн засаг ба нийгмийн ардчиллын төлөөх төрийн хоорондын харьцааны тухай асуудлын хариулт хялбар биш бөгөөд илүү өргөн хүрээнд авч үзэж иж бүрэн хариулт өгөхийг шаардаж буйг харууллаа.

Дэлхий дахинд хувьчлалын хоорондоо ялгаатай олон хэлбэр байдаг бөгөөд эдгээрийн талаархи судалгааг улс төрч, эрдэмтэн Эрнст Улрих фон Вайзсаекерын удирдлагын дор Ромын клубээс<sup>12</sup> эрхлэн гаргасан “Хувьчлалын хязгаарууд” гэдэг номонд нийтэлсэн. Нэн түрүүнд уг судалгаан дээр үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийсэн байна:

Ромын клуб илтгэлдээ нэг талаас хувьчлалыг ямар ч шүүмжлэлгүйгээр бүрэн дүүрэн дэмжих, нөгөө талаас төрд бүрэн итгэл үзүүлэх, аль болох их хөрөнгийг олон нийтийн мэдэлд байлгах санааны туйлшрал ямар үр дүнд хүрдгийг харуулсан байна.

Тухайн секторын онцлог нөхцөл байдалд зөв дүгнэлт өгч хувийн актёруудад хувьчлах уу?, олон нийт-хувийн түншлэлд хувьчлах уу?, эсхүл төрийн биелүүлэх ёстой үүрэг учраас төрд үлдээх үү? гэдгээс хамааран дээрх хоёр замын дундах замыг сонгон авахад тодорхой нөхцөл хангагдсан байхыг шаарддаг. Хувьчлал болон актёруулын хамтын ажиллагааны олон хэлбэр байдаг:

~ Төрийн компаниуд хувийн өрсөлдөгчидтэй өрсөлдөх боловч өмч нь олон нийтийн өмч хэвээр үлдэнэ. Жишээлбэл: Германы төмөр зам, 1994 оноос хойш хэсэгчилсэн байдлаар хувьчлагдсан ч Холбооны мэдлийн хувьцаат компани хэвээр үлдэж бусад олон компаниудтай улам бүр хатуу нөхцөлд өрсөлдсөөр байна.

~ Үүргээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх: Төр хувийн компаниар үүргээ гүйцэтгэтгүүлж дараа нь гүйцэтгэсэн ажлыг нь худалдан авна. Холбооны хэвлэлийн газар бол үүний нэг жишээ мөн. Холбооны хэвлэлийн газрыг хувьчлаад хувийн компанид аюулгүй байдлыг хангах тал дээр эргэлзээтэй байдал үүссэн учраас төр буцааж худалдан авсан.

~ Олон нийт-ба хувийн түншлэл (PPP) төрийн болон хувийн актёрууд хамтран ажиллаж хамтын шийдвэр гаргах

~ Бүрэн хувьчлал: Олон нийтийн өмчийг бүрэн худалдаж төр зах зээлийн үйл явдалд зөвхөн зохицуулах хэлбэрээр оролцохоос өөрөөр нөлөөлөх боломжгүй болдог.

Төрийн байгуулалт ба эдийн засгийн эрх чөлөөний хоорондын харьцаа, аюулгүй байдал ба техник технологийн дэвшилд суурилсан эдийн засгийн шинэчлэлийн харьцааны тэнцвэрт байдлыг байнга шинэчлэн тогтоож байх ёстой. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр

12 Ромын клуб нь нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлуудаар судалгаа хийдэг эрдэмтдийн олон улсын байгууллага юм. 1972 онд нийтлэгдсэн “өсөлтийн хязгаарууд” гэдэг судалгаагаараа олноо танил болсон. Уг судалгаагаар хүн амын өсөлт, байгаль орчны бохирдол, түүхий эдийн нөөцийн төгсгөл зэрэг асуудалд дэлхий дахины анхаарлыг хандуулсан бөгөөд байгаль орчныг хамгаалах хөдөлгөөнд хүчтэй нөлөөлж чадсан.

ерөнхий нөхцөлүүд өөрчлөгдөж байдаг. Цахилгаан холбооны салбарын хувьчлал ба либералчлал нь хувьчлалын эерэг жишээ болсоор байна. Өрсөлдөөний улмаас үйлчилгээний үнэ эрс буурч салбарын түвшинд техник технологийн шинэчлэл дээр суурилсан эдийн засгийн өсөлт нэмэгдэж хувьчлалаас олсон орлого төсвийн тогоо руу урсан орсоор байна. Үүний цаад шалтгаан нь 20-р зууны сүүлчээр нэгэнт бий болсон утсан холбооны сүлжээн дээр суурилан олон хувийн компаниуд үйлчилгээ үзүүлэх техникийн боломжтой болсон явдал юм. Үүнээс өмнө явагдсан хувьчлалуудын үр дүнд тухайн салбарын доторх өрсөлдөөн нэмэгдэх бус харин төрийн монопол хувийн монополиор солигдож байлаа.

Төр ба хувийн хэвшлийн хоорондын харьцаа цаг хугацаатай хамт өөрчлөгдсөөр байна. 19-20-р зууны үед төр ба хувийн хэвшлийн хоорондын харьцаанд төр давамгайлж төр улам бүр их хариуцлага, үүрэг үүрэх болж төрийн эзэмшлийн хувь газар сайгүй өсөж байлаа. Алсад мэдээ дамжуулах салбар, эрчим хүчний үйлдвэрлэлээс гангийн үйлдвэрлэл, авто машины үйлдвэр зэрэг үйлдвэрийн салбар хүртэл өнгөрсөн үед бүгд олон нийтийн эзэмшилд байсан бөгөөд өдгөө бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хувьчлагдаад байна. Сүүлийн хорин таван жилд германд хувьчлал эрчимтэй явагдаж төр ба хувийн хэвшлийн хоорондын харьцаанд хувийн хэвшил давамгайлах болсон байна.

Энэхүү харьцааны өөрчлөлтийн замыг засагч нь хэн байв аа? Олон улсын түвшинд Дэлхийн банк, Олон улсын валютын сан байлаа. Эдгээр санхүүгийн байгууллагууд нь Вашингтоны зөвшил гэж нэрлэгддэг тохиролцоонд шийдвэрлэх үүрэгтэй оролцсон юм. Тэдний боловсруулсан эдийн засгийн бодлогын үндсэн чиглэл нь төрийн оролцоог бууруулахад чиглэгдэж байсны нөлөөгөөр дэлхий дахинд зохицуулалтыг задлах, хувьчлалын давалгааг эхлүүлэх үндсийг тавьсан юм. "Хэн нэгэн тотинд "хувьчлал" гэдэг үгийг хэлүүлээд сургачихсан бол 1980-1990 ээд онуудад Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн олон зөвлөмжүүдийн оронд тогтот сурсан үгийг нь хэлүүлээд байхад хангалттай байлаа." гэж Нобелийн шагналт, дэлхийн банкны тэргүүлэгч эдийн засагч асан Э. Стилгитц (Стилгитц 2002: 78-81-р хуудас) бичжээ. Стилгитцын үзэж буйгаар ямар секторуудыг, ямар тохироо бүрдсэн үед хувьчлах нь зүйтэй бэ?. Актёруудын ямар бүтцээр тогтвортой өсөлт, Илүү шударга хуваарилалт ба хангамжийг хүртээх боломжтой бэ? гэдгийг нарийн хянахын оронд Вашингтоны зөвшилцлийн гол асуудал нь хувьчилж

л байвал болох нь тэр гэдэг байдлаар хандсанд байгаа юм. Хувьчлал ямар нөлөө үзүүлэх бэ? гэдэг нь хувьчлал хийгдэж буй салбар, тухайн салбарт үйлчилж буй ерөнхий нөхцөлүүдээс хамаардаг учраас аль нэг улс оронд амжилттай явагдсан хувьчлал өөр нэг орны ижил салбарт явуулсан хувьчлал бүтэлгүйтдэгийн цаад шалтгаан нь энэ юм.

Дараах хүчин зүйлс хувьчлалаас ямар үр дагавар гарах бэ? гэдэгт чухал нөлөөтэй байдаг:

~ Хувьчлах гэж байгаа салбарт өрсөлдөөн байна уу? Эсхүлтөрийн монополийг хувийн монополоор сольж байна уу? Нэн ялангуяа сүлжээний аж үйлдвэр гэж нэрлэгддэг салбаруудад жишээлбэл төмөр замын тээврийн тодорхой зам дээрх өрсөлдөөн зөвхөн хязгаарлагдмал хүрээнд явагддаг. Өрсөлдөхийн тулд төмөр замтай газарт зэрэгцээ төмөр зам тавихад үр ашигтай ажиллах боломж бараг байдаггүй. Нэг л замтай байх нөхцөлд галт тэрэгнүүд гүйцэж түрүүлэх боломжгүй. Бүтээмжээс хамааралтай ус, хий, цахилгаан хангамж нь мөн сүлжээний аж үйлдвэрт хамаардаг. Хувьчлал явуулдаг юм гэхэд өрсөлдөгч компаниуд зах зээл дээрх эрх мэдлээ давуу тал болгон ашиглахгүй байхаар зохицуулалтыг хийх ёстой.

~ Чухал таваар болон үйлчилгээний хэрэглэгчид зах зээлээс хасагдах, хаагдах аюул байна уу? үгүй юу? Жишээлбэл алслагдсан бүс нутгийн хүмүүс захидлаа хүлээн авч хүчрэх үү? Төлбөрийн чадвар муутай хүмүүс цахилгаан түгээх сүлжээнээс хасагдах аюул байна уу?

~ Төрийн зүгээс онцгой хамгаалалтанд байлгах сонирхол байна уу? Холбооны хэвлэлийн газрыг бүрэн хувьчилсны дараагаар хэвлэгдсэн баримт бичиг, захиргааны бичиг баримтад итгэж болох эсэх асуудал хурцаар тавигдсан учраас дахин олон нийтийн эзэмшилд буцааж өгсөн. /Төр буцааж худалдаж авсан./

Хувьчилсан болон төрийн мэдэлд шилжүүлсэн байдлын тайлан маш холимог хэлбэртэй байдаг. Тэдгээрийн үр дүн тухайн сектор ба салбарын бодлого зохицуулалтаас хүчтэй хамаардаг. “Хувьчлалын хязгаарууд” илтгэлд германы болон бусад орнуудын хувьчлалын жишээнүүдийг судалж үнэлгээ өгсөн. Хувьчлал эерэг ба сөрөг үр дүнд хүрсэн тухай олон жишээ бий. Дараах хэсэгт судалгаагаар тогтоогдсон судалгааны эерэг нөлөө болон Ромын клубын хувьчлалын эрсдэлүүдийн талаар хийсэн дүн шинжилгээг танилцуулна.



Хувьчлал нь өрсөлдөх боломжтой секторт явагдсан нөхцөлд зарчмын хувьд компаниудын үйлчлүүлэгчиддээ үзүүлэх үйлчилгээг сайжруулдаг. Хоорондоо өрсөлдөлж буй хувийн компаниуд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжийг өндөр байлгаж чадахгүй юм бол зах зээлд эзэлж буй байр сууриа алдах учраас техник, технологийн шинэчлэлд нээлттэй, үр ашигтай ажиллах ёстой. Цахилгаан холбооны салбарт хийгдсэн хувьчлал нь хувийн компаниудын өрсөлдөөний улмаас техник технологийн дэвшилд суурилсан шинэчлэл эрчимжиж зах зээл тэлэхэд хүргэсэн эерэг жишээ юм. Хэрэв цахилгаан холбоо төрийн монополд хэвээр байсан бол дээрх дэвшил гарахгүй байсан нь ойлгомжтой. Өрсөлдөх шаардлагагүй төрийн мэдлийн компаниуд нь (монопол нь) өртөг өндөртэйгээр ажиллаж шинэчлэлд төдийлэн нээлттэй биш байх хандлагатай байдаг. Өртгийг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулах нь хувьчлалыг заавал дагалддаг үр дагавар биш юм. Харин хувийн компаниуд төдийлөн ашиг авчирдаггүй үйлчлүүлэгчдийг үйлчлүүлэгчдийнхээ хүрээнээс хасах, өөрөөр хэлбэл “жимс түүх” хандлагатай байдаг. Жишээлбэл: алслагдсан нутагт суугаа иргэдэд захидал хүргэх үйлчилгээ өртөг өндөртэй тул үйлчлүүлэгчдийнхээ хүрээнээс хасдаг.

Төрд хөрөнгө оруулалт хийх мөнгө дутмаг, хувийн (олон улсын) хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байх нөхцөлд хувьчлал явуулах нь зүй зохистой байдаг. Ихэвчлэн ядуу орнуудад оршихуйн үндэс болсон усан хангамж мэт чухал тавааруудаар хангах хөрөнгө мөнгө хомс тул хувийн хөрөнгө оруулагчдын мэдэлд өгөх нь элбэг тохиолддог. Хувийн компанийн мэдэлд шилжсэнээр хангамж ерөнхийдөө сайжирдаг боловч төлбөрийн чадвар сайтай үйлчлүүлэгчдийн хангамж илүүтэй сайжирдаг тул тэгш бус байдлыг хурцатгадаг.

Хувьчлалын эргэн тойронд бас нэгэн элбэг тохиолддог бэрхшээл бол хөрөнгө оруулалтыг зохицуулдаг хууль, дүрэм хэтэрхий сул байдаг. Туршлагагүй төр үйл ажиллагааг доголдуулахгүй байх дарамтанд орсны улмаас худалдах нөхцөлүүдийг өөртөө алдагдалтайгаар тодорхойлж алдагдалтай хувьчлал явуулдаг. Асар их туршлага хуримтлуулсан олон улсын концернуудтай нэн ялангуяа хуучин коммунист орнууд хувьчлалын гэрээ байгуулахдаа бодит байдалд нийцэхгүй үнэ ба чанарын нормыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Ийм байдлаар зүүн европын шилжиж буй орнуудын эрчим хүч үйлдвэрлэгч компаниуд бодит үнээс маш доогуур үнээр хувьчлагджээ.

Эдгээр нь хувьчлагдаж буй салбарт хангалттай өрсөлдөөн байхгүйн улмаас хувийн монопол үүссэн жишээ юм. Жишээлбэл: Өөр ямар ч хувилбар байхгүй усан хангамж, цахилгаан түгээх сүлжээ зэрэг сүлжээний аж үйлдвэрийн хувьчлалд ямар бэрхшээл учирдаг талаар тайлбарлалаа. Мөн техник, технологийн шинэчлэл болон үнийн давуу талууд ч бий болдоггүй. Хувийн монополууд төрийнхөөс илүү их сөрөг талтай байдаг.

Өөр нэг эрсдэл бол эрсдэлийг бусдад үүрүүлж эрсдэлээс үүдэлтэй зардлыг бусдаар төлүүлж орхидог. Хувийн хөрөнгө оруулагч худалдан авсны дараагаар борлуулалтын эрсдэлийг төрд үүрүүлж орхисон жишээ бий. Жишээлбэл: Гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр өртөг нэмэгдэх, экологийн хохирлыг арилгах зэрэг зардлыг төрд үүрүүлж орхиод олсон ашигаа хувьдаа авчихдаг. Үүний нэг жишээ бол цөмийн энергийн хэрэглээний дайвар зардал юм.

Хувийн хөрөнгө оруулагчдын дараагийн нэг асуудал бол удаан хугацааны эдэлгээ, чанарыг тогтмол сайн байлгах шаардлагыг орхигдуулдаг. Энэ байдал нь зарим тохиолдолд урьд нь олон нийтийн хөрөнгөөр тордож байсан дэд бүтцийг нурахад хүргэдэг. Үүний нэг олонд танил болсон жишээ бол британийн төмөр зам юм. Хувьчлан авсныхаа дараагаар хөрөнгө оруулагчид төмөр замын сүлжээг тордолгүй орхигдуулсны улмаас ноцтой осол гарч сүлжээг төр дахин мэдэлдээ авсан.

Хувьчлал нь ихэнхдээ төрийн сан хөмрөгтэй холбоотой байдаг: Хувьчлалаас олсон мөнгөөр төсвийн онгорхой цоорхойг нөхдөг. Энэ нь заримдаа бодлогын бусад салбаруудад эерэгээр нөлөөлөх нь бий. Дрезден хот зуу гаруй мянган орон сууцаа худалдсаны дараа германы том хотуудын дунд өргүй ганцхан хот болж чадсан. Өмнөх жилүүдэд нь жил бүр зээлийн хүүд төлдөг байсан наян сая евроноос түрээсийн орлого ба засвар үйлчилгээний зардлын зөрүүг хасаад боловсрол гэх мэт олон нийтийн салбарт хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон.

Ромын клуб хувьчлал явуулахын өмнө бөглөдөг хяналтын хуудас боловсруулан гаргахыг санал болгож байна. Хувьчилж л байвал болох нь тэр гэдэг байдлаар хувьчлалд хандахаас сэргийлэхийн тулд

эхний ээлжинд чухам ямар учраас хувьчлал явуулах гээд байгаа шалтгаануудыг олон нийтээр хэлэлцүүлэх хэрэгтэй.

Хяналтын хуудсанд:

- ~ Хувьчлалаас ямар үр дүн хүлээгдэж байгааг хөрөнгө оруулагчдад тодорхой танилцуулж уг үр дүнд хүрэхэд шаардагдах зохицуулалтын найдвартай ерөнхий нөхцөлүүдийг тогтоож өгөх ёстой.
- ~ Төрийн мэдлийн өндөр бүтээмжтэй ажиллаж буй үйлдвэрүүдийг үзэл суртлын үүднээс хувьчлахгүй байх.
- ~ Хяналтын зөвлөлөөр дамжуулан ардчилсан хяналтыг хэрэгжүүлэх
- ~ Хувьчлалын дараа төр өмчлөгч нь биш болсон ч зах зээлийн зохицуулалтаар дамжуулах нөлөөгөө хэвээр хадгалах оролдлого хийхгүй байх.
- ~ Олон нийтийн үйлчилгээ, оршихуйн үндсэн нөхцөлүүдийг онцгойлон хамгаалах: Төрийн үйлчилгээ үзүүлдэг салбаруудын хувьчлалыг онцгойлон хянах шаардлагатай. (Боловсрол, эрүүл мэнд гэх зэрэг)
- ~ Эмзэг бүлгийнхнийг хамгаалах нийгмийн хартын хувьд: Дрезден хот үл хөдлөх хөрөнгөө зарахдаа түрээслэгчдийн эрхийг онцгойлон хамгаалах заалтыг гэрээнд тусгаж өгсөн.
- ~ Хувьчлалын тендерийг (сонгон шалгаруулалт) шударга бөгөөд ил тод явуулах
- ~ Хувьчлалын өмнө олон нийт ба хувийн түншлэлийн хэлбэрээр эсхүл хоршооллын хэлбэрээр аваад явчих хувийн хэвшил ба төрийн өмчийн хамтарсан гуравдагч зам байгаа эсэхийг судлах

#### 7.4. Сайн хөдөлмөр ба компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах Сайн хөдөлмөрийн бодлого Вольфганг Шроедер

Нийгэм бүрт өөрийн гэсэн хөдөлмөрийн тухай ойлголт байдаг. Түүгээр ч барахгүй нэг нийгмийн дотор ч хөдөлмөр, сайн хөдөлмөр гэдэг ойлголтын дор юуг төсөөлж байгаа талаар өөр өөр сэтгэлгээ байдаг. Өнөөгийн нийгэмд хөдөлмөрийг хэрхэн зохион байгуулж байна бэ? Ирээдүйд бид яаж хөдөлмөрлөх ёстой юм бэ? Хөдөлмөр нь бидний амьдрал, нийгмийн нэгдмэл байдалд ямар үүрэгтэй бэ? Нэг талд аж үйлдвэржилтийн эхний

үеийнх шиг цалин хөлс муутай хөдөлмөрийн нөхцөл байхад, нөгөө талд өндөр цалинтай, хууль эрх зүйн өндөр шаардлагад нийцүүлэн зохион байгуулсан хөдөлмөрийн нөхцөл бий болж хөдөлмөрийн харьцаанд хоёр туйл руу тэмүүлсэн хөгжил бий болсон нь түр зуурын үзэгдэл үү?<sup>13</sup> Эсхүл энэ туйлшрал засаж залруулах боломжгүй хөгжлийн эхлэл үү? Эдгээр асуултууд олны анхаарлыг онц ихээр татах боллоо. Эдгээр асуултанд хариулт өгөхгүйгээр хувь хүмүүсийн болон нийгмийн ирээдүйн төслүүдийг боловсруулах боломжгүй юм. “Хөдөлмөр дууссан” гэж нотлогчдын төлөөлөл нэг үе хүчээ авч байсан бол тэд одоо урьдахаасаа сулхан дуугарах болсон байна. Тэд орчин үеийн нийгэмд цалинтай хөдөлмөрийн үе өнгөрсөн, хүн бүрийг ажлын байртай болгох боломж үгүй болсон гэж нотолцгоодог. Тэдний энэхүү нотолгоо буруу гэдгийг ганцхан скандинавын орнуудын туршлага харуулж байна. Эдгээр орнууд хөдөлмөр эрхлэлтийн өндөр түвшинг нийгмийн өндөр стандартуудтай уялдуулж чадсан юм. Герман улсад мөн эдийн засгийн зогсонги байдал нэлээд хугацаагаар үргэлжлээд дууссаны дараагаар ажилгүйдлийн түвшинг бууруулж чадсан. Эдийн засгийн гүнзгий хямрал нүүрлэнэ гэдэг таамаглал идэвхжсэний дараагаар үй олноороо ажилгүйдэлд өртөнө гэдэг сэдэв дахиад олны анхаарлын төвд орлоо. Үүний зэрэгцээ “маш уян хатан электрон хөдөлмөрийн нийгэм” байгуулагдах нь гэдэг айдас ч орчин үед их болж байна. Үйлдвэрлэлийн бүтээмжийн дэвшил хөдөлмөрийг маш их хөнгөвчилсөн тул өмнөхөөсөө олон дахин бага хөдөлмөрөөр олон дахин илүү ДНБ үйлдвэрлэж байна. 40 жилийн өмнөхтэй харьцуулахад ДНБ ба хөдөлмөрийн (хүн\цагийн) харьцаа эрс өөрчлөгдсөн байна. Хөдөлмөрийн хувьслын тухай маргаанд уг харьцааны асуудал нь зөвхөн нэг сэдэв нь юм.

## ➤ Хөдөлмөр зохион байгуулалтын хувьсал

Цалинтай хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохион байгуулалтын асуудал нь зөвхөн хөгжлийн болон бүтцийн тодорхой үе шатанд нийгмийн өргөн хүрээтэй мэтгэлцээний сэдэв болдог бол хөдөлмөр эрхлэгсдийн хувьд өдөр тутмын амьдралыг тодорхойлж байдаг. Аж үйлдвэржилтийн үед хөдөлмөр нь үйлдвэрлэлийн дамжлага, машины өгсөн заалтын дагуу ажиллах хэлбэрүүдээр тодорхойлогдож байлаа. Машин, хяналт, стандартууд буюу тодорхой хэмжээнд шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр төлөвлөлтийг хийдэг тейлорын гэж нэрлэгддэг хөдөлмөр зохион байгуулалт нь бүх хүмүүсийн бодит амьдралыг тодорхойлоод зогсохгүй нийгэмд бүхэлд нь хүчтэй нөлөөлж ажлын дараах амьдралыг ч тодорхойлох болсон байна.

<sup>13</sup> Prekaer гэдэг үг нь латин хэлнээс гаралтай бөгөөд “гуйж гувшин байж” эсхүл “найдаргүй” гэдэг утгатай.

**Тейлоризм** гэдэг ойлголт нь /1856-1915 он/ Фредерик Тейлороос эхтэй. Тэр хөдөлмөрийг аль болох өндөр үр өгөөжтэй зохион байгуулах зорилтыг дэвшүүлж байлаа. Тэрбээр хөдөлмөрийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэлийн машинуудын гүйцэтгэж буй үйл ажиллагааны зарчмын дагуу хөдөлмөр зохион байгуулалтыг хийж үйлдвэрийн процессыг механик урсгал дамжуулалтанд шилжүүлэх нь зүйтэй гэж үзэж байлаа.

Ажилчны хөдөлгөөн, нэн ялангуяа үйлдвэрчний эвлэлийн түүхийг томоохон үйлдвэр аж ахуйн газрууд дахь Тейлорын хөдөлмөр зохион байгуулалтгүйгээр ойлгоход бэрхшээлтэй юм.

Тейлоризмын зэрэгцээгээр 1980-аад онд Тоёотатизм<sup>14</sup> хэмээх эдийн засгийн үр өгөөжийг дэмжигч үйлдвэрлэлийн хоёрдох загвар гарч ирсэн юм. Энэхүү үйлдвэрлэлийн загвар нь тухайн үед японы авто машин үйлдвэрлэгч Тоёота компанид бүлгийн ажил дээр суурилсан хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэр байсан тул Тоёотатизм гэж нэрлэсэн бөгөөд тухайн үеийн хөдөлмөрийн хатуу хувиарлалтын сөрөг талуудыг тэнцвэржүүлэх мэргэжлийн олон талт ур чадвартай хөдөлмөр эрхлэгсдийг илүү нэгтгэх зорилготойгоор хөгжүүлсэн юм. Энэ нь нөгөө талаас орлогын эх үүсвэрээ бүрдүүлэх хөдөлмөрийг илүү хүмүүнлэг болго гэдэг үйлдвэрчний эвлэлийн үйлдвэр, аж ахуйн газруудад хэрэгжүүлэх бодлогын үндсэн шаардлагатай нийцэж байлаа: Хөдөлмөрлөх нөхцөлийг илүү хүмүүнлэг болгосноор хөдөлмөрийн нөхцөл сайжирч, хөдөлмөрийн болон амьдралын чанарыг хооронд нь уялдуулж, эрүүл мэндийн шаардлагыг хөдөлмөрлөх нөхцөлтэй холбож, нийгмийн баялгийг нэмэгдүүлэх боломж нээгдэнэ гэж үзэж байлаа.

Хөдөлмөр зохион байгуулалтаар шинэчлэлийн тэргүүлэгчид нь ихэвчлэн автомашины үйлдвэрүүд байлаа. Шведийн Volvo-машины үйлдвэрт бүлгээр ажиллах шинэ хэлбэрийг нэвтрүүлснээр амжилтанд хүрсэн нь сайны жишээ болж уг хөдөлмөр зохион байгуулалтанд шилжих сонирхлыг нэмэгдүүлж байлаа. 1980-аад оны эхэн үед мөн авто машин үйлдвэрлэлийн салбарт бие даасан, хагас бие даасан бүлгийн ажлын шинэ хэлбэрүүдийг нээж үйлдвэрлэлийн шинэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн юм. Олон талт, сонирхолтой, мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан хөдөлмөрийн нөхцөлийг бүрдүүлж өгснөөр хөдөлмөр эрхлэгсдэд хөдөлмөрийн норм, хэмжээний хувиарлалтанд хувь хүний хувьд илүү чөлөөтэй орон зай бий болгож тэдний чухал шийдвэр гаргалтанд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хагас бие даасан бүлгийн ажлыг нэвтрүүлсэн юм. Үүний дараахан бүлгийн ажил нь хөдөлмөрийн шинэ ертөнцийн бэлэг тэмдэг болж хувь хүмүүс бүлгийнхээ дунд шинэ үнэлэмжтэй болсон мэт харагдаж байлаа.

<sup>14</sup> Энэхүү үйлдвэрлэлийн загвар нь авто машин үйлдвэрлэгч Тоёотагийн нэрээр нэрлэгдсэн. Бөөнөөр нь үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийн бүтээмжийг чанартай холбох гэсэн оролдлого юм.

Стандартчилагдсан дамжлагын хөдөлмөр хөгжлийнхөө дээд хязгаартаа хүрэхийн алдад (Тейлоризм) хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах тухай хүчтэй маргаан өрнөж улмаар хагас бие даасан бүлгийн ажлын хөгжлийг “сайн хөдөлмөр” гэдэг зорилтод ойртуулахыг эрмэлзэх боллоо. Энэхүү процесс германд олон улстай харьцуулахад илүү өргөн хүрээг хамарч зарим зохиогчид германы гэсэн тусгай замын тухай ярих хүртэл хэмжээнд хүчээ авсан юм. Германы тусгай замын чанарын цар хүрээ нь Тейлоризмын боловсруулсан мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд ба онол практик хослуулсан мэргэжлийн сургалтан дээр суурилж байлаа. Энэ суурин дээр хөдөлмөрийн нөхцөлийг хүмүүнлэг байлгах, үйлдвэрлэлийг өндөр үр ашигтай байлгах шаардлагуудыг зохих хэмжээнд уялдуулж чадсан бөгөөд нөгөөтэйгүүр экспортод чиглэсэн аж үйлдвэрийг уян хатан мэргэшүүлэх төслийн үйлдвэрлэлийн суурь нь болж байлаа. 1990-ээд оны дунд үеэс нэг талаас эдийн засгийн болон санхүүгийн хавчлага, нөгөө талаас бүлгийн ажлын хөгжилд гарах болсон зөрчлийн улмаас бүлгийн ажлын үр өгөөж, хүлээн зөвшөөрөгдөх байдалд эргэлзэх болж аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийг илэрхийлж байсан дээрх хөдөлмөр зохион байгуулалт бүхэлдээ өөрчлөгдөж эхэлсэн юм. Энэ хооронд дээрх эргэлзээ үгүй болжээ. Бүлгийн ажил ч хүрээгээ тэлсээр байна. Харин бүлгийн ажлыг нэвтрүүлснээр хөдөлмөрлөх нөхцөл илүү хүмүүнлэг болно гэдэг хүлээлт л биелэгдээгүй үлдсэн байна. Харин ч бүр эсрэгээрээ: олон салбарт стандартчилалын шаардлага улам хатуу болсны улмаас хөдөлмөрчдийн ажлын байран дээрх идэвх санаачилгатай оролцоо улам бүр хумигдсаар байна. Ийнхүү өнөөгийн аж үйлдвэрийн ертөнцөд аль болох өндөр бүтээмжийг үйлдвэрлэх зорилгод чиглэсэн хөдөлмөрийн олон төрлийн дэглэм хоорондоо өрсөлдөж байна.

Их аж үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн эзлэх хувь багасахын хэрээр хөдөлмөрийн өөр нэг шинэ хэлбэр нийгмийн мэтгэлцээний төвд орж ирж байна. Энэ бол уян хатан, мэдлэгт суурилсан үйлчилгээний хөдөлмөр юм. Хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэр бүр нь хувь хүний буюу ажилтнуудын бие даасан байдлыг дээшлүүлэх зорилтыг тавьдаг. Тэд аж үйлдвэрийн салбарынх шиг том компаниудад биш харин жижиг үйлдвэрүүдэд ажилладаг тул ажлынхаа үр дүнгийн өмнө илүү их хариуцлага хүлээдэг. Хөдөлмөрийн энэхүү шинэ хэлбэр нэвтрэх болсонтой холбоотойгоор ажлын цагийн тогтсон хуваарь төгсгөл болж байна. Ажлын цагийг богиносгоно гэж ярихын оронд эцэс төгсгөлгүй ажил гэж яригддаг болоод байна. Жишээлбэл:

электрон шуудан (e-mail) болон гар утас хэрэглээнд нэвтэрснээр олон ажилтнууд хуулиар тогтоосон ажлын цагаас үл хамааран тогтмол хэзээ ч дуудсан бэлэн байх ёстой болсон байна. Энэхүү хөгжлийн боломж болон эрсдэлүүдийн тухай мэтгэлцээнд ажилтнуудын хараат бус байдал буюу бие даасан байдлыг хэр хэмжээнд хангах бэ? гэдэг асуудал хөндөгдөхөд энэ нь ажилтнуудын боловсролын байдлаас шууд хамаарах аж. Ажилтнуудын боловсрол, мэргэжил өндөр байх тусмаа бие даасан байдал нь дээшлэх боломжтой. Эрсдэлтэй талууд нь гэвэл хүмүүс ажилдаа бүхнээ зориулах болсноор сэтгэл зүйн стрессын шинэ хэлбэрүүд (ажлаасаа болоод сэтгэл зүйн хувьд доройтох, ядрах) Burn-out-Syndroms гарч ирсэн нь амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатай зөрчилдөж байна.

Сүүлийн жилүүдэд ажилтан нь өөрийнхөө “ажиллах хүчний ажил олгогч”-ийн хувьд хөдөлмөр эрхлэх чадвараа дээшлүүлэх асуудлыг өөрөө хариуцдаг, ажилтнуудын шинэ хэлбэр байх ёстой юм биш үү гэдэг асуудал мэтгэлцээнд тодорхой байр эзлэх болоод байна. Ингэснээр эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажилладаг пролетарийн хөлсний ажилтнаас хаана ч ажиллах боломжтой, хөрвөх чадвартай ажиллах хүчнийхээ эзэн өөрөө болон хөгжих хөгжлийн процессын эхлэл тавигдах ёстой юм. Ажиллах хүчний эздийн онцлог шинжүүд нь гэвэл зах зээлтэй зарим талаараа төстэй үүрэг гүйцэтгэх харилцааны тодорхой хэсгийг ажилтан өөрөө зохион байгуулах боломжтой. Нэн ялангуяа дараах гурван цар хүрээнд: хувь хүний онцлогт тохирсон мэдлэг чадвар, ажлын системчилсэн өөрийн хяналт болон нийгмийн хамгааллын хүнд нөхцөлд өөрийгөө дарлан мөлжих аюул зэрэг нь шинэ хэлбэрийн онцлог юм. Зах зээлд суурилсан эдийн засгийн шинэ шатанд тохирсон ажиллах хүчний эзэд нь нийгмийн тодорхой бүтэц тул нийгэм судлаач Босс\Понгратц нар компанийн дотоод дахь эрх мэдлийн харьцаа өөрчлөгдөх болно гэдэг таамаглал дэвшүүлжээ: “Капиталист компани дахь хөрөнгө ба хөдөлмөр хоорондын зөрчил нь ажиллах хүчний эзэд гэдэг шинэ хэлбэр гарч ирснээр үгүй болохгүй харин өөр өөр эзэмшил бүхий эзэд хоорондын олон талт бүтцийн зөрчил болон өөр хэлбэрт шилжих болно.” (Босс\ Понгоратц 2003 он 3—р хуудас). Шүүмжлэгчдийн үзэж буйгаар энэ хэлбэр нь хэзээ ч хөдөлмөрийн ертөнцийг тодорхойлох хэмжээнд хүрэхгүй байлаа ч гэсэн дээр дурьдсан онцлогууд аль хэдийн өргөн хүрээнд тархаад байна.

Сайн хөдөлмөрийн бодлогод тулгараад байгаа томоохон сорилт бол өдгөө хүнд нөхцөлд хөдөлмөр эрхлэгсдийн тоо эрс нэмэгдээд

байгаа явдал юм. Хөдөлмөрийн хүнд нөхцөлтэй дээрх салбараас буцаж гарах зам улам бүр бэрхшээлтэй болсоор байгаа нь асуудлыг улам хурцатгаж байна. Нийгмийн ардчиллын төсөлд сайн хөдөлмөр нь хамрагдаж буй хувь хүмүүсийн эрх ашгийг хамгаалах дараах хоёр шалтгааны улмаас чухал байр суурь эзэлдэг. Нэгдүгээрт: муу хөдөлмөрийг илүү хүмүүнлэг болгох ёстой. Хоёрдугаарт: эдгээр секторт ажиллаж байгаа хүмүүс энэ бүсээс буцан гарч цаашид хөгжих боломжоор хангагдах ёстой.

### ➤ Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах аргачлал ба актёрууд

Ажүйлдвэрийн салбарт тогтсон хөдөлмөрийн дэглэмийн ач холбогдол буурахын зэрэгцээгээр сайн хөдөлмөрийн бодлогыг хэрэгжүүлж буй актёруудад шинэ шаардлага тавигдаж байна. Эвсэл холбоод ба төрийн зэрэгцээ компаниудын актёрууд нь хэлэлцээрт суурилсан сайн хөдөлмөрийн бодлогын германы загварын гуравдагч чухал багана болж байна. Тэдний үйл ажиллагаа нь 1980-аад оноос хойш компаниудаас гадуур явагдаж буй хэлэлцээрүүд, төрөөс нормчлон тогтоож буй стандартуудын хүрээнд хөдөлмөрийн нөхцөлийн үндсэн асуудлуудыг тусгуулах, сайжруулахад чиглэгдэж байлаа. Үүний үр дүнд компаниудаас гадуур хийгддэг зохицуулалтын загварт чиглэсэн, гэхдээ уг заалтуудыг шууд хуулбарлаагүй компанийн нийгмийн журам тогтсон байна. Германы загвар нь өргөн хүрээг хамарсан компаниудын үйл ажиллагааны ба солилцооны төрөл бүрийн бүтцүүдийг бий болгожээ. Гэхдээ уг бүтцүүдийг хооронд нь ерөнхий нөхцөлүүдийг тогтоох замаар хязгаарладаг. Ингэснээр компанийн удирдлага боловсон хүчний асуудалд хамт олон, ажилчдын зөвлөлийн сонирхол болон компаниудын дээд шатны байгууллагуудын, тарифын гэрээний болон төрийн зааврыг харгалзан үзэх хэрэгтэй болдог. Мөн нөгөө талд компанийн ажилчдын ашиг сонирхлыг төлөөлөх үүрэг бүхий компанийн ажилчдын зөвлөл хамт олны ашиг сонирхлыг төлөөлөхдөө компанийн үйлдвэрлэлийн бүтээмж, эдийн засгийн амжилтын өмнө хамтын хариуцлага хүлээдэг. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоо, хамтын ажиллагааг нэгэн зэрэг хангасан германы загвар нь компанийн засаглалын тухай хуулийн хөдөлмөрийн үндэслэлд тусгалаа олсон байдаг. “Ажил олгогч ба ажилчдын зөвлөл нь хүчин төгөлдөр үйлчилж буй тарифын гэрээг мөрдлөгө болгон харилцан итгэлцэл дээр тулгуурлан компанийн үйлдвэрчний эвлэл ба ажил олгогч эдийн холбоодтой ажилтнууд болон компанийн сайн сайхны тулд хамтран ажиллана. (Компанийн засаглалын тухай хууль 2-р бүлэг.1)



Германы ашиг сонирхлын төлөөллийн загвар нь компанийн ажилтнуудын зөвлөл ба үйлдвэрчний эвлэлийг хооронд нь хэлбэр төдий тусгаарладаг. Энэ нь компанийн ажилчдын зөвлөлийн гишүүд заавал үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх албагүй, үйлдвэрчин компанийн ажилтнуудын зөвлөлд шууд ба автоматаар нөлөөлдөггүй гэсэн үг юм. Энэхүү хэлбэр төдий тусгаарлалт нь германы загварын хамгийн том ололтуудын нэг юм. Компанийн ажилтнуудын зөвлөл, үйлдвэрчний хооронд зайлшгүй өрсөлдөөн үүсэхээс илүүтэй өдөр тутмын ажлын холбоо хөгжсөн байна. Жаран жилийн өмнөөс компанийн ажилтнуудын зөвлөлийн гишүүдийн 70-аас илүү хувь нь үйлдвэрчний эвлэлийн гишүүн байж үйлдвэрчний эвлэлүүдэд идэвх санаачилгатай сайн дурын үүргийг гүйцэтгэж байна. Компанийн ажилтнуудын зөвлөл нь хамт олон, компанийн удирдлагууд хоорондын зөрчилдөөнтэй талбар дээр ажиллаж үйлдвэрчний эвлэлийнхэн “хязгаарын байгууллагын” үүргийг гүйцэтгэдэг бол (Фюрстенберг 2000 /1958/ ) компанийн менежментийн баг хамт олон, компанийн ажилтнуудын зөвлөл, компанийн удирдлагын болон тэдний харъяалагддаг эздийн холбооны ашиг сонирхол болон зааварчилгааны хооронд савлах хэрэгтэй болдог. Компанийн ажилтнуудын зөвлөл ба компанийн менежментийн багийн хооронд сонирхлын зөрчилдөөн үүссэн нөхцөлд зохих аргачлалын дагуу шийдвэрлэдэг. Нээлттэй зөрчилдөөн үүсэх нь онцгой тохиолдолд тооцогддог. Компанийн хувиарлалт болон бодлого зохицуулалтын хүрээнд нээлттэй зөрчил үүссэн нөхцөлд компаниас гадуур хөндлөнгийн актёруудыг оролцуулан шийдвэрлэдэг. Компанийн ажилтнуудын зөвлөл ба менежментийн баг нь тэдний харъяалагддаг холбоодын тавцан дээрх үндсэн актёрууд мөн. Эдгээр нь харилцан адилгүй эрх зүйн байдал, ерөнхийдөө тэгш бус эрх мэдлийн нөөцтэй байдаг бөгөөд аж үйлдвэрийн харилцааны бодлогын салбарт үйл ажиллагаа явуулж буй актёрууд нь хүчний байдлын хувьд ерөнхийдөө тэгш бус байдаг гэж дүгнэж болох юм. Хамтын ажиллагааг дэмждэг, өдгөөг хүртэл уламжлагдан ирсэн байгууллагын бүтцийг хэвээр хадгалах болон, компанийн актёрууд холбоодын шийдвэр гаргалтын түвшинд таатай нөхцөл бүрдүүлэхийн тулд тарифын гэрээний бодлогод байр сууриа өөрчлөх эрхүүдээсээ татгалздаг байна. Тарифын гэрээний чухал бүрэлдэхүүн хэсгүүд нь бодлогын болон эдийн засгийн анхдагч түвшинд хоорондоо ялгагддаг.

➤ **Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангахад тулгарч буй сорилтууд**

Компанийн ажилтнуудын зөвлөлөөр дамжуулан компанийн шийдвэр гаргалтанд ажилтнуудын оролцоог хангасан, компанийн ажилтнуудын зөвлөл болон үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг компанийн хяналтын зөвлөлд оруулснаар эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлдөг хөдөлмөрийн хувиарлалтын энэхүү загвар нь өдгөө шинэ сорилтуудтай тулгараад байна.

**1. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангагч актёруудын хоорондын холбоос суларч байна.** Хөдөлмөрийн бодлогын салбарт компаниудын дээр байрлах шийдвэр гаргалтын түвшний шийдвэрийг компаниуд хүлээн зөвшөөрдөг байдал нь мэдээжийн хэрэг биш бөгөөд харин түүхэн цаг хугацааны туршид бүрдсэн харилцааны арга хэлбэр ба улс төрийн хүчний өнөөгийн харьцааны илэрхийлэл байдаг. Менежментийн удирдлагууд компанийн дотоод энх тайван, эдийн засгийн бүтээмжид сөрөг нөлөөгүйгээр өөрийн тарифын бодлогын замаар явах боломжтой гэж үзэж буй газруудад компанийн дээгүүр байрлах шийдвэр гаргалтын шийдвэрүүдийг харгалзан үзэхгүй байх оролдлого сүүлийн жилүүдэд олонтаа гарлаа. Нийгмийн ардчиллын үзэл баримтлалын үүднээс авч үзэхэд ажилтнуудын оролцоо тухайн нөхцөл байдалд шаардлагатай юу? үгүй юу? гэдгээс үл хамааран хуулиар баталгаажсан оролцооны үндсэн эрхийг хангах асуудал учраас ямар ч нөхцөлд хэлэлцээрээр шийдэх асуудал биш гэдэг нь ойлгомжтой юм.

Компанийн актёрууд холбоодын түвшинд тэдний нөлөө, ба ашиг сонирхол хангалттай хэмжээнд тусгагдаж байна гэж үзэж буй эсэхээс компаниуд дээд түвшинд боловсруулагдсан бодлогын хууль ёсны байдал ба хүлээн зөвшөөрөгдөх байдал хамаарна. Энэ нь зарчмын хувьд холбоодын хувьд үйл ажиллагаагаа тогтмол явуулж үүрэг хүлээх чадвартай гэдгээ гишүүдээрээ үнэлүүлэх нэгэн чухал нөхцөл юм. Уламжлал үүний нэгэн чухал холбоос, аж үйлдвэрийн харилцаанд бодлогын цар хүрээг тодорхойлогч байлаа. Гэтэл сүүлийн 20-иод жилийн дотор уламжлал улам бүр ач холбогдлоо гээсээр байна. Хэдэн арван жилийн туршид германы олон компаниудад баталгаатай, үндсэндээ төлөвшсөн үеэс үед дамжсан үүргийн хувиарлалт тогтсон байлаа. Холбоодын болон компанийн актёруудын соёл ба уламжлалын холбох хүч нөлөөгөө алдаж байгаа явдал харагдаж байна. 1980-аад оноос хойш холбоодын норм тогтоох хүч суларч байгаа хандлага ажиглагдаж байна. Менежмент

болон компанийн ажилтнуудын зөвлөл өөр өөрийн замаар явах тохиолдол улам бүр олширч холбоодын шийдвэрт сэтгэл хангалуун бус байгаагаа олны өмнө дуудалцах болж гарсан шийдвэрийн үр дагаврын өмнө хариуцлага хүлээхээс татгалзах болов.

**2. Компанийн ажилтнуудын зөвлөл нь ажилтнуудын хандах түнш ба бүх ажилтнуудын ашиг сонирхлыг төлөөлөгч мөн.** Компанийн ажилтнуудын зөвлөлийн өмнө гэрээт болон үндсэн хамт олны ашиг сонирхлыг ижил хэмжээнд төлөөлөх томоохон сорилт тулгараад байна. Компанийн ажилтнуудын бүтэц сүүлийн жилүүдэд хүчтэй өөрчлөгдөж байна. Тодорхой хугацаагаар ажиллагсад, өөр компаниас түр хугацаагаар ажиллагсад, хагас өдрөөр ажиллагсдын тоо эрс нэмэгдсэн байна. Ажиллагсдын бүтцийн энэхүү өөрчлөлт нь компанийн дотоодод зөрчил үүсгэх магадлалтай. Ингэснээр компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангахад зөрчил үүсч зуучлал хийх, эв санааны нэгдэлтэй байхад бэрхшээл тулгарч байна. Компанийн ажилтнуудын зөвлөл байнга өөрчлөгдөж байдаг хамт олныг төлөөлөх болж байна. Одоо ч компанийн ажилтнуудын зөвлөл хамгаалалт муутай хөдөлмөр эрхлэлтийн бүлгийн ашиг сонирхлыг компанийн үндсэн хамт олны ашиг сонирхолтой адилхан амжилттай хамгаалах онцгой бэрхшээлтэй тулгараад байхад дээрээс нь бүтцийн өөрчлөлт нэрмээс болж байна.

**3. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах асуудал улам бүр хоорондоо холдож буй компаниудын хариуцлагын хэлбэрүүдтэй зөрчилдөж байна.** Компанийн засаглалын хууль боловсруулагдаж байх үед зарчмын хувьд компанийн шийдвэр гаргагчид нь эдийн засгийн эрсдэлийг үүрэгсэд байлаа. Компанийн ажилтнуудын зөвлөлийн компанийн шийдвэр гаргалтанд оролцох оролцоо нь компанийн зохион байгуулалт, боловсон хүчний асуудлаар хязгаарлагддаг. Гэхдээ зарчмын хувьд эдийн засгийн шийдвэрийг мөн адил хэлэлцэж эрсдэлийг бууруулах боломжтой. Компанийн хөрөнгөнд олон улсын оролцоо нэмэгдэж компанийн өмчлөгсөд ба компанийн менежмент хоорондоо улам бүр салангид болж байгаатай холбоотойгоор компанийн актёруудад шийдвэр боловсруулалтын шатанд нөлөөлөх боломжийг олгохгүйгээр хамт олон, компанийн ашиг сонирхолтой зөрчилдсөн шийдвэр гарах нь олширч байна.

Ажилтнуудын эдийн засгийн хохирлыг тэнцвэржүүлэхийн тулд компанийн ажилтнуудын зөвлөлийн зүгээс хэлэлцээр явуулах замаар

эрсдэлийг бууруулж болно. Гэсэн хэдий ч компаниудын “санхүүгийн зах зээлд чиглэсэн удирдлага” нь компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах загварын өмнө шинэ сорилтуудыг тавьж байна.

**4. Компаниуд олон улсын бүтэцтэй болж байгаа нь компанийн ажилтнуудын зөвлөлийг мөн олон улсын бүрэлдэхүүнтэй байхыг шаардаж байна.** Хөдөлмөрлөх нөхцөл муудаж байгаагийн нэг үндсэн нотолгоо нь байршлын өрсөлдөөн хэвээр байна. Энэ өрсөлдөөн компаниудын хооронд байтугай нэг концерны салбаруудын дунд ч олонтаа тохиолддог. Жишээлбэл: авто машины нэгэн шинэ загварыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээс өмнө цалингийн зардал, нийгмийн хамгааллын зардлыг бууруулахын тулд компани даяар сонгон шалгаруулалт зарлаж салбарууд сонгон шалгаруулалтанд ялахын тулд аль болох цалингийн зардал багатай, нийгмийн хамгаалал султай газар үйлдвэрлэл явуулахыг эрмэлзэж байна. Гэхдээ эв санааны нэгдлийн зарчим дээр тулгуурлан амжилтанд хүрсэн жишээ бий. Женерал моторс компани европ дахь зарим нэгэн салбараа татан буулгана гэж сүрдүүлж эхлэхэд үүний эсрэг европын компаниудын ажилтнуудын зөвлөлүүд гэдэг олон үндэстний бүтэцтэй байгууллагуудыг байгуулсан нь одоо ч үр дүнтэй ажиллаж байна. Мэдээж ажилтнуудын төлөөллийг ажил олгогчидтой нэгэн түвшинд харах боломжоор хангахын тулд эдгээр байгууллагуудын эрх зүйн чадамжийг сайжруулах шаардлага бий. Компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах байдал нь олон улсын удирдамжаар тодорхойлогддог өөр нэг тавцан бол европын хувьцаат компаниуд юм. Үүний тулд мөн шинээр гарч ирсэн боломжуудыг алдахгүй ашиглахын зэрэгцээ эрсдэлүүдийг бууруулахад чиглэсэн стратеги, хөтөлбөрүүдийг боловсруулах шаардлагатай. Цаад логикийг ойлгоход хялбархан. Ажилтнуудын компанийн шийдвэрт оролцох эрхүүдийг хангахын тулд олон төрлийн актёрууд ба шийдвэр гаргалтын түвшнүүдийг оролцуулсан европын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Хамтын ажиллагааг хэдий чинээ бэхжүүлж чадна, үр дүн нь төдийчинээ сайн байх болно.

#### **7.5. Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоохын эргэн тойронд өрнөж буй мэтгэлцээн**

Клаудиа Вайнкоф<sup>15</sup>

Бага цалинтай секторын хүрээ өргөжиж байгаа нь улс төрийн үйл ажиллагаа шаардлагатай байгааг сануулаад байгаа хэрэг бус уу? Эсхүл ажилгүйдлийг бууруулах нөлөө бүхий стратегийг хэрэгжүүлэхэд

шаардагдах нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх үү? Энэ асуудал нь германд урьд өмнөх шигээ хурц маргаан дагуулсан хэвээрээ байгаа юм. Сүүлийн жилүүдэд явуулсан олон судалгааны үр дүн бага цалинтай сектор улам бүр өргөжин тэлсээр байна гэдгийг харуулсаар байна. Мөн цаашид ч бага цалинтай секторыг өргөжүүлэх тэр ч байтугай бага цалинтай ажлын байруудыг нэвтрүүлэхийг дэмжих нь зүйтэй гэж үздэг улс төрчид ч байсаар байтал бид маргалдсаар л сууна. (Шеафер 2003, Райн\Гартнер\Круг 2005, Гоевел\Краусел\Шуф 2005, Айххорст болон бусад судлаачид 2005 он)<sup>16</sup>

Сүүлийн жилүүдэд бага цалинг нэмэгдүүлэх нь гагцхүү төрийн үүрэг гэж үү? гэдэг асуултын эргэн тойронд маш их маргаж байна. Улсын төсөвт амьжиргааны баталгаажих доод түвшинг хангах орлого хэлбэрээр суулгаж өгөх үү? эсхүл компаниудын цалинг дахин бууруулах боломжийг хаахын тулд тарифын болон хуулийн түвшинд доод хязгаарыг тогтоож өгөх үү? Дараах хэсэгт бага цалин буюу цалингийн доод түвшинг нотолгоо үндэслэлтэй эсэхийг тогтоох мөн жендерийн тэгш байдлын шаардлагуудыг хангаж буй эсэхэд тайлбар өгнө.

Бага цалинтай ажлын байруудыг хамгаалахын тулд эдгээр ажлын байрууд нь өндөр цалинтай ажлын байруудад дэвшин ажиллах дамжлага болно гэж сурталчилдаг. Гэтэл сүүлийн үед хийгдсэн бага цалинтай ажлын байруудын тухай зарим судалгааны үр дүн тийм ч өөдрөг сэтгэлээр хандаад байх хэрэггүй юм гэдгийг харуулаад байна. Сүүлийн жилүүдэд Германд “Дэвших хөдөлгөөн” гэж нэрлэгддэг бага цалинтай ажлын байран дээрээс өндөр цалинтай ажлын байранд шилжих хөдөлгөөн эрс буурсан байна. (Райн\Гартнер\Круг 2005 он). Үүнийг Холбооны хөдөлмөрийн агентлагийн IAQ-үнэлгээний баримтууд ч давхар нотолж байна. Бид 1998 онд бага цалингийн босгоноос доогуур цалин аван бүтэн өдрөөр ажиллаж байсан ажилтнуудын хэд нь 2003 он гэхэд бага цалингийн босгоноос дээш давсан цалинтай ажлын байранд дэвшиж чадсан бэ? гэдэг асуултын дагуу судалсан юм. Дунджаар авч үзэхэд 2004 он хүртэл ажилтай хэвээр байсан ажилтнуудын 34.4 % буюу гуравны нэг хувь нь л өндөр

15 Энэ бүлэг нь “Бага цалин ба цалингийн доод хэмжээний тухай улс төрийн мэтгэлцээнийг жендерийн чиг хандлагаас тайлбарлах нь” гарчигтайгаар “Бага цалин ба цалингийн доод хэмжээ. Жендерийн чиг хандлагаас шинжлэх нь” гэдэг нийтлэлийн нээн бүлэг хэлбэрээр нийтлэгдсэн. Бид sigma хэвлэлийн газар болон зохиогчид уг бүлгийг сурах бичигтээ ашиглах боломж олгосонд талархаж байна.

16 Энэ бүлэгт бодитой ишлэл олоход хүндрэлтэй байсныг тэмдэглэж байна. 2006\2007 оны мэргэжилтнүүдийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжид: “Үйлчилгээний салбарт хөдөлмөр эрхлэлтийн өргөн боломж нээгдэж байна. Бусад орнуудын туршилага нэн ялангуяа АНУ ба Германы өнгөрсөн үеийн туршилага үйлчилгээний салбарын цалингийн зардал багатай олон тооны ажлын байр хэтэрхий өндөр цалин олгох шаардлагын улмаас үгүй болсон гэдгийг харуулж байна.” гэжээ.

цалинтай ажилд шилжиж чадсан байлаа. Энэхүү дэвшсэн хүмүүс нь олон салбарт ажилладаг. Насны хувьд залуу (25-аас доош насны 62.3%), өндөр боловсролтой (53.6% нь дээд боловсролтой), болон эрэгтэйчүүд (50.4%) илүү өндөр цалинтай ажлын байранд шилжиж чаджээ. Харин эмэгтэйчүүдийн хувьд дөнгөж дөрөвний нэг хувь нь цалин өндөртэй ажлын байранд шилжиж чаджээ. (27.1%) (Бош/Калина 2007:45)

Бага цалинтай ажлын байруудыг нийгмийн бодлогын талаас нь авч үзсэн үнэлгээнүүд хамгийн их маргаан дагуулдаг. Зарим нэг нь бүтэн цагаар ажилладаг хүмүүсийн авдаг цалин нь бие даан амьдрах амьжиргааны эх үүсвэрт хүрэлцээтэй байх ёстой, бүтэн цагаар хөдөлмөр эрхэлсээр атлаа ядууралд өртөх ёсгүй гэж үзэж байхад зарим нь бага цалинтай ажил хийдэг хүн бүр заавал ядууралд өртөх албагүй гэж нотолдог. Зарим хүмүүс бага цалинтай ажил эрхэлж буй хүмүүс амьжиргааныхаа эх үүсвэрийг бүрдүүлэх гэж буй харин “эхнэр эсхүл нөхрийнхөө орлогод” нэмэр болох зорилгоор ажилладаг гэж баталдаг. (Бренкел/Айххорст 2007:45) Дээрх хоёр дүгнэлтийн цаана эмэгтэйчүүд бага цалинтай ажил эрхлэхэд болохгүй нь юу байхав гэдэг санаа цухалзаж байгаа юм. Ингэснээр бага цалинтай ажлын байруудыг дэмжигсдийн дунд бүтэн цагаар ажиллаад дээрээс нь илүү цагаар ажиллаад гэр бүлээ тэжээж хүчрэхгүй байгаа өрхийн тэргүүн буюу аавуудыг бодлогын төвд тавих ёстой гэж үздэг хүмүүс дийлэнх нь байдаг. Харин эмэгтэйчүүд бага цалин авлаа гэхэд өнгөцхөн харахад төдийлөн асуудал үүсэхгүй. Бага цалинтай ажлын байранд ажиллах хүмүүс олноороо гарч ирээд байгаа нь “нөхрийнхөө орлогод нэмэр болох” гэсэн эмэгтэйчүүд, тэд бага цалин авлаа гээд ядууралд өртчихгүй, цаана нь тэртэй тэргүй өндөр цалинтай эр нөхөр, хамтран амьдрагчид нь байгаа гэж бодох дуртай хүмүүс олон байна.

Дээрх олон үзэл бодлыг дүгнэж үзэхэд өрхийн төсөвт олон төрлийн орлого орж ирдэг тул өрхийн нийлбэр орлого ядуурлын түвшнээс дээгүүр амьдрах бололцоог бүрдүүлдэг, бага цалинтай хүмүүс бүгдээрээ ядууралд өртөөгүй гэдэг нь үнэн. Бодит байдал дээр нэн ялангуяа ажилгүйчүүд буюу хөдөлмөр эрхлэхгүй байх нь ядууралд өртөх үндсэн шалтгаан, харин бага цалинтай ажил хийсний улмаас ядууралд өртсөн хүний тоо маш бага хувийг эзэлдэг. Гэхдээ бага цалинтай секторт ажилладаг ядуучуудын нийт ядуучуудын дунд эзлэх хувь 1990-ээд оны сүүлчээр 41% байсан нь Европын Холбооны дунджаас 37% дээгүүр байлаа. (Марлиер/Понтеукс 2000 он) Түүнчлэн бага цалинтай секторт ажиллаж буй эмэгтэйчүүдийн амьжиргаа

өрхийн нийлбэр төсвөөр баталгааждаг тул санаа зовох зүйлгүй гэдэг дүгнэлт ч эргэлзээтэй байгаа юм. Бекерийн дүн шинжилгээгээр (Бекер 2006 он) (гэхдээ уг судалгаанд зөвхөн бүтэн цагаар ажиллагсад хамрагдсан гэдгийг онцлох хэрэгтэй) бага цалинтай секторт ажилладаг эмэгтэйчүүдийн өрхийн төсвийг бүхэлд нь авч үзэхэд 19% нь ядуурлын түвшинд амьдарч байгаа нь мөн бага цалинтай секторт ажилладаг өрхийн төсөв нь ядуурлын түвшнээс доогуур эрэгтэйчүүдийнхээс (22%) зөвхөн ялимгүй доогуур байгаа юм. Гэхдээ зөвхөн өрхийн нийт төсөвт хөдөлмөр эрхлээд олсон орлогыг үндэслэн хийсэн судалгаа тул нийгмийн хамгаалын сангаас авдаг тэтгэвэр, ажилгүйдлийн мөнгө зэрэг нь зөвхөн хувь хүний өөрийнх нь олж буй орлогын хэмжээнээс тооцогдоно гэдгийг харгалзаж үзээгүй. Мөн гэр бүл тогтвортой биш нөхцөлд эхнэр эсхүл нөхрийн орлого байнгын баталгаатай орлогын эх үүсвэр биш гэдгийг харгалзан үзэх ёстой. Ажилгүйдэл, салалт зэрэг нь хурдан хугацааны дотор удаан хугацаагаар тогтвортой үргэлжлэх өөрчлөлтүүдийг дагуулдаг.

Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоохын эсрэг бага цалин бол доогуур бүтээмжийн илэрхийлэл, цалингийн доод хэмжээг төрөөс хуульчлан тогтоох нь хөдөлмөр эрхлэлтийг бууруулдаг гэх мэт олон жишээг дурьддаг. Нэн ялангуяа мэдлэг боловсрол муутай хүмүүсийн хөдөлмөрийн зах зээлд дээр амжилтолох магадлалыг үлэмж хэмжээгээр бууруулдаг гэж үздэг. Гэхдээ германд бага цалинтай секторт ажиллаж буй хүмүүс бүгдээрээ боловсрол багатай хүмүүс биш. Харин ч бүр эсрэгээрээ германд бага цалинтай секторт ажиллаж буй хүмүүсийн дөрөвний гурав нь мэргэжлийн боловсрол эзэмшсэн, тэр ч байтугай зарим нь дээд боловсролтой хүмүүс юм. Мөн хуулиар цалингийн доод хэмжээг тогтоож өгснөөр хөдөлмөр эрхлэлтэнд ямар нөлөө үзүүлэх бэ? гэдэг нь асар маргаантай асуудал юм. Их Британид 1999 онд цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосны дараагаар ажлын байр олноороо үгүй болно хэмээн болгоомжилж байсан ч бодит байдал дээр сүүлийн жилүүдэд цалингийн доод хэмжээг эрчимтэй нэмэгдүүлсэн ч хөдөлмөр эрхлэлт дорвитой нэмэгдсэн байна. (Бош/Вайнкоф 2006а) АНУ-д 2006 онд 650 гаруй эдийн засгийн салбарын эрдэмтэд (тэдний дунд Нобелийн шагналтнууд ч байсан) цалингийн доод хэмжээг үлэмж нэмэгдүүлэх шаардлагыг тавьсан юм. (Эдийн засгийн бодлогын институт 2006 он)

Германы эдийн засгийн ирээдүйд дээрх харилцан адилгүй байр суурь хараахан нэвтрээгүй байна. Германы эдийн засгийн профессоруудын олонхи нь цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох нь хөдөлмөр

эрхлэлтэнд сөргөөр нөлөөлнө гэсэн байр суурьтай байгаа юм. Европын эдийн засгийн судалгааны төвийн ерөнхийлөгч Вольфганг Франц 2005 оны 4-р сарын 12-нд хийсэн мэдэгдэлдээ “Улс ардын аж ахуйн онолд цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох нь ямар их сөрөг нөлөө дагуулах бэ? гэдэг дээр санал нэгдэж байсан шиг өөр бусад зүйлсийн талаар ингэж их санал нэгдэж байсныг би мэдэхгүй юм.” гэж мэдэгдсэн байна. (Шүлтен 2005 онд ишлэл татсанаар 109-р хуудас)

Бабарийн эдийн засгийн нийгэмлэг мөн дээрхтэй төстэй мэдэгдлийг бусад орнуудын цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосон туршлага дээр суурилан “Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосноор хөдөлмөрийн зах зээл дээр эерэг нөлөө үзүүлсэн жишээ өнөөг хүртэл алга байна.” гэж мэдэгджээ.<sup>17</sup>

Гэтэл бодит байдал дээр цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосноор хөдөлмөрийн зах зээл дээр ямар нөлөө үзүүлэх нь онолын хувьд тодорхой биш бөгөөд өнөөг хүртэл хийгдсэн судалгаануудын үр дүн харилцан адилгүй байна. (Бош/Вайнкоф 2006 б) Жишээлбэл: Эдийн засгийн зөвлөхүүдийн консулын дүгнэлт (Council of Economic Advisers) (Германы нийт эдийн засгийн хөгжилд үнэлгээ өгөх эрдэмтэн судлаачдын зөвлөлийн консул) 1999 онд ерөнхийлөгчид өгдөг жилийн тайландаа “The weight of evidence suggests that modest increases in the minimum wage have had little or no effect on employment.” (Шүлтений ишлэл татсанаар 2005 он, 198-р хуудас) буюу “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бага хэмжээгээр нэмэгдүүлэх нь ажилгүйдлийн түвшинд онцын нөлөө үзүүлдэггүй болохыг нотлох баримтуудаас харж болно.” гэжээ.

Мөн Фон Бофингерийн сүүлийн нэгэн судалгаанд (2006 он) “Улс орнуудын туршлага өөр өөр үр дүнд хүргэж байгаа нь цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох нь хөдөлмөр эрхлэлтэнд сөрөг нөлөө үзүүлдэг гэдэг дүгнэлт үндэслэлгүй гэдгийг харуулж байгаа юм. Энэ нь цалингийн доод хэмжээг хэр тааруухан хэмжээнд тогтоож байгаа нөхцөлд ямартай ч сөргөөр нөлөөлөхгүй.” гэжээ.

Бидний үзэж буйгаар Германд цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох дараах хоёр үндсэн шалтгаан байгаа юм: Германд улам бүр хүрээгээ тэлж буй цалингийн мөлжлөгийг зогсоох, суурь хамгааллын

17 Энд (буруу) Их Британи ба Ирландад “мэргэжлийн үр чадвар төдийлөн доогуур биш ажилтнуудын” цалингийн доод хэмжээг хуулиар тогтоодог гэж нотолжээ. /Вабарийн эдийн засгийн холбоо: 2006 он/ Бодит байдал дээр Их Британид үйлдвэрлэлийн сургалтын эхний 6 сар хүртэлх хугацаанд жинхэн ажилтнуудаас бага зэрэг доогуур цалинг олгодог. Үүнийг мэргэжлийн үр чадвар багатай ажилтнуудад ерөнхийд нь бага цалин олгодог зохицуулалт гэж ойлгох нь буруу.



баталгааг хангахын тулд төрөөс өгч буй татаас улам нэмэгдэж байгааг зогсоох. Германд бага цалингийн эзлэх хувь нэмэгдэж байгаа нь салбарын түвшинд олон жилийн туршид доод стандартуудыг тогтоож ирсэн тарифын гэрээний систем бага болон доод цалингаас найдвартай хамгаалах хэрэгсэл болж чадахгүй байгааг харуулж байна. Зүүн болон Баруун германд тарифын холбоос суларч байна. Мөн тарифын гэрээгээр тогтоож буй цалин зарим тохиолдолд дэндүү доогуур байна. (Германы Бундестаг 2004 он)

Цагийн хөлс нь 7.5 еврогоос доош байх бохир цалинтай секторуудад цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох шаардлагыг сүүлийн үед үйлдвэрчний эвлэлийнхэн тавьж байна. Уг цалинг бидний тооцоолж буйгаар холбооны улс даяар 5.5 сая хөдөлмөр эрхлэгсэд авч байна. (2006). Тэдний гуравны хоёр нь эмэгтэйчүүд байна. Бага цалинтай секторт ажиллаж буй эмэгтэйчүүд германы нийт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн 19,8%-ийг эзэлж байна. Ойролцоогоор 1.9 сая хөдөлмөр эрхлэгсэд тэр ч байтугай нэг цагт 5 еврогоос доош цалин авч байна. (Бош/Вайнкоф 2008 он) Цагийн 5 евро ба түүнээс доош цалинтай хүмүүс нийт хөдөлмөр эрхлэгсдийн 33%-ийг эзэлж байна. Ийнхүү германы бага цалинтай секторт ажиллагсад АНУ-д зөвшөөрөгдсөн хэмжээнээс ч бага цалин авч байна. АНУ нь олон улсын түвшинд хийгдсэн судалгаагаар германы бага цалинтай секторт ажиллагсадтай ойролцоо цалингийн доод хэмжээг бэлэг тэмдгийн чанартай хуулиар тогтоож өгдөг байна. (Гэхдээ ойрын хугацаанд үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгааг дурьдах хэрэгтэй.)

Европын Холбооны гишүүн 27 орны 20 нь цалингийн доод хэмжээг хуулиар тогтоодог. Үлдэж буй бусад орнуудад тарифтай нягт уялдаатайгаар тогтоож буй цалин нь германы цалингийн доод хэмжээнээс харьцангуй дээгүүр байлгах механизмтай байдаг. Франц, Нидерланд, Их Британи, Люксембург, Ирланд зэрэг орнууд 2007 оны намрын байдлаар цалингийн доод хэмжээг наймаас ес ба түүнээс дээш евро байхаар хуульчлан тогтоосон байна.

Энэ хооронд ажил олгогчдын эгнээнээс–барилгын салбарын ажил олгогчдоос бусад нь цалингийн хэмжээг тогтооход төрийн оролцоо хэрэггүй гэж үздэг уламжлалтай ажил олгогчид цалингийн мөлжлөгийг зогсоохын тулд стандартуудын доод хэмжээг тогтоож өгөх нь зүйтэй гэдэг шаардлагыг тавьж байна. Барилга, байшин цэвэрлэдэг болон цагийн ажилтнуудын ажил олгогчдын зүгээс дээрх

шаардлагыг хүчтэй тавьж байна. Нэр дурьдсан хоёр салбарын нэгд нь эмэгтэйчүүд бараг байхгүй, нөгөөд нь эмэгтэйчүүд дийлэнх нь ажилладаг. Барилга байшингийн цэвэрлэгээний салбар нь саяхнаас ажиллах хүч илгээх хуулинд хамрагдсан юм. Энэ нь тус салбарын хэмжээнд тарифын нэгдсэн гэрээ мөрдөгдөнө, мөн гадаадын ажиллах хүчинд тарифын ерөнхий гэрээ нэгэн адил үйлчилнэ гэсэн үг юм. Цагийн ажлын салбарт гурван том ажил олгогчдын холбоо байдаг бөгөөд үүний хоёр нь улам бүр өсөн нэмэгдэж байгаа цалингийн мөлжлөгийг бууруулах, ирээдүйд германы зах зээл дээр хүч түрэн орж ирэх гадаадын компаниудад ажиллах хүчнийг гадаадад гаргах тухай хуулийн дагуу стандартуудын доод түвшинг хангах үүрэг ногдуулахын тулд салбар даяараа дагаж мөрдөх цалингийн доод хэмжээний зохицуулалтыг нэвтүүлэхийг дэмжиж буйгаа илэрхийлсэн байна. (Дэлгэрэнгүйг Вайнкофын 2006 оны судалгаанаас үзнэ үү.)

Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоохыг дэмжих бас нэгэн шалтгаан бол нийгмийн баримжаат төрийн санхүүжилттэй холбоотой: Германы компаниуд өнөөг хүртэл бага цалинтай ажлын байранд ажиллагсдын ажилгүй байх үеийн баталгааг төрд даатгасаар ирсэн. Жишээлбэл: ажилгүйдлийн мөнгө II -ийг авах нөхцөлийг хөнгөрүүлсний улмаас уг мөнгийг авах ажилгүйчүүдийн тоо өссөн. 2006 оны 10-р сард Холбооны хөдөлмөрийн агентлагийн мэдээгээр хөдөлмөрийн чадвартай эмзэг бүлгийн иргэдийн 20.9% -ийн нийгмийн даатгалын суурь хамгааллын сангаас тэтгэмж авах эрхийг нь нээлттэй болгохын тулд төр татаас төлсөн байна. Германд эмзэг давхаргын нийт 5.339 сая иргэд байдгаас 1.117 сая иргэний өмнөөс төр нийгмийн даатгалын санд татаас төлсөн байна. Эдгээр иргэдийн дийлэнх нь нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй баталгаатай хөдөлмөр эрхлэгсэд байлаа. Эмзэг давхаргын иргэдийн 11.3% буюу 601.533 иргэнийг суурь даатгалд хамруулахын тулд тэдний төлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн хураамж дээр төр нэмж татаас төлжээ. Тэр ч байтугай эдгээр иргэдийн 8.3% нь бүтэн өдрөөр хөдөлмөр эрхлэгсэд байна. Эдгээр иргэдийн дийлэнх нь буюу 55.1% нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний 48.4% нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх ёстой баталгаат ажлын байранд ажилладаг бол 55.1% нь төдийлөн баталгаагүй ажлын байранд ажиллаж байна. Бекерийн судалгаагаар төрийн татаасыг нэмэрлэж байж суурь даатгалд хамрагдах эрх нь үүсэх хөдөлмөр эрхлэгсэд үүнээс ч олон байгаа бөгөөд тэд энэ эрхээ хараахан хэрэгжүүлээгүй байгаа аж. Цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосноор бага цалинтай иргэдийн нийгмийн даатгалд олгодог төрийн татаасыг бүрэн арилгах боломжгүй ч цалин буурсны улмаас төрийн ачаа нэмэгддэг байдлыг бууруулна. Цагийн

хөлсийг доогуур тогтоосноос гадна богино ажлын цагтай, гэр бүлийн чөлөөтэй хүмүүст олгох татаас хэвээрээ үлдэх болно. Нийгмийн даатгалын сангаас суурь хамгааллын тэтгэмж авахын тулд төрийн татаас авч буй иргэдийг ажилгүйдлийн болон бусад хэлбэрийн тэтгэвэр тэтгэмжийг авч байх явцдаа нэмэр болгох гэж цагийн ажил хийдэг гэж үздэг. Тэд цагийн ажлаас зөвхөн татвараас чөлөөлөгдөх хэмжээнд хүртэл орлого олдог. Татвар ногдох хэмжээнээс их хэмжээний орлого олвол татвар төлөх учраас илүү гаргах сонирхолгүй байдаг. Гэтэл mini-job буюу цагийн ажил нэмэгдэхийн хэрээр компаниудын боловсон хүчний бодлогод өөрчлөлт орж байгааг анхаарлын гадна орхигдуулж байна. Тэд татваргүй нэмэлт цэвэр орлого олохын төлөө цагийн ажил хийж байна гэж үзэх нь учир дутагдалтай юм. Барилга цэвэрлэгээний салбарт ажиллагсдын зөвхөн удирдах, зааварчилгаа өгөх хүмүүс л нийгмийн даатгалын шимтгэл хуулиар төлөх ёстой баталгаатай хагас өдрийн болон бүтэн өдрийн ажлын байранд ажилладаг. /Хиеминг 2005 он, Жаерлинг/Вайнкоф 2006 он/ Энэ бүхэн Германд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулиар тогтоох шаардлага байгааг харуулж байна. Зарчмын хувьд хэрэглэж болох олон хувилбарууд байгаагаас эмэгтэйчүүдийн эрх ашгийн үүднээс авч үзвэл цалингийн доод хэмжээг хуулиар тогтоох аргачлалыг нэвтрүүлэх нь хамгийн оновчтой шийдвэр юм. Учир нь цалингийн доод хэмжээг хуулиар тогтоосон нөхцөлд хөдөлмөр эрхлэлтийн бүх салбарын цалин тэр хэмжээгээр нэмэгдэх болно.

Харин тарифын гэрээгээр тогтоож буй цалингийн доод хэмжээ нь хуулиар тогтоож буй цалингийн доод хэмжээний нэгэн хувилбар биш харин тарифын цалинг нөгөө талаас нь хавчиж өгөх үүрэг гүйцэтгэж байгаа юм. Цалингийн доод хэмжээтэй уялдуулан цалинг тогтооход шаардагдах нөхцөл, гадаадад ажиллах хүч илгээх ба гадаадаас ажиллах хүч авах тухай хуулинд зөвхөн цөөхөн салбарууд хамрагдаад байна. Ихэвчлэн эмэгтэйчүүд ажилладаг бага цалинтай салбарууд тарифын шийдвэрийн гадна үлддэг.

Германы эмэгтэйчүүдийн нэлээд хувь нь хагас өдрөөр болон mini-job гэж нэрлэгддэг цалин багатай ажлын байруудад ажиллаж байгаа нөхцөлд хуулиар тогтоосон цалингийн доод хэмжээ нь дангаараа автоматаар эмэгтэйчүүдийн бие даан амьдрах амьжиргааны баталгаа болж чадахгүй, түүнчлэн цагийн 7.5 еврогийн цалин ч дангаараа эмэгтэйчүүдийн бие даан амьдрах амьжиргааны эх үүсвэрийн баталгаа болж чаддаггүй тул түүнээс доогуур цагийн хөлс авч байгаа эмэгтэйчүүдийн хувьд бүр хүрэлцэхгүй гэдгийг анхааралдаа авах ёстой.

## 8. ИРЭЭДҮЙГ ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

Нийгмийн ардчиллын цуврал сурах бичгүүд нь нийгмийн ардчиллын үндсэн асуудлууд болон бодлогын салбаруудын чиглэлийг тогтооход зам заагч луужин юм. Гэхдээ эдгээр цуврал сурах бичгүүдэд хувьсан өөрчлөгдөж буй эрин цагийн эргэлтэнд ямагт хүчин төгөлдөр байх хариултуудыг өгөх зорилтыг тавиагүй, хувиршгүй хариулт өгөх бололцоо ч байхгүй юм. Нийгмийн ардчилал нь нэгэн санаа, улс төрийн үйл ажиллагааны арга замын хувьд уг үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түүнийг ямагт хувьсан өөрчлөгдөж буй хөгжил, хувьслын явцад дахин дахин хянаж, мөн зохицуулж, шинэчилж байх учиртай.

Энэ дүгнэлт нь цаашид улам боловсронгуй болгож сэтгэн бодох шаардлага байгаа гэдгийг харуулж байна. Нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогыг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх бэ? 21-р зуунд нийгмийн ардчилалд ямар сорилтууд тулгарч байна бэ? гэдгийг эргэцүүлэн бодох ёстой.

Өнөө үед нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогод тулгараад байгаа хамгийн том сорилт бол нийгэмд төр ба зах зээлийн тэнцвэрт байдлыг шинэчлэн тогтоох явдал юм. ГСДН-ын Хамбургийн хөтөлбөр энэ чиглэлд дараах хоёр чухал санааг өгсөн юм.

Бидний хувьд зах зээл нь чухал бөгөөд эдийн засгийн зохицуулалтын бусад хэрэгслүүдээс давуутай гэдэг нь батлагдсан хэрэгсэл юм. Өөрийн гольдролоор хөгжих зах зээл нь нийгмийн болон экологийн хувьд сохортой адил. Зах зээл нь өөрийн зохицуулалтаар төрийн үйлчилгээг зохистой хэмжээнд нийлүүлэх чадамжгүй. Зах зээлд өөрийн эерэг нөлөөгөө хөгжүүлэх боломж олгохын тулд зохих дүрэм журмын дагуу торгууль шийтгэл ногдуулах чадамжтай төрийн зохицуулалт, өндөр чадамжтай хуулиуд, шударга үнэ тогтоолт хэрэгтэй.

(Хамбургийн хөтөлбөр 2007 он, 17-р хуудас)

Шинээр тулгарч буй сорилтуудыг даван туулахын тулд нийгмийн ардчилал байнга хөгжиж урагшилж байх ёстой. Нийгмийн ардчиллын үндэслэлийг ухамсарлан ойлгосны үндсэн дээр бодит байдалд соргог мэдрэмжтэй хандаж чадвал хөгжих ч болно.

Энэ нь нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын хувьд ч нэгэн адил. Энэхүү сурах бичиг нь НҮБ-ын үндсэн эрхүүдийн тунхаглалаар тодорхойлогдсон үндсэн эрхүүд болон нийгмийн ардчиллын үнэт зүйлс дээр суурилан нийгмийн ардчиллын эдийн засгийн бодлогын

бусад эдийн засгийн бодлогын чиглэлүүдээс ялгагдах онцлогуудыг тодруулан харуулах зорилготой юм. Иймд энэхүү сурах бичгийг орчин үеийн, үнэлэмж дээр суурилсан өсөлт, нийгмийн тэнцвэрт байдал, тогтвортой байдал гэдэг гурван үндсэн зарчим дээр суурилсан эдийн засгийн бодлогод хүрэх луужин хэмээн тодорхойлж болно.

## 9. ЗОХИОГЧДЫН ТУХАЙ

**Ёоахен Даам** (1981 он) нь Фридрих-Эбертийн сангийн улс төрийн академийн референт юм. Тэрээр Мюнстер, Малага хотноо улс төрийн шинжлэх ухаан, харилцааны шинжлэх ухаан, олон нийтийн эрх зүйгээр суралцсан.

**Доктор Михаел Даудерштаedt** нь (1947 он) 1980-аад оноос эхлэн Фридрих-Эбертийн санд ажиллаж байна. 2006 оноос эхлэн эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ажиллаж байна. Өмнө нь олон улсын бодлогын дүн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан. Тэрээр математик, эдийн засаг, хөгжлийн бодлогоор Аахен, Парис, Берлин хотноо тус тус суралцсан.

**Петер Франц** (1953) нь 1988 оноос хойш Холбооны байгаль орчин, Байгаль хамгаалал, цөмийн реакторын аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна. Тэр Берлин хотод ажиллах болсон 1999 оноос хойш “Байгаль орчин ба эдийн засаг, Эдийн засгийн шинэлэл ба хөдөлмөр эрхлэлт, Байгаль орчны аудит”-ын рефератуудыг удирдаж байна. Тэрээр улс ардын аж ахуйн онол, захиргааны шинжлэх ухаанд тус тус суралцсан байна.

**Товиас Гомберт** нь (1975 он) нь компанийн шийдвэрт ажилтнуудын оролцоог хангах сэдвээр явагддаг семинаруудыг хариуцдаг. Үүний зэрэгцээгээр мэдээлэл харилцаа болон онолын семинаруудын сургагч багшаар ажилладаг. 2003-2005 онуудад германы ардчилсан социалист залуучуудын холбооны дэд даргаар, 2005-2007 онд Германы ардчилсан социалист залуучуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байлаа. Энэ хооронд тэр залуучуудын сургуулийг үүсгэн байгуулахаар бусад нөхдийн хамт ажиллаж байлаа. 2007 оноос хойш тэрээр нийгмийн ардчиллын академид сургагч багшаар ажиллаж байна. Товиас Гомберт нь “Нийгмийн ардчиллын үндэслэлүүд” дэвтрийн үндсэн зохиогч юм. Тэрээр өнөөг хүртэл Jean-Jacques-Rousseau-ийн чиглэлээр болон Марксын онол, ёс суртахууны философийн чиглэлээр шинжлэх ухааны бүтээлүүдээ туурвисан.

**Доктор Эрик Гургдиес** (1944) нь 1993 оноос 2009 он хүртэл Фридрих-Эбертийн сангийн Мекленбург–Порпоммерн муж улс дахь салбарын даргаар ажилласан. Тэр эдийн засаг, нийгэм судлалаар

суралцсан. Дараа нь тэр Бернойштадт, Ааренбург хотуудын Ардын дээд сургуулиуд болон Хамбургийн эдийн засаг, улс төрийн дээд сургуульд эдийн засгийн доцентаар ажилласан.

**Доктор Кристиан Крелл** нь (1977) Фридрих-Эбертийн сангийн ажилтан бөгөөд нийгмийн ардчиллын академийг хариуцан ажилладаг. Тэрээр улс төрийн шинжлэх ухаан, түүх, эдийн засгийн шинжлэх ухаан, нийгэм судлалын чиглэлээр Сиегений Их Сургууль, Нью Йоркийн их сургуульд тус тус суралцсан. 2007 онд ГСДН, Хөдөлмөрийн нам, Социалист Намуудын Европын бодлого сэдвээр улс төрийн шинжлэх ухааны салбарт докторын зэрэг хамгаалсан юм.

**Доктор Флориан Майер** (1975 он) нь Холбооны байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн реакторын аюулгүй байдал хариуцсан референт, “Байгаль орчин ба эдийн засаг, эдийн засгийн шинэчлэл ба хөдөлмөр эрхлэлт, Байгаль орчны аудит” рефератад референт, Хайдельбергийн их сургуульд багшилдаг. Тэрээр эдийн засаг, нийгмийн шинжлэх ухаанд тус тус суралцсан.

**Доктор, профессор Бернер Паша** нь (1957 он) 1992 оноос хойш Дүисбург –Эссений их сургуульд Зүүн азийн эдийн засгийн (Япон, Солонгос) профессороор ажиллаж байгаа. Тэрээр Лондон, (LSE), Японы Нагоя хотуудад ялангуяа Брайтсгау дахь Фрайбург хотноо улс ардын аж ахуйн сургуульд суралцаж мөн тус сургуульдаа докторын зэрэг хамгаалж зэрэг дээшлүүлжээ.

**Доктор, профессор Вольфганг Шроедер** (1960 он) нь 2009 оноос Бранденбург холбооны улсын хөдөлмөр, нийгэм, эмэгтэйчүүд, гэр бүлийн яамны төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Мөн 2006 оноос ХБНГУ-ын төрт ёс, улс төрийн системийн хувьсал хариуцсан профессороор Кассел хотноо ажиллаж байна. Өмнө нь тэрээр ИГ Металл үйлдвэрчний эвлэлийн удирдах зөвлөлд төрөл бүрийн алба хашиж Франкфурт ам Майн, Дармштадт, Харвард хотуудад суралцаж багшилж байсан. Тэр Марбург, Вена, Тювинген хотуудад улс төрийн шинжлэх ухаанд суралцаж Гиезен хотноо докторын зэрэг хамгаалсан.

**Стефан Тидов** нь Холбооны Байгаль орчин, Байгаль хамгаалал, цөмийн реакторын аюулгүй байдал хариуцан “Байгаль орчин ба эдийн засаг, эдийн засгийн шинэчлэл ба хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны аудит”-ын рефератад ажилладаг. Тэр одоогоор түр

хугацаагаар чөлөө аван Холбоотон 90\Ногоонтнууд намын Бундестаг дахь фракцид ажиллаж байна.

**Симон Баут** (1977 он) нь Бранденбург холбооны улсын хөдөлмөр, нийгэм, эмэгтэйчүүд, гэр бүлийн яаманд референтээр ажилладаг. Германы хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэл сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Нийгмийн ардчиллын академийн сургагч багшийн хувьд эдийн засаг, даяаршлын сэдвүүдээр явагддаг семинаруудыг хариуцдаг. Тэр нийгмийн судалгаа, нийгмийн эдийн засгийн институт, Hiertie School of Gouvernance, эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагад (OCED) ажиллаж байсан.

**Доктор Клаудиа Вайнкоф** (1963) нь Хөдөлмөр ба мэргэжил дээшлүүлэх институт, Дүисбург-Эссений Их сургуулийн дэргэдэх "Уян хатан байдал ба аюулгүй байдал" судалгааны хэлтсийн удирдагч, дэд менежерээр ажилладаг. Тэрээр Дортмунд хотноо улс ардын аж ахуйн сургуульд нийгэм судлалыг хоёрдогч сэдвээр сонгон авч суралцсан бөгөөд тус сургуульдаа докторын зэрэг хамгаалсан.







Улс төрд тодорхой чиглэл хэрэгтэй. Үйл ажиллагаагаа ямар зорилгод хүрэхийн тулд явуулж байна бэ? гэдгээ сайн мэддэг хүн л зорилгодоо хүрч бусдыг араасаа дагуулж чадна. Ийм ч учраас “Эдийн засаг ба нийгмийн ардчилал” ном та бүхнээс “Нийгмийн ардчиллын орчин үеийн, үнэлэмжид суурилсан бодлого ямар байх ёстой бэ? Эдийн засгийн энэхүү бодлого ямар зарчмууд дээр суурилсан байх ёстой бэ? Уг бодлогыг практик дээр хэрхэн хэрэгжүүлэх бэ?” гэдэг асуулыг уншигчиддаа тавьж байгаа юм.

Академийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.fes-soziale-demokratie.de](http://www.fes-soziale-demokratie.de) вев-сайтаас аваарай.

“Мэдээлэл сайтай ном байна. Уг номын хоёрдох хэвлэлийг уншаарай. Номын зохиогчид санхүүгийн хямралын талаар бичих зорилго тавиагүй ч санхүүгийн капитализмын хүчит давалгаа хөөсрөн долгиж байгаа өнөө үед уншихад хамгийн оновчтой. Энэ номын сэдэв нь үнэлэмжид чиглэсэн эдийн засгийн бодлого ба хүн төвтэй нийгмийн ардчиллын бодлого. Эдгээр бодлого нь бүх хүний хангалуун амьдралын түвшинг дээшлүүлэх зорилгод чиглэгдэж байгаа бөгөөд уг зорилтыг урт хугацааны туршид, эдийн засгийн хувьд амжилттай, экологийн хувьд ухаалаг, нийгмийн хувьд тогтвортой бөгөөд шударгаар хүрэх боломжтой. Уг зорилт нь та биднийг урагш хөтлөх луужин юм.

**Франц Мюнтерферинг, ГСДН-ын дарга**

“Нэн ялангуяа санхүү эдийн засгийн хямрал нүүрлээд байгаа өнөө үед “Эдийн засаг ба нийгмийн ардчилал” дэвтэр Фридрих-Эбертийн санд сөхөж харахгүй байхын аргагүй санаа оноог өгч чадна.”

**Доктор Петер Штрук, ГСДН-ын Бундестаг дахь бүлгийн дарга**

“Нийгмийн ардчиллын сурах бичгүүд нь тайлж ойлгоход хүндрэлтэй асуудлуудыг энгийн бөгөөд ойлгомжтойгоор тайлбарладаг. Хэн, юуг, хэрхэн юуны өмнө ямар шалтгааны улмаас гэдэг асуултуудад өргөн хүрээтэй хариулт өгөх ачаалал ихтэй улс төрийн амьдралын өдөр тутамд алт шиг үнэтэй ном болжээ.”

**Дианна Коестер, үйлдвэрчний эвлэлийн нарийн бичгийн дарга**